



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛД
НӨЛӨӨЛӨХ МАКРО ОРЧНЫ СУДАЛГАА
Боть I



Гүйцэтгэсэн: “OASIS BEAR” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛГ. СОЁЛМАА

Хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Ider tower 61 тоот, утас:976-99183518, 86890199

И-мэйл хаяг: oasis.bear.llc@gmail.com

И-мэйл хаяг: oasis.bear.llc@gmail.com

2021

АГУУЛГА

1.	УЛС ТӨРИЙН ОРЧНЫ СУДАЛГАА	7
1.1	Алсын хараа 2050-ийн аймгийн аялал жуулчлалтай холбогдох зүйл заалтууд..	7
1.1.1	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2050	10
1.1.2	ДЭЛХИЙН МОНГОЛ ЗОРИЛТ	12
2.	БАЙГАЛИЙН НӨӨЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС	39
2.1	Говь-Алтай аймгийн нөөцүүд	40
2.1.1	Байгалийн тогтоц	40
2.1.2	Говь-Алтай аймгийн амьтан, ургамлын нөөц.....	42
2.1.3	Монгол улсын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ	48
2.2	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал	59
2.3	Засгийн газрын мөрийн хөтөлбөр.....	65
2.4	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр.....	71
2.5	Говь-Алтай аймгийн тусгай хамгаалалттай газар	73
2.5.1	СУТАЙ ХАЙРХАН (ТӨРИЙН ТАХИЛГАТ УУЛ).....	73
2.5.2	Говийн их дархан цаазат газрын А хэсэг	74
2.5.3	Говийн их дархан цаазат газрын Б хэсэг.....	75
2.5.4	Хасагт хайрхан уулын дархан цаазат газар.....	77
2.5.5	Ээж уулын байгалийн дурсгалт газар.....	77
2.5.6	Монгол элсний байгалийн дурсгалт газар.....	79
2.5.7	Алагхайрхан уулын байгалийн нөөц газар.....	80
2.5.8	Бурхан буудай уулын байгалийн нөөц газар	81
2.5.9	Шаргын нөөц газар	83
2.5.10	Хар Азаргын нурууны байгалийн нөөц газар	84
2.5.11	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн тоо.....	88
2.6	Үйл ажиллагааны хөтөлбөрүүд.....	92
2.6.1	Тусгай сонирхлын аялал жуулчлалын дэд хөтөлбөр.....	92
2.6.2	“Говь-Алтай аймгийн засаг даргын үйл ажиллагаан хөтөлбөр 2020-2024” (2020 он).....	96
2.6.3	Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008 – 2021 он) д тусгасан..	97
3.	ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	105
3.1	Үндсэн хууль	105
3.2	Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх хууль эрх зүйн орчны судалгаа	107
3.3	Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх засгийн газрын тогтоол.....	148
3.4	Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх сайдын тушаал, шийдвэр.....	150
3.5	Салбарын стандарт, журмууд.....	153
3.6	Аялал жуулчлалтай холбогдох бусад журам, гарын авлага	154
3.7	Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх үйлчилгээний технологи, монгол улсын болон олон улсын стандартууд	158
3.8	хэлэлцээрүүд	160

3.8.1	Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын хөгжүүлэхэд байгаль орчны гэрээ хэлэлцээр	160
3.8.2	Байгаль орчны чиглэлээр байгуулсан байгууллага хоорондын хэлэлцээр 160	
3.8.3	Говь-Алтай аймагт зочилох жуулчдын тээвэрлэлтэй холбоотой стандартууд.....	165
3.9	Олон улсын үндэсний паркуудын дүрэм.....	167
3.9.1	Франц улс дах үндэсний паркуудын дүрэм	167
3.9.2	Канадын Кюбэк мужийн үндэсний паркуудад мөрдөх дүрэм	172
3.9.3	Калифорни мужийн улсын паркийн журам.....	174
3.10	Говь- Алтай аймгийн аялал жуулчлалын салбарт мөрдөх дүрмийн санал	177
4.	ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫ СУДАЛГАА.....	182
4.1	Үр дүнгийн тойм.....	182
4.2	Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын эдийн засгийн өгөөж	183
4.3	Говь-Алтай аймгийн Эдийн засаг, хүн ам зүйн судалгаа.....	184
4.4	Монгол улсын эдийн засгийн орчны судалгаа	206
4.5	Бүсийн эдийн засгийн нөхцөл байдал	230
5.	ХҮН АМ ЗҮЙН СУДАЛГАА	233
6.	НИЙГЭМ СОЁЛЫН ОРЧНЫ СУДАЛГАА	235
6.1	Монгол улсын угсаатны бүтэц	235
6.2	Говь-Алтай аймгийн угсаатны бүтэц	238
6.3	Монголын тэмдэглэлт арга хэмжээнүүд	239
6.3.1	Гэмт хэрэг, зөрчил	241
7.	ТЕХНОЛОГИЙН ОРЧНЫ СУДАЛГАА	242
7.1	Нар, салхины эрчим хүч ашиглах шийдэл.....	243
7.2	Усны хэмнэлтийн технологи ашиглах нь	246
7.3	Мэдээллийн технологи ашиглах боломж	248
7.3.1	Хөрсний бохирдлоос сэргийлэх арга зам буюу байгаль орчинд ээлтэй эко ариун цэврийн байгууламжууд.....	248

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: 2040 оны усны хэрэгцээ	38
Хүснэгт 2: Говь-Алтай аймгийн өндөр уулс	41
Хүснэгт 3: Говь-Алтай аймгийн улаан номонд орсон амьтан, ургамал	43
Хүснэгт 4: Говь-Алтай аймгийн нутагт тархах аргаль хонины тархац	44
Хүснэгт 5: Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн эрчим хүчний төслүүд.....	46
Хүснэгт 6: Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлүүд	92
Хүснэгт 7: Үндсэн хуулийн шинэчилсэн зүйлүүд.....	105
Хүснэгт 8: Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх хууль эрх зүй.....	109
Хүснэгт 9: Засгийн газрын тогтоол	148
Хүснэгт 10: Сайдын тушаал, шийдвэр	150
Хүснэгт 11: Аялал жуулчлалын үйл ажиллагааны стандарт.....	153
Хүснэгт 12: Аялал жуулчлалтай холбогдох бусад журам, гарын авлага	154
Хүснэгт 13: Үйлчилгээний технологи буюу олон улсын стандартууд	159
Хүснэгт 14: Байгаль орчны салбарт нэгдэн орсон гэрээ конвенц-протоколууд	161
Хүснэгт 15: Аялал жуулчлалын салбарт баримтлах стандарт	163
Хүснэгт 16: Тээврийн салбарын стандартууд.....	165
Хүснэгт 17: Тээврийн салбарын стандартууд.....	169
Хүснэгт 18: днб-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь.....	184
Хүснэгт 19: дотоодын нийт бүтээгдэхүүн.....	184
Хүснэгт 20: нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн	185
Хүснэгт 21: Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц.....	187
Хүснэгт 22: Дотоодын нийт бүтээгдэхүүн салбараар.....	189
Хүснэгт 23: Ядуурлын үзүүлэлт	192
Хүснэгт 24: Хадгаламж ба зээлийн мэдээ	193
Хүснэгт 25: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	195
Хүснэгт 26: өрх толгойлсон ганц бие эцэг, эх	195
Хүснэгт 27: Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт	196
Хүснэгт 28: Ажилгүйдлийн түвшин	198
Хүснэгт 29: Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал	198
Хүснэгт 30: Төсвийн орлого, зарлага	199
Хүснэгт 31: Бүртгэлтэй ажилгүй иргэд/нас,хүйсээр/	201
Хүснэгт 32: бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн.....	202
Хүснэгт 33: Ажил хайгч иргэд, насаар	203
Хүснэгт 34: Ажил хайгч иргэд, насаар /эмэгтэй/	204
Хүснэгт 35: Ажил хайгч иргэд, насаар /эрэгтэй/	204
Хүснэгт 36: <i>Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо</i>	212
Хүснэгт 37: <i>Дэлхийн эдийн засгийн форумын өрсөлдөх чадварын судалгаа</i>	218
Хүснэгт 38: Дэлхийн эдийн засгийн форумын өрсөлдөх чадварын судалгаа	227
Хүснэгт 40. Хүн амын тоо, үндэс угсаа, насны бүлэг, хувиар, 2015 он.....	238
Хүснэгт 41. Мэдээллийн технологи	248
Хүснэгт 42. <i>Соруулдаг ариун цэврийн байгууламж загвар 1 –ийн тайлбар</i>	254
Хүснэгт 43. Хуурайшуулах шийдэлтэй ариун цэврийн байгууламжийн тайлбар	256
Хүснэгт 44: Мэдээллийн лавлагаа /байгууллагаар/	260
Хүснэгт 45: <i>Стандартууд</i>	280

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1: днб-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь	184
График 2: ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр.....	185
График 3: НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	186
График 4: Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц	188
График 5: Дотоодын нийт бүтээгдэхүүн салбараар.....	191
График 6: Ядуурлын үзүүлэлт	193
График 7: Хадгаламж ба зээлийн мэдээ.....	194
График 8: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД	195
График 9: ӨРХ ТОЛГОЙЛСОН ГАНЦ БИЕ ЭЦЭГ, ЭХ.....	196
График 10: Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт.....	197
График 11: Ажилгүйдлийн түвшин	198
График 12: Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал.....	199
График 13: Төсвийн орлого, зарлага	200
График 14: Бүртгэлтэй ажилгүй иргэд /нас, хүйсээр/	201
График 15: БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН.....	202
График 16: Ажил хайгч иргэд, насаар.....	203
График 17: Ажил хайгч иргэд, насаар /эмэгтэй/	204
График 18: Ажил хайгч иргэд, насаар /эрэгтэй/.....	205
<i>График 19. Монгол улсын эдийн засгийн өсөлт, хувиар.....</i>	<i>206</i>
<i>График 20. Нэг хүнд ногдох ДНБ /2010 оны зэрэгцүүлэх үнээр/.....</i>	<i>207</i>
<i>График 21. Үнийн өсөлт.....</i>	<i>207</i>
<i>График 22. Гадаад худалдаа.....</i>	<i>208</i>
<i>График 23. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, тэрбум төгрөг</i>	<i>208</i>
График 24. ДНБ-ний бүтэц.....	210
<i>График 25. Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ /сая.төг/.....</i>	<i>210</i>
<i>График 26. Хөрөнгө оруулалт /2009-2019/.....</i>	<i>211</i>
График 27. Гадаадын жуулчдын тоо	213
<i>График 28. ДНБ, дэд бүтцийн салбараар, сая төгрөг, /2010 оны зэрэгцүүлэх үнээр/.....</i>	<i>217</i>
График 29. ДНБ-нд дэд бүтцийн салбарын эзлэх хувь	218
График 30. Хөрөнгө оруулалт дэд бүтцийн салбараар, тэрбум төгрөг	219
<i>График 31. Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтад зарим салбарын хөрөнгө оруулалтын эзлэх хувь.....</i>	<i>219</i>
График 32. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын үйлдвэрлэл, /2010 оны зэрэгцүүлэх үнээр/.....	220
График 33. Хөрөнгө оруулалт, цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж.....	220
График 34. Гадаадын шууд хөрөнгө оруулалт: Цахилгаан, хий, уур, агааржуулалт, сая ам.доллар.....	221
График 35. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл /сая кВт.цаг/.....	221
<i>График 36. Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....</i>	<i>222</i>
График 37. Хөрөнгө оруулалт: Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	222
График 38. Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг	223
График 39. Зорчигчдын тоо, сая хүн	224
График 40. Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны үйлдвэрлэл /2010 оны зэрэгцүүлэх үнээр/	224
График 41. Түгээсэн ус, мян. м ³	225
График 42. Ус ариутгал, усан хангамжийн борлуулалт, сая төгрөг	225
График 43. Мэдээлэл холбооны ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.....	226

График 44. Мэдээлэл холбооны салбарын хөрөнгө оруулалт	226
График 45. Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг	227
График 46. Холбооны салбарын орлого, бүс нутгаар	228
График 47. Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо, бүс нутгаар.....	229
График 48. Суурин утасны цэгийн тоо (ширхэг)	229
График 49. Телефон яриа (сая минут).....	229
График 50. Үүрэн сүлжээнээс орсон гарсан яриа, сая минут	230
График 51. Баруун бүсийн нэг хүнд ногдох ДНБ, мян.төгрөг	230
График 52. Бүсийн ДНБ-ний бүтэц, салбараар, 2018, хувиар	231
График 53. Баруун бүсийн орон нутгийн төсвийн орлого, сая төгрөг	231
График 54. Баруун бүсийн орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөг	232
График 55: Монгол Улсын нийт хүн ам	233
График 56: Монгол улсын хүн амын нас хүйсийн суврага	234

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Өсүүдөөс дүүжингийн хүн ам.....	16
Зураг 2: Бүсчилсэн хөгжил	39
Зураг 3: Тогтвортой хөгжил	50
Зураг 4: Хүн гүрэн (МЭӨ 209-93)	54
Зураг 5: Сянби улсын газар нутаг	55
Зураг 6: Жужаан (Нирун) газар нутаг	56
Зураг 7: Түрэг (555-745)	57
Зураг 8: Уйгар улс газар нутаг	57
Зураг 9: <i>Киданы газар нутаг</i>	58
Зураг 10: Монголын хүн амын угсаатан	59
Зураг 11: <i>тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын уялдаа</i>	62
Зураг 12: Тогтвортой хөгжлийн зорилт	64
Зураг 13: Тогтвортой хөгжлийн зорилт	65
Зураг 14: Говийн Их дархан цаазат газар А	74
Зураг 15: Говийн Их дархан цаазат газар Б	75
Зураг 16: Хасагт хайрхан уулын дархан цаазат газар	77
Зураг 17: Ээж уулын байгалийн дурсгалт газар	78
Зураг 18: Монгол элсний байгалийн дурсгалт газар	80
Зураг 19: Алагхайрхан уулын байгалийн нөөц газар.....	81
Зураг 20: Бурхан буудай уулын байгалийн нөөц газар	82
Зураг 21: Шаргын нөөц газар	84
Зураг 22: Хар Азаргын нурууны байгалийн нөөц газар	86
Зураг 23: Тусгай хамгаалалтанд авсан газар нутаг	87
Зураг 24: Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн тоо.....	88
Зураг 25: Байгаль орчны аялал жуулчлалын стандарт	158
Зураг 26: Францын үндэсний паркийн журам.....	168
Зураг 27: аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал	214
Зураг 28: Жуулчдын зорилго.....	215
Зураг 29: Жуулчдын тоо бүсээр	215
Зураг 30: Аялалын зорилго, бүс	216
Зураг 32: Нийгэм соёлын орчны судалгаа.....	235
Зураг 33: Монгол орны ястнууд.....	236
Зураг 34: гэмт хэрэг, зөрчил	241

Зураг 35: Нар, салхины эрчим хүч ашиглах шийдэл	243
Зураг 36: нарны вакуум коллектор систем.....	244
Зураг 37: Хэрэглэсэн ахуйн усаа дахин ашиглах	247
Зураг 38 : хуримтлуулсан борооны усаа ашиглах.....	247
Зураг 39: ариун цэврийн байгууламж	256
Зураг 40: Зөөврийн буюу шилжүүлэх ариун цэврийн байгууламж	259
Зураг 41: Ахуйн бохирын септик системийн ерөнхий зураг	270
Зураг 42: Тунгаагчтай септик системийн ерөнхий бүдүүвч.....	271
Зураг 43: Септик системийн танкууд	272
Зураг 44: Системийн аюулгүй ажиллагаа	279
Зураг 45: Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны процесс	279

1. УЛС ТӨРИЙН ОРЧНЫ СУДАЛГАА

1.1 Алсын хараа 2050-ийн аймгийн аялал жуулчлалтай холбогдох зүйл заалтууд

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх баримт бичгийг дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

- Үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөр буюу үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн хөгжлийн бодлоготой нийцсэн байх;
- Аялал жуулчлалын үйл ажиллагааг Монгол орны байгалийн унаган төрхийг хадгалах, орчны бохирдлыг багасгах, экологийн тэнцвэрт байдал, хүний эрүүл, аюулгүй орчинд аялах нөхцөлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулах;
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлах, иргэд, олон нийтийн оролцоог дэмжих, салбар дундын болон төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангах;
- Аялал жуулчлалын салбарт дэвшилтэт техник, технологи, тэргүүн туршлагыг ашиглах;

Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050” хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын бичиг баримт боловсруулах ажлын зорилго, зорилтуудыг тавьж ажилласан болно. Тус баримт бичгийн хүрээнд 2050 онд хүрэхийг зорьж буй ногоон амьдралын хэв маяг бүхий эко аялал жуулчлалыг хөгжүүлэхээр гол үзэл баримтлалаа тодорхойлосон. Монгол улсыг бүсчилэлийн хөгжлийн зургаан бүстэй. Өвархангай, Баянхонгор, Говь-Алтай аймгууд нь БАЙГАЛИЙН НӨӨЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС–д хамаарна. Бүсчилсэн хөгжлийн **эрхэм зорилго** нь үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагалт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэй бүсүүдийг хөгжүүлэхэд оршино.

Энэ зорилгын хүрээнд гурван үе шатыг тодорхойлсон. Үүний

II- р үе 2031-2040 хүрээнд Дотоодын ба олон улсын амралт рашаан сувилал, аялал жуулчлалын сүлжээг хөгжүүлэх. Энэ хүрээнд Говь-Алтай аймагт Хүнхэр, Таван элсний сувилалыг хөгжүүлэх. Аялал жуулчлалыг гурван бүсчлэлээр хөгжүүлэхээр төлөвлөсөн.

III- р үе 2041-2050 Соёлын болон зугаа цэнгэлийн олон улсын аялал жуулчлалын цогцолборыг хөгжүүлэх. Аймгийн хэмжээнд арга хэмжээний соёлын хөтөлбөрөөр хөгжүүлэх. Нийгмийн амьдрал даяарчлагдаж, аялал жуулчлал эрчимтэй хөгжиж, гадаадын олон улс оронтой нээлттэй харилцаатай болсон өнөө үед бид энэ урсгалыг дагах нь дамжиггүй хэдий ч даяарчлалын эсрэг хүчтэй гарч ирж буй зүйлийн нэг бол үндэстний соёл, зан заншил юм. Өөрөөр хэлбэл дэлхийн олон үндэстэн, угсаатнуудыг бие биеэс нь тусгаарлаж байдаг цорын ганц зүйл бол соёл гэж үздэг. Энэ утгаараа даяарчлалд хамрагдаж үл болох цөөхөн зүйлсийн нэг болох үндэстний соёл, зан заншил нь өөрийн улс гүрний тусгаар тогтнол, үндэстний эрх ашгийг хамгаалах асуудалд үндэс суурь болж улмаар энэ нь соёлын аялал жуулчлалаар илрэлээ олж байна гэж үзэж болно.

Судлаач Жафари аялал жуулчлал ба соёлын харилцааны талаар судалж аялал жуулчлал нь 4 ялгавартай соёлын категорийг үүсгэдэг байна гэж тодорхойлжээ.

Үүнд:

- Эзэн соёл /Host culture/ жуулчдын аялж буй газар орны бүхий л онцлог ялгаа, өвөрмөц байдлыг бүхэлд нь хамруулсан ойлголт. Жуулчид олон ирэх тусмаа эзэн орны хүн амын тэдэнд хандах хандлагад сөрөг байдал үүсэх нь нэмэгдэж, жуулчдын тоо бага, цөөн үед эзэд, зочидын харилцаа эерэг байна гэж хэлж болно.
- Зочин соёл /Guest culture/ тухайн аялалд оролцож буй жуулчин хүн өөрийн байнга амьдран суурьшдаг газар орныхоо өвөрмөц онцлог шинж төрхийг буюу соёлыг хадгалан тээж явааг хэлнэ.
- Шилжилтийн соёл /Transitional culture/ эзэн ба зочин соёлын харилцан шилжсэн хэлбэр. Жуулчин хүн аялал явагдаж буй тухайн газар орныхоо өвөрмөц соёлыг ойлгон хүндэтгэх, түүний зарим элементүүдээс суралцах, тухайн тохиолдолд тэрхүү соёлыг дагах, баримтлах зэргээр нутгийн иргэдтэй харилцан ойлголцох хэлбэрээр илэрдэг түр зуурын шинжтэй соёл юм.

- Үлдэх соёл /Residual culture/ тухайн аялал явагдаж буй зорих газрын буюу эзэн соёлд жуулчдын соёл хүчтэй нөлөөлсөнөөс үүдэн бий болох соёлын үр хөврөлүүд юм

Зарим улсууд соёлын үйлдвэрлэл, бүтээлч үйлдвэрлэлийг аялал жуулчлалын салбартай холбон өөрийн дүр төрхийг илэрхийлсэн байгааг Испани, Шотланд, Тайланд, Шинэ Зеланд гэх зэрэг олон улсын туршлагаас харж болохоор байна. Соёлын сэдэвтэй эвент, арга хэмжээнүүдийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд бүтээлч аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож улмаар тухайн улс нь олон улсын аялал жуулчлалын гол зорин очих бүс нутаг болсон тохиолдлууд олон байдаг. Аймгийн аялал жуулчлал нь харьцангуй хөгжил тааруу нөөцийн хувьд сайн боловч ашиглалтын түвшин сул байна. Аймгийн газарзүйн байрлал, хойноос урагш сунаж тогтсон, өмнө хэсэг нь Говийн Их дархан газар оршдог, дэд бүтэц, түүх соёл байгалийн нөөцийн тархац, суурин газар, аялал жуулчлалд ашиглах нөөц, төвд татагдах орон зайн хувьд үндэслэн гурван бүс болгон хөгжүүлэхээр төлөвлөж байна.

Үүнд:

- **I-р бүс Алтай хотоос зүүн, зүүн хойд нутаг** (Дэлгэр, Тайшир, Жаргалан, Баян- Уул, Хөхморьт сумд)
- **II-р бүс Алтай хотоос баруун, баруун хойт нутаг** (Дарви, Тонхил, Бугат, Алтай, Төгрөг, Шарга сумд)
- **III-р бүс Алтай хотоос урагш** (Бигэр, Халиун, Цээл, Цогт, Эрдэнэ, Чандмань, Баянтоорой)

Монгол улсын алсын хараа 2050

Суурь үнэт зүйл	Хэмжээс	Өнгөрсөн	Одоо (2019)	Ирээдүй (2050)
		Монголын эзэнт гүрэн	Монгол Улс	Монгол Улс
Оюун санаа	Сайн засаглал	Сэцэдийн зөвлөл – Их засаг хууль	Тогтворгүй засаглал – тодорхой бус хөгжлийн философи	Хуулийн засаглал – хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм
	Ногоон хөгжил	Мөнх хөх тэнгэр	Байгалийн баялагт шүтсэн	Ногоон амьдралын хэв маяг

	Нийгмийн хөгжил	Мөнх хөх тэнгэрийн дор хүн бүхэн тэгш	Дэлхийн хөгжлийн суурь үзүүлэлт хангалтгүй нийгэм	Дундаж орлоготой боловсролтой эрүүл, идэвхтэй иргэд
Хурд	Эдийн засаг	Дэлхийн баялгийг хуваарилагч	Уул уурхайгаас хамааралтай эдийн засаг	Олон тулгуурт эдийн засаг – өндөр хөгжилтэй улс
	Дэд бүтэц- бүсчилсэн хөгжил	Торгоны зам, морин өртөө	Таатай байршил- үр ашиггүй хуваарилалт	Мэдээллийн технологийн дэвшилд тулгуурласан хөгжил
Мөн чанар	Монгол хүн	Монголын эзэнт гүрний иргэн	Ирээдүйдээ итгэлгүй – хуучнаа санагалзагчид	Ирээдүйдээ итгэл төгс- чинээлэг дундаж давхаргад хамаарах хүн
	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	Үл давтагдах нүүдэлчин соёл, сэтгэлгээ	Үнэт зүйлээ гэсэн Монгол	Үндэсний ижилсэл – ондоошлын гүн ухамсар дархлаатай үндэстэн
	Үндэсний аюулгүй байдал	Пакс Монголика – Алтан гэрэгэ	Хоёр том гүрний хооронд оршиж буй Монгол Улс	Өрсөлдөх чадвар бүхий Монгол Улс

1.1.1 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2050

1. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “нэг хэл, нэг түүх, нэг соёл, нэг итгэл үнэмшлийг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл, ондоошлын гүн ухамсар дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно

2. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй МОНГОЛ ХҮН-ийг хөгжүүлж, Хүний хөгжлийн индексийг 0.9-д хүргэж, аз жаргалын индексээр эхний 10 орны тоонд багтах болно

3. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэх болно

4. ЭДИЙН ЗАСАГ

Урт хугацааны хөгжлийн бодлогын үр дүнд эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засгаа бүрдүүлж чадсан улс орон болно. Ингэснээр 2050 он гэхэд ДНБ 6.1 дахин, нэг хүнд ногдох ДНБ 3.6 дахин нэмэгдэж 15000 ам.долларт хүрнэ

5. САЙН ЗАСАГЛАЛ

Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг - тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр - хувийн хэвшил - иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүхий л хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.

6. НОГООН ХӨГЖИЛ

Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж байгаль орчны тогтвортой байдлыг ханган, үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлэн, хүний амьдралын чанарыг сайжруулна.

7. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

8. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэй бүсүүдийг хөгжүүлэнэ.

1.1.2 ДЭЛХИЙН МОНГОЛ ЗОРИЛТ

Дэлхий дахинд Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030) МОНГОЛ СОЁЛЫН ХҮРЭЭ

1. Монголын түүх, соёлыг олон улсад, дэлхий нийтэд сурталчлан таниулах Монголын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /МОУХАН/, MICA /Mongolian Interanion - al Cooperation Agency/ олон улсын байгууллагыг байгуулах

II үе шат (2031-2040) МОНГОЛ СОЁЛЫН ОРОН ЗАЙ

1. Хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатнуудын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэн өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

2. Үндэсний соёл, спорт, хүнс хоолны үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх

III үе шат (2041-2050) МОНГОЛ СОЁЛЫН ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭЛТ

1. Монгол соёлыг олон улсын хэмжээнд сурталчлан таниулах үндэсний онцлог бүхий соёлын хөтөлбөрүүд бий болгох, түгээх

2. Дипломат харилцаатай дэлхийн улс бүрд “Нүүдлийн соёл иргэншлийн төв” байгуулах, тус төвөөр дамжуулан Монголын соёлыг түгээн дэлгэрүүлэх

3. Нүүдэлчдийн давуу талд суурилсан менежментийн ур чадварыг хөгжүүлэх, улмаар монгол соёлын түрэлт бий болгох

9. ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Дэлхийд танигдсан оюуны болон соёлын өвийг бүтээгч хувь хүн, баг, хамт олныг дэмжиж алдаршуулах, дараа үеийнх нь залгамж халааг бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ. Эдгээр оюуны болон соёлын, биет бус өвийн бүтээлүүдийг дагасан уламжлал, ёс заншил, үндэсний онцлог бүхий брэнд үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.
- Монголын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /МОУХАН/, MICA /Mongolian International Cooperation Agency/ олон улсын байгууллагыг байгуулж, гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлнэ.
- Нүүдэлчдийн соёлыг олон улсад сурталчлах үндэсний агуулга бүхий олон ангит кино, бүжгэн жүжиг, багт бүжиг гэх мэт урлаг, соёлын хөтөлбөр, агуулгыг бий болгон хөгжүүлж, тогтмол зохион байгуулагддаг үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгон дэлхий нийтэд таниулан хэрэглэж хэвших ба үндэсний онцлогтой 4 улирлын аялал жуулчлалын хөтөлбөрүүд бий болгоно.
- Монголын уламжлалт 5 өнгийн идээ ундаа / цагаан идээ (цагаан), мах шүүс (улаан), тосон төрлийн идээ (шар), үр тариа, эмийн ургамал, жимс жимсгэнэ (ногоон), архи, рашаан ундаа (хар)/- ыг ашиглан дөрвөн улирал, хүний насны онцлогт тохирсон хоол, тэжээл-сор бүтээгдэхүүнийг хөгжүүлж, улмаар дэлхийд таниулж, монгол хүнс хоолны сүлжээ байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ. (Говь-Алтайн хоол хүнсний бренд хөгжүүлэх)
- Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдын урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлүүдийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

10. НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ ЗОРИЛТ

Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ
I үе шат (2020-2030) Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үе

Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үе

1. Нүүдлийн соёл иргэншлийг хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудыг дэмжих

II үе шат (2031-2040) ҮНДЭСНИЙ ИЖИЛСЭЛ БҮХИЙ АЗИЙН МОНГОЛ

Монголчуудын үндэсний ижилсэл бэхжиж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе

1. Байгаль дэлхийд ээлтэй нүүдлийн соёл иргэншлийн бэлгэ тэмдэг болсон монгол гэрийг сайжруулан хэрэглэхэд хялбар болгон түгээн дэлгэрүүлэх

2. “Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-г өндөр уулын бүсэд байгуулснаар үндсэн таван бүс бий болж, аажмаар өргөтгөх, эрс өндрийн нүүдлийг сэргээх

3. Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, бүтээн үргэлжлүүлэх, өвлөн уламжлах үйл ажиллагаанд оролцогч талуудыг дэмжих

III үе шат (2041-2050) НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ БҮТЭЭГЧ НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ ДЭЛХИЙН МОНГОЛ

Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе

1. Үндэсний өв соёл, нүүдлийн ахуй бүрэн хамгаалагдаж, уламжлал, шинэчлэлийг хослуулсан, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох

2. “Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-гүүдийн үйл ажиллагааг уялдуулж, нүүдлийн соёл иргэншлийн тэргүүлэх улсын түвшинд хүрэх

3. Үндэсний ижилсэл, өв соёлын талаарх ард нийтийн хандлага бүрэн төлөвшихөд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

11. ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Дэлхийд ховор мал аж ахуйд суурилсан нүүдэлчин соёл, түүний унаган төрхөөрөө хадгалагдан үлдсэн өвөрмөц байдал, олон угсаатны бүлгүүдийн зэрэгцэн орших сонирхол татам соёлын илрэлүүд, хүн амын гарын ур дүй, хийж бүтээх авьяас, нутгийн олон түмний эелдэг найрсаг, зочломтгой зан хийгээд бахархам түүх. Энэ бүгд Монголын аялал жуулчлалын гол дүр төрх мөн. Тиймээс “Өөрсдийн язгуур соёл, түүний өвөрмөц илрэлийг аяллын бүтээгдэхүүн болгохдоо ойлгомжтой, хүртээмжтэй, өөриймсөг, жинхэнэ мөн чанараар нь хүргэхийг урьтал болгож түүндээ санхүү, эд материал, хүн хүчний нөөцийг хангалттай зориулж эцсийн үр дүндээ үндэсний соёлыг гайхан биширч, хүндлэх хандлагыг буй болгох” гэсэн гол өгөөжийг бүтээх,

ялангуяа дотоодын жуулчдад үндэсний өв соёл, нүүдлийн ахуйдаа суралцах, түүгээрээ бахархах үзэл төлөвшүүлж, соёлын дархлааг нь дэмжинэ. Нөгөө талаар нүүдлийн соёл, ахуйг хадгалж, тээж яваа малчин өрх, өв соёлоо дээдлэгч монгол гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг дэмжих нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлнэ.

- “Дэлхийн нүүдлийн соёл, иргэншлийн голомт” байгууллагыг байгуулах, Дэлхийн нүүдэлчдийн төв болох цогц хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- Соёлын үйлдвэрлэл, соёлын бүтээлч аялал жуулчлалыг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан нутагшуулж, үндэсний загвартай болох, үндэсний үнэт зүйлийг бүтээх, хадгалах, хамгаалах, аялал жуулчлалын эргэлтэд оруулахад зориулсан мэдээллийн систем, цахим технологи нэвтрүүлнэ

Бичиг үсгийн мэдлэг боловсрол


Говь-Алтай аймгийн 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг мэдлэгийн түвшин 98.2 хувь болж өмнөх тооллогоос 0.9 пунктээр өссөн. Харин байршлаар харвал хотын хүн амын 1.5 хувь, хөдөөгийн хүн амын 2.0 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байна. Бичиг үсэг мэддэггүй залуучуудын түвшин 2020 онд 15-19 насныхны хувьд 0.5 хувь болж 2010 онтой харьцуулахад 1.8, 20-24 насанд 1.1 хувь болж 1.2 пунктээр тус тус буурсан байна. Боловсролтой хүн амыг боловсролын түвшнээр харвал бага 5.2 пунктээр, тусгай мэргэжлийн дунд 1.2 пунктээр тус тус буурсан бол суурь, бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн, дээд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллоготой харьцуулахад өсжээ. Харин 10, түүнээс дээш насны нийт хүн амын 18.2 хувь нь дээд боловсролтой, байгааг хүйсээр харвал эрэгтэйчүүдийн 13.9 хувь, эмэгтэйчүүдийн 22.3 хувь нь дээд боловсролтой хүн ам байна. Сургуульд хамрагдалт өмнөх тооллогын үр дүнтэй харьцуулахад байнга өсжээ. 2020 оны тооллогоор 6-29 насны хүн амын 72.1 хувь нь сургуульд хамрагдаж , 2010 онтой харьцуулахад 13.0 пунктээр нэмэгдсэн байна. 6-17 насны буюу ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдүүдийн 98.5 хувь нь сургуульд хамрагдаж байна. Боловсролын түвшин 10аас дээш насны хүмүүс 10аас дээш насны хүмүүсийн судалгаа

Боловсролын түвшин

Боловсролтой 10, түүнээс дээш насны хүн амын дүнд эзлэх хувь 94.5 болж өмнөх тооллогын үеэс 6.6 пунктээр өссөн байна. Хүйсийн ялгаатай байдлаар

харвал эрэгтэйчүүдийнх 6.7 пунктээр, эмэгтэйчүүдийнх 6.5 пунктээр өсжээ. Боловсролгүй хүн амын эзлэх хувь 5.5 болж өмнөх тооллогын дүнгээс 6.6 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байна. Боловсролтой хүн амыг боловсролын түвшнээр харвал бага 5.2 пунктээр, тусгай мэргэжлийн дунд 1.2 пунктээр тус тус буурсан бол суурь, бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн, дээд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллоготой харьцуулахад өсжээ. Харин 10, түүнээс дээш насны нийт хүн амын 18.2 хувь нь дээд боловсролтой, байгааг хүйсээр харвал эрэгтэйчүүдийн 13.9 хувь, эмэгтэйчүүдийн 22.3 хувь нь дээд боловсролтой хүн ам байна. Манай аймагт дээд боловсролтой хүн ам сүүлийн 10 жилд даруй 7.8 пунктээр өссөн нь сайшаалтай хэрэг юм.

Зургаа болон түүнээс дээш насны хүмүүсийн бичиг үсгийн мэдлэг



Зураг 1: 6 түүнээс дээш насны хүн ам

12. МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ЗОРИЛТ

Монгол хэл бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэж хэвшинэ.

1 үе шат (2020-2030) МОНГОЛ ХЭЛ БИЧИГ ОРШИХУЙН ДАРХЛАА

Үндэсний монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвших үе

1. Хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, бүх шатны сургалтын байгууллагад монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлэх

2.Монгол хэл, бичгийг нийтээр болон гадны иргэд эзэмших таатай нөхцөл бүрдүүлж, нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвших, албан хэргийг хос бичгээр хөтлөх

3.Үндэсний хэл, бичгийн хэрэглээний уламжлалыг хадгалж, шинэчлэлийг хийхэд шинжлэх ухааны байгууллагуудыг дэмжих

4.Монгол хэлийг суралцагч гадаад иргэдийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрүүд болон олон улсад зориулсан Монгол хэлний шалгалтын үндэсний хөтөлбөрийг бий болгох

II үе шат (2031-2040) МЭДЛЭГ ШИНГЭСЭН МОНГОЛ ХЭЛ

Мэдлэг шингэсэн монгол хэл бий болгох үе

1. Мэдлэг шингэсэн монгол хэлний орчин бүрдүүлж, монгол хэлний үгсийн баялаг санг хамгаалах сан хөмрөг бий болгох

2. Монгол хэлийг хамгаалж, мэдлэг шингэсэн монгол хэлийг бүтээх

3. Гадаад улс орнуудад байгуулагдсан болон шинээр байгуулах монгол хэл, соёлын төвүүдийг дэмжих

III үе шат (2041-2050) МОНГОЛ ХЭЛ БИЧИГҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ

Монгол хэл, бичиг үндэсний нэгдмэл үнэт зүйлийн бүрдэл болж төлөвших үе

Ард нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг төгөлдөржүүлэх, нэгдмэл үнэт зүйл болгон төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх 2.Монгол хэлтэй гадаад хүмүүс, тэднээр дамжин монгол хэлийг гадаадад сурталчлах болон сургах үйл ажиллагааг эрчимжүүлж, монгол хэлний орчин бий болгох

13. ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ ЗОРИЛТ

1 Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.

I үе шат (2020-2030) ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ ДОР ЭВ НЭГДЛИЙГ ДЭЭДЛЭГЧ МОНГОЛ

Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе

1.Түүх соёлын дурсгал, урлагийн бүтээлүүд, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээх, биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, өвлүүлэх

II үе шат (2031-2040) ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ-ЭВ НЭГДЛИЙН ГАГНААС

Үндэсний бахархлыг иргэн бүрийн үйл хэрэгт шингээж, түүнд тулгуурласан үндэсний эв нэгдлийг төлөвшүүлэх үе

1.Археологи, палеонтологийн дурсгалын төрөл зүйлийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэх

2.Дэлхийд өрсөлдөх үндэсний археологич, палеонтологичдыг бэлтгэх, чадамжийг дээшлүүлэх, судлаач, эрдэмтэн бэлтгэх

3.Үндэсний болон сонгодог урлагийг түгээгч мэргэжлийн байгууллагуудын барилга байгууламжийн дэд бүтэц, орчин нөхцөл, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгээр бүрэн хангаж шинэчлэх

4.Үндэсний эв нэгдэл, нийгмийн зөвшилцлийг алдагдуулах эрсдэлийг хянах, түүнээс сэргийлэх чадавхыг бэхжүүлэх

III үе шат (2041-2050) НЭГДМЭЛ ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, НЯГТАРСАН ЭВ НЭГДЭЛ

Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшиж, эв нэгдэл нягтрах үе

1. Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлэх 2.Улс төр, эдийн засаг, нийгэм, шашин зэрэг бүхий л хүрээнд эв нэгдлийг нягтруулахад чиглэсэн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Газар усны нэрүүдийг эх байдлаар нь нэрлэх, өөрөөр нэрлэгдэх болсон нэрүүдийг эх сурвалжид тулгуурлан хуучнаар нь сэргээж, тахилгат уул ус, газар нутгийн уламжлалт зан үйлийг эх байдлаар нь сэргээнэ.

2. Монгол Улсын угсаатны бүлгүүдийн онцлог, зон олны ёс заншил, амьдралын хэв маягт үндэсний хэв шинжийг бүрдүүлэх, нэгдмэл үзэл ухамсар төлөвшүүлнэ.

3. Монгол Улсад түүх, соёлын өвийг сүйтгэгчидтэй хийх тэмцлийг орон даяар өрнүүлж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ.

4. Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэж, хамгаална.

5. Музейн үзмэр, эд өлгийн зүйл, урлагийн бүтээлийн улсын бүртгэлийн үнийг үнэлэх, даатгалын үнэлгээгээр үнэлнэ.

6. Археологийн үнэ цэнт дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл, ангиллыг шинэчлэж, дурсгалт газрыг хамгаалах соёлын өв харгалзагч, эзэнтэй болгоно.

7. Археологийн дурсгалт газар, шашны үйл явдалд үндэслэсэн эвент, фестивалийг бий болгож, палеонтологийн үнэт зүйлсийг тусгай сонирхлын үнэ цэнэтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.

14. ЭРДЭМ СУДЛАЛ-НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ ЗОРИЛТ

1. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж нийтийн хүртээл болгож хэвшиж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.

I үе шат (2020-2030) ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА - СОЁН ГЭГЭЭРЭЛ

Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлүүдийн судалгааг салбар тус бүрээр гүнзгийрүүлэн хийж, нийтийн хүртээл болгох үе

1. Үнэт зүйлийн суурь, хавсарга болон гүнзгийрүүлсэн судалгааг тогтворжуулах
2. Судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнүүдийг эрэн сурвалжилж, бүртгэн судалгааны эргэлтэд оруулах

II үе шат (2031-2040) СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ТӨР, НИЙГЭМД

Гүнзгийрүүлсэн судалгааны бүхий л үр дүнг төр, нийгмийн амьдралд хэрэгжүүлэх үе

1. Техник, технологийн шинэчлэлд тулгуурласан судалгаа шинжилгээний аргуудыг үндэсний үнэт зүйлийн судлалд нэвтрүүлэх
2. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн гүнзгийрүүлсэн судалгааны үр дүнг төр, нийгмийн амьдралд хэрэгжүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлэх

III үе шат (2041-2050) ҮНЭТ ЗҮЙЛ БҮХИЙ НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ

Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлээр судалгааны бүхий л үр дүнгийн хэрэгжилт хэвшил болж, нийгмийн соён гэгээрэл өндөр түвшинд хүрэх үе

1. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгааны бүхий л үр дүнг олон нийтийн хүртээл болгож, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Алтайн төрөл хэлнүүд ба монгол хэл, аялгуунуудын харьцуулсан иж бүрэн судалгаа хийж олон нийтийн хүртээл болгоно.
2. Археологи, палеонтологийн судалгааг үнэт зүйлийн судалгааны тэргүүлэх чиглэл болгож үндэсний хэмжээний судалгааны төслийг хэрэгжүүлнэ.
3. Тахилгат уул ус, газар нутгийг олж тогтоох, тухайн тахилгат газарт хэрэглэдэг сан судар, түүх домог, холбогдох уран бүтээл, эдлэл хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж олж тогтооно.
4. Монголын төрт ёсны түүхтэй холбоотой Хүрэл ба түрүү төмрийн үе болон Хүннү, Сяньби, Монголын эзэнт гүрний үед холбогдох археологийн малталт судалгааны үндэсний төслийг хэрэгжүүлнэ.

15. ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН ЗОРИЛТ

Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.

I үе шат (2020-2030) ЭРҮҮЛ БАТАЛГААТ ОРЧИН

Эрүүл баталгаат орчин бий болгох үе

1. Агаар, ус, хөрс, дуу чимээний бохирдлыг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчинтой болгох

II үе шат (2031-2040) АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН

Амьдралын таатай орчин бүрдүүлэх үе

1. Тохилог, амьдралын таатай орчин бүрдүүлж, орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтийг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн хог хаягдлын зохистой менежментийг хэвшүүлэх
2. Ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар хот, суурин газрын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх
3. Хүнсний хангамж, нийлүүлэлтийн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт шаардлагыг боловсронгуй болгож, баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй болон эрүүл хүнсний хэрэглээтэй болох

III үе шат (2041-2050) ӨРХ, ХҮН АМД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН

Амьдралын хэрэгцээ хангагдсан орчин бүрдүүлэх үе

1. Орчны бохирдлоос шалтгаалсан хүний эрүүл мэнд, эдийн засагт учрах сөрөг нөлөөлөл бүрэн арилж, хот, сум, суурингуудад авто зогсоол, оршин суугчид

амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулсан ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог эко орчинг бүрдүүлэх

2.Монгол брэндийн эко хүнс экспортлох нөхцөлийг сайжруулж, хүнсний боловсруулах салбарыг хөгжлөөр тэргүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОРОН СУУЦ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, СТАНДАРТЫГ МӨРДӨЖ, ЭРҮҮЛ БАТАЛГААТ АМЬДРАХ ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

2.5.5. Нэг хүнд оногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ.

2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

ХҮНСНИЙ СҮЛЖЭЭНИЙ БҮХ ҮЕ ШАТАНД БҮРТГЭЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГА, ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.5.15. Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдаалах, хадгалах, дамжуулан тээвэрлэхийг хориглоно.

2.5.16. Үрийн сан, хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан төмс, хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй байдлыг бүрэн хянанэ.

16. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ГАРААНЫ БИЗНЕС ЗОРИЛТ

3.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ

I үе шат (2020-2030) БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ЭРЧИМЖИЛТ

Хөдөлмөр эрхлэлт, энтерпрайзинг хандлага болон ур чадварыг хөгжүүлэн дэмжих, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үе

1. Ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуу өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргыг өргөтгөх

2. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, орчин нөхцөл бүрдүүлэх 3.Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчныг бэхжүүлж, төлөвшүүлэх

II үе шат (2031-2040) ӨРСӨЛДӨХҮЙЦ БИЗНЕС ЭРХЛЭЛТ

Жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үе

1. Инноваци, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн нөхцөлийг бүрдүүлж, экспортын чиг баримжаатай

бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортын зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлж, бичил, жижиг, дунд бизнес олон улсад өрсөлдөх боломж нөхцөлөөр хангах

III үе шат (2041-2050) ОЛОН УЛСАД ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БИЗНЕС ЭРХЛЭЛТ

Бичил, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үе

1. Олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэлтийн соёл бүрэн төлөвшүүлж, инноваци, шинэ технологи, мэдлэг шингэсэн бичил, жижиг, дунд бизнесийн хөгжлийг дэлхийн жишигт хүргэх

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮНДЭСНИЙ ЭКСПОРТЛОГЧ ТОМООХОН КОМПАНИУДАД ОРОН НУТГААС ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ТОГТВОРТОЙ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ СҮЛЖЭЭ, ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН БОДЛОГООР ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

1. Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэхийг санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулах энэхүү хөтөлбөрийн зохион байгуулалттай ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбоно.

2. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шууд худалдаалах төвийг сумдад байгуулж, борлуулалтын сүлжээ бий болгоно

3. Хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, мал нядлах, мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, загасны аж ахуй, зөгийн аж ахуй, төмс, хүнсний ногоо тарих, хадгалах, боловсруулах, хүлэмжийн аж ахуй, жимс, жимсгэнэ боловсруулах, үр тарианы аж ахуй, талх, нарийн боовны цех, цэвэр ус үйлдвэрлэх, ургамлын цай үйлдвэрлэх болон бусад);

4. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (арьс ширний анхан шатны тордолтын цех, арьс ширэн жижиг эдлэлийн цех, ноос, ноолуур бэлтгэн нийлүүлэх, яс боловсруулах цех, сүлжмэлийн цех, эсгий, эсгий эдлэлийн цех, оёдлын цех, мод, модон эдлэлийн цех, ойн хаягдал түүхий эд боловсруулах цех, модны үрсэлгээ, суулгацын аж ахуй, техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээний цех, мал бордох болон бусад);

5. Малчид, ногоочдын аж ахуй эрхлэх газрыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно.

6. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ

ОРГАНИК ХҮНС, ЭРЧИМ ХҮЧНИЙ ИДЭВХТЭЙ ТОГЛОГЧ АЧ ХОЛБОГДОЛ

Жижиг эдийн засагтай, хуримтлал багатай манай улсын хувьд эдийн засгийн хязгаарлагдмал нөөцийг тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад чиглүүлж, экспортын баримжаатай хөгжүүлснээр эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах боломжтой. Монгол Улсын харьцангуй давуу тал, нөөц боломж, гадаад зах зээлийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлага зэрэгт үндэслэн УУЛ УУРХАЙ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛОН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ТҮҮНД ТҮШИГЛЭСЭН ХӨНГӨН ҮЙЛДВЭР, ЭРЧИМ ХҮЧ, **ЛОГИСТИК АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**, МЭДЛЭГЖСЭН БҮТЭЭЛЧ ЭДИЙН ЗАСГИЙН салбаруудыг тэргүүлэх салбаруудаар тодорхойлон үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай байна

ҮНДЭСНИЙ ОНЦЛОГ, БҮХИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЖ, ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ӨРСӨЛДӨХ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.12. Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.

4.2.13. Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлнэ.

4.2.14. Зарим тусгай хамгаалалттай газар нутгийг байгальд ээлтэй эко аялал жуулчлалын зориулалтаар төлөвлөн хөгжүүлнэ.

4.2.15. Хөвсгөл нуурын БЦГ-т “Тогтвортой аялал жуулчлал”-ыг хөгжүүлж, Орхоны хөндийд “Аялал жуулчлалын үндэсний парк”, Хэнтий аймагт “Мянганы суут хүн их эзэн Чингис хаан”, “Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн”, “Шихихутаг нууц товчоо”, “Хүлэгбаатар Боорчи - Андлалын Өргөө”, “Монголын нууц товчоо” зэрэг аялал жуулчлалын цогцолборуудыг барьж байгуулна.

4.2.16. **Баруун бүсэд-Адал явдалт, тусгай сонирхлын**, Хангайн бүсэд Байгалийн, амралт зугаалгын, Төвийн болон Улаанбаатарын бүсэд Албан, бизнесийн, Говийн бүсэд-Байгалийн, палеонтологийн, Зүүн бүсэд-Түүхэн (биет соёлын өвүүдэд тулгуурласан) аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх, Баруун бүс, Орхоны хөндийд “Аялал жуулчлалын үндэсний парк” байгуулна.

4.2.17. “Их Түмэн голын санаачилга” хөтөлбөр болон Торгоны зам, Цайны замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ, худалдааг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

17. БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дэлхийн зах зээл дэх үнийн түвшин тогтвортой байх нөхцөлд суурь хувилбараар хийсэн тооцооллоор манай орны экспорт 2018-2030 онуудад жилд дунджаар 4.2-6.3 хувь, импорт 4.0-6.8 хувиар өсөхөөр байна. Дурдсан хугацааны үргэлжлэлд экспорт 1.71, импорт 1.77 дахин өсөж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр экспорт 13.9 тэрбум ам.долларт, оны үнээр 17.1 тэрбум ам.долларт, импорт 1.77 дахин нэмэгдэж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.4 тэрбум ам.долларт, оны үнээр 14.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарав. “Ногоон эдийн засаг” хувилбараар 2018-2030 онуудад экспорт жилд дунджаар 4.0-6.8 хувь, импорт жилд дунджаар 4.1-6.3 хувь, дурдсан хугацааны туршид экспорт 1.69 дахин, импорт 1.75 дахин өсөх тооцоо гарч байна. Ингэснээр 2030 он гэхэд манай улсын экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 13.4 тэрбум ам.долларт, оны үнээр 16.9 тэрбум ам.долларт, импорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.3 тэрбум ам.долларт, оны үнээр 14.3 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Томоохон төслүүдийг оруулсан тооцоогоор, тэдгээр төслийн нөлөөгөөр экспорт жилд 2.2-31.6 хувь, импорт 3.5-32.9 хувиар өсөж, дурдсан хугацааны туршид экспорт 2.56 дахин, импорт 2.62 дахин өсөх тооцоо гарч байна. 2030 он гэхэд экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 20.1 тэрбум ам.долларт, импорт 16.9 тэрбум ам.долларт, оны үнээр экспорт 25.6 тэрбум ам.долларт, импорт 21.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарлаа. Гадаад худалдааны бодлогын хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг хамгаалж хөгжүүлэх, экспортын бараа бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн уялдуулсан тарифыг бий болгох, шинээр үйлдвэрлэхээр төлөвлөж буй аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортлох таатай нөхцөлүүдийг урьдчилан бүрдүүлэх, үүний тулд тодорхой улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудалд онцгойлон анхаарах нь зүйтэй.

I үе шат (2020-2030) БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, БНХАУ, ОХУтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе

1. Монгол Улс, БНХАУ, ОХУ гурван улсын эдийн засгийн коридор бий болж, гадаад харилцааны тэнцвэртэй байдлыг хангах Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчлөх

II үе шат (2031-2040) ГУРАВДАГЧ ХӨРШИД ХҮРСЭН ЭДИЙН ЗАСАГ

Хөрш орнууд болон гуравдагч хөрш улсуудтай гадаад харилцааны тэнцвэртэй хөгжлийн түвшинг хангах үе

1. Дэлхийн түвшинд нэр хүнд бүхий өрсөлдөх чадвартай Зүүн хойд Азийн хөрөнгө оруулалтын гол төв болгох

III үе шат (2041-2050) АЗИЙН МОНГОЛ

Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар, худалдааг нэмэгдүүлэх үе

1. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцогч болох
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА МОНГОЛ УЛС, БНХАУ, ОХУ ГУРВАН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР БИЙ БОЛЖ ГАДААД ХАРИЛЦААНЫ ТЭНЦВЭРТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

4.4.1. Монгол Улсын хөгжлийн өнөөгийн шаардлагыг харгалзан үзэж ДХБ-д элсэхэд авсан амлалтыг эргэн харах саналыг гишүүн орнуудад тавих замаар гадаад худалдааны зохицуулалтыг боловсронгуй болгоно.

4.4.2. Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай хэмжээний нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон чөлөөт бүсийг хөгжүүлнэ.

4.4.3. Бараа, үйлчилгээг худалдах, тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлүүдийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан удирдлага ба хяналтыг бий болгоно

4.4.4. Эдийн засгийн коридорын хүрээнд “Талын зам” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойг барих асуудлыг гурван талт хэлэлцээрийн үр дүнд шийднэ.

4.4.5. Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улс тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ.

18. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН ЗОРИЛТ

4.5 Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ

I үе шат (2020-2030) КЛАСТЕР ХӨГЖИЛ, БҮТЭЭМЖТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацид тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх үе

1. Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх

2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерийн зарчмаар хөгжих нөхцөлийг бүрдүүлэх

II үе шат (2031-2040) БҮС НУТГИЙН НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ИДЭВХТЭЙ ТОГЛОГЧ

Бүс нутгийн болон олон улсын чанар, стандартын тогтолцоог нэвтрүүлэх, цахим худалдааг хөгжүүлэх замаар бүс нутгийн нэмүү өртгийн сүлжээнд холбогдож ажиллах үе

1. Бүс нутгийн эдийн засгийг дэмжих экспортын төрөлжил-тийг бий болгох

III үе шат (2041-2050) ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БРЭНД ҮЙЛДВЭРЛЭЛ

Технологийн дэвшил, ур чадвартай хүний нөөц, цахим худалдаанд тулгуурлан дэлхийд өрсөлдөх чадвартай, инновацид суурилсан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх үе

1. Инновацид суурилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТ, ШИНЭ САНАА, ОЮУНЫ БҮТЭЭЛ, БРЭНДЭД ТУЛГУУРЛАСАН ГАДААД ЗАХ ЗЭЭЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.5.1. Бизнес инкубатор төвүүдийг байгуулах, тэдгээрийн хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагааг дэмжинэ.

4.5.2. Инноваци, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

4.5.3. Эдийн засагт дижитал салбаруудыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.5.4. Үйлдвэрлэлийн автоматжуулалт, технологи болон мэдээлэл технологийн ололтыг өргөнөөр нэвтрүүлнэ.

4.5.5. Нано технологи, био технологи, ногоон технологи, оюуны бүтээлд тулгуурласан үйлдвэрлэлийг дэмжиж, хөрөнгө оруулалтын таатай орчноор хангана.

БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭЛТ, БОРЛУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ КЛАСТЕРЫН ЗАРЧМААР ХӨГЖИХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.5.6. Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хөгжлийг дэмжих институцийн тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

4.5.7. ЖДҮ эрхлэгчдэд дэлхийн өртгийн сүлжээнд тавигддаг шаардлагуудыг хангах удирдлагын болон ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулна.

4.5.8. Гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэлд шаардлагатай технологийн инновацийн талаарх мэдээлэл авах, олон улсын үзэсгэлэн, яармаг болон бизнес уулзалтууд зохион байгуулах замаар хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлнэ.

4.5.9. Жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгож буй төрийн болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн санхүүжилтийг үр ашигтай болгож, оролцогч талуудын уялдааг сайжруулна.

4.5.10. Санхүүжилтийн бусад эх үүсвэр, лизинг болон факторингийн талаарх ойлголт, хэрэглээг нэмэгдүүлэх, экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд зориулсан батлан даалт, даатгалыг нэвтрүүлнэ.

4.5.11. Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санал санаачилгыг урамшуулах, дэмжих замаар кластерын хөгжлийг хангана.

БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЭКСПОРТЫН ТӨРӨЛЖИЛТИЙГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР 4.5.12. Дижитал салбаруудын бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана.

4.5.13. Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтэц болон үйлдвэрлэлийн цогцолбор байгуулж, шинэ салбарыг хөгжүүлнэ.

4.5.14. Чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнасан худалдааны байнгын сүлжээг байгуулна.

19. НОГООН ХӨГЖИЛ

Монгол орон байгалийн унаган төрхөө харьцангуй хэвээр хадгалж үлдсэн дэлхийн цөөн орны нэг боловч хотжилт, үйлдвэржилт зэрэг хүний хүчин зүйлийн

нөлөө болон байгаль, цаг агаарын хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан байгаль орчин доройтон бохирдох, байгалийн нөөц баялаг хомстох улмаар зарим газар нутагт экосистемийн тэнцвэр алдагдахад хүрээд байна. Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өөрийн орны онцлогийг харгалзан хөгжлийн замаа тодорхойлохдоо байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж байгаль орчны тогтвортой байдлыг ханган, үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлэн, хүний амьдралын чанарыг сайжруулах зорилгыг үндэс болгоно. Монгол орны газар нутгийн байгалийн болон экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, нөөц, ачаалал даах чадамж, амьдрал тэтгэх хязгаарын босгыг тогтоож хамгаалах, нөхөн сэргээх, судалгаанд суурилан хөгжлийг төлөвлөж, байгалийн баялгийг төрийн зохицуулалттайгаар эдийн засгийн эргэлтэд оруулах, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай, хаягдал багатай дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэн зохистой ашиглах, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.

20. ЭХ БАЙГАЛЬ БА АНХДАГЧ ЭКОСИСТЕМ ЗОРИЛТ

6.1. Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

I үе шат (2020-2030) ЭХ БАЙГАЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛЭМЖ

Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, даацыг тогтоож, үнэлэмжийг нэмэгдүүлж эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх үе

1. Байгалийн баялгийн нөөц, экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, даацыг тогтоож, үнэлэх

Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаалах

II үе шат (2031-2040) АХИСАН ЧАДАМЖ БҮХИЙ ЭКОСИСТЕМ

Экосистемийн үйлчилгээг тэтгэж үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлэх үе

1. Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, нөөц, даацыг шинэчлэн тогтоож, үр өгөөжийг нэмэгдүүлэх

Онцлог, үнэ цэнэ бүхий экосистемүүдийг тусгай хамгаалалтад авч, анхдагч байгалийн унаган төрх, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгалах

III үе шат (2041-2050) ТЭНЦВЭРЖСЭН БАЙГАЛЬ ОРЧИН

Үнэлэмж, нөөц, нөхөн сэргэх чадавх, даацад суурилсан байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын бодлого баримталж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах үе

1. Хүрээлэн байгаа орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн эх дэлхийн экосистемийн үйлчилгээг тэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулах

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН НӨӨЦ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ЦЭНЭ, ДААЦЫГ ТОГТООЖ, ҮНЭЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.1.1. Экосистемийн үйлчилгээг үнэлэх зохицуулалтыг боловсронгуй болгож үнэлэх, экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэх, экосистемийн үйлчилгээ, түүний үнэ цэнэ, ач холбогдлыг олон нийтэд тайлбарлан таниулна.

НОГООН ХӨГЖИЛ МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО 2050

6.1.2. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

6.1.3. Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлнэ.

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ ЗЭРЭГ ОНЦЛОГ ЭКОСИСТЕМИЙГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВЧ, АНХДАГЧ БАЙГАЛИЙН УНАГАН ТӨРХ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАДГАЛАХ ЧИГЛЭЛЭЭР

6.1.4. Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж, өргөжүүлэх замаар онцлог экосистемийн үйлчилгээ, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

6.1.6. Олон талт байгаль хамгааллын менежмент, техник технологийн хөгжлийг нэвтрүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигтай байдлыг сайжруулна.

6.1.7. Гадаад орны тусгай хамгаалалттай нутгийн захиргаатай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, менежментийн дэвшилтэт арга туршлагыг нэвтрүүлнэ.

6.1.8. Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

21. БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ҮР ӨГӨӨЖ ЗОРИЛТ

6.2. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.

I үе шат (2020-2030) БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ

Байгалийн орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж, нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгох үе

1. Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлэх
2. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулах
3. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангах
4. Байгаль орчны хяналт шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийх

II үе шат (2031-2040) ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛАСАН ШИЙДЭЛ

Техник, технологийн ололт, инновацийг байгаль хамгаалалд ашиглаж, нөөцийн хомсдол, орчны доройтлоос сэргийлэх үе

1. Технологийн хөгжлийг биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, тарималжуулах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэхэд ашиглан нөөцийн хомсдолоос сэргийлэх
2. Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх
3. Байгаль орчны хяналтшинжилгээний сүлжээ, мэдээллийн нэгдсэн цахим санг өргөжүүлж, технологийн хөгжлийг нэвтрүүлэн, мэдээллийн ухаалаг цогц тогтолцоог бүрдүүлэх

III үе шат (2041- 2050) НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ АШИГЛАЛТ

Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, зохистой ашиглах, шавхагддаг нөөцийг зөвхөн улсын хөгжлийн түвшинг шат ахиулахад хязгаартай ашиглах үе

1. Байгалийн нөөцийн хомсдол, орчны доройтлыг зогсоон, нөхөн сэргээх, арвижуулах арга хэмжээг төгөлдөржүүлэн зохистой ашиглалтыг хэвшүүлэх
2. Байгалийн орчны хяналт-шинжилгээ, мэдээллийн ухаалаг тогтолцоог хөгжүүлж хүртээмжтэй болго

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, ТАРХАЦ НУТАГ, АМЬДРАХ ОРЧНЫГ НЬ ТЭТГЭЖ ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ, АШИГТ ЗҮЙЛИЙГ ҮРЖҮҮЛЭХ, ТАРИМАЛЖУУЛАХ, ОЙН АГРОПАРК БАЙГУУЛАХ ЗАМААР АШИГЛАЛТЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.2.1. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан, генетик нөөцийн төрөлжсөн сангууд /генбанк/ байгуулж сан хөмрөгийг баяжуулах, биотехнологийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжин хөгжүүлнэ.

6.2.2. Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэх, шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ.

6.2.3. Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулж, ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгож, байгалиас шууд авч ашиглах дарамтыг бууруулна.

6.2.4. Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдлоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.

6.2.5. Био аюулгүй байдлыг хангах материаллаг баазыг бэхжүүлнэ.

6.2.6. Экосистем, биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа аж ахуй эрхлэлтэд олгодог татаасыг бууруулах, экосистемийг үйлчилгээг тэтгэсэн, хамгааллын үйл ажиллагааг дэмжинэ.

6.2.7. Байгаль хамгааллын шинжлэх ухаан, дэвшилтэт технологид түшиглэсэн мэргэжлийн боловсролын тогтолцоог хөгжүүлнэ.

ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМ, ЧИЙГИЙГ ХАМГААЛЖ, ГАЗРЫН ДОРОЙТОЛ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭН, ЭВДРЭЛД ОРСОН, БОХИРДСОН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭЖ, АЖ АХУЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 6.2.8. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.2.9. Ногоон хүрэм төсөл хэрэгжүүлж, уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, хот байгуулалт, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгож эргэлтэд оруулах, ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлнэ.

6.2.10. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ.

6.2.11. Тариалангийн хагалж боловсруулах уламжлалт технологийг халж, агротехникийн болон усалгааны хэмнэлттэй дэвшилтэт технологи нэвтрүүлэх, шинээр нэмж газар хагалахгүй, зөвхөн атаршсан газрыг эргэлтэд оруулж хөрсийг тордож ашиглана

Монгол орны байгалийн тогтоц, эрс тэс уур амьсгал нь түүнд дасан зохицсон, жилийн ихэнх хугацааны хүйтэн, хахир хатуу нөхцөлийг даван туулах, тэсвэрлэх өвөрмөц чадвартай амьтан, ургамал, бичил биетнийг бий болгодог бөгөөд эдгээр генетик нөөц нь Монгол орны хувьд дэлхийд давтагдашгүй үнэт баялаг болно. Манай орон биологийн болон генетик нөөц, түүнийг ахуй амьдралдаа ашиглаж ирсэн өнө эртний түүхэн уламжлалт мэдлэгээр баян орон юм. Гэвч судалгаа шинжилгээ, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх өндөр түвшний лаборатори, мэргэжлийн боловсон хүчин, инновацийн хөрөнгө оруулалтын таатай орчин байхгүйгээс манай улс эдгээр үнэт баялаг- түүхий эдээр ханган нийлүүлэгчийн түвшинд байсаар байна. Биологийн олон янз байдлыг хамгаалаагүйгээс бий болох үр дагавар нь уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол зэрэг байгаль орчны бусад асуудлын нэг адил экосистемийн үйл ажиллагааг алдагдуулах, улмаар хүн төрөлхтний оршин тогтнолд эрсдэл учруулж болно. Биологийн нөөцийн экосистемд гүйцэтгэж байгаа хүнс тэжээл, эрчим хүчний хэрэгцээг хангах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, гоо зүйн үүргээс гадна тэдгээрт агуулагдаж байгаа генетик нөөц, биологийн идэвхт үнэ цэнэтэй нэгдлийг судалж ашиглах хүнс, хөдөө аж ахуй, эм бэлдмэл, гоо сайхны салбаруудын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах биологийн олон янз байдлын ашиглалт, хэрэглээг зохицуулах, генетик нөөцийн уламжлалт мэдлэгээ хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулж ашиглах шаардлага орчин үед тулгамдаж байна.

Генетик нөөцийн ашиглалтаас үүдэх үр шимийг шударга, эрх тэгш харилцан хүртэх харилцааг зохицуулсан олон улсын хэлэлцээр бол 2010 онд батлагдсан Нагояагийн протокол юм. Нагояагийн протокол нь генетик нөөц,

түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг, тэдгээрээс үүдэлтэй шинэ санаа, нээлтүүд, генетик нөөцийн ашиглалтаас хөгжиж байгаа хангагч орны иргэд үр өгөөж хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэдэг. Монгол Улсын Их Хурал Генетик нөөцийн тухай Нагояагийн протоколыг 2012 онд соёрхон баталсан. Монгол орны нутаг дэвсгэрээс гаралтай амьтан, ургамал, бичил биетний генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгаа, хөгжүүлэлтэд ашиглах, ашиглалтаас үүдэх үр шимийг тэгш, шударга харилцан хүртэх асуудлыг хуульчлах шаардлагатай байна.

**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛНА
ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ТОГТОЛЦОО БИЙ БОЛНО
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ХӨГЖИЛ ТЕХНОЛОГИ
ДАМЖУУЛАЛТ ӨРГӨЖИНӨ ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЭМЭГДЭНЭ**

Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаар эртний ном, судар бичгүүдэд тэмдэглэсэн ардын уламжлалт эм тан бэлтгэх, цагаан идээ боловсруулах, мал аж ахуй эрхлэхтэй холбоотой үндэсний уламжлалт мэдлэгээ бүртгэн баталгаажуулж үр дүнтэй ашиглана. Генетик нөөцийн судалгаа хөгжүүлэлт хийх, уламжлалт мэдлэгийг салбаруудад зүй зохистой ашиглах ёс зүйг төлөвшүүлнэ.

ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ТОГТОЛЦОО БИЙ БОЛНО

- Генетик нөөцийн ашиглалтын цахим бүртгэлээр дамжуулан Монгол орны генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн дотоод, гадаад дахь ашиглалтыг бүртгэж, Генетик нөөцийн тухай хууль, Нагояагийн протоколын хэрэгжилтийг хянах олон улсын тогтолцоог хэрэгжүүлж үр шимийг харилцан хүртэх үйл ажиллагааг өргөжүүлнэ.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ХӨГЖИЛ

- Бичил биетний өсгөврийн сан, амьтан, ургамлын эд, эсийн өсгөврийн сан, ургамлын гербари, үрийн санг багтаасан генетик нөөцийн үндэсний төрөлжсөн сангууд байгуулж, нэгдсэн зохион байгуулалт, хадгалалтын горим, стандарт шаардлагын дагуу ажиллуулна.
- Ургамлын биотехнологийн чиглэлд ховор, нэн ховор ургамлын бичил үржүүлэг хийх, тарималжуулах замаар биологийн олон янз байдлын хамгаалалд бодит хувь нэмэр оруулна.

ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ ӨРГӨЖИНӨ

Генетик нөөцийн үндэсний сангийн лабораториудын хүчин чадал өргөжин, хүний нөөц чадавхин, олон улсын дэвшилтэт технологи стандартыг нутагшуулан молекул биологи, генетик, биохими, биоорганик химийн орчин үеийн аргуудыг ашиглан аливаа биоматериалын гарал үүсэл ангилалзүйн байршлыг тогтоох, биологийн идэвхт нэгдлийг хайх, илрүүлэх, ашиглах үйл ажиллагааг өргөжүүлнэ.

ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЭМЭГДЭНЭ

- Биологийн олон янз байдлыг хамгаалж, түүнийг зохистой ашигласнаас үүдэх үр шимээс эрх тэгш, шударга хүртсэнээр нутгийн иргэдийн биологийн нөөцийг хамгаалах идэвх оролцоо сайжирч, хувийн хэвшил, судалгаа шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагаа, итгэлцэл сайжирна.

6.2.12. Бүсийн ялгавартай, шатлан өсгөх зарчимд суурилсан газрын төлбөрийн системийг бий болгож, малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэн хязгаарлаж бэлчээр ашиглалтын ачааллыг тэнцвэржүүлнэ.

6.2.13. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧИЛАН ТАНИУЛЖ, СТАНДАРТ, ХЭМ ХЭМЖЭЭГ МӨРДҮҮЛЭН, БАЙГАЛЬ ХАМГААЛАЛД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

6.2.14. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан байгаль орчны хууль тогтоомжийг сурталчлах, байгаль хамгаалах уламжлалт ёс заншлыг таниулах мэдээллийг тогтмол түгээж, байгаль хамгаалах үйлсэд иргэдийн оролцоог хангана.

6.2.15. Байгаль орчны мэдээллийн төвийн үйл ажиллагааг нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаатай уялдуулан олон нийтэд байгаль хамгаалал, уламжлалт ёс заншлын мэдлэг, тогтвортой хөгжлийн боловсрол олгоно.

6.2.16. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй болгоно.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭ, КАДАСТР, МЭДЭЭЛЛИЙН САНГ ӨРГӨЖҮҮЛЖ, ШИНЭ ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ЧИГЛЭЛЭЭР

6.2.17. Байгаль орчны шинжилгээний төв лабораторийг шинэчилж, орчны бохирдлын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж чадавхжуулна.

6.2.18. Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөцийн ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны е-зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.2.19. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ

22. ҮНЭТ БАЯЛАГ УС ЗОРИЛТ

6.3. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж хуримтлуулан, хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

I үе шат (2020-2030) УСНЫ УХАМСАРТАЙ ХЭРЭГЛЭЭ

Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах, усны нөөцийг хуримтлуулах үе

1. Усны нөөцийн үнэ тарифт шатлан өсгөх зарчмыг тогтоож, ус ашиглалтыг төлбөртэй болгон хэмнэлттэй хэрэглээ, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх
2. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулах
3. Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхлэх
4. Хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах, усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт, менежмент хийх нөхцөлийг бүрдүүлэх

II үе шат (2031-2040) УСНЫ АРИВЖУУЛСАН НӨӨЦ

Усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх, усны хуримтлалыг нэмэгдүүлж, хүртээмж, хангамжийг сайжруулах үе

1. Усны нөөцийн төлбөр, ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрлийн механизм, эдийн засгийн хөшүүргийг оновчтой болгох, хэмнэлттэй хэрэглээ, дахин ашиглалтыг хэвшүүлэх
2. Стратегийн үнэт баялаг усны талаарх олон нийтийн мэдлэг, хандлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж усны нөөц бохирдож, хомстохоос сэргийлэх
3. Хөв цөөрөм, урсцын тохируулгатай усан сан, ус нөөцлөх, дамжуулах далд систем байгуулах ажлыг эрчимжүүлж усны хуримтлалыг нэмэгдүүлэх
4. Газрын доорх усны судалгааг өргөжүүлж, олборлолт, ашиглалт, нөхөн сэргээлтэд хамгийн тэргүүний дэвшилтэт технологи (БАТ/БЭП) нэвтрүүлэх
5. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчилж өргөтгөн хүн амын 90-ээс доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангах

III үе шат (2041-2050) УСНЫ ГАЧААЛААС ҮЛ ХАМААРАХ ХӨГЖИЛ

Байгалийн болон зориудаар арвижуулсан нөөцийг хяналттай, зохистой ашиглаж хэвших үе

1. Усны хэмнэлт, усгүй технологи, зохистой хэрэглээг хэвшүүлэн усны нөөц бохирдох, хомстохоос сэргийлэх, хянах
2. Усыг хуримтлуулах, нөөцийг арвижуулахад чиглэсэн олон төрлийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх

3. Усны нөөц баялаг, ус ашиглалтын цогц мэдээллийг бүрдүүлэх, ус хангамжийн асуудлыг бүрэн шийдэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА УСНЫ НӨӨЦИЙН ҮНЭ ТАРИФТ ШАТЛАН ӨСГӨХ ЗАРЧМЫГ ТОГТООЖ, УС АШИГЛАЛТЫГ ТӨЛБӨРТЭЙ БОЛГОН ХЭМНЭЛТТЭЙ ХЭРЭГЛЭЭ, ДАХИН АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.3.1. Ус хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна.

6.3.2. Усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамаарсан шатлан өсгөх зарчимд суурилж тогтоох, төлбөрийн орлогыг дахин хуваарилах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж хэрэгжүүлнэ.

6.3.3. Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрлийн механизмаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, усны ул мөрийг бууруулна.

6.3.4. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС, УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ЭРҮҮЛ АХУЙН БҮСИЙН ДЭГЛЭМИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛЖ, УСНЫ НӨӨЦИЙН БОХИРДОЛ, ХОМСДОЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

6.3.5. Усны хууль тогтоомжийн хэрэгжилтийг чангатгаж, нийслэл болон бусад хот суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж газар чөлөөлөн усны нөөц бохирдож, хомстохоос сэргийлэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.3.6. Сав газрын захиргаадын бүтцийг оновчлон чадавхжуулж, улсын болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

6.3.7. Газрын доорх усны нөөц баялгаа бүртгэлжүүлж ашиглалтын зохистой менежмент явуулах, усны нөөцийн өөрчлөлт, ашиглалтын талаарх бодит мэдээллийг бий болгох үүднээс гадаргын усны харуулын тоо болон газрын доорх усны хэмжилтийн цэгийг нэмэгдүүлнэ.

ГАЗРЫН БАЙГАЛИЙН ТОГТОЦ, ГОЛЫН ТАТАМД ХУР ТУНАДАС, ХАЙЛСАН ЦАС, МӨСНИЙ УСЫГ ХУРИМТЛУУЛАХ ХӨВ ЦӨӨРӨМ, ДАЛД УСАН САНГУУД БАЙГУУЛЖ, ТОМООХОН ГОЛУУД ДЭЭР УРСЦЫН ТОХИРУУЛГАТАЙ, ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ УСАН САН БАРЬЖ ЭХЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.3.9. Газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах цувраа хөв цөөрөм, далд усан сангууд байгуулна.

6.3.10. Говь, хээрийн бүсэд газрын доорх усны ордын орчимд үерийн усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэх цөөрөм байгуулах замаар усны нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх арга технологи нэвтрүүлнэ.

ХҮН АМЫГ СТАНДАРТЫН ШААРДЛАГАД НИЙЦСЭН УНДНЫ УСААР ХАНГАХ, УСНЫ НӨӨЦИЙН ЭРЭЛ, ХАЙГУУЛ, ЗУРАГЛАЛЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ НӨӨЦ БАЯЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН БААЗ СУУРИЙГ ӨРГӨЖҮҮЛЖ ТӨЛӨВЛӨЛТ, МЕНЕЖМЕНТ ХИЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.3.13. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.

2040 оны усны хэрэгцээ (сая м3/жил)								
аймаг	Хүн амын унд, ахуйн ус	Нийтийн аж ахуйн үйлчилгээний & аялал жуулчлал & ногоон байгууламж	Үйлдвэрлэл	усад үйлдвэрлэл, эрчим хүч, барилга, зам тээвэ	Үйлдвэрлэл Уул уурхайн (олборлолт, боловсруулалт)	МАА (бэлчээрийн фермийн)	Усалгаатай талбай	нийт
Говь-Алтай	2.00	0.32	0.22	0.24	0.00	21.20	3.43	27.4

Хүснэгт 1: 2040 оны усны хэрэгцээ

Эх сурвалж: БХБЯ, ҮХГ, ЖАЙКА, Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн явцын тайлан, 2010

Бүсчилсэн хөгжил

- **Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс (говь-алтай, баянхонгор, өвөрхангай аймаг)**



Зураг 2: Бүсчилсэн хөгжил

Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн гол баримт бичгүүд нь УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” түүнийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас батлан мөрдүүлсэн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн,

Улаанбаатарын бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр байлаа. Эдгээр баримт бичгүүдийн хүчинтэй хугацаа 2018- 2020 онд дуусгавар болж, үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг шинээр боловсруулах эрхзүйн хэрэгцээ шаардлага байна. Мөн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, түүнийг хэрэгжүүлэх бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш 15-20 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дотоод, гадаад орчин, түүнд нөлөөлөх орон зайн хүчин зүйлсийн харьцаа, үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийг зохицуулах арга механизм, түүнд оролцох төрийн оролцоо, чиг үүрэг ихээхэн хувьсан өөрчлөгдсөн байна. Иймээс Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинээр боловсруулах, макро бүсүүдийг шинээр тогтоох практик шаардлага үүсч байна. Дэлхийн улсууд өөр өөрсдийн орны онцлогтоо тохируулан газар нутгаа бүсчлэн хөгжүүлэх асуудлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, томоохон газар нутагтай Орос, Хятад, Австрали болон Япон, Франц зэрэг улсын туршлагаас үзэхэд эдийн засгийн макро бүсүүдийг тодорхойлж, төрийн зохицуулалтыг тусгайлсан хууль, тогтоомж гаргаж, түүнийг стратегийн болон индекатив арга хосолсон нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд уялдуулан шийдвэрлэж, хэрэгжүүлж байна. Манайд ч ийм туршлага байсан бөгөөд бид үүнийг зах зээлд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байгаа юм.

2. БАЙГАЛИЙН НӨӨЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС

(Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймаг)

ЗОРИЛТ 8.3 Говийн уулс, тал хээрийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, бүс нутгийн интеграцад идэвхтэй оролцсон, мал аж ахуй, аялал жуулчлал рекреацийн бүс нутаг болгон хөгжүүлнэ.

2.1 Говь-Алтай аймгийн нөөцүүд

2.1.1 Байгалийн тогтоц

Говь-Алтай аймаг нь зүгт зүүн талаараа Баянхонгор, хойд талаараа Завхан, баруун талаараа Ховд, өмнөд талаараа БНХАУ-тай хил залган оршино. Тус аймгийн БНХАУ-тай хиллэдэг хилийн урт 360 км бөгөөд хилийн 128-171 дүгээр тэмдгээр тэмдэглэгджээ. Говь-Алтай аймаг нь 141.4 км.кв нутаг дэвсгэртэй. Дэлхийн цагийн 6 дугаар бүсэд байрладаг. Тус аймаг нь уул, тал, хөндий, уужим, тавиун хотгор, хонхор хосолсон газрын гадаргуутай

Аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалын хувьд Алтайн уулархаг их муж, Говийн их мужид хамаарах бөгөөд байгалийн бүс, бүслүүрийн хувьд гол төлөв говь, цөлийн бүсэд оршино. Мөн бага хэмжээгээр хээр тал болон өндөр уулсын босоо буюу тагийн бүслүүр тархсан байдаг.

Говь-Алтайн нутаг дахь уулсууд дөрөвдөгч галавын Альпын атриашлын сүүлээр тогтсон хийгээд тектоник хөдөлгөөний хүч их байсан тул өндөр болон сүндэрлэжээ. Жишээлбэл, Хасагт хайрхан зэрэг өндөр уулст одоогоор 600 сая жилийн өмнөх үеийн мөстлөгийн ор мөр бүхий бул чулуунууд илэрсэн нь дэлхийн геологийн шинжлэх ухаанд шинэ нээлт болжээ. Тус аймгийн гадаргын хотгор гүдгэрт талархаг хэлбэр голлох бөгөөд өөрөөр хэлбэл, сүүлийн үеийн уул тогтох хөдөлгөөнд нөлөөлөгдөөгүй дунд төрмөлийн эриний талархаг гадарга хэвээр хадгалагдан үлдсэн аж. Шинэ усны болон Халиун, Бигэр, Алтай сумын нутаг дахь Хайч уул, Улаан ганга, Ээж хайрхан уул, Бугат сумын нутаг дахь бунгийн гол зэрэг газруудаас аварга хирсний аймгийн шим үлдэгдлүүд олдсон байна. Ялангуяа шаргын говиос неогенийн галавын үеийн миоценийн бүлгийн амьтан болох шувуу, эх газрын дун, хясаа, эртний заан болон плиоценийн бүлгийн амьтан болох эртний адууны аймгийн зэрэг шим үлдэгдлүүд нэг газраас цогцолбор байдлаар олдсон нь палеонтологийн шинжлэх ухаанд онцгой сонирхол татах аж. Мөн Халиун, Бигэр сумын нутгаас эртний зааны болон адууны аймгийн шим үлдэгдлүүд олдсон байдаг.

Томоохон говь, хотгор хонхоруудын гадаргын үнэмлэхүй өндөр 743-1100 орчим метр, өөрөөр хэлбэл далайн түвшингээс дээш дунджаар 1000 гаруй метр өргөгдсөн Хүйс, Шарга, Захуй, Зарман, Отгон, Шаралдайн, Номин, Загт сайрын, Хар сайрын, Зүүн гарын, Талын, Нарансэвстэйн, Төхөм, Цагаан дэрс, Шалын, Улаан шалын хоолой, Хонин ус, Бигэр, Халиун зэрэг Монголын нэрд гарсан 33

говийн 10 гаруй нь оршдог. Эдгээрээс хамгийн нам өндөрлөгтэй нь Цэнхэр номингийн говь (583 м) юм.

Говь-Алтай аймагт Монгол Алтайн гол нурууны үргэлжлэл болох Мянган угалзтын нуруу, Бүс хайрхан, Алаг хайрханы уулс, Их хүрэн, Баян-Өндөр уул, Хар азаргын нуруу, Бурхан буудай уул, Гичгэний нуруу зэрэг үзэсгэлэнт сайхан уулс, Тонхил, Бугат, Төгрөг, Халиун, Цээл, Цогт, Бигэр, Эрдэнэ, Дэлгэр сумдын нутгаар дамнан сүрдэрлэнэ.

Энэ гол нуруунаас зүүн урагш Монгол Алтайн нурууны урд талын томоохон салбар Аж богдын нуруу Бугат, Алтай сумын нутгийг дамнан оршино. Монгол Алтайн нурууны хойд талын хоёр дахь салбар төрийн тахилгат Сутай хайрхан, Тонхил сумын нутагт оршино. Шаргын говийн зүүн хойд талаар Монгол Алтайн гол нурууны дөрөв дэх салбар болох Хасагт хайрхан, Хан тайшир, Сэрхийн нурууд нь Баян-Уул, Шарга, Тайшир, Бигэр, Дэлгэр сумын нутгаар баруун хойноос зүүн урагш чиглэн оршино. Монгол Алтайн нурууны өврийн салбар болох Таянгийн нуруу Ээж хайрхан уулаар дамжих ба түүнээс зүүн урагш Цогт, Эрдэнэ сумын нутгаар дайрсан Идрэнгийн нуруу үргэлжилнэ.

Аймгийн хамгийн өндөр мөнх цаст Сутай хайрхан уул далайн түвшнээс дээш 4090 метр өндөр бөгөөд үүнээс гадна Аж богд (3802 м), Бурхан буудай (3765м), Алаг хайрхан (3738 м), Хасагт хайрхан (3578м), Бүс хайрхан (3393 м) , Буга хайрхан зэрэг байгалийн үзэсгэлэнт өндөр уулс оршино.

Хүснэгт 2: Говь-Алтай аймгийн өндөр уулс

№	Нэр	Өндөр (дтд, метр)	Сум
1	Сутай хайрхан уул	4090	Тонхил
2	Аж богд	3802	Алтай
3	Бурхан Буудайн уул	3765	Халиун
4	Гүнгээгийн Шовх уул	3684	Дарви
5	Ар Ягаан Чулуут уул	3511	Цогт
6	Урд хөх шовх уул	3496	Чандмань
7	Алтан Хайрхан уул	3387	Алтай
8	Зост Өндөр Хар уул	3311	Жаргалан
9	Цагаан Чулуут уул	3228	Тонхил
10	Гялангарийн Орой уул	3224	Цээл
11	Тахидаг уул	3201	Тонхил
12	Хан Хайрхан уул	3191	Эрдэнэ

13	Хүнхэрийн Ирмэг уул	3167	Төгрөг
14	Сэрх уул	3155	Дэлгэр
15	Алаг Хайрхан уул	3149	Чандмань
16	Чандмань уул	3087	Баян Уул
17	Төгөл Хайрхан уул	3082	Бигэр
18	Хөндлөн уул	3070	Есөнбулаг
19	Баян-Өндөр уул	3026	Бигэр
20	Залаа уул	3021	Тайшир
21	Цагаан Өндөр уул	3008	Есөнбулаг
22	Баян-Өндөр уул	2999	Халиун
23	Дан уул	2973	Цогт
24	Улаан Хайрхан уул	2937	Бугат
25	Алаг Овоо	2901	Цогт
26	Цагдуулт уул	2875	Төгрөг
27	Могойн уул	2870	Халиун
28	Эрдэнэ уул	2838	Чандмань
29	Бөмбөгөр Ямаат уул	2803	Тонхил
30	Цагаан Хайрхан уул	2787	Төгрөг

2.1.2 Говь-Алтай аймгийн амьтан, ургамлын нөөц

Говь-Алтай аймаг амьтны аймгаар баян бөгөөд тухайлбал ойт хээр, хээр, говь буюу заримдаг цөл, цөл, өндөр уулын тагийн бүслүүрийн хад асга, ус орчмын шугуй, сэвсгэр элсний амьтад хөршлөн тархжээ. Амьтдын тархалтыг хөхтөн, хоёр нутагтан ба мөлхөгчид, шувуу, шавьж, загас гэсэн ангит бүлгүүдээр авч үзэж болно. Тухайлбал тагийн бүслүүрийн хөхтөн амьтан аргаль, янгир, ирвэс, түүнчлэн жижиг амьтад хадны баргачин, алтайн огодой, урт сүүлт шижүүхэй зэрэг нь аймаг дахь Монгол Алтайн гол болон түүний салбар уулсад амьдарна. Уулархаг нутагт элдэв янзын шавжийн бүрдэл тааралдана. Хээрийн бүсийн болон бусад бүсэд түгээмэл тархсан тарвага, зурам, чоно, хярс, туулай, үнэг, хүрэн зэрэг амьтдын бүлгэмдлийг нэрлэж болно. Ойт хээрийн буга согоог, буган хандгай, суусар, жирх зэрэг амьтад дархан цаазат хасагт хайрхан зэрэг уул, мөн хар азаргын нуруунд бий.

Говь болон цөлийн бүсийн дархан цаазат хийгээд ховордсон амьтадаас хавтгай, хулан, бөхөн, мазаалай, зэгсний гахай, хар сүүлт, мөн махчин цоохондой зэрэг тархсан. Говь, цөлийн мөлхөгч амьтадаас хонин гүрвэл, могой гүрвэл, могой, замба гүрвэл нутагладаг бөгөөд үүнээс загалт гүрвэл, тэмээн сүүлт могой нь зөвхөн

Алтайн өвөр говьд нутагладаг байна. Алтайн хойлог, цагаан ахууна, ятуу, хахилага, ёл, тас зэргээс гадна говьд, хээрийн бүсийн шувуудын гол бүрдэл болох монгол болжмор, талын бүргэд, тэрчлэн говь, цөлийн бүсийн тоодог, хулан жороо, чогчого, зэржгэнэ мэтийг нэрлэж болно.

Хүснэгт 3: Говь-Алтай аймгийн улаан номонд орсон амьтан, ургамал

Амьтан					
№	Зүйлийн нэр	ШУ-ны нэр	Статус	ОУ	Бүс нутаг
1	Шарнад цөөвөр	-	НХЗ	УБ	УС
2	Суусар булга	Martes Foina	ХЗ	АӨ	МД
3	Эрээн хүрнэ	Vormela peregusna	ХЗ	АӨ	МД
4	Тахь адуу	Equus przewalskii	НХЗ	УБ	УБ
5	Монгол хулан адуу	Equuz hemionus	ХЗ	ЭМ	ХО
6	Алтайн аргаль	Ovis ammon	ХЗ	ЭМ	УБ
7	Янгир ямаа	Capra sibirica	ХЗ	АӨ	ХБ
8	Мазаалай				
9	Хавтгай				
10	Ирвэс				
11	Харсүүлт				
12	Монгол бөхөн				
Шувуу					
1	Алтайн хойлог	Tetraogallus altaicus	ХЗ	ХБ	-
2	Загийн бор шувуу	Passer ammodendri	ХЗ	ХБ	-
Мөлхөгч					
1	Нарийн могой	Coluber spinalis	ХЗ	-	ХБ
Дээд ургамал					
1	Элдэвнавчит улиас (тоорой)	Populus diversifolia	НХЗ	ҮХ	ЭМ
2	Иконниковын гичгэнэ	Potentilla ikonnikovii	ХУ	-	-
3	Монгол буурцгана	Chesneya mongolica	НХЗ	ҮХ	ХБ
4	Хэврэгнавчит ортууз	Oxytropis fragilifolia	НХЗ	ҮХ	ЭМ
5	Арзгар сухай	Tamarix hispida	ХЗ	-	-
6	Зүүнгарын гоёо (Улаан гоёо)	Cynomorium songaricum	ХЗ	-	-
7	Банзрагчийн зүлэглиг	Swertia banzragczii	НХЗ	ҮХ	ЭМ
8	Чөдөр зэллэг цэцэг	Calystegia hederecea wall	ХЗ	-	-
9	Цөлийн ганга	Thymus mongolicus	ХЗ	-	-
10	Говь-Алтайн ганга	Thymus Gobi-Altaiicus	ХЗ	-	-

11	Сайханы бамбай	Valeriana saichanensis	НХЗ	ҮХ	ЭМ
12	Нөмрөгт банздоо	Saussurea involucrate	НХЗ	ҮХ	УБ
Хаг					
1	Говийн харлаг	Tonina gobica	НХЗ	-	-
2	Хангайн шигмээ	Aspicilia changaica	ХЗ	-	-

Хүснэгт – ийн тайлбар: НХЗ – Нэн ховор зүйл

УБ – Устаж болзошгүй

ХЗ- Ховор зүйл

УС - Устсан

ОУ- Олон улсад

АӨ – Анхааралд

ертөхөөргүй

МД – Мэдээлэл дутмаг

ЭМ – Эмзэг

ХО – Ховордсон

ХБ – Ховордож болзошгүй

Монгол орны аргаль хонины тархцыг газарзүйн мэдээллийн систем

Монгол улсад 15 аймгийн 110 сумын 48732,5 км 2 талбайд аргаль хонь тархжээ. аргаль хонины үндсэн тархац нутаг нь газарзүйн бүс, бүслүүр бүрд харилцан өөр хэмжээтэй байв. Энэхүү үндсэн тархац нутгаас хэмжээний хувьд харьцангуй том нь Ховд аймгийн Мянган Угалзат, Бөөрөг орчим /4836,04 км2, **Говь – Алтай аймгийн нутагт орших Аж богд уул /2471,19 км2/**, Өвөрхангай аймгийн Өшиг /1522,30 км2/, Дорноговь аймгийн Толийн толгой, баруун нарийн уул, /1092,30 км2/, Хасар, Өндөр, Жавхлант, Цац /1037,82 км2/ зэрэг газруудад байна. Хамгийн бага талбайтай нь Төв аймгийн нутагт орших Баян-Эрхт уул /5,19 км2/, Өнжүүл /6,46 км2/, Дундговь аймгийн Хөөтийн хар толгой /6,59 км2/, төв аймгийн Хоньт /8,83 км2/, Хар Хад /9,55 км2/, Уянга /9,73 км2/, Говьсүмбэр аймгийн Чойрын богд /9,19 км2/, зэрэг газрууд болно.

Говь–Алтай аймагт аргаль хонь нь 6 сумдын 6263,84 км2 талбайд тархсан. Алтай, Эрдэнэ сумдад аймгийн нийт аргаль хонины тархац нутгийн 69,5 хувь оногддог байна. Сүүлийн жилүүдэд аргалийн тоо эрс буурч байна. 1980 – аад оноос агнуурын нөөц хомсдсон учир угалз агнуур зогссон.

Хүснэгт 4: Говь-Алтай аймгийн нутагт тархах аргаль хонины тархац

Аймаг	Сум	Сумын нийт талбай км2	Аргаль хонь тархсан талбай км2	Аргаль хонины тархцын сумын талбайд эзлэх хувь
Говь-Алтай	Алтай	20066,984	2697,53	13,44
	Бугат	9981,470	661,98	6,63

	Тонхил	7485,668	690,72	9,23
	Цогт	16678,525	452,61	2,71
	Цээл	5556,510	102,49	1,84
	Эрдэнэ	24945,432	1658,51	6,65

I үе шат (2020-2030) ХОС ТЭНХЛЭГ

Алтайн бүсийн босоо, хэвтээ чиглэлийн дэд бүтцийн үндсэн тэнхлэгүүдийг байгуулах, бэлчээрийн мал аж ахуйг дэмжих, түүхий эдийг гүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлэх үе

1. Бүсийн босоо, хэвтээ тэнхлэгийн авто замуудыг барьж, мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логикийн төвүүдийг байгуулах
2. Экспортын чиг баримжаатай органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх
3. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүсийн дотоодын хэрэгцээг хангах
4. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, байгаль экологийн, эрүүл мэндийн болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх
5. Уламжлалт анагаах ухааны чиглэлийн их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг байгуулах
6. Мезо, микро бүсүүдийн төвүүдийг нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн хөгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх

II үе шат (2031-2040) РАШААН СУВИЛАЛ-ЭРҮҮЛ МЭНДИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Дотоодын ба олон улсын амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын сүлжээг хөгжүүлэх үе

4. Ховор, нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах, өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх үндэсний паркийг байгуулах, тусгай сонирхол, амралт, рашаан сувиллын аялал жуулчлалын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх
5. Рекреацийн нөөц болон органик бүтээгдэхүүнд түшиглэн анагаах ухаан, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэл, инновацийн төв байгуулах

6. Аялал жуулчлалын хот, сууринг олон улсын ногоон хотын норм, стандартын дагуу төлөвлөж, хөгжүүлэх

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо тэнхлэгийн шугам, дэд станцыг барьж байгуулан бүсийн эрчим хүчний хангамжийг найдваржуулна.

Хүснэгт 5: Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн эрчим хүчний төслүүд

Төрөл	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа	Нийт
				2031-2040	
ЦДАШ	Улиастай-Есөнбулагийн 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км	194	194

8.3.5. Ховор, нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах, өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх үндэсний парк байгуулна. Аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.

8.3.6. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, **Говь-Алтайн нуруу**, говь, хангай, хээр хосолсон байгалийн өвөрмөц ландшафтыг түшиглэсэн байгалийн болон адал явдалт аялал жуулчлал, Хангайн нурууны өвөр хэсгийн Шаргалжуут орчмын рашааныг түшиглэсэн амралт, нөхөн сэргээх аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Бүсийн төвүүдэд аялал, жуулчлалын мэдээллийн төв, аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.

Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төсөл

Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн урьдчилсан тооцоог гаргахдаа төсөвт байгууллагын урсгал зардлын хүрээнд хэрэгжих арга хэмжээнүүдийн санхүүжилтийг оруулж тооцоогүй болно. Монгол Улсын төрийн болон албаны нууцын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 13 дугаар зүйлд заасан төрийн нууцад хамааруулах төрийн бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн, батлан хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлы болон бусад хүрээний нууцалбал зохих мэдээлэл бүхий төсөл, арга хэмжээ, тэдгээрийн төсөвт өртгийг энэ бодлогод тусгаагүй болно. Улсын төсвийн урсгал зардлаас гадуур төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, гадаад, дотоодын хувийн

хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр хэрэгжих зорилго, зорилтуудын урьдчилсан санхүүжилтийн тооцоог гаргахад **“Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх 30 жилийн хугацаанд өнөөгийн өртгөөр 145.1 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдах юм. Монгол Улсын бодит эдийн засаг нь 2018 онд 18.1 их наяд төгрөг байсан бөгөөд уг бодлогод туссанаар эдийн засгийн бодит өсөлт жилд 6 хувь байхаар төсөөлж байна.** Ингэснээр “Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” хэрэгжиж дуусах 2050 онд өнөөгийн бодит өртгөөр 100 гаруй их наяд төгрөгийн эдийн засагтай болох юм. Уг хөтөлбөрт туссан арга хэмжээнүүдийг 30 жилийн хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжтой эдийн засгийн суурь бий болно.

Уул уурхайн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон төслүүд нь эдийн засгийн зорилгод багтсантай холбоотойгоор уг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн 37.6 хувь нь энэхүү зорилгод туссан байна. Тухайлбал, Тавантолгой ордын баруун, зүүн Цанхийг ашиглах төслүүд нь 17.7 их наяд төгрөгийн санхүүжилт шаардахаар байгаа юм. Бүсчилсэн хөгжил зорилгын хүрээнд эдийн засгийн өсөлт, бүс нутгийн хөгжлийг дэмжих автозам, төмөр зам, эрчим хүч болон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буйтай холбоотойгоор улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, хувийн хөрөнгө оруулалт зэрэг эх үүсвэрийн 48.2 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна. Хүний хөгжил зорилгын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, шинжлэх ухаан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд урьдчилсан тооцоогоор 16.4 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна. **Ногоон хөгжил зорилгыг хэрэгжүүлэхэд 13.7 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдах юм.** Ховд, Баян-Өлгий, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Өвөрхангай, Дорнод аймгийн нутаг дэвсгэр дэх Ховд, Орхон, Туул, Эг, Хэрлэн, Онон зэрэг томоохон голууд болон бусад голын татмууд, 21 аймгийн байгалийн тогтоцуудыг хамгаалахтай холбоотой томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогод нийт 187 төсөл хэрэгжүүлэхээр тусгаснаас 135 нь төслийн техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгаа, бодлогын судалгаа эсхүл зураг төсөл гэх мэт ямар нэг түвшний судалгаа хийгдсэн байгаа ба 52 төслийн хувьд судалгаа, тооцооллыг шинээр хийх шаардлагатай байна.

Говь-Алтай аймгийн аяллыг хөгжүүлэх бодлогын бичиг баримтыг боловсруулахад “Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн

бодлого”-ын бичиг баримт, аймгийн засаг даргын “ ”бодлогын баримт бичигтэй нэг үндсэн үзэл баримтлалтай боловсруулагдсан болно.

Түүнчлэн тус бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлэгт дурдагдсан: Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд дараах чиглэлүүдийг гол зорилго, зорилтуудаа болгосон. Үүнд:

- Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх чиглэлээр Стратегийн бодлого төлөвлөлтийн хэсэгт тусгав.
- Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлэх чиглэлээр олон улсын туршлагыг судалж тусгав.
- Тусгай хамгаалалттай газар нутгийг байгальд ээлтэй эко аялал жуулчлалын зориулалтаар төлөвлөн хөгжүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээнд анхаарч төлөвлөсөн.
- Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд нөхөрлөлийн зарчим бүхий нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бодлогын бичиг баримтанд тусгалаа. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал загварыг боловсруулсан.
- Ингэснээр нутгийн иргэд морь, тэмээ зэрэг ердийн хөсөг, мах, сүү, ногоо, бэлэг дурсгал зэрэг бэлтгэн нийлүүлэлтийг хангах зарчмаар нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх юм.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийг үндэс болгон Ээж хайрхан, Алаг хайрхан, Монгол элс, Хасагт хайрхан, Шарга Манхан, Бурхан буудай Говийн Их дархан газар А, Б (Зүүн гарын дархан газар) Сутай хайрхан, Хар Азрагын нуруу зэрэг тусгай хамгаалалттай газар аялал жуулчлалын бааз отог байгуулан зорилтот аялал жуулчлалыг хөгжүүлэхээр төлөвлөсөн.
- Аялал жуулчлалыг гурван бүс болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн.
- Бүс бүрт орон зайн төлөвлөлт дэд бүтэц, аялал жуулчлалын нөөц, рекреацийн үнэлгээ нөөцөд тулгуурлан жуулчны бааз, отог, аялал жуулчлалын төв, түр амрах цэгүүдийг төлөвлөсөн.

2.1.3 Монгол улсын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ

ДАВУУ ТАЛ

- Дэлхийд өөрийн хувь нэмрээ оруулсан баялаг түүх, Монгол нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлстэй- Нүүдэлчдийн нийгэм, соёлын давуу тал
- Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, өөрсдийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, олон улстай харилцан тэгш эрхтэй хамтран ажиллах чадавх
- Гадаад, дотоод зөрчил, мөргөлдөөнгүй
- Оюуны өндөр чадамжтай иргэд, Монгол хүүхэд, залуучууд оюуны спорт, уралдаанд дэлхийд тэргүүлэх чадамж өндөртэй
- Өргөн уудам нутаг дэвсгэр, Бэлчээрийн мал аж ахуй, органик газар тариалан эрхэлж, хүнсээ дотоодоосоо бүрэн хангах чадавх
- Байгалийн арвин нөөц баялаг
- Түүхийн эдийн хамгийн том хэрэглэгч буюу эрэлттэй зах зээлтэй хамгийн ойр байршил
- Төв ба Дундад Ази, Европын орнуудыг Зүүн хойд, Зүүн өмнөд Азийн орнуудтай холбох транзит тээвэрт тохиромж газарзүйн байршил
- Дэлхийн банкны гаргасан судалгаагаар 2050 он гэхэд дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэх 10 орны тоонд багтах 2 том их гүрний дунд оршдог
- Социализмын үеийн төлөвлөлтийн арвин туршлага

ХӨГЖЛИЙН БОЛОМЖ

- Монгол соёлын нэгдмэл үнэт зүйлийг сэргээх, гадаад дахь нөлөө, орон зайг тэлэх, аялал жуулчлал, соёлын үйлдвэрлэлийн боломж;
- Дэлхийн тэргүүлэх 2 эдийн засаг (зах зээл)-д ойр байрлал хоёр хөрштэй найрсаг хамтын ажиллагаа, зах зээл, эдийн засгийн ирээдүйн боломж
- Мэдээлэл технологийн эрчимжилт, аж үйлдвэрийн 4-р хувьсгалын үр нөлөөний зардал бууруулах, шинэ бүтээгдэхүүн гаргалтыг хурдасгах, үр ашгийг нэмэгдүүлэх байдал
- Даяаршлын хүрээнд үйлдвэрлэлийн хямд орцуудыг хайсан гадны хөрөнгө оруулалтыг татах боломж өндөр
- Байгалийн цэвэр, органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж экспортлох боломж
- Дэд бүтэц, төмөр зам, тээвэр логистикийн төвийн тогтолцоо бүрдүүлж зах зээлийн хараат байдлаас гарах боломж
- “Гуравдагч хөршийн бодлого”-ын хүрээнд дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэг
- Харьцангуй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж

СУЛ ТАЛ

- Төрийн бодлого тогтворгүй, залгамж холбоогүй, сонгууль дагасан дөрвөн жилийн циклтэй, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах институц бүрдээгүй
- Хүнд суртал, авлига их
- Бизнес эрхлэх орчин муу
- Хүн амын нягтшил бага, тархай суурьшилтай, хил орчмын нутаг дэвсгэрийн хүн ам цөөн, амьдрах орчин муу
- Хүн амын дунд харьцангуй сэргийлж болох өвчлөлөөс сэргийлэх мэдлэг, хандлага дутмаг
- Хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал, мэргэжлийн өндөр ур чадвар, мэдлэгтэй хүний нөөц дутмаг;
- Бүтээмжгүй, хоцрогдсон технологитой, бүтээгдэхүүний чанараар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар сул
- Хөрөнгө санхүү, валютын нөөц ихээхэн хязгаарлагдмал
- Байгалийн нөөцийн жигд бус тархалт, үнэлэмж хангалтгүй
- Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл, гадаад эрэлтийн өөрчлөлт зэрэг хүчин зүйлсээс хамаарах эмзэг байдал өндөр

Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.

I үе шат (2016-2020): Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэх.



Зураг 3: Тогтвортой хөгжил

II үе шат (2021-2025): Бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг

хөгжүүлэх, Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах, гадаадын жуулчдын тоог 1.5 саяд хүргэх.

III үе шат (2026-2030): Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчилан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэн, гадаадын жуулчдын тоог 2.0 саяд хүргэх

Нүүдэлчдийн тухай ойлголт

Нүүдэлчид гэж мал ахуйгаа дагаж, нэг газраас нөгөөд байнга шилжин нүүж амьдардаг ард түмнийг нэрлэдэг. Гэхдээ ан агнуур, загас барьж амьдардаг нүүдэлч ард түмэн ч бий. Нүүдэлчид мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой хуурай тал, хагас цөл, өндөр уулсын бүсээр аж төрдөг.

Нүүдлийн ахуй оршин тогтнох зайлшгүй нөхцөл гэдэгт:

- Их бага хэмжээгээр ой модгүй орон зайтай байх
- Байнгын цасан хучлагагүй буюу эсвэл цасны зузаан нь 40см-ээс хэтрэхгүй байх,
- Суурьшмал хот суурин, тосгонтой их бага хэмжээгээр хөршлөн амьдрах зэргийг шаарддаг байна.

Нүүдэлчдийг эдийн засаг, суурьшсан түвшнээр нь үндэслэж:

- Нүүдлийн
- Хагас нүүдлийн буюу хагас суурьшмал
- Бэлчээрийн
- Хагас бэлчээрийн буюу зуслант
- Босоо нүүдлийн буюу уул тал хослуулсан нүүдэл гэж ангилдаг байна.

Хэвтээ буюу өргөрөгийн, босоо буюу уртрагийн дагуу нүүдэлдэг, мөн тойрог байдалт нүүдэл гэсэн ангилал бий. Энэ ангиллын үүднээс мөчидхөн харвал халимагууд нь өргөрөгийн дагуу нүүсээр баруун тийш тасран одсон бол хөх нуур, шинжаан уйгарын монголчууд уртрагийн дагуу нүүдэг байсаар маниасаа тасран одсон болтой. Харин тойрон эргэх байдлаар нүүдэг нүүдэлчид нь одоогийн голомтоо сахин үлдсэн байх магадлалтай.

Газар зүйн хувьд нүүдэлчдийг зургаан гол бүсэд хуваадаг байна.

Евразийн тал - таван хошуу мал (адуу, том эвэрт үхэр, хонь, ямаа тэмээ. Бид таван хошуу мал гэдэгт юу ордгийг нэг бүрчлэн мэддэг бол гадныханд энэ нь харь

ойлголт юм) үржүүлэн өсгөдөг Монгол, Казах, Түрэг, Киргизүүд орно. Энэ бүс нутагт нүүдэлчид талын хүчирхэг гүрнүүдийг (Скиф, Хүннү, Түрэг, гэх мэт) үүсгэж байсан юм.

Ойрхи Дорнод – мухар эвэрт үхэр болон уналга эдэлгээнд адуу, тэмээ, илжгийг өргөнөөр ашигладаг Бахтияр, Бассер болон Пуштун зэрэг нүүдэлчид үүнд багтана.

Аравийн элсэн цөл, Сахар – тэмээний аж ахуй эрхлэдэг Бэдэн, Туарег зэрэг нүүдэлчид оршин амьдрана.

Дорнод Африк, Сахарын өмнөх саван – том эвэрт үхэр өсгөн үржүүлдэг Нуэр, Динк, масайчууд амьдардаг байна.

Өвөр азийн өндөр уулсын бүс болох Төвд, Памир ба өмнөд Америкийн Андын нуруу – сарлаг, лам гөрөөс, альпак өсгөн үржүүлдэг оршин суугчид багтана.

Хойд зүгийн буюу субарктикийн бүс – цаа бугын аж ахуй эрхлэдэг Саам, Чукча, Эвенкүүд оршин амьдрана.

Монгол нутаг дахь нүүдэлчдийн үүсэл:

Нүүдэлчид хэзээнээс бүрэлдэн бий болов. Археологичид Монголд хүн амьдарч эхэлсэн цаг хугацааг 800000 жил орчим ийн өмнө гэж үздэг. Чулуун зэвсэг, эд зүйлс зэргээс тээж аваад гадаадын том лавроторуудад он цаг тогтоолгодог байна. Нүүрс хүчлийн задаргаа гэх с 14 буюу (carbon 14 dating) гэдэг арга бий. Нарын гол дээр 1 сая орчим жилийн өмнө хүн амьдарч байсныг тогтоосон. Монгол орноос олдсон хүний ясны олдвор бол харьцангуй залуу байна. Манайхаас Африк, Зүүн өмнөд Азиас олдсон шиг хэдэн зуун мянган жилийн настай олдвор бол олдоогүй. Монголоос олдсон хамгийн эртний олдвор бол Дорнод аймгийн шинэ чулуун зэвсгийн үеийн Тамсагбулагийн суурингаас 10000 жилийн настай оршуулга байдаг.

Монгол нутагт амьдрагсад хонь, ямаа, үхэр зэргийг хамгийн эхэнд гаршуулсан гэж тогтоожээ. Гэхдээ манай хонь, ямаа, үхэр гаршуулсан түүх Дундад Ази, Зүүн Европ ийн орнуудын амьтан гаршуулсан он цагаас хожуу байдаг байна. Монгол, Казахстан, Дундад ази, Зүүн европыг орнуудаас малын генетикийн судалгаа хийхэд Монголд хонь ямаа бусад орнуудаас нэлээн түрүү үед орж ирсэн байдаг байна. Тодруулбал хүрлийн түрүү үед одоогоос 3500-4000 жилийн өмнө нутагшсан байна. Гэхдээ бид мал бусад орнуудаас өмнө мал гаршуулсан гэдгээ

батлахын тулд судалгаа хийж тогтоох ёстой. Харамсалтай нь одоогийн байдлаар хүрлийн түрүү үеийн малын олдвор олдоггүй байна. Гэвч Увс аймгийн Сагиль суманд байдаг шинэ чулуун зэвсгийн үед хамаарах (12000-4000) Могоогийн хадний зурагт үхэр хөтөлж яваа хүнийг дүрсэлсэн байдаг нь Монгол оронд одоогоос 12000 жилийн өмнө үхрийг гаршуулсныг батлаж байгаа юм. Адуу, адууны соёл бол сонирхолтой байдаг байна. **Говь-Алтай аймгаас хүрлийн үеийн маш нарийн хийцтэй хүрэл морь олдсон нь бас сонирхолтой, өвөрмөц олдвор.**

Хүн төрөлхтөн тахийг огт гаршуулж байгаагүй гэж үзэж байсан ч Ботон адуу нь тахь болох нь тогтоогдсон. Гэхдээ яагаад тахийг үргэлжлүүлэн гаршуулалгүй орхив гаршуулахад хэцүү байв уу? Тэгээд одоогийн бидний мэдэх адууг гаршуулсана уу? гэдэг нь сонирхолтой асуудал юм. Монгол улс адууны соёлоо урагшлуулахын тулд археологийн шинжилгээ хийж батлах хэрэгтэй. Түүхэн сурвалжууд Монгол нутагт МЭӨ 4000-5000 жил буюу одоогоос 6000-7000 жилийн өмнөөс зэрлэг адууг гэрийн тэжээвэр амьтан болгон сургасан түүхтэйг баталдаг байна. Адуу бол нүүдэлчдийн хөгжлийн хамгийн гол тулгуур гэж хэлж болно. Байлдах, нүүх зэрэгт гол үүрэг гүйцэтгэхээс гадна идэш хүнс нь ч болдог байжээ. Эртний буган чулуун хөшөөний эзэд болон Дөрвөлжин булшны эзэд бол нүүдэлчид юм. Өөр хоорондоо тэмцэлдэж байсан ул мөр хүртэл байдаг.


Монгол нутагт үүссэн хамгийн анхны төрт улс бол Хүн гүрэн гэж үздэгч сүйлийн үеийн судалгаанууд үүнийг үгүйсгэхэд хүргээд байна. Хүннүгээс өмнө Монгол угсаатан бүрэлдсэн эсэх асуудалд археологийн судалгааны үүднээс хариулт хэлж болно. Одоогоос 3500 орчим жилийн өмнө өнөөгийн Монгол орны нутагт Хангай нутгаар зааглагдсан угсаа, соёлын хоёр том бүс зэрэгцэн оршиж байсан нь археологийн судалгаагаар тодорхой болсон. Өөрөөр хэлбэл, гарал үүсэл, ёс заншлаар харилцан өөр бүлгүүд гэсэн үг болно.

Баруун хэсгээр нутаглаж байсан нүүдэлчид бол хиргисүүр, буган хөшөө үлдээгчдийн соёл гэж нэрлэгдэх уг соёл маань Хангайн нурууны ар биеэр илүү нягтралтай тархсан бөгөөд зүүн тийш ховордсоор Хэнтийн Биндэр сумын нутаг хүрдэг. Үүнийг буган чулуун хөшөө, хирэгсүүрийн тархалтаар тооцоолж болно. “Түрүү болон хөгжингүй хүрэл зэвсгийн үед Алтай даван түрж ирсэн индо-аричуудын үлдэц хийгээд Мөнгөн тайгын гэх мэтээр нэрлэгддэг.” (*Археологич, доктор, профессор С.Өлзийбаяр “lead.style”*)

архелогич Т.Идэрхангай илрүүлсэн юм. Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт эртний Хүн гүрний хүмүүний ген, соёл, зан үйл хадгалагдсаар байна.

Сянби (150-318)

Үндэслэгч нь Таньшихуай. Хүннү улсын дараа НТ II-III зуунд Төв Азийн улс төрийн тавцанд Сяньби улс гарч ирсэн бөгөөд тэд Хүннү нартай гарал нэгтэй Сүмбэ нэртэй эртний Монгол угсаатны аймаг юм. Эртний Монгол хэлт аймгуудын томоохон холбоо нь одоогийн Манжуур, Өвөрмонголд нутаглаж байв. Оросын эрдэмтэн Л.Викторова зэрэг эрдэмтэд Сяньбичууд Эрчис мөрнөөс Хянганы нуруу хүртэл тархан суурьшсан байсан гэж үздэг.




Зураг 5: Сянби улсын газар нутаг

Нирун (330-555)

Үндэслэгч нь Шэлунь Хаган. “Язгуур монголчуудын шууд өвөг, нирунчуудыг зарим түүхэнд хүннүгээс, зарим сурвалжид дунхугаас (сяньбигаас) гаралтай гэж бичжээ.

(Г.Сүхбаатар, "Их Нирун Улс") Нирунчууд Морио хуягладаг байсан тухай олон ном сурах бичигт дурьджээ. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутаг дахь Цамбагарав уулын хадан дээрх сүг зурагт Жужаны хуяглагдсан Морин цэргийн тухай дүрслэгдсэн байдаг. “438-489 онд бурхны шашны судар, гүн ухааныг тайлж чаддаг эрдэмтэн лам нарыг төрийн багшаар томилж 3000 өрх айлын дунд бурхны шашинг дэлгэрүүлж байжээ. Бичиг үсэгтэй, бичгийн түшмэлтэй, харьцангуй өндөр соёлтой байсан бөгөөд төв нь Хангай нурууны хавьд төвлөрч байв.

Жужаан(Нирун) газар нутаг




Зураг 7: Түрэг (555-745)

Уйгар (745-840)

Үндэслэгч нь Күтлүг Билэг Кэл. МЭӨ 740 оны үед Түрэг улсын захиргаанд байсан уйгарууд бослого гарган өөрийн улсыг байгуулан 100 орчим жил оршин тогтносон байна. Цэрэг айрам нь баруун зүүн хоёр анги байсан бөгөөд өөрийн бичиг үсгээс гадна хятад, согд бичгийг ашиглаж, албан хэрэг хөтлөн ном зохиол бичиж, гадаад хэлнээс судар шастир орчуулан дэлгэрүүлж байсан түмэн сурвалж байдаг байна. Уйгурын хаант улсын нийслэл бол Хар балгас юм. Архангай аймгийн Хотонт сумын нутагт бий.

Уйгар улс газар нутаг



Зураг 8: Уйгар улс газар нутаг


Кидан (907-1125)

Үндэслэгч нь Амбагян. Кидан үндэстэн нь анх Лууха голын баруун талаар, Шар мөрний умард саваар нутаглаж байсанаа яваандаа өргөжин тэлж Шар тэнгисийн эрэг хүртэлх нутагт тархан суужээ. Тэд Сяньби нарын адил дорнод ху нарын удам

байсан ба Алтайгаас зүүн тийш Хэрлэн голын хойт бие хүртэл нутгаа тэлж соёл, түүхийн олон зүйл дурсгал Монгол нутагт үлдээжээ.

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг дахь Хэрлэн барс гэдэг хааш хаашаагаа 1800 метр талбай эзэлсэн хотын үлдэгдэл нь Хятаны Дун Чен хот байсныг судлаачид тогтоожээ.

Киданы газар нутаг



Зураг 9: Киданы газар нутаг

Их Монгол улс (1206–1405)

Үндэслэгч нь их эзэн Чингис Хаан. Эртний нүүдэлчид дундаасаа онцгойрч 2,5 сая хүн амтай, 250 мянган цэрэгтэй атлаа Дэлхийн Талийг буюу 33 сая км² дөрвөлжин газар дээрх дөрвөн том шашин шүтлэгтэй 100 сая гаруй иргэдийг нэгтгэн зангидаж чадсан улс юм. Их Монгол улсын нийслэл нь Хархорум хот юм. Чингис хаан 1220 онд Их Монгол улсын нийслэл хотыг Аураг ордноос тус хотод шилжүүлэхийг зарилагдаж. Өгэдэй хааны үеэс албан ёсны нийслэл хот болсон юм. Хархорум хот нь Хубилай хаан хаан ширээнд суух хүртэл Их Монгол улсын нийслэл хот байв.



Зураг 10: Монголын хүн амын угсаатан

2.2 Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор МУ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг 2015 оны 11-р сард баталсан. 2016 оны 2-р сард УИХ-ын тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (ТХҮБ-2030)-ыг баталсан. Дэлхийн ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилт нь манай улсын ТХҮБ-2030-ын 4 бүлэг, 44 зорилттой уялддаг.



НИЙГЭМ



ЭДИЙН ЗАСАГ



БАЙГАЛЬ ОРЧИН

НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс

болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ. Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:

- Хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх;
- Иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;
- Эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байх;
- Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах;
- Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэх;
- Нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;
- Нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;
- Нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх.

ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах макро эдийн засаг, салбарын хөгжлийн бодлого нь дараахь суурь зарчимд тулгуурлана:

Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим:

- Урт хугацааны эдийн засгийн дундаж өсөлтийг 6.6 хувиас доошгүй байлгах;
- Нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах, төсвийн тэнцлийн алдагдалын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ 2020 онд 15 хувь, 2025 онд 10 хувь хүртэл бууруулах;
- Гадаад зах зээлийн болон түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзлээс сэргийлэх бодлогыг баримталж, хуримтлалын санг бий болгон арвижуулах;
- Гадаад валютын нөөцийн зохистой хэмжээг байнга бүрдүүлж байх;
- Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн шинжтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлэх;
- Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах.



Зураг 11: тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын уялдаа

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгаль орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг сайжруулах үндэс болно. Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах зарчим: байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах;

- Байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах; цэвэр технологийг дэмжих,
- Хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төлөвшүүлэх;
- Байгаль орчны нөхөн сэргээлтийг олон улсын стандартын түвшинд хийж, хэвшүүлэх;
- Байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх
- Усны нөөцийн нэгдсэн менежмент- Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.
- Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл,

байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.

- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна.
- Экосистемийн тэнцвэрт байдал- Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.
- Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тогтвортой засаглал мөн. Тогтвортой засаглалыг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын үзэл баримтлал, батлан хамгаалах номлолын дагуу улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино.




Зураг 12: Тогтвортой хөгжлийн зорилт

Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим:

- Төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах;
- Хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;
- Удирдлагын ил тод байдлыг хангах;

Төвлөрлийг **сааруулж**, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;

- Төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авлигыг арилгах.
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ.
- Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.
- Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.
- Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.



Зураг 13: Тогтвортой хөгжлийн зорилт

2.3 Засгийн газрын мөрийн хөтөлбөр



Улсын Их Хурлын ээлжит 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнд МАН олонхийн саналыг авч ялалт байгуулсан нь Монгол Улсын Засгийн газар бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломж гарч байна. Говь-Алтай аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын бичиг 2021-

2031 Засгийн газраас дэвшүүлсэн хөгжлийн зорилго, зорилтуудыг тусгасан болно.

ЗАСГИЙН ГАЗРААС АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Аялал жуулчлалын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээг БОДЛОГЫН БИЧИГ-д төлөвлөсөн болно. Үүнд:

- Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг **бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж**, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэх, **бүтээгдэхүүн, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах** цогц бодлого хэрэгжүүлнэ.
- Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, **аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж** хэрэгжүүлнэ.
- Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлж, хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно.
- Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу **байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг** дэмжинэ.
- **Олон улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, туршлага, стандартыг нэвтрүүлэх, нутагшуулах**, олон талт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий судалгаа шинжилгээний орон тооны бус зөвлөл, нэгжийг байгуулна.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО



Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно.

Засгийн газраас дэвшүүлсэн “Байгаль, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийн” чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан болно. Үүнд:

- Хүний эрүүл мэнд, хүрээлэн **байгаа орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлж, нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулан ашиглах** ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- **Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж**, нүүрс боловсруулж ашиглах шинэ технологи нэвтрүүлэн, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үйлдвэрлэл, бизнесийг олон улсын хамтын ажиллагааны хүрээний дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.
- **Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх** цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.
- **Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах**, дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлэх, байгаль орчин, уур амьсгалын санг байгуулж, үндэсний чадавхыг бэхжүүлнэ.
- “Тогтвортой хөгжлийн боловсрол” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, **олон нийтэд эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэх мэдлэг олгож, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.**
- Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, **байгальд ээлтэй аялал жуулчлал, ногоон хөгжлийн түшиц газар** болгон хөгжүүлнэ.

- Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, **хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг** дэмжинэ.
- **Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж**, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулж ус хангамжийг нэмэгдүүлнэ.
- **Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж**, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ.
- Байгаль орчинг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, **ашиглалтын үр өгөөжийг** сайжруулна.
- Устах аюулд орсон болон аж ахуйн гоц ашигт амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, **тарьж ургуулах ажлыг** хөрөнгө, санхүү, татварын бодлогоор дэмжинэ.

ЗАСГИЙН ГАЗРААС БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АЖИЛД БҮХ НИЙТИЙН ХАМТЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх ажил эрхэлж байгаа **иргэн, нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих** эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлж, орон нутагт ажлын байр, орлогын нэмэлт эх үүсвэр бий болгох ажлыг зохион байгуулна.
- Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, **гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах**, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.
- **Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийг эмхлэн зохион байгуулж**, орчны хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлж, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд хүрэх мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулна.

Дээр дурдсан зорилтуудын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэх стратегид тусгасан болно. Эдгээр нь:

- Алсын хараа 2050, Тогтвортой хөгжлийн бодлого зэрэг хөгжлийн бодлого, Говь-Алтай аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасны дагуу аяллын хөтөлбөрүүдийг байнга сайжруулах, байгаль орчинг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлэх
- Үндэсний паркийн дүрэм, журам, дэгийг сурталчлах, таниулах, журмыг заавал мөрдүүлж байгаль орчныг бохирдуулахгүй, сөрөг нөлөөллийг үүсгэхгүй байх, нөхөн сэргээх ажлыг тогтмол зохион байгуулах
- Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаатай хамтран ажиллаж сумдын иргэдийн нөхөрлөлийн бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэлт хийж, орон нутгийн иргэдийг дэмжсэн, байгалийн унган тархийг хадгалж, хамгаалж, нөхөн сэргээсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Говь-Алтай аймагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бусад бодлого хөтөлбөрүүдийн дагуу иргэдийн аялах, жуулчлах зан төлөв, байгальд мөргүй аялах аяллын боловсролыг дэмжих, сурталчлах, таниулах үйл ажиллагааг зохион байгуулах
- Хүн, ам зүй, нийгэм соёлын нөлөөллийн ажлыг зохион байгуулах замаар иргэд болон төрийн байгууллагуудын харилцан ойлголцлыг бий болгох хүрээнд төлөөллийн байгууллагуудыг дэмжин ажиллах замаар нэр хүнд, нөлөөг бий болгох
- Аялал жуулчлалын гол чиглэлийн зам дагуу түр буудаллах болон боловсон ариун цэврийн байгууламж, хогийн цэгүүдийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шаардлагатай байршилд байгуулах
- Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн байгууллагуудад ногоон гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулж дэмжлэг үзүүлэх
- Аялал жуулчлалын салбарт мөрдөж байгаа стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хяналтын механизмыг тусгав.
- Байгаль, цаг уур, газар зүйн болон эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хяналтыг сайжруулах
- Иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, боловсролыг нэмэгдүүлж, зөв зохистой аялах дадал, соёлыг нэвтрүүлэх
- Цөлжилтийн бүсүүдийг шинэчлэн тогтоож, цөлжилтийн эсрэг зохион байгуулалттай арга хэмжээ авах
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр иргэд, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудтай хамтран, тэдгээрийн санал, үйл ажиллагааг дэмжиж ажиллах

- Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлэх;
- Байгаль орчинд учруулсан хохирлыг эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан арилгах бодлогыг хэрэгжүүлэх
- Газрын нөөцийн менежментийг сайжруулж, газар зохион байгуулалтын орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах
- Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, тариалангийн талбайг тойруулж ойн зурвас тарьж ургуулах, таримал болон тэжээлийн, эмийн ургамал тариалах замаар ашиглах
- Усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах, чиглэлээр олон нийтийг хамарсан сурталчилгааг зохион байгуулах
- Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоог нэмэгдүүлэх
- Загасны нөөц, байршлыг тогтоох агнуур зохион байгуулалтын ажлыг сайжруулах
- Байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлалт аргуудыг өргөн хэрэглэх
- Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг эхний ээлжинд хамгаалах, нөхөн сэргээх
- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах
- Элсний нүүдлийг зогсоох, говийн ургамалжилтыг нөхөн сэргээхэд ашиглаж болох ургамлуудыг (заг, жигд, хайлаас, харгана, бүйлс, хотир, саваа мод гэх мэт) тодорхой үе шаттайгаар сонгон тариалах
- Мал ихээр бөөгнөрч бэлчээр талхлагдахаас урьдчилан сэргийлэх
- Сул хөрсийг тогтоох, ургамалжуулах талаар гадаад орнуудын дэвшилтэт технологийг судалж нэвтрүүлэх
- Цөлжилттэй тэмцэх ажилд нутгийн санаачлагатай иргэд болон ажилгүй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- Цөлжилттэй тэмцэх төслүүдийг боловсруулан гадаад, дотоодын хандивлагч байгууллагуудад хандан хэрэгжүүлэх арга хэмжээ авах

2.4 Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр

Говь-Алтай аймгийн хувьд байгалийн унаган төрх, түүх соёлын дурсгалт зүйлс, нэн ховор, ховор амьтан, ургамал, тэдгээрийн тархац нутгийг хамгаалах, газрын доройтлыг нөхөн сэргээх зорилгоор аймгийн нийт нутаг дэвсгэрийн **4212624,3** га буюу **29.78** % нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт, **1765137.23** га талбай буюу **12.47** %-ийг нь орон нутгийн тусгай хамгаалалтад тус тус аваад байна.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, судалгаа шинжилгээ явуулах, экотуризм хөгжүүлэх зорилгоор Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргаа, Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн хамгаалалтын захиргаа, Монгол элсний УТХГН-ийн хамгаалалтын захиргаад үйл ажиллагаа явуулж байна. Монгол орны байгаль харьцангуй унаган төрхөө хадгалж үлдсэн хэдий ч аж ахуйн зохисгүй үйл ажиллагаа, байгаль орчны хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан нийгэм, эдийн засаг, байгаль орчны тэнцвэрт харьцаанд үлэмж өөрчлөлт орж, байгаль орчин бохирдох, зарим газарт экологийн тэнцэл алдагдах хандлага ажиглагдаж байна. Сүүлийн 40 гаруй жилд ховор ан амьтан, ургамлын зарим төрөл зүйл устах, бэлчээр талхлагдан хөрсний үржил шим муудах, цөлжих, ой, усны нөөц хомсдох, хот суурингийн агаарын бохирдол ихсэх зэргээр амьдрах орчны чанар доройтож байна. Иймд нийт орны нутаг дэвсгэрийн хэмжээнд эрчимтэй ашиглалтын болон хамгаалалтын газар нутгийн оновчтой харьцааг тогтоосны үндсэн дээр цаашдын хөгжлийн төлөвийг томъёолох шаардлагатай болж байна. Монгол Улс дэлхийн шим мандлын өвөрмөц бүрдэл хэсэг болсон экологийн эмзэг орчин бүхий унаган байгалиа хамгаалах, түүндээ зохицсон уламжлалт аж ахуйгаа хүн төрөлхтний соёл иргэншлийн нийтлэг ололтоор баяжуулан хөгжүүлэх үүднээс экологийн тэнцлийг хангахад онцгой нөлөө бүхий газар нутгаар төрийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг үе шаттайгаар өргөжүүлж байна. 1995 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1997 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийг тус тус баталж, газар нутгийг хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг хууль зүйн хувьд зохицуулах нөхцөл бүрдсэн боловч тусгай хамгаалалттай газар нутгийн талаар баримтлах урт хугацааны цэгцтэй бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн эрх зүйн хүрээнд

Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн зорилго нь Монгол орны экологийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдол бүхий газар нутгийг хамарсан тусгай хамгалалттай газар нутгийн сүлжээг өөрийн орны өвөрмөц нөхцөл байдал болон олон улсын жишиг, хандлагад нийцүүлэн хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтооход оршино гэсэн заалтыг бодлогын бичигт тусгасан болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг чиглэл болгон баримталсан. Үүнд:

- Хөтөлбөр нь байгаль, орчныг хамгаалах бусад хөтөлбөр, нийгэм, эдийн засаг, бүс нутгийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагаатай уялдан, харилцан зохицсон байх;
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд өргөнөөр оролцох нөхцөл бүрдүүлж, тэдний хувь нэмрийг хөхүүлэн дэмжих;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монгол орны өргөн уудам нутгийн байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөл, аж ахуй эрхлэх онцлог, иргэдийн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан уян хатан байх.

Тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи бодлогын чиглэлийг тусгав. Эдгээр нь:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс нутгийг экологийн баримжаатай тогтвортой хөгжлийн загвар нутаг болгон хөгжүүлнэ.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн баялгийн ашиглалтыг экологийн даацад нийцсэн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй хэлбэрээр явуулах нөхцөл бүрдүүлнэ.
- Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажил нь байгалийн зүй тогтол, экологийн үйл явцыг танин мэдэх, тухайн газар нутгийн менежментийн үйл ажиллагааны үндэслэл болоход чиглэгдсэн байна.
- Тусгай хамгаалалттай газар нутаг болон түүний орчны бүсэд амьдарч буй хүмүүсийг тухайн нутгийн төлөвлөлт, хамгаалалтын үйл ажиллагаанд өргөнөөр хамруулан, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Байгалийн баялгийн ашиглалтаас олж буй аливаа ашиг, орлогын тодорхой хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчин доройтохоос

урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулдаг журамд шилжинэ.

- Байгалийн гоо үзэсгэлэн хэмээх нөөцийг байгалийн аялал, жуулчлал хөгжүүлэх замаар аж ахуйн эргэлтэд оруулж, түүнийг байгаль хамгаалах нэг гол хэрэгсэл болгон ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг хөгжүүлэхэд гадаад улс, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- Тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох мэдээлэл, сурталчилгааны сүлжээг бий болгож үйл ажиллагааг нь тогтмолжуулах;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь менежментийн төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажилд нутгийн иргэдийг татан оролцуулах нөхцөл бүрдүүлэх;
- Газар нутгийг тусгай хамгаалалтад авснаар нутгийн иргэдээс байгалийн баялгийг ашиглах хязгаарлалтын хэмжээг тогтоож, түүнийг нөхөх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Нэгдсэн Үндэстний байгууллагын төрөлжсөн байгууллага, олон улсын бусад байгууллага, гадаад орнуудтай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх;

2.5 Говь-Алтай аймгийн тусгай хамгаалалттай газар

2.5.1 СУТАЙ ХАЙРХАН (ТӨРИЙН ТАХИЛГАТ УУЛ)


Сутай хайрхан уулын ихэнх нь Говь-Алтай аймгийн Тонхил сумын нутагт оршдог боловч цаад талаараа Ховд аймгийн Дарви, Цэцэг сумын нутагт хамаарах хайрхан юм. Ноён оргил Цаст богд нь д.т.д 4234 метр өндөр бөгөөд Сутай хайрхан уул 60 км сунаж тогтсон. 2000 онд Сутай хайрханд уулчин авирч энэ өндрийг тогтоосон. Араараа хар модон ойтой, Монгол Алтайн нурууны 13 мөнх цаст уулсын нэг. Хайрханы өврөөс Усан зүйлийн гол эх авч Тонхил нуурт цутгана. Сутай хайрханы өвөрт байх нэг бага шиг өндөрлөг дээр эрт үеэс тахиж ирсэн Их овоо бий. 2007 оны 7-р сарын 26-нд Ерөнхийлөгч Н.Энхбаярын 183 тоот зарлигаар Их овоог тахиж Сутай хайрханыг төрийн тахилгатай болгосон бөгөөд 2008, 2012, 2016, 2020 онуудад үйлджээ. Сутай уулын мөнх цаст оргилоос олон гол эх авч урсдагийн дотроос хамгийн үзэсгэлэнтэй нь улиас, бургас, хар модон төгөл ойтой Цагаан голын уулзвараас эх авсан Мөрөнгийн голын хөндий юм. Уг

хөндий 50 гаруй км үргэлжилж Хөвхөрийн хойд үржил шимт хөрсийг усжуулан хадлан, тариалангийн арвин ургац бүхий нугыг тэтгэдэг. Сутай хайрханы тухай олон янзын домгууд бий. Тэдгээрээс өгүүлбэл, Цаст Гималайн уулсаас тасарч Алтайн нурууны нэг хэсэг болон Баатар хайрхан уулын зүүн талд урган тогтсон ажээ. Эрт цагт хүмүүс уулнаас зэрлэг үхэр буулган гаршуулж, сүүг нь саан ахуй амьдралдаа хэрэглэдэг байснаас үүдэн Сүүтэй уул хэмээн нэрлэдэг байсан нь он цагийн аясаар “Сутай” болон хувирчээ. Өөр нэгэн домогт, Сутай нутагт унааны ганц морьтой ирсэн харь хошууны нэгэн ард нутгийн олноос цөөн тооны хонь худалдан авч өсгөөд хот дүүрэн хоньтой болжээ. Энэ явдлаас үүдэн Сутай хайрханыг ерөөхдөө “халзан цагаан хонин сүргийн өлзий хишиг дүүрэн Сүмбэр цагаан Алтай юм аа” гэж хэлдэг болжээ.

2.5.2 Говийн их дархан цаазат газрын А хэсэг

Хамгаалалтад авсан үндэслэл

Цөлийн бүсийн эмзэг экосистемийг унаган төрхөөр нь, нэн ховордсон амьтан ургамлыг амьдрах орчинтой нь хамгаалахын сацуу, түүх, соёлын өвийг хамгаалах, танин мэдэх, зохистой ашиглах, улмаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Говийн Их дархан цаазат газрыг 1976 оны АИХ-ын Тэргүүлэгчдийн 283 дугаар зарлигаар улсын тусгай хамгаалалтанд авсан билээ.




Зураг 14: Говийн Их дархан цаазат газар А

Монгол оронд төдийгүй дэлхийд ховорт тооцогдох мазаалай, хавтгай, хулан, хар сүүлт, аргаль, янгир зэрэг хөхтөн болоод жороо тоодог, хулан жороо зэрэг шувууд, махир хуруут геккон, замба гүрвэл, тэмээн сүүл могой зэрэг ховор амьтад орших энэ нутгийн олон улсын ач холбогдлыг нь харгалзан 1991 онд ЮНЕСКО-ийн шийдвэрээр Олон улсын шим мандалын нөөц газрын сүлжээнд хамруулсан билээ. Говийн Их дархан цаазат газар нь “А, Б” гэсэн хоёр хэсгээс тогтох ба нийтдээ 5.3 сая га талбайг эзэлж талбайн хэмжээгээрээ дэлхийд 15-д ордог байна.

2.5.3 Говийн их дархан цаазат газрын Б хэсэг

Хамгаалалтанд авсан үндэслэл

Цөлийн бүсийн эмзэг экосистемийг унаган төрхөөр нь, нэн ховордсон амьтан ургамлыг амьдрах орчинтой нь хамгаалахын сацуу, түүх, соёлын өвийг хамгаалах, танин мэдэх, зохистой ашиглах, улмаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Говийн Их дархан цаазат газрыг 1976 оны АИХ-ын Тэргүүлэгчдийн 283 дугаар зарлигаар улсын тусгай хамгаалалтанд авсан билээ. Алтайн өвөр говь нь хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөнд бага өртөж унаган төрхөөрөө хадгалж үлдсэн говь цөлийн экосистем бөгөөд амьтан, ургамлын зүйлийн бүрдлийн хувьд дэлхийн ач холбогдол бүхий онцгой газарт тооцогдоно.




Зураг 15: Говийн Их дархан цаазат газар Б

2.5.4 Хасагт хайрхан уулын дархан цаазат газар

Хамгаалалтанд авсан үндэслэл

Хасагт Хайрхан уул нь Говь-Алтай аймгийн Шарга, Жаргалан, Баян-Уул, Тайшир сумдын нутагт Их Нууруудын хотгор руу гүн түрж орсон Алтайн салбар уулсын нэг билээ. Энэ уулын буга, аргаль, янгир, ирвэс зэрэг ховор ан амьтдын өлгий нутаг бөгөөд байгалийн үзэсгэлэнт байдлыг хамгаалах зорилгоор 1965 онд онд АИХ-ын Тэргүүлэгчдийн 17 дугаар зарлигаар дархан газар болгожээ. Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор дархан цаазат газрын ангиллаар баталгаажуулжээ. Талбайн хэмжээ нь 27448 га.




Зураг 16: Хасагт хайрхан уулын дархан цаазат газар

2.5.5 Ээж уулын байгалийн дурсгалт газар

“Ээж Хайрхан уул” нь манай орны баруун өмнөд хязгаарт орших өвөрмөц тогтоцтой байгалийн үзэсгэлэнт газрын нэг бөгөөд Говь-Алтай аймгийн Цогт сумын нутагт оршино.

Байгалийн дурсгал болохоос гадна түүхийн дурсгал болсон Ээж Хайрхан уулыг 1992 онд УБХ-ын 11-р тогтоолоор тусгай хамгаалалтанд авч улмаар Монгол Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолоор байгалийн дурсгалт газар болгон улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамрагдсан. Нийтдээ 22475 га талбайг эзэлнэ. “Ээж Хайрхан уул” нь уулс хоорондын цөлөрхөг хотгорт орших пермийн галавын настай цайвардуу ягаан өнгийн дунд ба жижиг ширхэгт боржин чулуунаас тогтсон нүцгэн цулдам, хад чулуурхаг өнчин уул юм.



Зураг 17: Ээж уулын байгалийн дурсгалт газар

Ерөнхий төрх нь хойноос урагш өндөршиж сунасан майхан хэлбэртэй, цац суварган оргилтой. Хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2274 м өндөрт өргөгдсөн бөгөөд дундаж өндөр нь 1600 м болно. Уулын аль ч өндөрлөгийн хажуу дунджаар 50 орчим градусын налуу бөгөөд элгэн улаан хаднаас тогтжээ.


Ялангуяа гол оргилын урд тал ихээхэн шовх, түүний орой хэсэгт жигүүртнээс өөр амьтан гарах боломжгүй эгц цавчим халил цохиотой. Мөн цөлийн гандуу хуурай нөхцөлд орших тул гадарга нь цөлийн өгөршилд автаж бараан өнгөтэй болсон байна.

2.5.6 Монгол элсний байгалийн дурсгалт газар

Байгаль орчны тэнцлийг хангах, унаган төрхийг хадгалах, хамгаалах болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын 234400 га, Баян-Уул сумын 85600 га, Жаргалан сумын 29200 га хамарсан Монгол элсны орчмын нийт 349200 га газар нутгийг УИХ-ын 2010 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 06 дугаар тогтоолоор байгалийн цогцолборт газрын ангилалаар авсан байна.

Монгол элс нь Завхан голын хөндий дагуу баруун, баруун хойноос зүүн, зүүн ургаш чиглэн 300 шахам км үргэлжлэн тогтсон элсэн хуримтлал юм.

Элсэн хуримтлалд бөөрөг, хонхорт бөөрөг, манханжсан хонхорт бөөрөг манхан хэлхээ, цац суварган оргил бүхий өндөр манхан, бүрхэвч зэрэг элсэн хуримтлалд ялгарах хотгор гүдгэрийн бүхийл хэлбэрүүд байдаг бөгөөд Монгол элсний хойд захаар Завхан гол эмжин урсахын хамт Эрээн, Ажиг, Сангийн далай, Гүн зэрэг олон нуур тогтсон байдаг нь байгалийн үзэсгэлэнт байдал Эко системийн өвөрмөц хослолыг бий болгожээ, Монгол элсний байгалийн цогцолборт газар нь нийт 451800 га талбайтай. Үүнээс Говь-Алтай аймгийн Хөхморьт сум 234400 га буюу нийт талбайн 52.0 % Баян-Уул сум 85600 га буюу нийт талбайн 19% Жаргалан сум 29200 га буюу нийт талбайн 6.3 % Завхан аймгийн Алдархаан сум 24000 га буюу нийт талбайн 5.1 % Дөрвөлжин сум 77600 га буюу нийт талбайн 17.6 % -ийг тус тус эзэлнэ.



Зураг 18: Монгол элсний байгалийн дурсгалт газар


2.5.7 Алагхайрхан уулын байгалийн нөөц газар

Алаг хайрханы БНГ-ын байршил, байгуулагдсан түүх, зорилго

Говь-Алтай аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт орших Алаг хайрхан уул нь аргаль, янгир, ирвэс, шилүүс, хойлог зэрэг ховор ан амьтад тархсан, вансэмбэрүү, юмдүүжин, сэржмядаг, бамбай, нохойн хошуу, зэрэг эмийн ургамал ургадаг Алтайн

нурууны дунд хэсгийн өндөр уулсыг төлөөлдөг байгалийн үзэсгэлэнт нутгуудын нэг юм.УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах мөн ховор, ховордсон амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад бүртгэн авсан.

Алаг хайрхан уулын хажуу эгц бөгөөд эртний мөстлийн үеийн мөсөн голын нөлөөгөөр үүссэн хунх, тэвшин хөндий элбэг. Энэ нутаг нь Алтайн уулт өндөрлөгийн мужид багтдаг бөгөөд Бүс, Барзан, Алаг хайрхан, Буга хайрхан, Бага хайрхан зэрэг салбар уулсаас тогтдог. Энэ уул нь зүүн талаасаа маш хэц, энэ



Зураг 19: Алагхайрхан уулын байгалийн нөөц газар

уулын орой дээрээс Ховд аймгийн Баатар хайрхан, Завхан аймгийн Отгонтэнгэр, Говь-Алтай аймгийн Сутай хайрхан, зэрэг мөнх цаст уулс, Шарга, Цэнхэр номин, Хонь усны говиуд тод харагддаг. Алаг хайрхан уулын ноён оргил нь д.т.д 3738 м өндөрт оршдог бөгөөд Бугат сумын олон гол, горхи, булаг, шандууд энэхүү уулнаас эх авч урсдаг.

Алаг хайрхан уулын байгалийн нөөц газар нь 36400 га талбай бүхий газар нутгийг хамардаг.

Уур амьсгал: Байгалийн эрс тэс уур амьсгалтай, хур бороо бага, жилд унах тундасны олон жилийн дунджаар 71.5 мм, жилийн хамгийн дулаан 7 дугаар сард 36 хэм, хамгийн хүйтэн 1,2-р сард 40 хэм хүртэл хүйтэрдэг.


2.5.8 Бурхан буудай уулын байгалийн нөөц газар

Хамгаалалтанд авсан үндэслэл

Говь-Алтай аймгийн Бигэр, Цогт, Халиун сумдын нутагт орших Бурхан буудай уулын өвөрмөц үзэсгэлэнт тогтоц, эртнээс шүтэж ирсэн уламжлалыг хадгалан үлдээх, ашиглалт, хамгаалалтыг зүй зохистойгоор явуулах зорилгоор УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авсан байна. Нийт талбайн хэмжээ 52110га.

Газарзүйн онцлог

Бурхан буудай уул нь Монгол Алтайн бөөн цулдам уулт өндөрлөгийн мужийн уулын нуга, уулын хээрийн дэд мужид багтдаг бөгөөд ноён оргил нь 3765м өндөр мөнх цастай уул юм. Уулын их бие, ам хөндийд эртний мөстлийн ул мөр болох хотгор гүдгэрийн тавцан дэнж, хунх нилээд их байхын зэрэгцээ асга нуранги ихтэй. Бурхан буудай уулнаас Урд гол, Дунд гол, Хойт гол, Уст чацран голууд эх авч урсдаг.



Зураг 20: Бурхан буудай уулын байгалийн нөөц газар

2.5.9 Шаргын нөөц газар

Хамгаалалтад авсан үндэслэл


Монгол бөхөнг хамгаалах зорилгоор Монгол орны баруун хэсэг дэх бөхөнгийн хоёр популяцийн байршил нутгийг 1993 оны УИХ-ын 83-р тогтоолоор Шарга-Манханы байгалийн нөөц газрыг бий болгож улсын тусгай хамгаалалтанд авчээ. Шарга-Манханы байгалийн нөөц газар нь Говь-Алтай аймгийн Шарга, Төгрөг, Тонхил, Дарви, Халиун сумдын нутгыг хамарсан Шаргын говийн хэсэг, Ховд аймгийн Буянт, Манхан сумын нутгыг хамарсан Манханы хэсэг гэсэн хоорондоо холбоогүй 200-аад километр зайтай тусгаарлагдсан нийт 390071 га талбайг хамарна.

Газарзүйн онцлог

Шаргын говь нь Монгол алтайн уулсын төв хэсэг рүү түрж орсон, Шаргын цагаан нуурыг тойрсон хужир марз бүхий хотгортой, цөлөрхөг, чулуу хайргархуу хөрс бүхий тэгш тал газар бөгөөд ландшафтын бүс, бүслүүрийн зүй тогтол богино зайд тод илэрдэг онцлогтой бүс нутаг юм.

Монгол бөхөн

Шарга-Манханы байгалийн нөөц газрын голлох амьтан нь монгол бөхөн юм. Монгол бөхөн Дэлхийн байгаль, байгалийн нөөцийг хамгаалах олон улсын холбооноос (IUCN, амьтан, ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай олон улсын конвенцийн (CITES) II хавсралтад (1995) буюу хатуу чанд хяналтан дор худалдаалах амьтдын жагсаалтад бүртгэгдсэн. Монгол улс бөхөнг 1930 оноос эхлэн хуулиар агнахыг хориглон дархан цаазтай амьтны тоонд оруулсан. Мөн “Монгол улсын Улаан ном”-ын 1987, 1997 оны хэвлэл, 1995 оны шинэчлэн найруулсан Ан агнуурын тухай “Монгол улсын хууль”-иар нэн ховор ангилалд оруулан агнахыг хатуу хориглосон.



Зураг 21: Шаргын нөөц газар

2.5.10 Хар Азаргын нурууны байгалийн нөөц газар


Хар Азаргын нуруу нь Говь-Алтай аймгийн Цээл, Халиун сумын нутгийг дамнан оршдог бөгөөд монгол орны шинэсэн ойн тархалтын хамгийн өмнөт хил болдог. Хар Азаргын нурууны ойн сан бүхий газар 30 000 орчим мян/га талбайтай. Халиуны хоолой, Шаргын Цагаан нуурын усыг хөрсөн доогуур тэтгэж байдаг Урд, Дунд, Хойд Улиастай, Бургаст, Бор гол, Салааны гол, Цагаан гол, Цангилахын голууд эх авдаг голуудын сав нутаг. Эдгээр голуудын ус нь говийн байгалийн оршин тогтнох үндэс болж байдаг юм.

Хар Азаргын нурууны ар бэл, хойд хоолойд Говь-Алтай аймгийн нийт заган ойн 8 хувь тархдаг бөгөөд энэ заган ойн бүхий нутаг шинээр тусгай хамгаалалтанд авсан байгалийн нөөц газрын хилд орж байгаа юм. Хар Азаргын нурууг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авснаар Монгол Алтайн нурууны байгалийн өвөрмөц сонин тогтоцтой ландшафтын хуурай хээр, цөлжүү хээрийн бүсийн ландшафтын хослолыг тэнд оршин амьдрах буга, ирвэс, аргаль, янгир, шилүүс зэрэг монголд төдийгүй дэлхийд ховордож буй ан амьтадтай нь

ойн сан бүхий нутгийн голуудын эх, голын сав нутгийг хамгаалах боломж бүрдэж байгаа юм. Мөн ландшафтын иж бүрдлийг хамгаалахын зэрэгцээ, энэ нурууны түүх, соёл, шашны дурсгалуудыг хадгалан хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэх болно.


Хар Азаргын нурууг байгалийн нөөц газрын ангиллаар улсын хамгаалалтанд авснаар Монгол Алтайн уулсын экосистемийн унаган төрх, тэнцвэрт байдлыг хадгалах байгалийн өвөрмөц тогтоц, онцлогийг судлах, бусад нутгийг хамгаалах, зүй зохистой ашиглах загвар нутаг болгох, улмаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах ач холбогдолтой. Хар Азаргын нуруу нь Монгол Алтайн нурууны цувраа уулсын системийн үндсэн нуруу юм. Энэ нуруу нь хавтгайдуу бөмбөгөр оройтой эгц хажуу бүхий дундаж өндөр уулс, тэдгээрээс эх аван урсах голуудын хөндий хослосон томоохон нуруу юм. Далайн түвшнөөс дээш дунджаар 2500-3100 метр өндөр өргөгдсөн баруунаас зүүн тийш 70 гаруй км сунаж тогтсон хамгийн өргөн газраа Баян-Өндөрийн овооны нуруу орчим 26 км өргөн, хамгийн нарийн газраа Бор гол орчим нарийн хэсгээрээ 10 км өргөн юм.

Хар Азаргын нурууг УИХ-ын 2012 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар тогтоолоор байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авсан бөгөөд 192,5 мянган га талбайтай.



Зураг 22: Хар Азаргын нурууны байгалийн нөөц газар

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН
ТУСГАЙ ХАМГААЛАЛТАНД АВСАН ГАЗАР НУТГИЙН
БАЙРШЛЫН ЗУРАГ



Зураг 23: Тусгай хамгаалалтанд авсан газар нутаг

2.5.11 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн тоо



Зураг 24: Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн тоо

Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018 он, УБ хот

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт дараах агуулгыг тодорхойлсон байна. Үүнд:

1. Олон улс, бүс нутгийн аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага

Аялал жуулчлалыг нэгдсэн төлөвлөлт, сайн менежментийн үндсэн дээр хөгжүүлж чадвал тухайн орны эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэн, ажлын байр бий болгодог, дотоодын үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг өсгөдөг салбар юм. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан “Аялал жуулчлал-2020 он” судалгаанаас үзэхэд XXI зуунд аялал жуулчлалын дараах төрлүүд эрчимтэй хөгжиж байна:

- Адал явдалт аялал жуулчлал;
- **Эко аялал жуулчлал;**
- **Тусгай сонирхлын аялал жуулчлал;**
- **Тойрон аялал;**
- **Соёл-танин мэдэхүйн аялал жуулчлал;**

- Хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн аялал жуулчлал
- Эрүүл мэндийн аялал жуулчлал

Хөтөлбөрийн зорилго

Монгол улсын ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ 2050 үзэл баримтлал, бүсчлэлийн хөгжил, байгаль, түүх соёлын нөөцөд тулгуурлан БАЙГАЛЬД ТҮШИГЛЭСЭН ЗОРИЛТОТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ хөгжүүлэх.

Тус зорилготой уялдуулж Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, тогтвортой хөгжлийг ханган өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, нутгийн иргэдийн оролцоог ханган, төр хувийн хэвшил, олон нийт, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг хагасан бодлогын баримт бичгийн зорилгыг чиглүүлсэн.

Хөтөлбөрийн зорилт ба Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын баримт 2021-2031 – ᠔ тусгасан байдал

Зорилготой уялдаж дараах үйл ажиллагааг тусгасан. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, зорилтот аялал жуулчлалыг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг ханган Тогтвортой хөгжил 2050 д нийцсэн, олон улсад өрсөлдөхүйц байгальд түшиглэсэн ховор амьтан ургамал, байгалийн бүс бүслүүрийн өвөрмөц дүр бүхий өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэх.

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлүүдээр зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн болно. Үүнд:

1. **Аймгийн хэмжээнд дараах тусгай хамгаалттай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх, төлөвлөх:** Говийн их дархан цаазат газрын А хэсэг, Говийн их дархан цаазат газрын Б хэсэг, Хасагт хайрхан уулын дархан цаазат газар, Ээж уулын байгалийн дурсгалт газар, Монгол элсний байгалийн дурсгалт газар, Алагхайрхан уулын байгалийн нөөц газар, Бурхан буудай уулын байгалийн нөөц газар, Шаргын нөөц газар, Хар Азаргын нурууны байгалийн нөөц газарт аялал жуулчлал хөгжүүлэх
2. **Байгалийн аяллыг хөгжүүлэх:** Говийн гайхамшигт GG-6, Уулын эзэн Ирвэс, Алтайн унаган ургамал, амьтаныг судлах аялал, Галдан хааны

онгон, уул усны тахилга зан үйлийн аялал, эмчилгээ сувилгаа, эрүүл мэндийн аялал зэрэг, байгалийн зураг авах, элс, Тогтвортой хөгжил 2050 д тусгасан чиглэлийг дэмжин төлөвлөсөн.

3. **Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх:** Аялал жуулчлалын нөөц, орон зайн төлөвлөлт, нутаг орны онцлогийг харгалзан гурван бүсчлэлээр хөгжүүлэхээр төлөвлөсөн. Бүс бүрийн онцлогт тохирсон жуулчны бааз отог, амрах цэгийг төлөвлөсөн.
4. **Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх:** Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд 3 үндсэн 21 туслах тусгай сонирхлын маршрутыг боловсруулсан.
5. **Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн хөгжлийг хангах;** Говь-Алтай аймгийн аялал жуулчлалыг 2021-2031 он хүртэл төлөвлөн аймгийн аялал жуулчлалд хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлсон.
6. **Аялал жуулчлалын салбарын гадаад хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх:** Олон улсын болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, Гадаад орнууд болон Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, монгол, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, Говь-Алтайн аялалыг гадаад орнуудад болон дотоодод сурталчлах ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, Дотоодын аялал жуулчлалын байгууллагуудад танилцуулах, дотоодын жуулчдын захиалгын хөтөлбөрийг нэвтрүүлэх, Олон улсын жуулчдыг урьдчилсан захиалгаар авах зэрэг ажлуудыг стратегийн төлөвлөгөөнд тусгасан болно.

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт ба бодлогын бичиг баримтыг хэрэгжсэнээр гарах үр дүн:

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарт дараах үр дүн бий болно. Үүнд:

1. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын гол чиглэлийн зам дагуу түр буудаллах болон боловсон ариун цэврийн байгууламж, хогийн цэгүүдийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан байна;

2. Жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын өсөлтийг жилд 10 хувьд хүргэнэ;
3. Говь-Алтай аймгийн үндсэн болон дэмжих аялалуудын төлөвлөгдсөн газарзүйн цэгүүдийн хүрээнд байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэн байгууллагуудад ногоон гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулж нэвтрүүлсэн байна.
4. Хятад улстай аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүныг хөгжүүлэх түншлэлийг бий болгосон байна;
5. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулахад чиглэсэн 3 үндсэн төрлийн 27 бүтээгдэхүүн, 23 арга хэмжээг шинээр бий болгосон байна;
6. Аялал жуулчлалын мэдээллийн сүлжээг хөгжүүлж, салбарын мэдээллийн нэгдсэн сан бий болсон байна;
7. Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын статистик мэдээлэл боловсронгуй болсон байна;
8. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн эрэлтэд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, сургалтыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна;
9. Орон нутгийн аялал жуулчлалын хөтөч-тайлбарлагч, үйлчилгээний ажилтнуудын ур чадварыг үндэслэн зэрэглэл тогтоон, гэрчилгээ олгох үйл ажиллагааг нэвтрүүлсэн байна;
10. Хүний нөөцийг бэлтгэж, давтан сургах, чадавхжуулах ажлыг зохион байгуулсан байна.
11. Тусгай хамгаалалттай болон соёлын өвийн бүс нутгуудын аялал жуулчлалын нэгдсэн менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна;
12. Дотоод, гадаадын жуулчдад зориулсан Алтай хотод мэдээллийн төв, цогцолборыг байгуулсан байна;
13. Аялал жуулчлалын салбарт мөрдөж байгаа стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хяналтын механизмыг сайжруулсан байна;
14. Иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, боловсролыг нэмэгдүүлж, зөв зохистой аялах дадал, соёлыг нэвтрүүлсэн байна;

- 15.Эвент арга хэмжээг тогтмол зохион байгуулж олон улсад суртачлан таниулсан байна;
- 16.Бүс нутагт жуулчны бааз, отогоудыг байгуулан үйл ажиллагааг тогмолжуулсан байна;
- 17.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бүс нутгийн онцогт тохируулан хөгжүүлсэн байх;
- 18.Төр хувийн хэвшил, олон нийтийн байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдаатай бодлоготой нийцүүлэн хэрэгжүүлдэг болсон байх;
- 19.GG-6 брендийг хөгжүүлэх, олон улсын зах зээлд таниулсан байна;
- 20.Байгалийн аялал жуулчлалын Говь-Алтай брендийг хөгжүүлсэн байх

2.6 Үйл ажиллагааны хөтөлбөрүүд

2.6.1 Тусгай сонирхлын аялал жуулчлалын дэд хөтөлбөр

Монгол улсад тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр үндсэн агуулгаар судлаачид дараах чиглэлүүдийг тодорхойлсон байна.

Тусгай сонирхлын аяллыг 21 аймагт хөгжүүлэх чиглэл:

Хүснэгт 6: Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлүүд

№	Аймгийн нэр	Тусгай сонирхлын аяллыг хөгжүүлэх чиглэл
1	Архангай	<p>Голлох үзэмэр: Соёлын өв/Булш, бунхан, буган чулуу</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-1 Нүүдэлчний соёлтой танилцах аялал - Маршрут-2 Байгалийн аялал - Маршрут-3 Буган хөшөө судлах аялал - Маршрут-4 Хүннү судлалын аялал - Маршрут-5 Эртний хотын туурь судлал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Тайхар чулуу - Тэрхийн цагаан нуур - Өгий нуур - Чулуут гол орчим - Алтан сандал уул орчим - Эрдэнэмандал - Гол мод

		<ul style="list-style-type: none"> - Хөшөө цайдам - Жаргалант - Хархорин - Хар балгас - Билгэ хааны цогцолбор
2	Баян-Өлгий	<p>Голлох үзмэр:</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-3 Хадны сүг зураг ажиглах аялал - Маршрут-5 Уулын аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Цагаан салаа, Хар ямаат - Таван богд Хүйтэн уул
3	Баянхонгор	<p>Голлох үзмэр: Археологи /хүний үүсэл/</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн бүсийн маршрут-1 Чулуун зэвсэгийн бууц суурин <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Баянлиг Цагаан агуй , Чихэн агуй Уран хайрхан
4	Булган	<p>Голлох үзмэр: <i>Адууны аж ахуй</i></p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Эртний хотын туурь судлал</i> <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Байбалык, Цогтын цагаан байшин</i>
5	Говь-Алтай	<p>Голлох үзмэр: Ховор амьтад</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-1 Ховор амьтан ажиглах аялал - Маршрут -4 Нэн ховор амьтан ажиглах <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Тахийн шар нуруу, - Тунгалагийн баян бүрд, - Зарман, Захуйн баян бүрд, - Баян бүрдүүд дээр
6	Говьсүмбэр	Голлох үзмэр: Эрдсийн музей үзэх аялал
7	Дархан-Уул	<p>Голлох үзмэр:</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-1 УБ-Дархан -УБ <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Дархан
8	Дорноговь	Голлох үзмэр:

		<p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-1 Шувуу судлах аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Хамрын хийд, Хан Баянзүрх хайрхан
9	Дорнод	<p>Голлох үзэмэр: Түүх, археологийн /Хүннү, Түрэг, 13 дугаар зуун/ Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-1 Нүүдэлчний соёлтой танилцах аялал - Маршрут-2 Байгалийн аялал - Маршрут-4 Хүннү судлалын аялал - Маршрут-5 Эртний хотын туурь судлал - Төвийн бүсийн маршрут -1 Чулуун зэвсэгийн бууц суурин судлах аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөх нуур, Буйр нуур, Дэгээ гол, Сангийн далай нуур
10	Дундговь	<p>Голлох үзэмэр: Соёлын аялал /язгуур урлаг, хурим найр/</p>
11	Завхан	<p>Голлох үзэмэр:</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Отгонтэнгэр /Агаарын аялал/ - Завхан гол - Нуур болон уулсын аялал - Элс болон усан аялал - Түүхэн үйл явдал
12	Орхон	<p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Эрдэнэт
13	Өвөрхангай	<p>Голлох үзэмэр: Түүх, археологийн /Хүннү, Түрэг, 13 дугаар зуун/ Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-1 Нүүдэлчний соёлтой танилцах аялал - Маршрут-2 Байгалийн аялал - Маршрут-4 Хүннү судлалын аялал - Маршрут-5 Эртний хотын туурь судлал - Төвийн бүсийн маршрут -1 Чулуун зэвсэгийн бууц суурин судлах аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Хархорин орчим - Мойлтын ам , Орхон-7
14	Өмнө-Говь	<p>Голлох үзэмэр: Палентологи</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-1 Чулуун зэвсэгийн бууц суурин судлах аялал

		<ul style="list-style-type: none"> - Маршрут-2 Палеонтологийн аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Баян заг, Цахиуртын хөндий, - Баянзаг
15	Сүхбаатар	<p>Голлох үзмэр:</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-2 Хүн чулуу судлах аялал - Маршрут-5 Ганга нуур Шилийн Богд <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Дарьганга, Хөргийн хөндий, Алтан овоо - Ганга нуур
16	Сэлэнгэ	<p>Голлох үзмэр: Хил орчмын аялал жуулчлал</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн бүсийн аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Амарбаясгалант хийд
17	Төв	<p>Голлох үзмэр:</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут -2 Монголын эртний бичиг үсгийн дурсгалыг судлах аялал - Маршрут-4 Байгалийн аялал - Зүүн бүсийн Маршрут-1 Бурхан Халдуны аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Тоньюукук, - Эрдэнэсант Элсэн тасархай - Цонжинболдог орчим
18	Ховд	<p>Голлох үзмэр: Угсаатан судлалын төв</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-2 Шувуу ажиглах аялал - Маршрут-1 Ховор амьтан ажиглах аялал - Маршрут-3 Хадны сүг зураг ажиглах аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Нуур бүр дээр - Мянган угалзат уул орчимд - Цэнхэрийн агуй орчимд
19	Хөвсгөл	<p>Голлох үзмэр: Угсаатны аялал /цаатан, бөө/</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-1 Нүүдэлчний соёлтой танилцах аялал

		<ul style="list-style-type: none"> - Маршрут 2 байгалийн аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Улаан уул сум цаатны отог, Ренчинлхүмбэ сум цаатны отог - Хөвсгөл нуур, Шинэ-Идэр
20	Хэнтий	<p>Голлох үзэмэр: Чингис хаан</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут -1 Чингэс хааны түүхт газрын аялал - Маршрут-3 Булш бунхан судлах аялал - Маршрут-4 Шувуу судлах аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Бүрэг эрэг, Бурхан Халдун - Дуулга уул, Хурх , Биндэрийн Асгат, Дуурлиг нарс - Онон, Балж,
21	Увс	<p>Голлох үзэмэр: Соёлын өв/ хадны сүг зураг</p> <p>Маршрут:</p> <ul style="list-style-type: none"> - Маршрут-3 Хадны сүг зураг ажиглах аялал - Маршрут-2 Шувуу судлах аялал <p>Амралтын цэгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Моожоогийн хадны зураг, Бургастын хөндийд, Мөнгөт цахир - Хар ус нуур, Хяргас нуур, Увс нуур

Дээр дурдсан тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Говь-Алтай аймагт ховор амьтан, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр дурдагдсан болно.

Улаанбаатар хотын 400 орчим иргэдээс түүврийн аргаар авсан судалгаанаас үзэхэд байгалийн аялал жуулчлалын хөтөлбөрийг түлхүү сонирхож байсан.

2.6.2 “Говь-Алтай аймгийн засаг даргын үйл ажиллагаан хөтөлбөр 2020-2024” (2020 он)

Говь-Алтай аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын бичиг баримт боловсруулахад Байгаль түүх соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

- Орон нутгийн онцлог тохирсон аялал жуулчлалын шинэлэг, бренд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

- Аялал жуулчлалын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж ур чадварыг нэмэгдүүлнэ
- Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын хүчин чадал, үйлчилгээг сайжруулж, жуулчдын амрах, үйлчилэх ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлнэ. Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг дэмжин төлөвлөгөө гаргасан.

2.6.3 Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008 – 2021 он) д тусгасан

Хөгжлийн давуу талууд

- БНХАУ-ын томоохон зах зээлд ойр дөт;
- Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжтой зэрэг болно
- Байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилттэй тэмцэх, ойн зурвас байгуулах, хөрс, бэлчээрийг хамгаалах зэрэг ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөн оролцуулах;
- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуулчлалын салбарт хөдөлмөр эрхлэлтийг тууштай дэмжих;
- Хүнхэр, Цутгалан, Гүн нуур, Цангилахын гол зэрэг байгалийн үзэсгэлэнт газар рашаануудыг түшиглэн амралт, сувиллын тохилог газруудыг байгуулах;
- Эрээн нуур, Ээж уул, Бигэрийн таван элс (Бөөрийн сувилал)-ийг түшиглэн дотоод, гадаадын хөрөнгө оруулалт бүхий улсын чанартай сувилал, амралт, байгалийн аялал жуулчлалын төв байгуулах;
- Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох;
- Аялал жуулчлалыг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээг бүх чиглэлээр хөгжүүлэх;
- Бургастайн боомтыг түшиглэн худалдааны чөлөөт бүс байгуулах;
- Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор гол мөрний эх, ойн бүс, говийн баян бүрд, нуур цөөрөм, түүхийн дурсгалт газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх.
- Халиун, Төгрөг, Шарга, Бигэр сумдад ингэ, цагаан гүү, ямааны сүүний сувилал, эмчилгээний цэгүүдийг нээн ажиллуулах;
- Говь-Алтай аймгийн унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, говь цөл, тал хээр, нүүдэлчдийн өвөрмөц ахуй, зан үйл, түүх, соёлын эртний дурсгалууд нь дотоод, гадаадын жуулчдын сонирхолыг ихээхэн татдаг. Нийт нутаг

дэвсгэрийн 25,6 хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг. Энд дэлхийд ховордсон олон зүйлийн ургамал, амьтан бүртгэгдсэн байна. Гэвч өнөө хүртэл аялал жуулчлал шаардлагын хэмжээнд хүртэл хөгжөөгүй байна. Жуулчид хүлээн авах шаардлага хангасан зочид буудал, жуулчны бааз, зоогийн газар, үзвэрийн газрууд байхгүй, үйлчилгээний чанар, нэр төрөл тун хангалтгүй, мэрэгжилтэй боловсон хүчний хүрэлцээ, жуулчин хүлээн авах даац, сурталчилгаа дутмаг байгаа нь аялал жуулчлал хурдан хөгжихөд саад болж байна. Аймагт аялал жуулчлалыг 1) Байгаль экологийн аялал жуулчлал, 2) Тvvх соёлын дурсгалт зvйлийг сонирхох аялал жуулчлал, 3) Өвлийн улирлын аялал жуулчлал гэсэн хэд хэдэн чиглэлээр хөгжүүлэх боломж байна.

Нэгдүгээр үе шат (2008-2015 он):

- **Стратегийн зорилт 1.** Аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 13 хувьд, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлд аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг 63 хувьд хүргэж аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно:
- Экологийн аялал жуулчлалыг дараах маршрутаар хөгжүүлэх:
 - Алтай хот- Хvнхэр амралт- Жаргалангийн сvмийн дэнгийн хvн чулуун хөшөө- Эрээн, Ажиг нуур- Долоон тогооны талын агуй-Сэнжид хад- Тайширын УЦС- Завхан голын Шохойн булан- Шар булаг- Алтай хот;
 - Алтай хот- Бигэрийн улаан явар- Таван элсний бөөрний сувилал- Цагаан хаалганы рашаан- Бурхан буудай уул- Найтаастийн бичигт хад- Ээж уул- Хаяагийн говь, услалтын систем- Буурийн гол давсны орд газар- Цагаан голын бичигт хад- Алтай хот;
 - Алтай хот- Шаргын хар заг- Цагаан нуур- Сутай- Гурван хулд- Тахь нутагшуулах төв- Бижийн амны далан- Ширтийн агуй- Алаг нуурын говь- Шvvтийн хавцал- Алтай хот;
- Баруун бүсийн бусад аймгийн аялал жуулчлалын маршруттай холбон Хамтын аялал жуулчлал (Community based tourism), спортын аялал жуулчлалыг тууштай хөгжүүлэх;
- Аялал жуулчлалын цогцолбор, бааз байгуулах төслүүдийг боловсруулж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад санал болгох;
- Аялал жуулчлал хөгжүүлэх бүсүүдэд дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчдын бааз, түр буудаллах дэн буудлын сүлжээ байгуулахыг дэмжих;

- Аялалын тогтоосон маршрутын дагуух авто замыг засварлаж, тэмдэгжүүлэх;
 - Жуулчдын баазын ойролцоо угсаатны зүйн болон бусад зан үйлийг сонирхуулах, эмнэг мал сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, морин аялал хийх, үзэсгэлэн гаргаж үзүүлэх зэрэг арга хэмжээг өргөн зохион байгуулах, энэ чиглэлээр сурталчилгаа явуулах;
 - Байгальд халгүй, орчин үеийн технологид суурилсан эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангах арга хэмжээ авах;
 - Тайширын УЦС-ын нуурыг түшиглүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Стратегийн зорилт 2.** Аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэн, менежментийг нь боловсронгуй болгоно:
- Одоо ажиллаж байгаа жуулчдын бааз, амралт, сувилалын газруудыг тохижуулах, шинээр байгуулах замаар жилд 10-15 мянга хүртэл жуулчин хүлээн авах хүчин чадалтай болгох;
 - Аялал жуулчлалын маршрутын авто замыг сайжруулах зорилтыг дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх;
 - Музейн үзмэрүүдийг баяжуулах, аялал жуулчлалын маршрутын дагуух түүх соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах;
 - Аялал жуулчлалын отог, баазуудын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг нь төрөлжсөн сургалтад хамруулах, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах;

Хоёрдугаар үе шат (2016 – 2021 он):

Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэн үйлчилгээний салбарт аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жинг 68 хувьд хүргэнэ:

- Аймагт жил бүр хүрэлцэн ирэх жуулчдын тоог аймгийн хүн амын тоотой тэнцэх хэмжээнд хүргэх;
- Орчин үеийн зочид буудал, жуулчны бааз, нүүдлийн отог шинээр барьж тохижуулан үйлчилгээний нэр төрлийг олшруулах;
- Бигэр номунхан, Наробанчин хийдийг сэргээн босгож, шашин, соёл, жуулчны төв болгох;
- Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах;

2.6.3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Говь-Алтай аймагт дэлхийд ховордож улаан номонд орсон мазаалай, ирвэс, хулан, тахь, хавтгай, аргаль, янгир ямаа, хар сүүлт, цоохондой, зэгсний гахай, соотон алаг даага, зэрэг амьтад, 3 төрлийн тогоруу, 2 төрлийн галуу, 2 төрлийн жороо тоодог, цахлай, хотон өрөвтас, сар, цагаан сүүлт бvргэд, гургуул зэрэг шувууд бий бөгөөд сүүлийн үед тоо толгой нь улам цөөрсөөр байна. Мөн вансэмбэрүү, гоёо, зээрийн ундаа, хулангийн ундаа, эрээн гомбо, үүргэнэ, юмдүүжин, алтан гагнуур, чихэр өвс, зээргэнэ, гандигар, хурдан цагаан, лидэр, тарваган шийр, дэгд, таван салаа, минжиннавга, газрын үс зэрэг эмийн болон суль, сульхир, сонгино, хармаг, нохойн хошуу, тошлой зэрэг хүнсний ургамал бий. Ашигт малтмалын нөөцийг ашиглаж эхлэх бэлтгэл ажлууд хийгдэж байна. Аймаг нийт нутаг дэвсгэрийнхээ 86 хувь буюу 12,2 сая га газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглаж байгаа боловч ихэнх сумдад малын тоо толгойн өсөлттэй уялдан бэлчээрийн даац хэтэрсэний зэрэгцээ үлийн цагаан оготно, царцаа, дэвхрэг 591,0 га талбайд тархсан нь цөлжилтөд нөлөөлөх болов. Аймгийн нутгийн 60 шахам хувь нь байгалийн хүчин зүйл болон хүний зүй бус үйл ажиллагааны нөлөөгөөр цөлжилтийн байдалд ороод байна. Ялангуяа Хөх морьт, Ургамал зэрэг сумд шаваг, харгана зэргийг зүй бусаар ашигласны улмаас сумын төв элсэнд дарагдаж, Монгол элс, Бөөрөг дэл зэрэг томоохон элстэй нутгийн элсний нүүдэл ихсэх хандлагатай байна.

Аймгийн хэмжээнд 1010 орчим булаг, шанд, гол горхи, рашаан тоологдсоноос цөлжилт болон хүний зүй бус үйлдлийн улмаас ширгэх, бохирдох нь ихсэж байна. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогоор аймгийн хэмжээнд 6463 суурин эх үүсвэр, 3000 гаруй хөдөлгөөнт эх үүсвэр байгаа нь тогтоогджээ. Иймд Говь-Алтай аймагт байгаль орчныг хамгаалах, нөөц баялагийг зохистой ашиглах, хяналтыг чангатгах нь онцгой ач холбогдолтой болж байна.

Бүх үе шат (2008-2021 он):

Стратегийн зорилт 1. Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулна:

- Аймгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар 2010 он хүртэл хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Аймаг сумдын байгаль орчны мэдээлэлийн сангийн бүрдүүлэлтийг иж бүрнээр хийж, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг ашиглах шийдвэр гаргах зэрэгт үндсэн хэрэглэгдэхүүн болгож занших;

- Байгаль орчинд учруулсан хохирлын эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүч ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлж, нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрийн дан болон хоршсон хэрэглээг хөгжүүлэх;
- Айл өрх, албан байгууллагын хашаа, эзэмшил газар, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх;
- Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр иргэд, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудтай хамтран, тэдгээрийн санал, үйл ажиллагааг дэмжиж ажиллах;

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ:

- Газар ашиглалтын төлөв байдал, үржил шимийг дээшлүүлэх, түүнчлэн стандартын холбогдолтой мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх оновчтой тогтолцоог бий болгох;
- Газрын нөөцийн менежментийг сайжруулж, газар зохион байгуулалтын орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;
- Уул уурхайн үйлдвэрлэл ялангуяа алтны хайгуулын болон ашиглалтын замбараагүй үйл ажиллагааны уршгаар бий болсон хохирол гажуудлыг арилгуулахад нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулах;
- Химийн хорт бодисоор бохирдсон газар нутгийн хөрс, усыг хоргүйжүүлэх арга хэмжээ авах;
- Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар нэн ховор, ховордсон ан амьтан, ургамалтай бүс нутгийг аймгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтанд авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайн хөрсний эвдрэлийг зогсоож, олон наст ургамлын үр тарих, бэлчээрийн нөөцөд шилжүүлэх арга хэмжээ авах;

- Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, тариалангийн талбайг тойруулж ойн зурвас тарьж ургуулах, таримал болон тэжээлийн, эмийн ургамал тариалах замаар ашиглах;

Стратегийн зорилт 3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалаж, зохистой ашиглан хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангана:

- Төв, суурингийн усны бохирдлыг бууруулах арга хэмжээг тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх;
- Хүн амын ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх бага оврын тоног төхөөрөмжийг сумдад суурилуулж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх;
- Экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүй услалтын системүүдийг газар тариаланд ашиглах;
- Жил бүр 60-аас доошгүй уст цэгт засвар шинэчлэлтийг үргэлжлүүлэн хийж, бэлчээр усжуулалтын түвшинг 50-аас доошгүй хувьд хүргэх;
- Хурын усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулах;
- Усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах, чиглэлээр олон нийтийг хамарсан сурталчилгааг зохион байгуулах;
- Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоог нэмэгдүүлэх;

Стратегийн зорилт 4. Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ажлыг сайжруулан экологийн тэнцвэрт байдлыг нь хадгална:

- Аймгийн ойн нөөцийг сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинэчлэн тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээ хийлгэн нөхөн сэргээх, ашиглах, хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангах;
- Жил бүр нийтээр мод тарих өдөртэй болж, хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах;
- Ойн нөхөн сэргээлтийн ажлыг эдийн засгийн хөшүүрэг хэрэглэн урамшуулж, энэ талын сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах;
- Заг болон говийн бутлаг ургамлыг үрээр тариалж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн санаачилгыг дэмжих;
- Шарга, Халиун сумдад заган ойн үржүүлгийн газар байгуулах;

- Аймгийн заг болон шинэсэн ойн нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цаашид энэ ажлыг тогтмолжуулах;
- “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр 30-аас доошгүй га талбайд ойн зурвас байгуулах;
- Улс, орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр жил бүр 80-аас доошгүй га талбайд ойжуулалт хийх;
- Газрын генератор ашиглан цаг агаарт зориудаар нөлөөлж хур тундасыг нэмэгдүүлэх;

Стратегийн зорилт 5. Амьтан, ургамлын нөөцийг хамгаалж, тэдгээрийн байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ:

- Аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлалт аргуудыг өргөн хэрэглэх;
- Байгалийг хайрлан хамгаалах хүмүүжлийг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг эхний ээлжинд хамгаалах, нөхөн сэргээх;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах;
- Дархан цаазат газар болон байгалийн цогцолбор газрын орчны бүсүүдэд байгаль орчинд халгүй аж төрөх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлж эхлэх;
- Ховор, нэн ховор амьтан ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, зориудын аргаар үржүүлэх, генийн санг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах;
- Шарга-Манханы байгалийн нөөц газарт “Монгол бөхөн” хамгаалах төслийг хэрэгжүүлэх;
- Агнуурын эдэлбэр нутагт ан амьтдад зориулан өвс тэжээл бэлтгэх, булаг шанд задгайлах, тэжээлийн ургамал тариалах, үүр ноохой бэлдэх, долооц тавих, мараа ургуулах зэрэг биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн, эдэлбэр нутгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах;
- Байгаль хамгаалагчдыг шаардлагатай техник хэрэгслээр бүрэн ханган, ТХГН-ийн хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагчид, сумдын байгаль хамгаалагчдыг сүлжээнд холбох;
- Байгаль хамгаалах чиглэлээр олон улсын байгууллага, гадаад төсөл,

хөтөлбөрүүдтэй өргөн хамтран ажиллах;

Стратегийн зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цөлжилтийг сааруулах, сөрөг үр дагаврыг бууруулах чадавхийг бүрдүүлнэ:

- Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төлөв байдал, байгалийн гамшгийн мэдээллийн төвийг байгуулан ажиллуулах;
- Байгаль орчны мэргэжлийн хяналтын лабораторуудыг орчин үеийн техник хэрэгслэлээр бэхжүүлж, мэргэжилтнүүдэд оношлогоо шинжилгээний орчин үеийн мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль цаг уурын гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, техникийн хүчин чадлыг бий болгох;
- Аймгийн хэмжээнд цөлжилттэй тэмцэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж цөлжилтийн хамрах хүрээг багасгах;
- Цөлжилтөд илүүтэй нэрвэгдсэн Хөхморьт сумын төвийн эргэн тойронд болон Монгол элсний өвөр хэсгээр ногоон төгөл байгуулах;
- Элсний нүүдлийг зогсоох, говийн ургамалжилтыг нөхөн сэргээхэд ашиглаж болох ургамлуудыг (заг, жигд, хайлаас, харгана, бүйлс, хотир гэх мэт) тодорхой үе шаттайгаар сонгон тариалах;
- Бигэрийн Өөш, Мянгайн гол, Дагналтайн услалтын системийг түшиглэн элсний нүүдлийг сааруулах зорилгоор ойн зурвас байгуулах, мөн орон нутгийн түлшний хэрэгцээг хангах зориулалт бүхий саваа мод үржүүлгийн аж ахуй байгуулах;
- Мал ихээр бөөгнөрч бэлчээр талхлагдахаас урьдчилан сэргийлэх;
- Сул хөрсийг тогтоох, ургамалжуулах талаар гадаад орнуудын дэвшилтэт технологийг судалж нэвтрүүлэх;
- Цөлжилтэй тэмцэх ажилд нутгийн санаачилгатай иргэд болон ажилгүй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- Орон нутгийн түлшний хэрэгцээг үйлдвэрлэлийн аргаар хангах;

3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

3.1 Үндсэн хууль

Манай улсад өнөөдрийн байдлаар нийт 749 хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага-үе үеийн Монгол Улсын Их Хурлаас өнгөрсөн хугацаанд 749 хууль, УИХ-ын 1974 тогтоол, Монгол Улсын олон улсын 585 гэрээ баталжээ. Монгол улсын хэмжээнд нийт 5900 орчим стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 2018 оны байдлаар Байгаль орчин аялал жуулчлалын салбарт шууд хамаарах 394 үндэсний стандартууд мөрдөж байна. Үүнд: Усны чиглэлээр 147, хөрсний чиглэлээр 38, агаарын чиглэлээр 47, ой хамгааллын чиглэлээр 61, уул уурхайн нөхөн сэргээлт, байгаль хамгааллын чиглэлээр 14, биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр 29, байгаль орчны менежементийн тогтолцооны 25, аялал жуулчлалын 9, бусад 24 тус тус байна. 1992 онд баталсан Үндсэн хууль 6 бүлэг, 70 зүйлтэй бөгөөд 2019 оны 11-р сарын 14-ний УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар Үндсэн хуулийн 19 зүйл, 30 гаруй хэсэгт өөрчлөлт оруулахыг дэмжин батлаад 2020 оны 05 сарын 25-ны өдрөөс мөрдөж эхэлж байна.

Говь-Алтай аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх 2021-2031 баримт бичигтэй холбоотой Үндсэн хуулийн гол заалт нь “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх” төдийгүй түүнийг сурталчилан таниулах шаардлага юм.

Хүснэгт 7: Үндсэн хуулийн шинэчилсэн зүйлүүд

Хуулийн нэр	Нөлөөлөх гол зүйл заалтууд
1 Монгол улсын үндсэн хууль	<p>Монголын ард түмэн бид:</p> <ul style="list-style-type: none"> Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, Хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

2020.05.25- Зургадугаар зүйл.

ны өдрөөс
мөрдөх
үндсэн
хуулийн
өөрчлөлт,
шинээр
орсон
заалтууд

- 1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.
- 2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.
- Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.
- Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.
- */Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан/.*
- 3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.
- 4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл

мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

- 5. Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

59-р зүйлийн 2

- Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй.
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.

3.2 Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх хууль эрх зүйн орчны судалгаа

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ агаарын тухай хуулийг баримтлан эко жуулчны бааз, эко барилга байгууламж барих, ашиглалтын шийдлийг сэргээгдэх эрчим хүч ашиглан шийдвэрлэх, эко бие засах газар, шүршүүр ашиглах, цахилгаан халаагуур ашиглах зэргээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа жуулчны баазуудад шаардлага тавьж ажиллахын зэрэгцээ, агаарын тухай хуулийн дагуу урамшуулалд хамрагдахад дэмжин ажиллана. Хэрэв зайлшгүй нөхцөл байдлаар агаарыг бохирдуулах ямар нэг зүйл ашигласан тохиолдолд агаарын бохирдолын төлбөрийн тухай хуулийн дагуу төлбөр төлж байхаар хамтран ажиллагч хувийн хэвшлийн байгууллагуудтай гэрээ хийж ажиллахаар төлөвлөж байна.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын авто замыг зориулалтын дагуу ашиглах, зам дагуух үйлчилгээ, сурталчилгааны самбаруудыг зохих журмын дагуу ашиглах, зам дагасан хог хаягдлыг бууруулах, хогыг цэвэрлэх талаар паркийн захиргаа арга хэмжээ авч ажиллах зэрэг үйл ажиллагааг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллана.

Мөн дараах хуулийг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Үүнд:

- Аялал жуулчлалын тухай хууль /2000/
- Амьтны тухай хууль
- Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль /1995/
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль /1988/
- Газрын тухай хууль /2002/
- Гол мөрний урсац бүрэлдэхэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сайн бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль /2009/
- Иргэний хууль
- Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Улсын нисэхийн тухай хууль
- Ургамал хамгааллын тухай хууль /2007/
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Усны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Төрийн албаны тухай
- Төсвийн тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай /1997/
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай /1994/
- Ойн тухай хууль /2012/
- Харилцаа холбооны тухай хууль
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль /2006/
- Ховордсон амьтан ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль /2002/

- Хог хаягдлын тухай хууль /2017/
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль /2012/
- Хөрөнгө оруулалтын тухай хууль
- Эрүүгийн хууль
- Эрүүл ахуйн тухай хууль /2017/
- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль зэрэг юм.

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамаарах хуулийн заалтуудыг дараах байдлаар ашиглахад хялбар, тус паркийн удирдлага болон хүний нөөцийг богино хугацаанд зорилтот мэдлэгээ авах боломжтой байдлаар орууллаа. Үүнийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 8: Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх хууль эрх зүй

Хуулийн нэр	Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх гол зүйл заалтууд
1 Агаарын тухай хууль /2012/ шинэчилсэн/	<p>13.2. Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд дараах үндсэн зарчим баримтална:</p> <p>13.2.1. түүхий нүүрсийг ахуйн зориулалтаар хэрэглэхээс татгалзаж, цахилгаан, газрын гүний дулаан, хагас коксон болон хийн түлшийг ашиглах;</p> <p>14.1. Дараах нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан өрхөд энэ хуулийн 6.1.6-д заасны дагуу урамшуулал олгоно:</p> <p>6.1.8. Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох;</p> <p>14.1.1. стандартын шаардлага хангасан дулаалгатай гэр, амины орон сууцтай;</p> <p>14.1.2. цахилгаан дамжуулах, түгээх шугам сүлжээнд холбогдож цахилгаан халаагуур хэрэглэж байгаа;</p> <p>14.1.3. бүх төрлийн хийн түлшээр ажилладаг халаалттай;</p> <p>14.1.4. газрын гүний дулаан, нар, салхины болон бусад сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж байгаа;</p>

	<p>14.1.5. стандартын шаардлага хангасан шахмал болон хагас коксон түлш, сайжруулсан зуух, яндангийн шүүлтүүр хэрэглэж байгаа;</p> <p>14.1.6. байгаль орчинд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй байшин, амины орон сууцтай;</p> <p>14.1.7. түлш хэмнэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг багасгаж, энэ чиглэлийн дотоод, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж, төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа;</p>
<p>2</p> <p>Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль /2010/</p>	<p>5.5. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, хохирлын хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр агаарын бохирдлын нөхөн төлбөр ногдуулан, төлөлтөд нь хяналт тавина.</p> <p>5.6. Агаарын бохирдлын нөхөн төлбөрийг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэн Байгаль орчин, уур амьсгалын санд төлнө.</p>
<p>3</p> <p>Авто замын тухай хууль</p>	<p>29.1. Иргэн, хуулийн этгээд нь тэдгээрийн харьяалал, өмчийн хэлбэр үл харгалзан авто зам, замын байгууламжийг зориулалтын дагуу ашиглах эрхтэй.</p> <p>29.2. Авто зам ашиглагч нь дараахь эрх, үүрэгтэй:</p> <p>29.2.1. Хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд авто зам, замын байгууламжийг үнэ төлбөргүй ашиглах;</p> <p>29.2.2. Авто замын арчлалт, засвар, хөдөлгөөний аюулгүй байдлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах, шаардлага тавих;</p> <p>29.2.3. Авто замын засвар, арчлалт хариуцсан байгууллагын буруугаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;</p> <p>29.2.5. Авто замд үүссэн бусдад хохирол учруулж болзошгүй ноцтой эвдрэл, зөрчлийн талаар хариуцсан байгууллагад нэн даруй мэдээлэх;</p> <p>29.2.6. Барилга байгууламж барих, өргөтгөх, шугам сүлжээнд холболт хийх зэрэг зайлшгүй шаардлагаар авто замыг сэтлэх, орц, гарц гаргах зэрэг авто замын хэвийн байдлыг алдагдуулах тохиолдолд авто зам эзэмшигч байгууллагаас</p>

	<p>зөвшөөрөл авч, ажил дууссаны дараа ашиглалтын хэвийн байдлыг ханган, хүлээлгэн өгөх.</p> <p>29.3. Авто зам ашиглагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>29.3.1. Авто зам, замын байгууламжийг эвдэж гэмтээх;</p> <p>29.3.2. Зохих зөвшөөрөлгүйгээр авто замын бүтээц, төлөвлөлт, зориулалтад өөрчлөлт оруулах;</p> <p>29.3.3. Авто зам барих, засварлах, арчилж хамгаалах ажилд саад учруулах;</p> <p>29.3.4. Авто замын зорчих хэсэг, хөвөө, зурвас газарт хог хаях, ус урсгах, чулуу, төмөр зэрэг зүйлс үлдээх, хөдөлгөөнд саад учруулж, үзэгдэх орчин хязгаарласан хаяг, сурталчилгааны самбар, эд зүйлс байрлуулах;</p> <p>29.3.5. Тусгай хамгаалалтгүй, эсвэл зөвшөөрөлгүйгээр гинжит болон тухайн авто замын үзүүлэлтээс хэтэрсэн овор, хэмжээ, даацтай тээврийн хэрэгсэл зорчуулах;</p> <p>29.3.6. Авто замын зурвас газарт авто замын ашиглалттай холбоогүй болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;</p>
<p>4</p> <p>Авто тээврийн тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>11 дүгээр зүйл. Тээвэрлүүлэгч, зорчигчийн эрх, үүрэг</p> <p>11 .1. Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараахь эрх эдэлнэ:</p> <p>11.1.1. Тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах;</p> <p>11.1.2. Нийтийн тээврийн тогтоосон чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь баримтлахыг тээвэрлэгчээс шаардах;</p> <p>11.1.3. Тээвэрлэлтийн үнэ тариф, замын чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь, ачаа хүргэх хугацааны талаар үнэн зөв мэдээлэл авах;</p> <p>11.1.4. Тээвэрлэлтийн гэрээнд зааснаас бусад тохиолдолд улс, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь өвчлөх зэрэг хүндэтгэх шалтгаанаар худалдан авсан зорчих</p>

	<p>тасалбарт заасан чиглэлд зорчиж чадахгүй болсон буюу хүрэх газартаа хүрээгүй буусан тохиолдолд замын үлдсэн хэсэгт ногдох тээврийн хөлсийг тээвэрлэгчээс буцааж авах;</p> <p>11.2. Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>11.2.1. Ачааны савлалт, баглаа, боодол, бэхэлгээг стандартын дагуу хийж, нэр төрөл, илгээх чиглэлээр нь ялган тээвэрлэхэд бэлтгэх;</p> <p>11.2.2. Ачааг ачих, буулгах зам, талбайг автотээврийн хэрэгсэл явахад саадгүй байлгах;</p> <p>11.2.3. Ачих, буулгах машин механизм, нэмэгдэл төхөөрөмж, хүн хүчийг бэлэн байлгаж ачааг</p> <p>11.2.6. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь зорчих тасалбарыг худалдан авах;</p> <p>11.2.7. Нийтийн тээврээр зорчихдоо бусдын амь нас, эрүүл мэндэд аюул, гэм хор учруулж болзошгүй эд зүйлийг авч явахгүй байх;</p> <p>11.2.8. Нийтийн тээврээр зорчихдоо автотээврийн хэрэгслийг эвдэж, гэмтээхгүй байх;</p> <p>11.2.9. Зорчигч нь улс, хот хооронд, орон нутагт зорчихдоо иргэний паспорт, холбогдох бусад баримт бичиг, зорчих тасалбарыг биедээ авч явах, тэдгээрийг жолооч, кондуктор болон шалгах эрх бүхий хүмүүсийн анхны шаардлагаар үзүүлэх.</p>
<p>5 Амьтны тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>6 дугаар зүйл.Амьтныг хамгаалах хэлбэр</p> <p>6.1. Амьтныг дор дурдсан хэлбэрээр хамгаална:</p> <p>6.1.1.Амьтныг ашиглахад хорио, хязгаарлалт тогтоох;</p> <p>6.1.2.Нэн ховор, ховор амьтныг олон улсын болон Монгол Улсын "Улаан ном", бусад холбогдох гэрээ, конвенцийн хавсралтад бүртгэх;</p> <p>6.1.3. Амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах;</p> <p>6.1.4. Амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах;</p> <p>6.1.5. Амьтны нөөц тогтоож, ашиглалтыг зохицуулах;</p> <p>6.1.6. Амьтныг сэргээн нутагшуулах;</p>

	<p>6.1.7. Үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;</p> <p>6.1.8. Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p> <p>6.1.9. Өөвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах;</p> <p><i>/Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>6.1.10. Амьтныг хамгаалах арга хэмжээний үндэслэлийг гаргахад чиглэсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх;</p> <p>6.1.11. Иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах</p>
<p>6 Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1 .Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>ХОЁРДУГААР БҮЛЭГ</p> <p>Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх</p> <p>9 дүгээр зүйл.Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих нийтлэг шаардлага</p> <p>9.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд иргэн, хуулийн этгээд дараахь нийтлэг шаардлагыг хангасан байна:</p> <p>9.1.1. Монгол Улсаас гадаад улстай амьтан, ургамлын хорио цээрийн талаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид заасан стандарт, удирдамж, зөвлөмжийн нөхцөлийг мөрдөх;</p> <p>9.1.2. Экспортлогч улсын хорио цээрийн хяналт, баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээтэй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг хорио цээрийн үзлэг, шалгалтанд оруулах;</p> <p>9.1.3. Амьтан, ургамал,</p>
	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих, аялал жуулчлалын үйл</p>

7	Аялал жуулчлалын тухай хууль /2000/	<p>ажиллагаа эрхлэх, жуулчны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо</p> <p>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1 "аялал жуулчлал" гэж хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хүртэлх хоногийн хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхүйн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явахыг;</p> <p>3.1.2. "аялал жуулчлалын байгууллага" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчлах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулж байгаа ашгийн төлөө хуулийн этгээдийг;</p> <p>3.1.3. "аялал жуулчлалын бүс нутаг" гэж Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэхэд тохирсон байгаль, түүх, соёлын нөөц бүхий газар нутгийг;</p> <p>3.1.4. "аялал жуулчлалын бүтээгдэхүүн" гэж аялал жуулчлалын байгууллагаас үзүүлж байгаа жуулчдын сонирхлыг татах, тэдний аялах тав тухтай нөхцөлийг хангасан төлбөрт үйлчилгээг;</p> <p>3.1.5. "жуулчин" гэж аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;</p> <p>3.1.6. "жуулчны үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчны бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн зэрэг үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг;</p> <p>3.1.7. "хөтөч-тайлбарлагч" гэж аялал жуулчлалын хөтөлбөрийн дагуу жуулчинд газарчлан, орчуулга, тайлбар хийх хувь хүнийг;</p> <p>3.1.8. "дээд зэрэглэлийн зочид буудал" гэж зочид буудлын цогц үйлчилгээний жишиг шаардлагын 3 ба түүнээс дээш од бүхий зэрэглэлийг хангасан үйлчилгээний байгууллагыг.</p>
<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг</p>		

<p>8 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль</p>	<p>төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>ТӨЛБӨР НОГДОХ ЗҮЙЛ, ҮНЭЛГЭЭГ ТОГТООХ</p> <p>5 дугаар зүйл. Ургамал ашигласны төлбөр ногдох зүйл</p> <p>5.1. Дараах ангиллын ургамалд төлбөр ногдуулна:</p> <p>5.1.1. Нэн ховор ургамал;</p> <p>5.1.2. Ховор ургамал;</p> <p>5.1.3. Элбэг ургамал.</p> <p>6 дугаар зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл</p> <p>6.1. Дор дурдсан зориулалтаар ашигласан ус, рашаан тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна:</p> <p>6.1.1. Хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус;</p> <p>6.1.2. Уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус;</p> <p>6.1.3. Эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан;</p> <p>6.1.4. Эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин.</p> <p>7 дугаар зүйл. Ойн нөөц ашигласны төлбөр ногдох зүйл</p> <p>7.1. Аливаа зориулалтаар ойгоос бэлтгэж ашигласан бүх төрлийн хэрэглээний мод, түлээнд төлбөр ногдуулна.</p> <p>7.2. Ойн дагалт баялгийн нөөц самар, мөөг, давирхай, шилмүүс, мөчир, үр, хусны шүүсэнд төлбөр ногдуулна.</p> <p>8 дугаар зүйл. Ан амьтны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл</p> <p>8.1. Төлбөр ногдох зүйл нь дор дурдсан зориулалтаар ашигласан ан амьтан байна:</p> <p>8.1.1. Ахуйн зориулалтаар агнасан, барьсан;</p> <p>8.1.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар агнасан, барьсан;</p> <p>8.1.3. Тусгай зориулалтаар агнасан, барьсан /соёл, шинжлэх ухаан, тусгай төлбөртэй/.</p> <p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p>
---	---

<p>9 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</p> <p>4.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэгт дор дурдсан үнэлгээ хамаарна:</p> <p>4.1.1. Байгаль орчны стратегийн үнэлгээ /цаашид “стратегийн үнэлгээ” гэх/;</p> <p>4.1.2. байгаль орчны төлөв байдлын үнэлгээ /цаашид “төлөв байдлын үнэлгээ” гэх/;</p> <p>4.1.3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ /цаашид “нөлөөллийн үнэлгээ гэх/;</p> <p>4.1.4. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ.</p> <p>4.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг зохицуулах, энэ хуулийн 4.1.1, 4.1.4, 7.1.2-т заасан үнэлгээний үр дүн, тайланд дүгнэлт өгөх, үүрэг бүхий байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл /цаашид “мэргэжлийн зөвлөл” гэх/ ажиллана.</p> <p>4.3. Мэргэжлийн зөвлөлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилон ажиллуулна.</p>
	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь ой болон таримал ургамлаас бусад ургамал /цаашид "ургамал" гэх/-ыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>ХОЁРДУГААР БҮЛЭГ</p> <p>УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ</p> <p>7 дугаар зүйл.Ургамлыг хамгаалах</p>

<p>10 Байгалийн ургамлын тухай хууль /1995/</p>	<p>1. Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.</p> <p>2. Нэн ховор, унаган буюу үлдвэр ургамлын удмын санг хамгаалах зорилгоор ургамлыг тарималжуулах, нутагшуулах ажлыг төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.</p> <p>3. Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж, хими, биологийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох журмыг хуулиар тогтооно.</p> <p>4. Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьжаас хамгаалахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид *төрийн захиргааны төв байгууллага* гэх/-ын зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно.</p> <p>5. Нэн ховор ургамал бүхий газрыг тухайн ургамал хамгаалах, нөхөн сэргээхээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэхийг хориглоно.</p> <p>6. Харь ургамлыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр байгальд тарималжуулахыг хориглоно</p> <p>7. Харь ургамлыг байгальд тарималжуулахад зориулалтын хязгаарлаж битүүмжилсэн талбайг ашиглана.</p>
<p>11 Байгаль орчныг хамгаалах тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл.Хуулиар хамгаалах объект, түүнтэй холбогдсон нэр томъёо</p> <p>1. Энэ хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ:</p>

		<p>1/газар, түүний хөрс; 2/газрын хэвлий, түүний баялаг; 3/ус; 4/ургамал; 5/амьтан; 6/агаар.</p>
12	Газрын хэвлийн тухай хууль /1988/	<p>1 дүгээр зүйл.Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт</p> <p>Газрын хэвлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт нь өнөөгийн болон хойч үеийнхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулахад оршино.</p> <p>41 дүгээр зүйл.Газрын хэвлийг хамгаалах талаар тавих үндсэн шаардлага</p> <p>1.Монгол Улсын газрын хэвлий нь улсын хамгаалалтад байна. 2.Газрын хэвлийг хамгаалахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:</p> <p>1/газрын хэвлийн геологийн судалгааг иж бүрэн гүйцэд хийх; 2/газрын хэвлийг ашиглуулахаар олгох журмыг чанд сахин биелүүлэх, түүнийг дур мэдэн ашиглах явдлыг гаргуулахгүй байх; 3/үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийг зөв зохистой, и ж бүрэн, бүрэн гүйцэд ашиглах;</p>
13	Газрын тухай хууль /2002/	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.</p> <p>5 дугаар зүйл. Газар өмчлөгч</p> <p>5.1. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн.</p> <p>5.2. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.</p> <p>5.3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.</p> <p>6 дугаар зүйл. Газар эзэмшигч, ашиглагч</p>

6.1. Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана.

6.2. Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана:

6.2.1. бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газар;

6.2.2. хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэрийн газар;

6.2.3. зам, шугам сүлжээний газар;

6.2.4. ойн сан бүхий газар;

6.2.5. усны сан бүхий газар.

6.3. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно.

6.4. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн суугчид, өмчлөгчдөд зориулагдсан ногоон зүлэг, мод, бут, сөөг, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, явган хүний болон автомашины зам, машины зогсоол зэрэг барилгын нормын дагуу баригдсан байгууламжийг арчлан хамгаалах зориулалтаар Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4.1.6-д заасан орчны газрыг сууц өмчлөгчдийн холбоонд ашиглуулж болно.

14	<p>Гол мөрний урсац бүрэлдэхэх , усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сайн бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль /2009/</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох, тухайн газарт байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох</p> <p>4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн хайх, ашиглахыг сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.</p> <p>4.2. Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй.</p>
-----------	--	--

	<p>4.3. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно.</p> <p>4.4. Энэ хуулийн 4.3-т заасан хилийн заагийн гадна үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр байгаль орчны нөхөн сэргээлт хийж, таримал ой, хиймэл нуур, усан сан байгуулсан бол энэхүү хуулийн үйлчлэлд хамаарахгүй.</p> <p>4.5. Энэ хуулийн 4.1-д заасан газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.</p> <p>4.6. Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно.</p>
<p>15 Иргэний хууль</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p> <p>1.2. Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ.</p> <p>1.3. Хуульд өөрөөр заагаагүй бол татвар, төсөв, санхүү зэрэг захиргааны хууль тогтоомжоор зохицуулах болон захиргааны талаар нэг этгээд нөгөөдөө захирагдах эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.</p> <p>8 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл</p> <p>8.1. Иргэний эрх зүйн харилцаа дараахь үндэслэлээр үүснэ:</p> <p>8.1.1. Хуульд заасан буюу заагаагүй боловч агуулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл;</p> <p>8.1.2. Иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн шүүхийн шийдвэр;</p> <p>8.1.3. Хуульд заасан бол иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн захиргааны шийдвэр;</p> <p>8.1.4. Оюуны үнэт зүйл бүтээх;</p> <p>8.1.5. Гэм хор учруулах;</p> <p>8.1.6. Үндэслэлгүйгээр эд юмс олж авах, эзэмших;</p>

	<p>8.1.7. Иргэний эрх зүйн харилцааг үүсгэсэн хууль зүйн үйл явдал бий болох;</p> <p>8.1.8. Иргэний эрх зүйн харилцаа үүсгэхээр хуульд заасан бусад үндэслэл.</p>
<p>16 Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангахад оршино.</p> <p>5 дугаар зүйл.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч</p> <p>5.1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч гэдэгт дараахь шаардлагыг хангасан, энэ хуулийн 6.6-д заасны дагуу бүртгүүлсэн аж ахуйн нэгж, иргэнийг ойлгоно:</p> <p>5.1.1. Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;</p> <p>5.1.2. Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;</p> <p>5.1.3. Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;</p> <p>5.1.4. Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 49-өөс дээшгүй бөгөөд 1 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;</p> <p>5.1.5. Контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, эсхүл контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 9-өөс дээшгүй бөгөөд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг, 50-250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн.</p> <p><i>/Энэ заалтад 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i></p>

	<p>5.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь компани, хоршоо, нөхөрлөл гэсэн хэлбэртэй байх бөгөөд энэ хуулийн 5.1-д заасан шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоохдоо тухайн хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, хараат болон охин компанийн холбогдох үзүүлэлтийг оруулж тооцно.</p>
<p>17 Компанийн тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>КОМПАНИ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ</p> <p>3 дугаар зүйл.Компани, түүний хэлбэр</p> <p>3.1. Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.</p> <p>3.2. Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд харин компанийн эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.</p> <p>3.3. Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.</p> <p>3.4. Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.</p> <p>3.5. Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ.</p> <p>3.6. Хувьцаат компани нь нээлттэй болон хаалттай гэсэн төрөлтэй байна.</p> <p>3.7. "Нээлттэй хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ.</p>

	<p>3.8. "Хаалттай хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ.</p> <p>3.9. Хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь тусгай зориулалтын компани хэлбэртэй байна. Уг хэлбэрийн компанийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон харилцааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар зохицуулах бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн зохицуулалт хамаарахгүй.</p>
<p>18 Соёлын тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад соёлын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэс, соёлын үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, соёлын удирдлагын тогтолцоо, соёлын ажилтны нийгмийн халамж баталгаа, соёлын байгууллагын өмч, санхүүжилтийн зарчим, арга хэлбэрийг тогтоож, уг үйл ажиллагаанд оролцогчдын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>Энэ хуульд хэрэглэсэн дор дурдсан нэр томъёог дараахь утгаар ойлгоно:</p> <p>1/ "соёлын үйл ажиллагаа" гэдэгт соёлын үнэт зүйлийг бүтээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой дараахь үйл ажиллагаа хамаарна:</p> <p>а/ уран зохиол, хөгжим, дүрслэх урлаг, театр, цирк, киноны урлаг, уран барилга, дизайн зэрэг урлагийн бүх төрлийн бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох;</p> <p>б/ соёлын үнэт зүйлийг бүтээх, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгоход чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;</p> <p>в/ монгол үндэстэн болон угсаатан, ястны хэл, аялгуу, аман болон бичгийн соёлыг хадгалж хамгаалах, сэргээн хөгжүүлэх;</p> <p>г/ иргэдийн соёлын ерөнхий төвшинг дээшлүүлэх, уран сайхан-гоо зүйн боловсрол, хүмүүжил олгох;</p> <p>д/ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулах;</p> <p>е/ соёл судлалыг хөгжүүлэх;</p> <p>ж/ соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.</p>

	<p>2/ "соёлын үнэт зүйл" гэдэгт гоо сайхны үзэл баримтлал, эх хэл, бичиг үсэг, аман аялгуу, уламжлалт технологи, газар усны нэр, зан заншил, бэлгэ тэмдэг, ардын аман зохиол, ном, судар, шашдир, угийн бичиг, им, тамга, хадны зураг, бичээс, гар урлал, урлагийн бүх төрлийн болон соёл судлалын бүтээл, судалгааны арга барил хамаарна;</p> <p>3/ "соёлын байгууллага" гэдэгт энэ хуулийн дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж хамаарна;</p> <p>4/ "соёлын ажилтан" гэж бүх төрлийн уран бүтээлийг бүтээн туурвих, соёлын үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, хадгалан хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд дагнан эрхэлж байгаа иргэнийг хэлнэ.</p>
<p>19 Соёлын өвийг хамгаалах тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл.Соёлын өвийн ангилал</p> <p>4.1. Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна.</p> <p>4.2. Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.</p> <p>4.3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь дангаар болон цогцолбор байдлаар оршино.</p> <p>5 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал</p> <p>5.1. Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:</p> <p>5.1.1. Эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;</p> <p>5.1.2. Эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;</p> <p>5.1.3. Чулуун зэвсгийн олдворт газар;</p> <p>5.1.4. Хадны зураг, бичээс;</p> <p>5.1.5. Булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;</p> <p>5.1.6. Эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;</p> <p>5.1.7. Хөшөө дурсгал;</p>

5.1.8. Эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;

5.1.9. Тахилгат газар;

5.1.10. Түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;

5.1.11. Бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

6 дугаар зүйл. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл

6.1. Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна:

6.1.1. Ховор эрдэс;

6.1.2. Эрдэнийн чулууны ховор олдвор;

6.1.3. Солир;

6.1.4. Ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл;

6.1.5. Эртний ургамал, амьтны олдвор;

6.1.6. Археологийн олдвор;

6.1.7. Угсаатны хувцас, чимэглэл;

6.1.8. Уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг; 6.1.9. угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл; 6.1.10. уламжлалт тоглоом, наадгай;

6.1.11. Уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл;

6.1.12. Бичгийн дурсгалт зүйл;

6.1.13. Дүрс, дуу авианы баримт;

6.1.14. Дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл, холбогдох эд өлгийн зүйл;

6.1.15. Уламжлалт монгол эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэрэглэгдэхүүн, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

6.1.16. Гэр, сууц, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

6.1.17. Бусад түүх, соёлын дурсгалт зүйл.

6.2. Энэ хуулийн 5.1.1, 6.1.1-6.1.3-т зааснаас бусад байгалийн өвийг хамгаалах асуудлыг холбогдох хуулиар зохицуулна.

7 дугаар зүйл. Соёлын биет бус өв

7.1. Дараах соёлын өвийг соёлын биет бус өвд хамааруулна:

7.1.1. Эх хэл, бичиг, түүний хүрээний соёл;

7.1.2. Аман зохиолын уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэр;

- 7.1.3. Урлагийн тоглох үзүүлбэр;
 - 7.1.4. Үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил;
 - 7.1.5. Уламжлалт гар урлалын дэг сургууль, арга барил;
 - 7.1.6. Ар дын ёс заншил, зан үйл;
 - 7.1.7. Ардын уламжлалт мэдлэг, арга ухаан;
 - 7.1.8. Ардын бэлгэдэх ёсны уламжлал;
 - 7.1.9. Үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйл;
 - 7.1.10. Ардын уламжлалт технологи;
 - 7.1.11. Угийн бичиг хөтлөх уламжлал;
 - 7.1.12. Гэрийн дэг сургуулийн шилдэг өв уламжлал;
 - 7.1.13. Уламжлалт шашин, шүтлэгийн зан үйл, ёс заншил;
 - 7.1.14. Газар, усны уламжлалт нэр;
 - 7.1.15. Бусад соёлын биет бус өв.
- 8 дугаар зүйл. Соёлын өвийн зэрэглэл
- 8.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалтын түвшингээр нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалттай гэж зэрэглэнэ.
 - 8.2. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлээс энэ хуулийн 8.3-т заасан шалгуурын дагуу хосгүй үнэт, үнэт гэж зэрэглэл тогтооно.
 - 8.3. Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлийг дараах шалгуураар тогтооно:
 - 8.3.1. Түүх, соёл, урлаг, гоо зүй, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол;
 - 8.3.2. Холбогдох цаг үе;
 - 8.3.3. Дахин давтагдашгүй байдал;
 - 8.3.4. Ур хийц, дэг сургууль;
 - 8.3.5. Үнэт металлын орц, эрдэнийн чулууны хэмжээ.
 - 8.4. Соёлын биет бус өвийг төлөөллийн үндэсний жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэж хамгаална.
 - 8.5. Энэ хуулийн 8.4-т заасан жагсаалтад оруулах соёлын биет бус өвийг дараах шалгуураар тогтооно:
 - 8.5.1. Түүх, соёл, заншил, уламжлалыг илэрхийлэх байдал;
 - 8.5.2. Ховордсон, устсан, эрсдэлд орсон байдал.

21 Ургамал

хамгааллын

тухай

хууль

/2007/

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

10 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

10.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1. Ургамал хамгааллын тухай хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, технологийг мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

10.1.2. Нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, зардлын төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;

10.1.3. Ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, олшролт, хөнөөлийн тухай төрийн захиргааны төв байгууллагад жил бүр мэдээлэх;

10.1.4. Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;

10.1.5. Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархсан болон тархаж болзошгүй нутаг дэвсгэрийн тухай нийтэд зарлан мэдээлэх;

10.1.6. Ургамлын хорио цээр тогтоосон үед тэмцэх арга хэмжээг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд иргэн, хуулийн этгээдийг дайчлан оролцуулах;

10.1.7. Ургамал хамгааллын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах;

/Энэ заалтад 2011 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

10.1.8. Бэлчээр, тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд ургамал хамгааллын талаар

	хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах.
22 Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус бохирдуулсны төлбөр ногдуулах, төлбөрийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл.Ус бохирдуулсны төлбөр төлөгч, түүнийг бүртгэх</p> <p>4.1. Ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсны төлбөр төлөгч байна.</p> <p>4.2. Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл сав газрын захиргаа ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.</p> <p>4.3. Ус бохирдуулагчийн талаарх мэдээлэлд төлбөр төлөгчийн нэр, хаяг, байршил, ус бохирдуулагчийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, хаягдал усны эзлэхүүн, хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ зэрэг татварын хяналтад шаардлагатай бусад үзүүлэлтийг тусгана.</p> <p>4.4. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагад хаягдал ус хаях зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.</p> <p>4.5. Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журмыг энэ хуулийн 7.1-д заасныг үндэслэн Засгийн газар тогтооно.</p>
23 Усны тухай хууль	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл.Усны нөөцийн нэгдсэн менежмент</p> <p>4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны нөөц нь стратегийн үнэт баялаг мөн.</p> <p>4.2. Усны сан бүхий газрыг төрийн байгууллагын зохицуулалттайгаар нийтээр ашиглана.</p>

4.3. Усыг ашиглах боломжит нөөцийн хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим баримтална.

4.4. Энэ хуулийн 21.1-д заасан мэргэжлийн байгууллага нь усны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг хайгуул, судалгаагаар тогтооно.

4.5. Усны нийт нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг усны нөөцийн зөвлөл батална.

4.6. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн усны нөөцийн зөвлөлийг байгуулж, дүрэм, бүрэлдэхүүнийг батална.

4.7. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө /цаашид “сав газрын менежментийн төлөвлөгөө” гэх/-г энэ хуулийн 4.4-т заасан ашиглах боломжит нөөцийн хэмжээг үндэслэн боловсруулна.

4.8. Сав газрын менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.9. Гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг усны сав газар /цаашид “сав газар” гэх/ бүрээр байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

4.10. Энэ хуулийн 10.1.2-т заасан сав газар нь сав газрын захиргаатай байх бөгөөд сав газрын захиргааг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

4.11. Усны нөөц нь экологи-эдийн засгийн үнэлгээтэй байна.

24 Татварын
ерөнхий хууль

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

6 дугаар зүйл. Татвар ногдох зүйл

6.1. Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна.

7 дугаар зүйл. Татварын төрөл, ангилал

7.1. Татварыг татварын төрөлд ангилах ба тодорхой төрлийн татварын харилцааг энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.

7.2. Тодорхой төрлийн татвар нь улсын болон орон нутгийн татварын аль нэгэнд хамаарна.

7.3. Улсын Их Хурал, Засгийн газраас хувь хэмжээг нь тогтоосон бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтлэг үйлчлэх дараахь татвар улсын татварт хамаарна:

7.3.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;

7.3.2. Гаалийн албан татвар;

7.3.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар;

7.3.4. Онцгой албан татвар;

7.3.5. Авто бензин, дизелийн түлшний албан татвар;

7.3.6. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;

7.3.8. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр.

7.3.13. Агаарын бохирдлын төлбөр.

7.3.14. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т заасан улсын тэмдэгтийн хураамж.

7.3.15. Ус бохирдуулсны төлбөр.

7.3.16. Газрын тосны нөөц ашигласны төлбөр;

/Энэ заалтыг 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн/

7.3.17. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр.

25

Төрийн албаны тухай

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино..

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“төрийн алба” гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг;

				<p>3.1.2.“төрийн албан хаагч” гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг;</p> <p>3.1.3.“чадахуйн зарчим /мерит/” гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг;</p> <p>3.1.4.“сул орон тоо” гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг;</p> <p>3.1.5.“албан тушаалын тодорхойлолт” гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг.</p>
26	Төсвийн хууль	тухай	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>4.1.1.“төсвийн тусгай шаардлага” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг;</p> <p>4.1.2.“дунд хугацаа” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.9-д заасныг;</p> <p>4.1.3.“дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.10-т заасныг;</p> <p>4.1.4.“төсвийн төсөл” гэж дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн, хуульд заасан шаардлагын дагуу төсвийн шатлал бүрээр төсвийн ангилал ашиглан Засгийн газраас Улсын Их Хуралд, түүнчлэн бүх шатны Засаг даргаас</p>	

тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн саналыг;

4.1.5.“төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;

4.1.6.“улсын төсөв” гэж Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар болон улсын төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

4.1.7.“суурь түвшинд үндэслэсэн төсөв” гэж макро эдийн засгийн таамаглалд нийцүүлж, тухайн төсөв хэрэгжих жилд хууль тогтоомж, эсхүл төрийн бодлогод өөрчлөлт орохгүй байхаар тооцсон төсвийн тооцоог;

4.1.8.“жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг;

4.1.9.“төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг;

4.1.10.“төсвийн зарлага” гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг;

4.1.11.“төсвийн тэнцэл” гэж тухайн төсвийн жилийн төсвийн нийт орлого, зарлагын зөрүүг;

4.1.12.“төсвийн ашиг” гэж төсвийн зарлагаас давсан орлогыг;

4.1.13.“төсвийн алдагдал” гэж төсвийн орлогоос давсан зарлагыг;

4.1.14.“орлого” гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гаднаас хүлээн авах бүх төрлийн гүйлгээг;

4.1.15.“зарлага” гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гадагш чиглэсэн бүх төрлийн гүйлгээг;

			<p>4.1.16.“хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг;</p> <p>4.1.17.“арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;</p> <p>4.1.18.“орц” гэж тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг;</p> <p>4.1.19.“эдийн засгийн томсгосон ангилал” гэж эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллын хэд хэдэн зүйлийг нэгтгэн бүлэглэснийг;</p> <p>4.1.20.“эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал” гэж эдийн засгийн ангиллын анхдагч зүйлийг... хэлнэ</p>
27	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай /1997/	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүсийг тогтоох, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Орчны бүсийг тогтоох шалгуур</p> <p>4.1. Дараахь шалгуурыг харгалзан орчны бүсийг тогтооно:</p> <p>4.1.1. Экологийн шалгуур:</p> <p>4.1.1.а. Экологи, нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий биологийн төрөл, зүйлийг хамгаалах шаардлагатай газар нутаг;</p> <p>4.1.1.б. Нэн ховор, ховор ан амьтны байршил, нутагшилт, тархац, тэдгээрийн нүүдлийн зам;</p> <p>4.1.1.в. Нэн ховор, ховор ан амьтан нутагшаагүй боловч цаашид нутагшиж болох газар нутаг;</p> <p>4.1.1.г. Тусгай хамгаалалттай газрын байгаль орчинд онцгой нөлөө үзүүлэх гол, голын эх, сав газар.</p> <p>4.1.2. Нийгэм, эдийн засгийн шалгуур:</p> <p>4.1.2.а. Тухайн тусгай хамгаалалттай газраас байгалийн баялаг ашиглан орлого олдог нутгийн иргэдийн амьдардаг газар нутаг;</p> <p>4.1.2.б. Байгаль орчныг бохирдуулах эх үүсвэрийн байршил, нөлөөллийн хүрээ;</p> <p>4.1.2.в. Нутгийн хүн ам, айл өрх, малын нягтрал нь бэлчээрийн даац, усны хангамжийн хүрэлцээнд сөрөг нөлөө үзүүлж байгаа газар нутаг;</p>	

	<p>4.1.2.г. Нийгэм, эдийн засгийн хөгжил нь тухайн тусгай хамгаалалттай газар, түүний орчны байгаль, байгалийн нөөцөөс онцгой хамаарал бүхий суурин.</p> <p>4.1.3. Бусад шалгуур:</p> <p>4.1.3.а. Байгалийн өвөрмөц тогтоц, онцлог бүхий газар нутаг;</p> <p>4.1.3.б. Түүх, соёлын дурсгалт зүйлс бүхий газар нутаг.</p>
<p>28 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай /1994/</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх,соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах,танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал</p> <p>1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараахь байдлаар ангилна:</p> <p>1/ дархан цаазат газар;</p> <p>2/ байгалийн цогцолборт газар;</p> <p>3/ байгалийн нөөц газар;</p> <p>4/ дурсгалт газар.</p> <p>2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно.</p> <p>ХОЁРДУГААР БҮЛЭГ</p> <p>Дархан цаазат газар, түүний хамгаалалтын дэглэм</p> <p>7 дугаар зүйл. Дархан цаазат газар</p> <p>Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ.</p> <p>Хэвлэх</p> <p>8 дугаар зүйл. Дархан цаазат газрын бүс</p> <p>Дархан цаазат газрыг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл</p>

ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан дараахь бүсэд хуваана:

- 1/ онгон бүс;
- 2/ хамгаалалтын бүс;
- 3/ хязгаарлалтын бүс.

9 дүгээр зүйл. Онгон бүсийн дэглэм

1. Онгон бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлнэ.

2. Онгон бүсэд байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болох бөгөөд үүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм

Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна ургамал, амьтны аймгийн өсч үржих нөхцөлийг хангах, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

11 дүгээр зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм

Хязгаарлалтын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно:

- 1/ энэ хуулийн 9,10 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа; 2/ хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх;
- 3/ ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;
- 4/ ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах;
- 5/ рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах;
- 6/ байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах;
- 7/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах;

	<p>8/ зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах;</p> <p>9/ уул,овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх;</p> <p>10/ нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах.</p>
<p>29 Харилцаа холбооны тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, хамгаалах, зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих, иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>2 дугаар зүйл.Харилцаа холбооны тухай хууль тогтоомж</p> <p>2.1. Харилцаа холбооны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p> <p>2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.</p> <p>2.3. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбогдох харилцааг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна. /Энэ хэсгийг 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/.</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1."шугам" гэж мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах, хүлээн авах зорилгоор байгуулсан аливаа дамжуулагч орчин /утас, радио долгион, орон зай зэрэг/, тэдгээрийг хамгаалахад хэрэглэдэг тусгаарлагч, сувагчлал, багана, цамхаг, байр, талбай болон бусад зүйлсийн цогцолборыг; /Энэ заалтад 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/.</p> <p>3.1.2. "сүлжээ" гэж хоёр буюу түүнээс дээш хэрэглэгчийн хооронд мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авахад хэрэглэх холбооны шугам, түүнчлэн шуудангийн</p>

		<p>илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, гардуулахад зориулалттай техник хэрэгслийн иж бүрдлийг;</p> <p>3.1.3. "ашиглалт" гэж харилцаа холбооны сүлжээний тогтвортой ажиллагааг хангахад чиглэсэн засвар, хэмжилт, тохируулга хийх үйл ажиллагааг;</p> <p>3.1.4. "үйлчилгээ" гэж харилцаа холбооны сүлжээг ашиглан хэрэглэгчийн холбоо мэдээллийн хэрэгцээг хангах үйл ажиллагааг;</p> <p>3.1.5. "үйлчлэгч" гэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.1-15.16.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээдийг;</p>
30	<p>Хог хаягдлын тухай хууль /2017/</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ</p> <p>ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ</p> <p>14 дүгээр зүйл. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх</p> <p>14.1. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан байна.</p> <p>14.2. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.</p>

	<p>14.3. Энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.</p> <p>14.4. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө.</p> <p>14.5. Энэ хуулийн 14.4-т заасан хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгнө.</p> <p>14.6. Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.</p> <p>14.7. Энгийн хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.</p> <p>14.8. Энэ хуулийн 14.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга</p>
<p>31 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.</p> <p>6 дугаар зүйл.Хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл</p> <p>6.1. Хөгжлийн бодлогын баримт бичиг нь дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран дараах төрөлтэй байна:</p> <p>6.1.1. урт хугацааны;</p> <p>6.1.2. дунд хугацааны;</p> <p>6.1.3. богино хугацааны.</p> <p>6.2. Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.</p> <p>6.3. Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:</p> <p>6.3.1. төрөөс баримтлах бодлого;</p>

	<p>6.3.2. бүсчилсэн хөгжлийн бодлого;</p> <p>6.3.3. аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.</p> <p>6.4. Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:</p> <p>6.4.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;</p> <p>6.4.2. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;</p> <p>6.4.3. Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;</p> <p>6.4.4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.</p> <p>6.5. Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна:</p> <p>6.5.1. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;</p> <p>6.5.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;</p> <p>6.5.3. Энэ хуулийн 6.5.1-д заасан үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв.</p> <p>6.6. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг Засгийн газар батална.</p>
<p>32 Хөдөлмөрийн тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулах харилцаа</p> <p>4.1. Энэ хуулиар дор дурдсан талуудын хоорондын хөдөлмөрийн гэрээний болон түүнээс уламжилсан хөдөлмөрийн бусад харилцааг зохицуулна:</p> <p>4.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага болон Монгол Улсын иргэн хоорондын;</p> <p>4.1.2. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон Монгол Улсын иргэн хоорондын;</p> <p>4.1.3. Дотоодын аж ахуйн нэгж, байгууллага болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн хоорондын;</p>

		<p>4.1.4. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, харьяалалгүй хүн хоорондын.</p> <p>4.2. Эд хөрөнгө болон хөдөлмөрөө нэгтгэн ажиллагчид нь хөдөлмөрийн харилцааны талаар журам тогтоогоогүй, эсхүл энэ хуулийг мөрдөхөөр тохиролцсон бол энэ хуулийн холбогдох заалтыг хэрэглэнэ.</p> <p>4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон хөдөлмөрийн нөхцөлтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.</p>
33	<p>Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль /2012/</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь хөрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтөөс сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>6 дугаар зүйл.Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх нийтлэг арга хэмжээ</p> <p>6.1. Хөрс хамгаалахад дараах нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>6.1.1. Сул зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд сэргийлэх;</p> <p>6.1.2. Дунд зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд сааруулах;</p> <p>6.1.3. Хүчтэй зэрэглэлийн доройтол илэрсэн хөрсөнд тэмцэх;</p> <p>6.1.4. Хөрсийг нөхөн сэргээх;</p> <p>6.1.5. Хөрс хамгаалах чиглэлээр чадавхийг бэхжүүлэх;</p> <p>6.1.6. Олон салаа зам гаргахгүй байх.</p> <p>6.2. Цөлжилттэй тэмцэхэд дараах нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>6.2.1. Бүс нутгийн онцлогт тохируулан газрын тогтвортой менежментийг бий болгох;</p> <p>6.2.3. Усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нэмэгдүүлэх;</p> <p>6.2.5. Тариалангийн талбайн хөрс хамгаалах.</p> <p>7.1.4. Бэлчээрийг тухайн орон нутгийн малын тоо толгойд тохируулан улирлын хуваарьтай ашиглах.</p> <p>7.2. Хот тосгон, суурин газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p>

	<p>7.2.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх;</p> <p>7.2.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх;</p> <p>7.2.3. Барилга байгууламж барьж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх;</p> <p>7.2.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх;</p> <p>7.2.5. Тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох.</p> <p>7.3. Тусгай хэрэгцээний газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>7.3.2. Аймаг дундын отрын бэлчээрийн болон улсын тэжээлийн сангийн хадлангийн талбайн газрыг хуваарьтай сэлгэн ашиглах;</p> <p>7.4.3. Хөрсний ялзмаг, үржил шимийг тогтоох, доройтлоос хамгаалах зорилгоор гуу, жалга үүсэж болох газарт хаалт хамгаалалт хийх, ойжуулах.</p>
<p>34 Хөрөнгө оруулалтын тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын орчныг тогтворжуулах, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох болон хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.</p> <p>5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хэлбэр</p> <p>5.1. Хөрөнгө оруулалтыг Монгол Улсад дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1. Хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;</p> <p>5.1.2. Хөрөнгө оруулагч хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;</p>

		<p>5.1.3. Компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;</p> <p>5.1.4. Концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;</p> <p>5.1.5. Санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх;</p> <p>5.1.6. Хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр.</p>
<p>35 Эрүүл ахуйн тухай /2017/</p>	<p>сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон хууль харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон хууль харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Хүрээлэн байгаа орчинд тавих эрүүл ахуйн шаардлага</p> <p>4.1. Хүн амыг ундны болон ахуйн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан усаар хангана:</p> <p>4.1.1. Ундны болон ахуйн ус нь эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан, аюулгүй байх;</p> <p>4.1.2. Ундны болон ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээг эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах;</p> <p>4.1.3. Харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг энэ хуулийн 4.9-т заасан стандартыг хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга хэрэгжүүлэх;</p> <p>4.1.4. Хүн амын хэрэглэж байгаа ундны болон ахуйн усны чанар, аюулгүй байдалд тухайн нутаг дэвсгэрийн төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамж хариуцсан байгууллага, албан тушаалтан холбогдох стандарт, дүрмийн дагуу хяналт, шинжилгээ хийж, усны чанарыг сайжруулах арга хэмжээг авах;</p> <p>4.1.5. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийлгэх, гарсан үнэлгээний дагуу арга хэмжээг авах үүргийг тухайн шатны Засаг дарга хүлээх.</p> <p>4.2. Энэ хуулийн 4.1.5-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх зааврыг эрүүл мэндийн болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>

4.3. Хүн амын оршин суугаа орчны агаар нь эрүүл ахуйн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байна:

4.3.1. Хүний амьдрах, ажиллах, суралцах орчны агаар нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөргөөр нөлөөлөхгүй, агаарын чанарын нөхцөл, шаардлагыг хангасан, бохирдоогүй байх;

4.3.2. Хөдөлгөөнт эх үүсвэр, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бохирдуулах бодис гаргаж, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг эх үүсвэр ашигладаг байгууллагаас гарч байгаа утаа, тоосны хэмжээ нь агаарын чанарын стандартыг хангасан байх.

4.4. Хүн амын суурьшлын хөрс нь эрүүл ахуйн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан байна:

4.4.1. Оршуулгын газар, хог хаягдлын зориулалтын цэг, ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу байгуулж, ашиглах;

4.4.2. Хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэх, тогтоосон тусгай цэгт булшлах буюу зориулалтын байгууламжид устгах;

4.4.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх;

4.4.4. Энэ хуулийн 4.7-д заасан стандартын дагуу төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага барих, ашиглах.

4.5. Энэ хуулийн 4.4.2-т заасан хог хаягдлын жагсаалт, булшлах, устгах аргачлалыг эрүүл мэнд болон хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

4.6. Энэ хуулийн 4.4.3-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ногдох газартаа цэвэрлэгээ, арчилгаа хийж байгаа эсэхэд тухайн баг, хорооны Засаг дарга хяналт тавина.

4.7. Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжийн стандартыг барилгын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж,

	<p>стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p> <p>4.8. Цацраг идэвхт болон химийн хорт бодис, ионжуулдаг, ионжуулдаггүй туяа, физик хүчин зүйл /шуугиан, доргион, цахилгаан соронзон орон, радио долгион, хэт авиа зэрэг/-ийн үүсгүүр, нянгийн өсгөвөртэй ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж, иргэний аюулгүй ажиллагааны дүрмийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож, биелэлтийг хангана.</p> <p>4.9. Хүн амын ундны ус, хүний амьдрах орчны агаар, хөрсний эрүүл ахуйн стандартыг эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж, стандартчиллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p>	
36	<p>Эрчим хүчний тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1.“эрчим хүч” гэж эрчим хүчний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан, шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хийг;</p> <p>3.1.2.“эрчим хүчний нөөц” гэж цахилгаан, дулаан үйлдвэрлэх зориулалтаар ашиглаж болох бүх төрлийн түлш, сэргээгдэх болон бусад эх үүсвэрийг;</p> <p>3.1.3.“түлш” гэж цахилгаан, дулаан үйлдвэрлэхэд ашиглагдах бүх төрлийн нүүрс, занар, мазут, газрын тос, уран ба торийн хүдэр, тэдгээрийн дагавар бүтээгдэхүүн болон баяжмал, байгаль дээр оршиж байгаа биомасс, бусад органик материал, хийн түлшийг;</p>

3.1.4.“эрчим хүчний эх үүсвэр” гэж эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламжийг;

3.1.5.“нэгдсэн сүлжээ” гэж цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний нэгдлийг;

3.1.6. ”нэгдсэн сүлжээний дүрэм” гэж нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн хэсгийн техникийн үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг;

3.1.7.“цахилгаан дамжуулах сүлжээ” гэж нэгдсэн сүлжээ үүсгэж байгаа цахилгаан дамжуулах зориулалт бүхий 110 кв, түүнээс дээш хүчдлийн шугам, дэд станц, түүнчлэн энэ сүлжээнд холбогдсон, эсхүл техник, технологийн хувьд энэ сүлжээнд хамрагдах шаардлагатай бусад хүчдлийн шугам, дэд станцыг;

3.1.8.“цахилгаан түгээх сүлжээ” гэж эх үүсвэрээс шууд холбогдсон болон цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцаас хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх цахилгаан түгээх зориулалт бүхий 110кВ, түүнээс доош шугам, дэд станцыг;

3.1.9.“эрчим хүчний барилга байгууламж” гэж эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам, дэд станц болон технологийн зориулалттай бусад байгууламжийг;

3.1.10.“эрчим хүчний барилга байгууламж барих” гэж эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам, дэд станцыг барьж байгуулах, технологийн үндсэн тоноглолд техникийн шинэчлэл хийх, сэргээн засварлах, өргөтгөх үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэхийг;

3.1.11.“төвлөрсөн дулаан хангамж” гэж дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэдэг болон дулааныг дангаар үйлдвэрлэдэг эх үүсвэрээс диспетчерийн зохицуулалттайгаар, эсхүл төв суурин газрын нийт хэрэглээний 50 хувиас дээш хэсгийг шугам сүлжээгээр хангах үйл ажиллагааг;

3.1.12.“төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм” гэж төвлөрсөн дулаан хангамжийн бүрэлдэхүүн хэсгийн техникийн үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг;

	<p>3.1.13.“дулаан дамжуулах сүлжээ” гэж эрчим хүчний эх үүсвэрээс дулаан хуваарилах төв хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг;</p> <p>3.1.14.“дулаан түгээх сүлжээ” гэж дулаан хуваарилах төв, түүнээс хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг;</p> <p>3.1.15.“халаалтын улирал” гэж барилга, байгууламжийг дулаанаар хангах шаардлагатай, хүний ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон жилийн цаг агаарын дундаж үзүүлэлтэд тулгуурлан тогтоосон хугацааг....</p>
<p>37 Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.</p> <p>10 дугаар зүйл. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрх, үүрэг</p> <p>10.1.Үүрэг хүлээсэн хэрэглэгч дараах эрхтэй:</p> <p>10.1.1.эрчим хүчний аудитын байгууллагыг сонгох;</p> <p>10.1.2.эрчим хүчний аудитын зөвлөмж, дүгнэлтийн талаар үндэслэлтэй тайлбар өгөхийг шаардах;</p> <p>10.1.3.энэ хуулийн 13.4.2-т заасан зөвлөмжийг сонгон хэрэгжүүлэх;</p> <p>10.1.4.эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд урамшуулал эдлэх.</p> <p>10.2.Үүрэг хүлээсэн хэрэглэгч дараах үүрэгтэй:</p> <p>10.2.1.эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх;</p> <p>10.2.2.эрчим хүчний хэрэглээнд эрчим хүчний аудит хийлгэх;</p> <p>10.2.3.өөрийн байгууллагад эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;</p> <p>10.2.4.эрчим хүчний аудитын тайлан, эрчим хүч хэмнэлтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх;</p> <p>10.2.5.эрчим хүч хэмнэлтийн менежерийг томилох, чөлөөлөх, энэ тухай Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэх;</p> <p>10.2.6.эрчим хүчний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон гомдлыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх.</p>

11 дүгээр зүйл. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын бүрэн эрх
11.1.Иргэн, аж ахуй нэгж, байгууллага дараах эрх, үүрэгтэй:
11.1.1.эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр мэргэжлийн
үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас зөвлөгөө авах;
11.1.2.сайн дурын үндсэн дээр эрчим хүчний хэрэглээнд аудит
хийлгэх.

3.3 Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх засгийн газрын тогтоол

Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаанд улс төрийн орчинд хэрэгжүүлэхэд гаргасан аялал жуулчлалыг дэмжих бодлогуудын хүрээнд дараах УИХ, ЗГ –ын тогтоол, тушаалуудыг дараах байдлаар авч үзлээ. Үүнд аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, жуулчны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, дэд бүтцийг хэрэгжүүлэхийг тодорхой салбарын яамд, албан тушаалтанд үүрэг болгосон байна. Энэ нь Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, үйл ажиллагаагаа дэмжүүлэх бүрэн боломжтойг харуулж байна.

Хүснэгт 9: Засгийн газрын тогтоол

№	Тогтоолын нэр	Гол агуулга
1	Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай /2018.06.13-ны 171-р тогтоол/	<p>1. Монгол Улсын аялал жуулчлалын гол чиглэлийг 1 дүгээр хавсралт, Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын чиглэлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.</p> <p>2. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжил, жуулчны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, тээврийн дэд бүтцийн хөгжлийн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд, дээр дурдсан ажил, арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд, гол маршрутын дагуу хийгдэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгахыг Үндэсний хөгжлийн газрын дарга тус тус даалгасугай.</p> <p>3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймаг, нийслэлийн аялал жуулчлалын чиглэлүүдийг аялал жуулчлалын гол чиглэлтэй нийцүүлэн баталж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>
2	Аялал жуулчлалын санг бүрдүүлэх,	Сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

<p>зарцуулах, хяналт тавих журам батлах тухай засгийн газрын тогтоол /2001 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр/</p>	<p>а/монгол орны байгалийн үзэсгэлэнт газар, үндэсний соёл, хүн ардын зан заншил, түүхийг сурталчилсан кино, дүрс болон дууны бичлэг хийх, ном, ил захидал танилцуулга цомог хэвлэх, мэргэжлийн сонин, сэтгүүл гаргах, улсын болон олон улсын чанартай хурал, зөвлөлгөөн, дотоод, гадаадын үзэсгэлэн, яармаг зохион байгуулах;</p> <p>б/аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>в/аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг санхүүжүүлэх;</p> <p>г/байгаль, түүх, соёлын өвийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах.</p>
<p>3 Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 1995 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр</p>	<p>2. Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд 1995-1996 онд хэрэгжүүлэх ажлын хөтөлбөр-төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор баталж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Худалдаа, үйлдвэрийн яам (Ц.Цогт), Байгаль орчны яам (З.Батжаргал), Дэд бүтцийн хөгжлийн яам (Р.Сандалхан), Эрүүл мэндийн яам (П.Нямдаваа)-д даалгасугай.</p>
<p>4 Аялал жуулчлалын гадаад сурталчилгааны уриа үг батлах тухай /2014 оны 2 дугаар сарын 21-ний өдөр /</p>	<p>Монгол Улсын аялал жуулчлалын гадаад сурталчилгааны уриа үгийг англи хэлээр “Mongolia, Nomadic by Nature” гэж хэрэглэхээр тогтсугай.</p>
<p>5 Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр батлах тухай</p>	<p>Дөрөв. Хөтөлбөрийн зорилт</p> <p>4.1.1. Монгол Улсын түүх, соёл, урлагийн өв сан, спортын амжилтыг дэлхийн ард түмэнд таниулах, хуваалцах, хөгжүүлэх;</p> <p>4.1.2. эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</p>

/2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр/	<p>4.1.3. аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих;</p> <p>4.1.4. олон улсын спорт, уралдаан тэмцээнд амжилт гаргаж эх орныхоо нэр хүндийг өргөх.</p> <p>Тав. Гадаадад сурталчилгаа хийх тэргүүлэх чиглэл</p> <p>5.1.1. түүх, соёл, урлаг;</p> <p>5.1.2. аялал жуулчлал;</p> <p>5.1.3. үндэсний брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ;</p> <p>5.1.4. спорт, олон улсын арга хэмжээ.</p> <p>Ес. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт</p> <p>9.1.1. сурталчилсан брэндийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортын өсөлт;</p> <p>9.1.2. жуулчдын тоо;</p> <p>9.1.4. аялал жуулчлалын салбарт шинээр бий болсон ажлын байрны тоо;</p>
<p>6 Зарим нисэх буудлыг хилийн олон улсын боомт болгох тухай 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр</p>	<p>1. Дорнод аймгийн Чойбалсан, Ховд аймгийн Ховд, Өмнөговь аймгийн Даланзадгад, Хөвсгөл аймгийн Мөрөн хотын нисэх буудлуудыг зорчигч, ачаа тээврийн харилцааны хилийн олон улсын боомт байхаар тогтоосугай.</p> <p>2. Өмнөговь аймгийн Даланзадгад, Хөвсгөл аймгийн Мөрөн хотын нисэх буудлын хилийн олон улсын боомтыг 2012 оны 5 дугаар сараас нээн ажиллуулсугай.</p>

3.4 Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх сайдын тушаал, шийдвэр

Хүснэгт 10: Сайдын тушаал, шийдвэр

№	Тушаалын нэр	Гол агуулга
1	Журам батлах тухай /2019.10.29/ А/618	<p>1. “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг хавсралтаар баталсугай.</p> <p>2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газар, аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус үүрэг болгосугай.</p> <p>3.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам батлах тухай” Байгаль орчин, ногоон</p>

	хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06–ны өдрийн А-05 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
2	<p>Хоёр. Аялал жуулчлалын ажил үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл, ангиллын төрлүүд</p> <p>2.2.Аж ахуйн нэгж нь эрхлэх үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран тур-оператор /tour operator/ болон тур агент /tour agent/ гэсэн ерөнхий ангилалтай байх ба тур оператор нь үйл ажиллагааны онцлогоос хамааран олон улсын аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэх тур оператор /international tour operator/, гадаад орноос жуулчин хүлээн авах тур оператор /inbound tour operator/, гадаад орон руу жуулчин илгээх тур оператор /outbound tour operator/, дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэх тур оператор /domestic tour operator/ гэсэн төрөлтэй байна.</p> <p>2.2.1. Олон улсын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тур оператор /international tour operator/ нь гадаад орноос жуулчин хүлээн авах болон гадаад орон руу жуулчин илгээхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлэх ба дээрх чиглэлүүдээр дагнан 10-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, аялал жуулчлалын байгууллагад мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан 4-өөс дээш боловсон хүчинтэй байна.</p> <p>2.2.2. Гадаад орноос жуулчин хүлээн авах тур оператор /inbound tour operator/ нь А, В, С гэсэн 3 зэрэглэлтэй байх ба Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүрдүүлэх, сурталчлах, багцаар болон хэсэгчлэн худалдах, аялал зохион байгуулах, тээврийн хэрэгслийн тийз, байр үзвэрийн захиалга, аяллын бичиг баримтын бүрдүүлэлт хийх, виз авахтай холбогдсон үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>2.2.3. Гадаад орон руу жуулчин илгээх тур оператор /outbound tour operator/ гадаад улс орнуудад аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг төлөвлөх, бүрдүүлэх, дотоодод сурталчлах, багц болон хэсэгчлэн худалдах, аялал зохион байгуулах,</p>

тээврийн хэрэгслийн тийз, байр үзвэрийн захиалга, аяллын бичиг баримтын бүрдүүлэлт, виз авахтай холбогдсон үйлчилгээ үзүүлнэ.

2.2.4. Дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэх тур оператор /domestic tour operator/ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, бүрдүүлэх, сурталчлах, багцаар болон хэсэгчлэн худалдах, аялал зохион байгуулах, тээврийн хэрэгслийн, байрны, үзвэрийн захиалга, аяллын бичиг баримтын бүрдүүлэлттэй холбогдсон үйлчилгээ үзүүлнэ.

2.2.5. Гадаад, дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагааг зуучлагч тур агент /tour agent/ нь виз болон аяллын бичиг баримтын бүрдүүлэлт хийх, байр, хоол, унаа, үзвэрийн захиалга хийх, гадаад дотоодын тур операторын бүтээгдэхүүнийг гэрээний үндсэн дээр бүхэлд нь болон хэсэгчлэн зуучлан худалдаалахтай холбогдсон үйлчилгээ үзүүлнэ.

- 3** Тусгай хамгаалалттай газар нутаг аялал жуулчлал явуулах журам Байгаль орчны сайдын 2002 оны 117 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт
- ТХГН-т байнга байрлаж, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд БОС-ын 218 тоот тушаалаар "Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт газар ашиглах зөвшөөрөл олгох журам"-нд заасан нөхцөл болзлын дагуу БОЯ-ны холбогдох газраас "ТХГН-т газар ашиглах гэрчилгээ"-г олгоно.
2. ТХГН-т батлагдсан замын дагуу жуулчдыг аялуулах тохиолдолд ТХГН-ийн хамгаалалтын захиргаа, хамгаалалтын захиргаа байхгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг даргатай хийсэн гэрээний үндсэн дээр явагдана.
- Долоо. Хориглох үйл ажиллагаа
1. ТХГН дэвсгэрт газар ашиглах гурвалсан гэрээ байгуулаагүй, гэрчилгээгүй, эсвэл хугацааг нь сунгуулаагүй.
 2. Гэрээнд заагдаагүй үйл ажиллагаа явуулах.
 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй, уг үнэлгээнд ороогүй зураг, төслөөр барилга байгууламж барих, ашиглах.
 4. Аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж буй газраа өөр зориулалтаар ашиглах, бусдад хэсэгчлэн буюу бүтнээр нь шилжүүлэх, түрээслүүлэх, зарах, барьцаалах.
 5. Зөвшөөрөлгүйгээр байгалийн дагалт баялаг ашиглах, хөрс, ус болон байгалийн баялгаас дээж авах, амьтан барих,

ургамал түүх, мөн тухайн нутаг дэвсгэрт унаган бус амьтан, ургамал оруулж ирэх, түүх соёлын дурсгалт зүйлсийг гэмтээх, байрнаас нь хөдөлгөх.

6. "ТХГН-ийн тухай" Монгол улсын хууль болон тухайн газрын хамгаалалтын нийтлэг бөгөөд онцлог горим, мөн байгаль хамгаалах бусад хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаа явуулах.

7. Жуулчдыг батлагдаагүй замаар аялуулах.

8. Хуурай хог хаягдал, бохир усыг ил задгай хаяж хөрс, ургамал, агаарыг бохирдуулах болон байгаль орчны тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулах.

9. Нутаг дэвсгэрээрээ дайран өнгөрч яваа жуулчдаас журмаар батлагдсан жишгээс бусад хэлбэрээр татвар, төлбөр хураамж авахгүй байх.

3.5 Салбарын стандарт, журмууд

3.5.1.1 Аялал жуулчлалын үйл ажиллагааны стандарт

Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй оролцогч талуудад хамгийн өндөр нөлөөлөлтэй 18 стандартыг орууллаа.

Хүснэгт 11: Аялал жуулчлалын үйл ажиллагааны стандарт

№	Стандартын нэр, тэмдэглэгээ		
1	MNS - 2013 10х	6426	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
2	MNS - 2007 3х	5824	Аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлага
3	MNS - 2004 4х	5409	Чөлөөт цаг. Аялал жуулчлал. Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёо
4	MNS - 2013 10х	6426	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
5	MNS - 2009 7х	6043	Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага
6	MNS - 2002 12х	4934	Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага

7	MNS - 2008 9x	4588	Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ -Зочид буудалд тавих ерөнхий шаардлага
8	MNS - 2005 16x	4946	Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага
9	MNS - 2003 3x	5231	Жуулчны автотээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага
10	MNS 5738 - 2007 3X		Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ- Дэн буудал ерөнхий шаардлага
11	MNS 5374 - 2004 3X		Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ- Амралтын газрын үйлчилгээний чанар, үндсэн шаардлага
12	MNS 5231- 2003 3X		Жуулчны авто тээврийн үйлчилгээ, ерөнхий шаардлага
13	MNS 5537- 2005 12X		Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ- Авто зам дагуух үйлчилгээний байгууламж, үндсэн шаардлага
14	MNS 5021-1- 2005		“Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага
15	MNS 4946: 2019		“Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавих шаардлага
16	MNS 6777- 2019		“Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын нэр томъёо, тодорхойлолт”
17	MNS ISO 14001 - 2016 34x		Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар
18	MNS ISO 14015 - 2002 20x		Байгаль орчны удирдлага (менежмент) – Байрласан газар ба байгууллагын талаархи байгаль орчны үнэлгээ (БББОУ)

3.6 Аялал жуулчлалтай холбогдох бусад журам, гарын авлага

Хүснэгт 12: Аялал жуулчлалтай холбогдох бусад журам, гарын авлага

Баталсан эрх бүхий газар	Журам, гарын авлагын нэр	Гол агуулга
1 БОАЖЯ /2002.117- р тушаал 1/ явуулах журам	ТХГН-т аялал жуулчлал журам	Дөрөв. Аймаг, сум, дүүргийн Засаг даргын үүрэг, эрх 1. аялал жуулчлалын талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийг хангах, 2. ДЦГ, БЦГ-т аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөөг тухайн газрын хамгаалалтын захиргаатай, БНГ, ДГ-т аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөөг холбогдох

мэргэжлийн байгууллагатай хамтарч боловсруулах, биелэлтэнд хяналт тавих

3. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага болон тухайн хамгаалалтын захиргаатай хамтарч аялал жуулчлалын зориулалтын зам тогтоох, хоноглох, отоглох, түр буудаллах болон нэвтрэх цэг, мэдээллийн төвүүдийг батлагдсан зураг, төсвийн дагуу байгуулах, тохижуулах

4. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага болон тухайн хамгаалалтын захиргаатай ТХГН-т газар ашиглах гурвалсан гэрээ байгуулах;

5. БНГ, ДГ-ын аялал жуулчлал эрхлэх үйл ажиллагаанд хяналт тавих

6. БНГ, ДГ-т аялал жуулчлал эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагаас энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд үйл ажиллагааг нь түр зогсоох

7. Өөрийн нутаг дэвсгэрт хэрэгжих аялал, жуулчлалын үйл ажиллагааны төслийг хянаж санал өгөх

Долоо. Хориглох үйл ажиллагаа

1. ТХГН дэвсгэрт газар ашиглах гурвалсан гэрээ байгуулаагүй, гэрчилгээгүй, эсвэл хугацааг нь сунгуулаагүй

2. Гэрээнд заагдаагүй үйл ажиллагаа явуулах

3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй, уг үнэлгээнд ороогүй зураг, төслөөр барилга байгууламж барих, ашиглах

4. Аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж буй газраа өөр зориулалтаар ашиглах, бусдад хэсэгчлэн буюу бүтнээр нь шилжүүлэх, түрээслүүлэх, зарах, барьцаалах

5. Зөвшөөрөлгүйгээр байгалийн дагалт баялаг ашиглах, хөрс, ус болон байгалийн баялгаас дээж авах, амьтан барих, ургамал түүх, мөн тухайн нутаг дэвсгэрт унаган бус амьтан, ургамал оруулж ирэх, түүх

		<p>соёлын дурсгалт зүйлсийг гэмтээх, байрнаас нь хөдөлгөх</p> <p>6. "ТХГН-ийн тухай" Монгол улсын хууль болон тухайн газрын хамгаалалтын нийтлэг бөгөөд онцлог горим, мөн байгаль хамгаалах бусад хууль тогтоомжийг зөрчсөн үйл ажиллагаа явуулах</p> <p>7. Жуулчдыг батлагдаагүй замаар аялуулах</p> <p>8. Хуурай хог хаягдал, бохир усыг ил задгай хаяж хөрс, ургамал, агаарыг бохирдуулах болон байгаль орчны тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулах</p> <p>9. Нутаг дэвсгэрээрээ дайран өнгөрч яваа жуулчдаас журмаар батлагдсан жишгээс бусад хэлбэрээр татвар, төлбөр хураамж авахгүй байх</p>
2	Говь-Алтай аймгийн ЗДТГ, ИТХ	<p>Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021/</p> <p>4. Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогыг дараах таван тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ:</p> <p>1. Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ.</p> <p>2. Дэлхийн болон дотоодын зах зээлд өрсөлдөх Говь-Алтай аймгийн чадвартай, хувийн хэвшилд тулгуурласан экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийг олон талтай, мэдлэгт суурилсан болгоно.</p> <p>3. Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.</p> <p>4. Сумдыг бүсчилэн хөгжүүлж хөдөөгийн хөгжлийг хурдасгана. Аймгийн төв, сумдын төвүүдийг оновчтой хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана .</p> <p>5. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгож, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг арилгаж цөлжилтийг сааруулан экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.</p>
3	Говь-Алтай аймгийн ЗДТГ, ИТХ	<p>Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бодлого, аялал жуулчлалын бүсийн төлөвлөлт, Байгаль орчны бодлого</p>
4	Монгол улсын Тогтвортой хөгжлийн баримтлал-2030 -Аялал хөгжүүлэх хөтөлбөр /2015/	<p>үзэл үндэсний</p>

-Ногоон хөгжлийн
бодлого /2014/
-Ногоон хөгжлийн
бодлогыг хэрэгжүүлэх үйл
ажиллагааны төлөвлөгөө
/2018/

3.7 Аялал жуулчлалын салбарт нөлөөлөх үйлчилгээний технологи, монгол улсын болон олон улсын стандартууд

Говь-Алтай аймгийн 3 үндсэн 27 тусгай аяллын хөтөлбөрүүд ихэвчлэн тусгай сонирхолын аяллыг санал болгож байгаа учраас олон улсын тусгай сонирхолын аяллын стандартуудыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй юм. Тиймээс бид үйл ажиллагааг тогтмол хугацаанд магадлан итгэмжлүүлж ажиллана. Үүнд дараах стандартууд багтаж байна.

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СТАНДАРТ

2018 оны байдлаар Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт шууд хамаарах 394 үндэсний стандартыг мөрдүүлж байна.

	УСНЫ ЧИГЛЭЛЭЭР	147
	ХӨРСНИЙ ЧИГЛЭЛЭЭР	38
	АГААРЫН ЧИГЛЭЛЭЭР	47
	ОЙ ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР	61
	УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ, БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН	14
	БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР	29
	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ	25
	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН	9
	БУСАД	24

“Тогтвортой хөгжилд суурилсан ногоон хөгжлийн хэтийн зорилт”

2016-2018 онд “Тогтвортой хөгжилд суурилсан ногоон хөгжлийн хэтийн зорилт” дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулсан аймгуудын нэрс.

- Нийт 13: Улаанбаатар хот болон 12 аймаг
- 2016 онд Ховд, Архангай, Булган, Хэнтий,
- 2017 онд Хөвсгөл, Баянхонгор, Орхон,
- 2018 онд Төв, Дархан-Уул аймгууд боловсруулсан.
- Улаанбаатар хот, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорноговь аймгууд батлуулахад бэлэн болсон.



Зураг 25: Байгаль орчны аялал жуулчлалын стандарт

Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018 он, УБ хот

Хүснэгт 13: Үйлчилгээний технологи буюу олон улсын стандартууд

№	Тэмдэглэгээ	Стандартын нэр
1	ISO 21101:2014	Адал явдалт аялал жуулчлал – Аюулгүйн зөвлөмж – Үндсэн шаардлага
2	ISO/AWI 21902	Нийтэд зориулсан аялал жуулчлалд хамаарах үйлчилгээ – Үндсэн шаардлага ба санал зөвлөмж
3	ISO 18065:2015	Тусгай хамгаалалттай газарт нийтийн аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх – Үндсэн шаардлага
4	ISO 13810:2015	Аялал жуулчлалын үйлчилгээ - Үйлдвэржилтийн аялал жуулчлал
5	ISO 17679:2016	Аялал жуулчлалын үйлчилгээ – Спа – Үйлчилгээний шаардлага
6	ISO 13009:2015	Аялал жуулчлалын үйлчилгээ – Далайн эргийн аялал жуулчлалд тавих үндсэн шаардлага, санал зөвлөмж
7	ISO/TR 21102:2013	Адал явдалт аялал – Манлайлагчдын ур чадвар
8	ISO/TS 13811:2015	Аялал жуулчлалын үйлчилгээ – Байрлах хэрэгслийг барихад байгальд ээлтэй элементүүд хэрэглэх нь
9	ISO 18513:2003	Аялал жуулчлалын үйлчилгээ – Зочид буудал болон бусад төрлийн байрлах хэрэгслүүд- Нэр томъёо
10	ISO 21103:2014	Адал явдалт аялал – Мэдээлэл өгөх нь
11	ISO/AWI 22483	Адал явдалт аялал – Байрлах хэрэгсэл: Зочид буудал – Үйлчилгээний шаардлага.
12	ISO 14785:2014	Аялал жуулчлалын мэдээллийн төв – Жуулчинд мэдээлэл өгөх ба угтах үйлчилгээ – Үндсэн шаардлага
13	ISO/DIS 20611	Адал явдалт аялал – Сайн туршлагауд – Үндсэн шаардлага ба санал зөвлөмж
14	ISO 17680:2015	Аялал жуулчлал ба холбогдох үйлчилгээнүүд - Thalassotherapy – Үйлчилгээний шаардлагауд
15	ISO 20121:2012	Арга хэмжээний удирдлагын тогтолцоо – Үндсэн шаардлага ба гарын авлага
16	ISO 31000:2009	Эрсдлийн удирдлага – Зарчмууд ба гарын авлага
17	<u>CSN</u> <u>EN</u> <u>13809</u>	Аялал жуулчлалын үйлчилгээ – Аяллын агент болон тур операторууд
18	<u>CSN</u> <u>EN</u> <u>15565</u>	Аялал жуулчлалын үйлчилгээ- Мэргэжлийн хөтчийг бэлтгэх, сургах, чадавхжуулах хөтөлбөр, гарын авлагад тавигдах шаардлагауд
19	ISO 50001	Эрчим хүчний удирдлагын тогтолцоо

20	ISO 14001	Байгаль орчны удирдлагын тогтолцоо
21	ISO 9001	Чанарын удирдлагын тогтолцоо
22	Аялал жуулчлалын ёс зүйн ерөнхий дүрэм – Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан.	

3.8 хэлэлцээрүүд

3.8.1 Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын хөгжүүлэхэд байгаль орчны гэрээ хэлэлцээр

Байгаль орчны чиглэлээр байгуулсан засгийн газар хоорондын хэлэлцээр

1. БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр /1990.05.06/
2. Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1993. 07.10/
3. Монгол улсын Засгийн газар, Оросын холбооны улсын Засгийн газрын хооронд Байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр /1994.02.15/
4. Хилийн усыг хамгаалах болон ашиглах тухай Монгол улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1995. 02.15/
5. Хилийн усыг хамгаалах болон ашиглах тухай Монгол улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1994.04.29/
6. Ус, цаг уур, орчны мониторингийн салбарт шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах тухай Монгол улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн хоорондын хэлэлцээр /1994.04.05/

3.8.2 Байгаль орчны чиглэлээр байгуулсан байгууллага хоорондын хэлэлцээр

1. Монгол Улсын Байгаль Орчны Яам, Японы Цүкүбагийн Их Сургуулийн газрын шинжлэх ухааны хүрээлэнгийн хооронд цаг уур, байгаль орчны талаар хамтран ажиллах хэлэлцээр /1993.05.05/
2. Монгол Улсын Байгаль Орчны Яам, ОХУ-ын Орчны Хамгаалалт, Байгалийн Нөөцийн Яам, БНХАУ-ын Байгаль Хамгаалах Агентлагийн хооронд Монгол, Орос, Хятадын хамтарсан дархан цаазтай газар байгуулах тухай хэлэлцээр /1994.03.29/

3. Монгол Улсын Байгаль Орчны Яам, ОХУ-ын Ойн Аж Ахуйн Улсын Албаны хооронд ойн аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр /1995.04.05/
4. Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам, Байгаль Орчны Яам болон Унгар Улсын Тээвэр Холбоо, Усны Аж Ахуйн Яамны хооронд усны аж ахуйн салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх тухай меморандум /1995/
5. АНУ-Ын Агаарын Нислэг, Сансрын Уудмыг Шинжлэх, Судлах, Үндэсний Газар /NASA/ болон Монгол Улсын Зайнаас Тандан Судлах Үндэсний Төв /NRSC/-ийн хооронд 1 километр ялгах чадвартай мэдээлэл цуглуулах талаар хамтран ажиллах тухай харилцан ойлголцох меморандумд нэмэлт өөрчлөлт оруулах хэлэлцээр /1995.12.07/
6. Монгол Улсын Байгаль Орчны Яам, Бранденбургийн Байгаль Орчин, Байгаль Хамгаалах, Газар Зохион Байгуулах Яамны хооронд харилцан ойлголцох меморандум хэрэгжүүлэх хүрээнд байгуулсан гэрээ.
7. Харилцан ойлголцсон тухай санамж бичиг /1996.10.03/
8. Монгол Улсын Байгаль Орчныг Хамгаалах Алба, БНСУ-ын Ойн Аж Ахуйн Захиргааны хооронд ойн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан ойлголцох тухай санамж бичиг /1996.10.25/

Дэлхийн аялал жуулчлалын эрх зүйн орчны судалгаа явуулахад байгаль орчинд ээлтэй, эерэг үйл ажиллагаа явуулахыг чухалчлан үзэж байгаа бөгөөд Монгол улсад аялал жуулчлалын үйл ажиллагааг тогтвортой явуулахын тулд унаган байгаль орчин, үндэсний өв соёл дээр түшиглэсэн, аюулгүй ажиллагааг эрхэмлэсэн, олон улсын стандарт шаардлагад нийцсэн бодлогыг баримтлах нь чухал цаг үе болсон байна. Ийм ч учраас Монгол улс олон улсын байгаль хамгааллын 22 гэрээ конвенцэд нэгдэн орсон байна. Тиймээс дараах барилгын салбарын стандартаас Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай стандартуудыг ашиглах юм.

Хүснэгт 14: Байгаль орчны салбарт нэгдэн орсон гэрээ конвенц-протоколууд

№	Огноо	Байгаль орчны салбарт нэгдэн орсон гэрээ конвенц-протоколууд
1	1945 он 2002 он	Далайн халим агнуурыг зохицуулах конвенци батлагдсан Монгол улс нэгдэн орсон.
2	1971 он 1997 он	Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенц батлагдсан. /Иран улс/ Монгол улс нэгдэн орсон.

3	1973 он 1996 он	Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Вашингтоны конвенц /CITES/ батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
4	1979 он 1999 он	Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай Бонны конвенц (CMS) батлагдсан. /ХБНГУ/ Монгол улс нэгдэн орсон.
5	1985 он 1996 он	Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн конвенц батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
6	он 1996 он	Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протокол батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
7	1989 он 1997 он	Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих Базелийн конвенц батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
8	1993 он	Биологийн төрөл зүйлийн тухай конвенци /НҮБ-ын суурь/ ба Биологийн төрөл зүйлийн тухай конвенцийн био аюулгүй байдлын тухай Картагений протокол батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
9	1993 он	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенци батлагдсан Монгол улс нэгдэн орсон.
10	1993 он	Бразилийн Рио де Жанейро хотод хуралдсан Дэлхийн дээд хэмжээний уулзалтаар “Биологийн олон янз байдлын тухай Конвенц (CBD)”-ийг баталсан.
11	1992 он 2005 он	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ –ийн суурь конвенцийн Киотогийн протокол /НҮБ-ын суурь/ батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
12	1994 он 1996 он	Ган цөлжилтөнд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ийн конвенц батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
13	1998он 2000	Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх тухай Роттердамын конвенц батлагдсан Монгол улс нэгдэн орсон.
14	1998 он	Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах талаарх Аархусын конвенц батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
15	2004	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стогкольмын конвенц батлагдсан.

		Монгол улс нэгдэн орсон.
16	2002	Биологийн олон янзын байдлыг хамгаалах, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө учруулж болзошгүй хувиргасан амьд организмтэй аюулгүй харьцах, зөөвөрлөх, хэрэглэх, зохих түвшний хамгаалалтыг бүрдүүлэх, улсын хилээр дамжуулан нэвтрүүлэх үед онцгой анхаарах тухай био аюулгүй байдлын Картагены Протокол батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
17	2011 он	Биологийн олон янз байдлын тухай Конвенцийн Генетик нөөцийн ашиглалт, түүнээс гарах үр шим, ашгийг харилцан тэгш, шударга хуваарилах тухай Нагоягийн Протокол батлагдсан. Монгол улс нэгдэн орсон.
18	2008	"Байгаль орчны мэдээллийг чөлөөтэй солилцох тухай Европын хамтын нийгэмлэгийн удирдамж"
19	2008	Хүний сайн сайхан байдал ба ус, чийг бүхий намгархаг газрын тухай Чангвоны тунхаглал

Монгол улсын хэмжээнд нийт 5900 орчим стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй оролцогч талуудад хамгийн өндөр нөлөөлөлтэй 18 стандарт байна.

Хүснэгт 15: Аялал жуулчлалын салбарт баримтлах стандарт

№	Стандартын тэмдэглэгээ	Стандартын нэр, тэмдэглэгээ
19	MNS - 2013 10х	6426 Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
20	MNS - 2007 3х	5824 Аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлага
21	MNS - 2004 4х	5409 Чөлөөт цаг. Аялал жуулчлал. Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёо
22	MNS - 2013 10х	6426 Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
23	MNS - 2009 7х	6043 Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага
24	MNS - 2002 12х	4934 Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага

25	MNS	4588	Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ -Зочид буудалд тавих ерөнхий шаардлага
	- 2008 9x		
26	MNS	4946	Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хоолны газрын ангилал, зэрэглэл. Ерөнхий шаардлага
	- 2005 16x		
27	MNS	5231	Жуулчны автотээврийн үйлчилгээ.Ерөнхий шаардлага
	- 2003 3x		
28	MNS 5738 - 2007		Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ- Дэн буудал ерөнхий шаардлага
	3X		
29	MNS 5374 - 2004		Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ- Амралтын газрын үйлчилгээний чанар, үндсэн шаардлага
	3X		
30	MNS 5231- 2003 3X		Жуулчны авто тээврийн үйлчилгээ, ерөнхий шаардлага
31	MNS 5537- 2005		Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ- Авто зам дагуух үйлчилгээний байгууламж, үндсэн шаардлага
	12X		
32	MNS 5021-1- 2005		“Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага
33	MNS 4946: 2019		“Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавих шаардлага
34	MNS 6777- 2019		“Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын нэр томъёо, тодорхойлолт”
35	MNS ISO 14001		Байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар
	- 2016 34x		
36	MNS ISO 14015		Байгаль орчны удирдлага (менежмент) – Байрласан газар ба байгууллагын талаархи байгаль орчны үнэлгээ (БББОУ)
	- 2002 20x		

3.8.3 Говь-Алтай аймагт зочилох жуулчдын тээвэрлэлтэй холбоотой стандартууд

Бараа бүтээгдэхүүн, хүн тээврийг хийх тээврийн салбарын стандартуудыг дараах хүснэгтээр авч үзлээ. Үүнд

Хүснэгт 16: Тээврийн салбарын стандартууд

Стандартын нэр	Стандартын код	Стандартын хуудасны тоо
Техникийн найдварт ажиллагааны үндсэн нэр томъёо, тодорхойлолт тайлбар толь	MNS 3831:2003	11
Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ	MNS 5346:2003	6
Автомашин угаалгын үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага.	MNS 5347:2003	5
Жуулчны автотээврийн үйлчилгээ	MNS 5231:2003	3
Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага	MNS 4597:2003	90
Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага	MNS 4759:2003	32
Замын тээврийн хэрэгслийн ерөнхий асуудал. Автотээврийн хэрэгслийн хэрэглээний үзүүлэлтүүд. Ангилал. Ерөнхий шаардлага	MNS 4470:2005	9
Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж. Үндсэн шаардлага	MNS 5537: 2005	12
Замын тэмдгийн гэрэл ойлгогч. Техникийн шаардлага	MNS ASTM D 4956:2005	9
Замын гэрлэн дохио ба үндсэн үзүүлэлт	MNS 4980:2006	10
Барилгын ширхэгийн ба нурмаг ачаа тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага	MNS 5645:2006	7
Үр тариа, гурил, будаа тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага	MNS 5649:2006	4
Төмс, хүнсний ногоо тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага	MNS 5648:2006	4
Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх журам	MNS 4596:2007	75
Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага	MNS 5342:2007	7

Нийтийн такси үйлчилгээ. Ангилал ба тодорхойлолт. Ерөнхий шаардлага	MNS 5122:2008	9
Хурд сааруулагч. Техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм	MNS 5968:2009	8
Автотээврийн хэрэгсэл төрөл, нэр томъёо, тодорхойлолт	MNS ISO 3833:2010	13
Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв. Ангилал. Ерөнхий шаардлага	MNS 5044:2010	6
Авто үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага	MNS 5025:2010	6
Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт	MNS 4601:2011	15
Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага	MNS 5012:2011	11
Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага	MNS 4598:2011	15
Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5343:2011	7
Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5344:2011	5
Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага	MNS 5345:2011	5
Автотээврийн үйлчлгээ. Зорчигч тээврийн автобуудал. Ерөнхий шаардлага	MNS 6300:2011	13
Нийтийн тээвэр. Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага	MNS 5879:2012	11
Автотээврийн хэрэгсэл. Техникийн хяналт болон үйлчилгээний үед ажилласан хийн хорт бодисын агууламжийг хэмжих аргууд	MNS ISO 3929:2014	
Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо. Зааврыг ашиглах хэрэгцээ шаардлага	MNS 39001:2014	ISO 44
Монгол Улсад үйлдвэрлэсэн авто тээврийн хэрэгсэлд MNS ISO 3779:2010 (VIN) стандартыг хэрэглэх заавар	MNS 6512:2015	15
Автотээврийн хэрэгсэл. Нийтийн тээврийн автобусны жолоочийн ажлын байранд тавигдах	MNS ISO 16121-1:2016	15


эргономикийн шаардлага. 1-р хэсэг: Ерөнхийтодорхойлолт, үндсэн шаардлага.		
Автотээврийн хэрэгсэл. Нийтийн тээврийн автобусны жолоочийн ажлын байранд тавигдах эргономикийн шаардлага. 4-р хэсэг: Жолоочийн бүхээгийн орчин	MNS ISO 16121-7	
Авто замын төлбөр хураах цэг. Ерөнхий шаардлага	MNS 6592:2016	11
Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт. Нэр томъёо тодорхойлолт	MNS 6593:2016	26
Автотээврийн салбарын ажилчдын ажил мэргэжлийн стандарт	MNS 6595:2016	23
Мотоцикл болон мопедийн жолооч болон зорчигчийн хамгаалах малгай болон шилэн нүүрэвч	MNS 6629 : 2016	54

3.9 Олон улсын үндэсний паркуудын дүрэм

3.9.1 Франц улс дах үндэсний паркуудын дүрэм

Франц улсын аялал жуулчлалын сайтад (<http://www.parcsnationaux.fr/fr>) дурдсанаар Франц улсад 2019 оны байдлаар 11 үндэсний парк байна. Эдгээр паркуудад жил бүр 8 сая жуулчин зорчдог. Францын үндэсний паркуудын гол онцлог нь байгаль, ус, газар нутгийн баялгаа хамгаалах гол зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Францын үндэсний паркийн журам



Зураг 26: Францын үндэсний паркийн журам

Үндэсний парк 2 гол хэсэгтэй. Байгаль бол баялаг гэхдээ эмзэг. Тиймээс байгалиа хамгаалах хэрэгтэй.

- Паркийн төв хэсэг бол паркийн хамгаалалттай зүрхэн хэсэг. Энэ хэсэгт аялагчид чөлөөтэй, дурын үйл ажиллагаагаа явуулж болохгүй.
- Гишүүнчлэлийн хэсэг. Парк нь тусгай хэдэн заавартай. Энд паркийн хөгжилд хувь нэмэр оруулах гишүүнчлэлт хувь хүн болон хамтрагч байгууллагууд ихэвчлэн хамрагддаг. Жишээ нь: Зар сурталчилгаа байрлуулж болох эсэх, моторт хөдөлгүүр байрлуулж болох эсэх гэх мэт дотоод дүрэмтэй. Байгаль хамгаалагч нар тусгай зөвшөөрөлтэй. Тэд мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх гол үүрэгтэй. Хэрвээ дүрэм зөрчсөн аялагчид байвал хариуцлага тооцох эрхтэй. Паркийн зүрхэн хэсэгт юу хийж болох эсхүл юу хийж болохгүйг сайтар тайлбарлаж өгөх ёстой.










Паркад дараах дүрмүүд үйлчилдэг. Үүнд:

- Паркийн төв хэсэгт мөрдөх дүрэм
- Аялагч, алхагч, зорчигчид зайлшгүй мэдэх ёстой дүрэм.
- Майхан барьж буудаллах дүрэм

Майхан барьж буудаллах, майхангүй буудаллах зэргээс хамаарч өөр дүрмүүд үйлчилнэ. Олон өдрөөр нэг газраа майхан барихгүйгээр байрлаж болдог газар бас байдаг.

Хүснэгт 17: Тээврийн салбарын стандартууд

Тэмдэглэгээ	Тайлбар
	Майхан юмуу халхавч /сүүдрэвч барих хориотой.
	<p>Паркийн хязгаарлагдмал хэсэгт 1-2 цагаас илүү алхаж болохгүй. Машинаа зогсоолд байрлуулна. Чиргүүлтэй машин, майхан, халхавч хориотой. Гал түлэх, плитка асаах, барбекью хийх хориотой. Гал түймрийн аюулаас сэргийлж гал хэрэглэх хориотой. Мөн газрыг гэмтээх, цэцэг ургамал сүйтгэхээс хамгаална.</p> <p>Barels (commune de Guillaumes), Molières et Torte (commune de Valdeblore), Valabres (commune de Roure), Vignols (commune de Roubion), Bousieyas et Le Pra (commune de St-Dalmas-le-Selvage) - ийн малчид л галын аюулгүй байдал хангасан тохиолдолд барбекью хийж болно. Тэд галын аюулгүй байдал хангасан плитка л зөвхөн тусгай зөвшөөрлөөр хэрэглэж болно.</p>
	<p>Нохой хориотой.</p> <p>Зөвхөн хоточ нохой эсвэл хараагүй хүмүүст тусалдаг, хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусалдаг нохойг зөвшөөрнө.</p> <p>Нохойгоо заавал уяагаар оосорлосон байх ёстой.</p>
	<p>Хог хаягдал хаях, чимээ шуугиан гаргах, элдэв юм бичих хориотой</p> <p>Паркийн дотор хог хаягдал хаяж болохгүй. Хог хаягдлаа авч яваад хогийн саванд хийнэ.</p>
	<p>Байгаль орчинд таагүй нөлөөлөх дуу чимээ гаргаж болохгүй.</p> <p>Радио, дефузер, чанга яригч, чанга дугарах өгсөгч болон янз бүрийн аппарат, хэрэгсэл хэрэглэхгүй.</p>
	<p>Чулуу, барилга, мод, самбар дээр бүх төрлийн бичвэр бичих, зураг, сийлбэр хийх, зурах хориотой</p>
	<p>Буу хэрэглэх хориотой. Ан хийх, буу барьж явах хориотой</p>

	<p>Загасчлал Загас барих бол заавал зөвшөөрөлтэй байх ёстой. Завин дээрээс загас барихыг хориглоно.</p>
 	<p>Байгаль дээр байгаа зүйлс, байгалийн чулуу, амьтны яс, цэцэг дураараа түүж авч болохгүй</p>
 	<p>Моторт машин хориотой Ихэнхи газруудад машин тавих хориотой, хурд хязгаартай Зарим газруудад үндэсний паркийн зөвшөөрөлтэйгээр малчид, оршин суугчид, үйлчилгээний ажилчид зорчиж болно.</p>
 <p>canyoning</p> 	<p>Спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаанууд, усны гүнд сэлэх г.м хориотой.</p>
 <p>navigation</p>	<p>Завиар явах хориотой</p>
	<p>Дугуй унах газруудыг дүрэмд оруулсан байх ёстой.</p>

	<p>Явган аялагч, морьтой аялагчид заасан замаар явах бөгөөд аялагчдын тоо хэмжээ тодорхой хязгаартай байна.</p>
	<p>Шүхэр, үсрэлтийн хэрэгсэл хориотой Чөлөөт шүхрээр уналтыг дүрэмдээ заасан. /Зарим газар 1000 метрээс дээш үсрэлтийг зөвшөөрдөг./</p>
	<p>Агаарын тээврийн хэрэгсэлээр 1000 метрээс доогуур нисэх хориотой. Аюулгүй ажиллагааны зайлшгүй шаардлагаар, зөвшөөрөлтэй бол нисч болно.</p>
	<p>Шинэ жим, зам гаргах хориотой.</p>
	<p>Merveilles, Fontanableu паркуудад дрон ашиглах хориотой. Паркийн удирдлагын тусгай зөвшөөрлөөр нисгэж болно.</p>
	<p>Хадны сийлбэр, дурсгал дээр гишгэж болохгүй</p>
	<p>Хадны сийлбэрт хүрч болохгүй</p>
	<p>Таяг, тулах төмөр хэрэгсэл зэргийг ашиглаж болохгүй</p>
	<p>Merveilles, Fontanalba паркуудад буудаллаж хоноглож болохгүй. Зөвшөөрөл авна.</p>

Эх сурвалж: Франц хэлнээс орчуулав. <http://www.mercantour-parcnational.fr/fr/le-parc-national-du-mercantour/la-reglementation/>

3.9.2 Канадын Кюбэк мужийн үндэсний паркуудад мөрдөх дүрэм

Эрүүл агаар ба хамгаалалт: Канадад мөрөө үлдээхгүй байх 7 мөрдлөг

Олон мянган хүмүүс жилийн турш байгаль, эрүүл агаар, байгальтай харьцах хүслээсээ болж Канадын үндэсний паркуудаар зочилдог байна. Аялагчид аялал зугаалгаар явахдаа байгальтайгаа зөв харьцаж байгалиа хамгаалж байх хэрэгтэй. “Leave No Trace” Америкийн хөтөлбөрийн канад хувилбар “Sans Trace Canada”=“Канадад мөрөө үлдээхгүй аялцгаая” хөтөлбөр нь эрүүл агаарт аялахдаа мөрдөх ёс зүйн код болох 7 мөрдлөгийг гаргасан.

Энэ Кюбэкийн үндэсний паркууд дотор олон төрлийн паркууд орсон. 80-парк 6995 км² газар нутгийг хамарсан

Бид бүгд паркуудаа хамгаалах үүрэгтэй. Бид гэдэгт аялагчид, паркийн удирдлага бүгд багтана. Паркад мөрдөх дүрэм нь байгалиа хамгаалахад бидний оролцоог чиглүүлэх ёс зүйн дүрэм, кодтой.

Ёс зүй ба журам

Хэрэв энэхүү журмыг аялагчид мөрдөхгүй бол паркийн удирдлагуудын хичээл зүтгэл талаар болно. Паркад зочлохдоо мөрдөх гол дүрэм журмуудыг хараарай.



Парк хамгаалах, сайжруулах үйл ажиллагаанд зориулж засгийн газраас Паркад зочлох үнийг тогтоосон. Та төлбөр төлсөн баримт болон жилийн турш хэрэглэх үнэмлэхтэй байх ёстой.



Үр хойчдоо байгалийн баялагаа хадгалж үлдээхийн тулд ан амьтан, ургамал, мод, чулуу зэрэгт хүрч болохгүй.



Ургамал цэцэг ногоо бол эмзэг. Олон мянган аялагчид явж байгаа учир явган аялагчдад зориулан гаргасан жимийг дагаж явах ёстой.



Байгаль бол өөрийн тэнцвэртэй. Амьтдад зориулсан өөрсдийнх нь идэх зүйлс байгаа. Тиймээс тэднийг хооллох хориотой. Та бүхэн өөрсдийн идсэн зүйлс болон хогоо хаяж болохгүй. Машинадаа хогоо тээвэрлэж авч явна.



Кюбэк мужийн паркуудад нохойгоо дагуулж явж болно. Зарим газруудад нохойг хориглоно. Харин хөтөч нохой болон аюулгүй байдлын туслагч нохойнууд бүх паркад орох эрхтэй. Өөр гэрийн тэжээмэл амьтдыг үндэсний паркад авчрах хориотой.



Хуваарилагдсан газартаа майхан барьж, гал түлэхийг зөвшөөрнө. Паркад олон хүмүүс байгаа тул хүмүүсийн тоо, машин хэрэгсэлийн тоо зэргийг тооцон амрах газрыг тооцоолон хуваарилдаг.



паркад хэт чанга чимээ шуугиан гаргахыг хориглоно.



Хог хаягдлаа хогийн цэгт хаяна. Байгальд хортой бодис, тос, саван, шатамхай зүйлсийг хаяхыг хориглоно. Ийм хог хаягдлыг аялагчид буцаан авч явах үүрэгтэй.



Аюулгүй байдлын үүднээс паркад зарим үйл ажиллагаа, тоглоомыг зөвшөөрөгддөг тул аяллаа төлөвлөхдөө зочлох паркынхаа үйл ажиллагаа дүрэм журмыг урьдчилан судлаж, заавар зөвлөгөө авах хэрэгтэй.



Үйлчлүүлэгчдийнхээ болон ан амьтад эко системд үзүүлэх нөлөөнөөс шалтгаалан ихэнх үндэсний паркуудад дрон хэрэглэхийг хориглоно.

Түлээ болон модны өвчлөл

Мод тээвэрлэлт нь модны өвчнийг тараадаг тул модонд зарим төрлийн шавж тээвэрлэгдэн ирж ойд модонд хохирол авчирч эрсдэлтэй байдаг тусл аялагчид хувиара түлээ авч ирэхийг хориглодог. Түлээг тухайн паркад ойрхон байрлах мод

бэлтгэлийн газраас бэлтгэдэг. Ой модыг хамгаалах байдал энэ мэт жижиг үйлдэлээс эхэлдэг байна.

3.9.3 Калифорни мужийн улсын паркийн журам

"ЗОХИЦУУЛАХ ДҮРЭМ, ЖУРМУУД"-ын хураангуй

Паркууд, Амралт, Чөлөөт Цагийн Удирдах Газар нь ирээдүй үеийнхний таатай сайхан байдлын төлөө болон паркад ирсэн хүмүүсийг аюулгүй, тэдэнд эвтэйхэн байлгахын тулд паркийн нутаг дэвсгэрийг хамгаалах зорилгоор баримтлах дүрэм, журмуудыг батлуулан мөрддөг байна. Паркад зочлох аяллаа таатай байлгахын тулд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай:

БАЙГАЛИЙН ҮЗЭХ ЗҮЙЛС, УРГАМАЛ, АМЬТДЫН АМЬДРАЛ нь улсын ихэнх паркуудын хувьд аялагч жуулчдыг татах гол зүйлс нь байдаг. Тэдгээр нь экосистемийн болон байгалийн ургамал, амьтдын аймгийн чухал бүтэц хэсгүүд юм. Ийм учраас Холбооны, Улсын болон Паркийн хуулиудын дагуу тэдгээрийг хамгаалж байдаг. Байгалийн эдгээр эх үүсвэр, нөөцийг хөндөх, гэмтээхийг хатуу хориглодог.

ЦЭНЭГЛЭСЭН ГАЛТ ЗЭВСЭГ БОЛОН АН ХИЙХ. Улсын Паркуудын Системийн нэгжүүд дотор ан хийхийг зөвшөөрдөггүй. Цэнэглэсэн галт зэвсэг, эсвэл хийн буу ашиглах хориотой юм. Харин Улсын Парк болон Амралт, Чөлөөт Цагийн Хорооноос тогтоож өгсөн, чөлөөт цагийн нутаг дэвсгэрт ан хийж болдог.

ХАТСАН, ӨГӨРСӨН БОЛОН УНАСАН МОД нь байгалийн өөрийн нөхцөл, төлөв байдлын хэсэг нь юм. Хатаж, муудаж байгаа ургамлууд нь ялзмаг агуулсан хөрс үүсгэдэг бөгөөд мод, бусад ургамлуудын ургалтыг дэмжиж байдаг. Иймээс хатсан, унасан модыг түүж авахыг хориглодог. Аялагч жуулчдад чирэгдэлгүй, эвтэй байлгахын тулд паркууд өөрсдөө түлээгээ худалддаг. (Харин эрсдэл, осолтой гэж тооцсон үед паркийн ажилтнууд хатсан, өгөрсөн модыг өөрсдөө хурааж, холдуулна.)

ГАЛ АСААХ бол зөвхөн ийм зорилгоор бэлтгэсэн тоног, хэрэгсэл дотор л асаахыг зөвшөөрдөг. Энэ нь гал түймэрийн аюулаас сэргийлэхэд зорилготой. Зөвхөн заасан газруудад зөөврийн зуухыг хэрэглэхийг зөвшөөрнө. Ирсэн аялагч жуулчид тамхи болон аливаа бусад шатах материалуудыг хэрэглэх бол маш өндөр сонор сэрэмжтэй байх нь тэдний үүрэг юм. Мөн бүх төрлийн салютыг хориглодог.

АМЬТАД, паркийн нэгжүүд дотор гэрийн тэжээвэр амьтдыг сул чөлөөтэй явуулж болохгүй. Өвс иддэг амьтдаас бусад бүх амьтдыг заавал дэргэд нь, биечилсэн хяналтанд байлгах ёстой. Нохдыг бол 1,8 м-ээс илүүгүй оосортой байлгах, эсвэл битүү автомашин, майхан, эсвэл тусгаарласан жижиг хашаан дотор хязгаарлах ёстой. Хэрэв өөрөөр заагаагүй бол, хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусалдагаас бусад нохдыг хүмүүс очдог газрууд, далайн эрэг, болон холбогдох бусад газарт байлгахыг хориглоно. Догширч болзошгүй, аюултай, чимээ шуугиантай, эсвэл бусад хүнд түвэг учруул магадгүй амьтдыг паркийн нэгжүүдээс гадагш гаргана.

ЧИМЭЭ ШУУГИАНТАЙ ХӨДӨЛГҮҮРЭЭР АЖИЛЛАДАГ, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРҮҮД. Бусдад түвэг учруулж болох ийм генератор, эрчим хүчний эх үүсвэрийг зөвхөн өглөөний 10:00 цагаас үдшийн 20:00 цагийн хооронд ажиллуулах боломжтой. Чанга дуу чимээг бүх хугацааны турш хориглодог бөгөөд энэ нь орой 10:00 цагаас өглөөний 6:00 цагийн хооронд унтдаг хүмүүст тээртэй байх эрсдэлтэй.

БҮХ ТӨРЛИЙН АВТОМАШИНЫ АЯЛАЛ -ыг тогтоосон зам, нутаг дэвсгэрээс хэтрүүлэхгүй хязгаарлах ёстой. Бүх төрлийн автомашины хурд нь кэмп, хээр хооллох орчин, хэрэглээний зүйлсийн, эсвэл удирдлагын байрлах талбайд болон хүмүүс цугларах бусад талбайд нэг цагт 15 миль (1 миль нь 1609метр) байна. Зөвхөн зориулалтын талбайд машин тавихыг зөвшөөрнө. Машин тавих зай талбайг хааж, хязгаарлахыг хориглоно.

КЕМПИЙН ТАЛБАЙГ АШИГЛАХ-ын өмнө төлбөрийг урьдчилан төлнө. Кемпийн талбайг урьдчилан захиалж авах, мөн уг талбайдаа заавал байрлах ёстой. Бусдын газар, талбай руу хэтрүүлж орохоос сэргийлэхийн тулд кемпийн талбай бүрийн хязгаарыг паркы байцаагч зохицуулж болно. Талбайг чөлөөлж өгөх хугацаа нь өдрийн 12:00 цаг байна. Аль болох олон зочдыг хүлээж авахын тулд аливаа нэг кэмпэд нэг зочны КЕМПИЙН ТАЛБАЙД БАЙРЛАХ ХЯЗГААР нь календарийн нэг жилд 30 хоног байна.

ХОГ ХАЯГДАЛ, тамхи, цаасан хайрцаг, лонх, үнс нурам болон бусад хог хаягдлыг зөвхөн зориулалтын сав болон цэгт үлдээнэ. Учир нь паркийг цэвэр байлгавал зочдод илүү таатай, бахархалтай байх боломжтой болно.

ТАМХИ ТАТАХ: чулуу шигтгэж зассан, эсвэл цементэн зам, эсвэл машин тавих талбайн тамхи татах газраас бусад газарт Улсын Паркууд дотор тамхи татахыг зөвшөөрдөггүй. 2020 оны 01-р сарын 01-с эхлэн, Сенатын 8-р Хуультай холбогдох хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тухайн сар өдөр, Нийтийн Эх Үүсвэр, Нөөцийн тухай Хуулийн 5008.10-т заахдаа “Улсын мэдлийн эрэг бүхий

газар дээр, эсвэл улсын паркийн системийн нэгж дотор аливаа хүн тамхи татаж болохгүй. Гэхдээ энэ хориг нь улсын эргийн, эсвэл улсын паркийн системийн нэгжийн чулуун, цементэн зам, эсвэл машин тавих талбайн тамхи татах зориулалтын газарт хамаарахгүй.” гэж заасан юм.

ДРОН: Одоогийн байдлаар дроныг Дүүргийн холбогдох түшмэл шийдвэр гарган байрлуулж, хориглосноос бусад газарт, Улсын Паркууд, Улсын Эргүүд, Улсын Түүхт Паркууд, Улсын Амралт, Чөлөөт Цагийн газрууд болон Автомашины Чөлөөт Цагийн Улсын газар нутгуудад зөвшөөрч байна. Дроныг хориглож магадгүй шийдвэрийг байрлуулах шалтгаанууд нь ховордсон амьтан, ургамлыг хамгаалах, соёлын болон байгалийн эх үүсвэр, нөөцөд үүсэж болзошгүй эрсдлийг багасгах, гал түймэр гарах өндөр осол, эрсдлээс сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдал, амралт, чөлөөт цагийн үеийн аливаа зөрчлүүдээс зайлсхийх, мөн бусдын хараа, анхаарлаас тусдаа байхыг хүссэн хувь хүмүүс, аялагч жуулчдад үүсэж болох сөрөг нөлөө, паркийн нэгжийн ангилал зэрэг олон шалтгаанаас хамаарч болно. Иймээс, дрон ашиглагчид нь өөрийн муж, дүүргийн Улсын Паркад аливаа, тухайлсан захирамж, шийдвэр гарсан, байрлуулсан эсэхийг үргэлж шалгах шаардлага тавигдана.

3.10 Говь- Алтай аймгийн аялал жуулчлалын салбарт мөрдөх дүрмийн санал

ГОВЬ-АЛТАЙ АЙМГААР АЯЛАГЧДЫН МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журмын зорилго нь Говь-Алтай аймгийн зорин очиж байгаа гадаад дотоодын жуулчид, аялагчид, нутгийн иргэдийн аялал жуулчлалын хэвийн үйл ажиллагаа, түүнд зүй зохистой оролцох, бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Аялал жуулчлалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Хог хаягдлын тухай болон бусад холбогдох Монгол улсын хуулиуд, Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр, Говь-Алтай аймгийн ерөнхий төлөвлөгөө, аймгийн ТХГН-ийн хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөө, бусад нийцүүлэн гаргасан дүрэм, журам эрх зүйн бусад актад нийцсэн байна.

1.3. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь байгаль орчны эко системийг алдагдуулахгүй, байгаль орчин, хүн болон нийгэмд эерэг байх ба хяналтын дор явагдана.

Хоёр. Аялал жуулчлалд оролцох

2.1. Энэхүү журмаас гадна тухайн орон нутгаас гаргасан дүрэм журам болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, түүнтэй холбогдох бусад дүрэм, журмыг чанд мөрдөн зөвхөн зөвшөөрөгдсөн отоглох цэг, жуулчны баазад байрлан, шаардлага, зааврын дагуу амарч аялах болно.

Гурав. Аялал жуулчлалын үйлчилгээнд оролцоход тавигдах нийтлэг шаардлага:

3.1. Говь-Алтай аймгийн төвд аялагч, болон иргэдэд журмыг танилцуулна.

3.2. Аялал жуулчлалын үйлчилгээнд оролцогсад доорхи шаардлагуудын дагуу ая тухтай, зөв зохистой амарч аялна.

Дөрөв. Отоглох цэгийн майхны үйлчилгээнд тавигдах шаардлага

- 4.1. Жуулчин, амрагчид отоглох цэг дээр ирж, майхнаа заасан газар барина.
- 4.2. Майхан хоорондын зай 5 метрээс доошгүй байх ба байгалийн үзэгдэл, салхи шуурга, аадар бороо, мөндөр, галын аюулгүй байдал, амрагчдын ая тух, аюулгүй байдлыг хангасан байна.
- 4.3. Отоглох цэгийн орчинд ил задгай жорлон ашиглахгүй, цэвэр цэмцгэр байдлыг эрхэмлэн, зөвхөн зориулалтын ариун цэврийн байгууламжийг ашиглана.
- 4.4. Бусад амрагчдын тав тухтай байдлыг хангах үүднээс оройны 22 цагаас хойш чанга дуу чимээ гаргахгүй.
- 4.5. Амрах цэг дээр бусдын амгалан тайван байдалд анхаарч нохой, муур гэрийн тэжээвэр амьтдыг оруулахгүй.
- 4.6. Машин, мотоцикль, ердийн хөсөг унаагаа зориулалтын заасан зогсоол дээр зөв байрлуулна.
- 4.7. Майхны орчимд гал түлэх, тамхи татах зэргийг хориглох ба зөвшөөрөгдсөн зориулалтын цэгт очиж үйлдэнэ.
- 4.8. Гал түлэх мод түлээг өөрсдөө авчрах шаардлагагүй, паркийн захиргаанаас хэлж авах ба төлбөрийг паркийн төлбөр дээр нэмж тооцно.
- 4.9. Отоглох цэгт байрлах хугацаандаа архи согтууруулах ундаа хэрэглэхгүй, бусдыг хүндэтгэж, зөв боловсон үйлчлүүлнэ.

Тав. Байршуулах хэрэгсэл болох жуулчны баазын үйлчилгээ, амрагчдад тавигдах шаардлага:

- 5.1. Жуулчны баазууд Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6426:2013 стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулах ба баазын дотоод дүрэм журам, ариун цэвэр, үйлчилгээний стандарт шаардлага, санамжийг аялагчид чанд дагаж мөрдөнө.
- 5.2. Жуулчны баазад байрлахад ёс зүйн дүрмийг баримтлах ба үйлчилгээний ажилчидтай зөв боловсон харьцана.
- 5.3. Баазын урьдчилсан захиалгыг шууд буюу паркийн захиргаанд урьдчилан мэдэгдэж, холбоо тогтоон баталгаажуулж болно.
- 5.4. Жуулчны баазуудын хоорондын зай 1км-ээс ойргүй байх гэрүүдийн зай хоорондоо 5км-ээс холгүй байна. Энэ нь амрагчдын аюулгүй ажиллагааг хангаж байгаа ба амрагчид галын аюул, дуу чимээг онцгой анхаарч байрлана.
- 5.5. Жуулчны баазын гадаа буудаллахыг хориглоно.

5.6. Жуулчны баазын хооллох газар, рестораны үйл ажиллагаа нь хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавигдах шаардлага MNS 4946:2019 стандартын дагуу явагдах ба амрагчид өглөөний хоолны цагийг мөрдөх ба захиалгат хоолоо цагтаа авч үйлчлүүлнэ.

5.7. Амрагчид гадаадын жуулчдын адил соёлч боловсон, чимээ шуугиангүй үйлчлүүлэх ба орой 22:00 цагаас хойш дуу чимээ гаргахгүй, нам гүм байхыг эрхэмлэнэ.

5.8. Ил задгай хог хаях, зөвхөн заагдсан цэг дээр байрлах ариун цэврийн байгууламжийг цэвэр нямбай ашиглана.

Зургаа. Хог хаягдлыг зайлуулахад тавигдах шаардлага

6.1. Аяллын явцад гарч буй хог хаягдлын асуудалд Хог хаягдлын тухай хуулийн дагуу хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, холбогдсон харилцааг зохицуулахад анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

6.2. Аливаа хог хаягдлыг ил задгай хаяхыг хориглоно. Гарсан хог хаягдлыг авч буцна.

6.3. Мөн аяллын зам дагуу хог хаяхыг хориглох бөгөөд тухайн аймаг, сум, суурин газрын зөвшөөрөгдсөн хог хаягдлын цэг хүргэж хаяна.

6.4. Хогийг хаяхдаа төрөлжүүлэн ангилж, хэмжээг багасгах ба аюултай хог хаягдлыг ил задгай хаяж болохгүй

6.5. Амрах явцад гарч байгаа хог хаягдыг нуурын уснаас хол, эмх цэгцтэй, салхинд алдахааргүй, уут саванд хийж битүүмжилнэ.

6.6. Амархан муудах, авч буцахад тохиромжгүй хог хаягдлыг паркийн заасан зориулалтын цэг хүргэж, хогийн саванд төрөлжүүлэн хийнэ.

6.7. Хогийг хаяхдаа шавж, мэрэгч амьтад, нохой, бусад амьтдаас хамгаалан битүүмжилсэн саванд хийж, тагийг сайтар таглана.

6.8. Хогийг шатааж болохгүй ба нийтийг хамарсан цэвэрлэгээг тогтмол хийж, орчныг хүний эрүүл мэнд, байгаль орчинд харшлахааргүй, цэвэр ариун байлгана.

Долоо . Аялал жуулчлалын орчны бүсд аяллын үед тавигдах шаардлага

- 7.1. Жуулчид, амрагчид аяллын зааварчлага, гарын авлага, самбарыг уншиж танилцан, шаардлагыг биелүүлнэ.
- 7.2. Байгаль эх байгалийн унаган байдлыг алдагдуулахгүй, “ул мөргүй аялах” зарчмыг баримтлах бөгөөд орчмын бүсийн байгалийн тогтоц, мод чулуу, дурсгалт газрын эд зүйлсэд гар хүрч болохгүй.
- 7.3. Аяллын бүс нутагт амьтдыг үргээж, цочоохгүй, идэх юм болон бусад эд зүйлсийг ил задгай хаяхгүй, зөв боловсон аялна.
- 7.4. Зөвшөөрөгдсөн бүсээс өөр газарт зугаалах, байгаль хамгаалагч болон байцаагч нарын тавьсан зүй ёсны шаардлагыг зөрчих үйлдэл хийхгүй байхыг анхаарна.
- 7.5. Хүмүүс амрах, байгалийн сайхныг мэдрэх гэж ирдэг тул хэт чанга чимээ шуугиан гаргаж, бусдад саад хийж болохгүй. Аль болох дуу чимээгээ бага байлгаж аялана.
- 7.6. Аялагчид элсэн дээр болон орчны бүсэд аюулгүй ажиллагааг мөрдөх ба зориулалтын бус газар отоглох, хооллох, орчныг бохирдуулахгүй, байгууламж, таниулах самбаруудыг эвдэж сүйтгэхгүй байхад анхаарна.
- 7.8. Нутгийн ёс заншил, уламжлалт зан үйл, байгалийн болон түүхийн дурсгалт зүйлсэд хүндэтгэлтэй хандан, нутгийн иргэдийг хүндэтгэж харьцана.
- 7.7. Аялагч жуулчид, амрагчид нь стандарт хангасан тэмээ, морин хөтөч, хүнсний бүтээгдэхүүн, цагаан идээ, бэлэг дурсгалын үйлчилгээг авч нутгийн иргэдийг дэмжинэ.

Найм. Морин, тэмээн аялалд тавигдах шаардлага

- 8.1. Морь, тэмээ унахдаа зөвшөөрөгдсөн мэргэжлийн хөтчийг паркийн захиргаанд урьдчилан захиалга өгч үйлчлүүлнэ.
- 8.2. Аялагч морь, тэмээн аялал эхлэхийн өмнө хувийн бэлтгэлээ сайн хийж, зориулалтын малгай, гуталаа хамгаалах түрүү, хувцаслалтандаа анхаарч, нарны малгай, цув г.м шаардлагатай зүйлсээ бэлдсэн байна.
- 8.3. Мэргэжлийн хөтчийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг анхааралтай сонсч, танилцан, гарын үсэг зурах ба хөлсийг урьдчилан төлнө.
- 8.4. Аялал цагаар болон өдрөөр байх тул сонголтыг зөв хийнэ. Өдөрт дунджаар 30-35 км аялна.
- 8.5. Морин, тэмээн аяллын дундуур шаардлагатай гэвэл 1 цаг тутамд бууж биеэ амрааж, чилээг гарган, морь, тэмээнийхээ олом, жирмийг шалгуулна.

8.6. Аяллын явцад бусдад саад хийн дуу чимээ гаргах, үргээх, бусдаасаа дур мэдэн ганцаар түрүүлэх, хоцрох гэх мэт зохисгүй үйлдэл хийхгүй бөгөөд ийм үйлдэл гаргаж буй бусдад шаардлага тавина.

8.7. Цаг агаарын саад бэрхшээл, бороо, шуургатай үед хөтчийн заавраар явж гэнэтийн үйлдэл хийж унаагаа үргээхгүй, мөн морь мал үргээхээргүй зөв зохистой хувцаслаж, биеээ зөв авч явж аяллыг дуусгана.

8.8. Морин, тэмээн аялалд оролцохын өмнө даатгалыг хийлгэж болно.

Ес. Хяналт, Хариуцлага

9.1. Энэхүү журамд ороогүй зүйлсийг Говь-Алтай аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Бодлого Зохицуулалтын Газар, Аймгийн Аялал Жуулчлалын Холбооноос шинэчлэх буюу дотоод журмаараа зохицуулна.

9.2. Журмыг аяллын бүсийн байгууллагууд мөрдлөг болгоход анхаарч хяналтыг тавьж ажиллана.

9.3. Журам зөрчиж, хохирол учруулсан тохиолдолд хариуцлагыг тооцон, дотоод журмын дагуу арга хэмжээ авна.

4. ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫ СУДАЛГАА

4.1 Үр дүнгийн тойм

Говь-Алтай аймгийн аяллын бүс нутагт зохион байгуулах бичил төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд санхүүгийн ерөнхий загварчлалыг ашигласан бөгөөд энэхүү загвар нь тогтвортой аялал жуулчлалын Жафари загвар, мөн Тейлорын онолд тулгуурласан болно.

Цаашлаад макро болон микро орчин, байгаль экологийн хүчин зүйлсийн нөлөөлөл өндөр байгаа нь судалгааны явцад илэрхий байсан бөгөөд эдгээр эрсдлийг харгалзан үзэж санхүүгийн тооцоололд тусгах зорилгоор 3 цэгийн шинжилгээний аргыг ашиглан сценари хувилбараар үнэлэв.

Сценари шинжилгээнд өөдрөг дэвшилтэт, бодит суурь, эрсдэлтэй гутранги зэрэг хувилбаруудыг дэвшүүлсэн ба эдгээрийн зэрэглэлийг тодорхойлохдоо орлого болон зардлын урсгалд индексийн үнэлгээ ашиглан тооцоолов. Сценари индексийг тооцоолохдоо макро болон микро орчин, байгаль экологийн хүчин зүйлс, ковид-19 вирусын нөлөөллийг шинжилсний үндсэн дээр дундаж үнэлгээ боловсруулж түүний стандарт хэлбэлзэл -0.2ээс +0.1 хооронд байгааг илрүүлэв. Тиймээс дээрх 3 хувилбарын хамгийн эрсдэлтэй хувилбарыг -0.2, бодит суурь хувилбарыг 0.0, өөдрөг хувилбарыг +0.1 гэсэн коэффициентуудаар тус тус тооцоолов.

КОВИД-19 цар тахлын дэгдэлттэй холбогдуулан Монгол Улсын 2020 оны эдийн засаг, нийгмийн төлөв байдлыг ҮСХ-ноос 2020 оны 4-р сарын 13-ны өдөр гаргасан нийгэм, эдийн засгийн байдлын статистик мэдээллээр 2020 оны эхний улирлын байдлаар улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс:

- Улсын нэгдсэн төсвийн орлого 8.6 хувиар, экспорт 41.5 хувиар, импорт 9.7 хувиар,
- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 19.9 хувь, тэр дундаа уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 29.8 хувиар,
- Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 33.4 хувиар, зорчигч 31.4 хувиар,
- Жуулчдын тоо 51.6 хувиар,
- Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 10.8 хувиар,
- Халдварт өвчнөөр өвчлөгчид 7.1 хувиар,
- Бүртгэгдсэн гэмт хэрэг 19.2 хувиар тус тус буурсан байна

Харин

- Нийт хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 25.9 хувиар,
- Улсын нэгдсэн төсвийн зарлага 19.3 хувиар,
- Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн тоо 9.9 хувиар тус тус өсжээ.

Эдийн засагт үзүүлж буй дээрх нөлөөллийг шинжилгээнд тусгасан бөгөөд энэхүү төсөл нь дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлын хугацааг тооцон үзээд 2023 оноос эхлэн бүрэн хэрэгжүүлнэ гэж үзвэл тус вирусын нөлөө буурах хандлагатай байна. Мөн түүнчлэн дээрх эрсдэлтэй байдлыг харгалзан үзээд тооцооллыг дотоодын жуулчдад тулгуурлан хийсэн болно. (Монгол иргэн, монголд амьдарч байгаа гадаад иргэн).

4.2 Говь-Алтай аймгийн аялал жуулчлалын салбарын эдийн засгийн өгөөж

Санхүүгийн ашиг, эдийн засгийн өгөөжийг нутгийн иргэд болон аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд хэрхэн нөлөөлж байгаа болон дэмжлэг үзүүлж байгааг эхний 10 жилийн байдлаар сциенари хувилбараар тооцон харуулав.

Тооцооллыг хийхдээ иргэдийн дундаж орлого, аймгийн иргэдийн орлого, Говь-Алтай аймгийн ДНБ, аймгийн хөдөлмөр эрхлэлт зэргийг 2000-2019 оны датанд суурилан 2031 он хүртэл таамаглалыг бодож гаргав. Эдгээр таамаглалд үндэслэн иргэдийн орлогын өсөлтийн %, Говь-Алтай аймгийн ДНБ өсөлтийн хувийг тооцсон болно. Тооцооллыг ,000 төгрөг (мянга)-өөр тоймлов.

- **Суурь хувилбар**
- **Өөдрөг хувилбар**
- **Эрсдэлтэй хувилбар**

4.3 Говь-Алтай аймгийн Эдийн засаг, хүн ам зүйн судалгаа

хүснэгт 18: днб-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь

ДНБ-Д ХУВИЙН ХЭВШЛИЙН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, бүс, аймаг, нийслэлээр										
2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
84.7	80.7	78.9	80.6	77.8	77.45	75.2	78.51	80.92	77.12	80.44



График 1: днб-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь

Графикаас харахад 2010 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр буюу 84.7 байсан бол 2016 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн бага дүн буюу 75.2 болж буурсан байна.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр															
	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр	46,587.4	55,716.5	75,002.9	62,783.6	65,977.1	89,180.9	125,825.4	164,803.4	219,617.4	232,001.7	239,171.2	268,537.4	321,816.6	333,345.0	410,467.9

Хүснэгт 19: дотоодын нийт бүтээгдэхүүн



График 2: ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр

Графикаас харахад уг үзүүлэлт 2006 оны байдлаар хамгийн бага буюу 46587.4 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 410467.9 болж өссөн байна.

Хүснэгт 20: нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн

НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр															
	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр	811.6	980.7	1337.8	1138.1	1223.2	1686.1	2375.5	3101.1	3890.3	4116.6	4243.9	4705.7	5562.2	5759.3	7087.9



График 3: НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Графикаас харахад уг үзүүлэлт 2006 оны байдлаар хамгийн бага дүн буюу 811.6 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 7087.9 болж өссөн байна.

ГОВЬ- АЛТАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ДЭГЭЭС ХИМ-БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ-1											
	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Хөдөө аж ахуй	43.5	43.6	52.1	57	48.4	55.1	55.2	56.7	57.7	52	54.24
Газар тариалан	1.5	0.8	0.8	0.6	0.3	0.5	0.6	0.5	0.6	0.6	0.62
Мал аж ахуй	41.5	42.6	51	56.3	48	54.4	54.2	55.6	57	51.2	53.45
ХАА-н бусад	0.6	0.2	0.2	0.1	0	0.3	0.4	0.6	0.2	0.2	0.17
Үйлдвэрлэл	2.3	10.1	7.8	8.2	17.7	11.1	12.5	13.3	15.7	17.5	19.18
Уул уурхай, олборлох	0.2	1.1	0.4	0	5.8	0.4	0.6	0.7	0.6	0.5	0.63
Боловсруулах	6	9	6.8	8.1	7.5	8.7	7.3	10.1	12.2	13.3	15.44
Цахилгаан, хий, уур хангамж; усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	-5.6	-1.3	-0.7	-1	3.5	1.2	3.7	2.1	2.3	2.8	1.84
Барилга	1.7	1.3	1.3	1.1	1	0.8	0.9	0.6	0.7	1	1.27
Үйлчилгээ	54.2	46.4	40.2	34.8	33.9	33.8	32.3	30	26.5	30.5	26.57
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	21.9	15.1	8.8	6	5.7	5.4	4.6	4.7	4.2	4.7	3.31
Тээвэр, мэдээлэл, холбоо	2	1.8	1.4	1.4	1.2	1.1	0.9	1	0.9	0.9	0.45
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	8.1	8.4	7.6	7.2	6.4	6	5.9	5.5	5.1	5.5	5.25
Бусад үйлчилгээ	22.3	21.1	22.4	20.2	20.5	21.3	21	18.8	16.4	19.4	17.56

Хүснэгт 21: Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц




График 4: Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц

Графикаас харахад хөдөө аж ахуйн үзүүлэлт 2010 оны байдлаар байдлаар хамгийн бага дүн буюу 43.5 байсан бол 2018 оны байдлаар 57.7 болж өссөн байна. Газар тариалан 2010 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 1.5 байсан бол 2014 оны байдлаар хамгийн бага дүн буюу 0.3 болж буурсан байна. Мал аж ахуй 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 41.5 байсан бол 2018 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 57 болж өссөн байна. ХАА-н бусад 2010 ба 2017 хамгийн өндөр дүн буюу 0.6 байна. Үйлдвэрлэл 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 2.3 байсан бол

2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 19.18 болж өссөн байна. Уул уурхай, олборлол 2013 оны байдлаар хамгийн бага дүн буюу 0 байсан бол 2014 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 5.8 болж өссөн байна. Боловсруулах 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 6 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 15.44 болж өссөн байна. Цахилгаан, хий, уур хангамж, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу -5.6 байсан бол 2016 оны байдлаар хамгийн өндөр буюу 3.7 болж өссөн байна. Барилга 2010 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 1.7 байсан бол 2017 оны байдлаар 0.6 болж буурсан байна. Үйлчилгээ 2010 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 54.2 байсан бол 2018 оны байдлаар хамгийн бага дүн буюу 26.5 болж буурсан байна. Худалдаа, зочид буудал, зоогийн газар 2010 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 21.9 байсан 2020 оны байдлаар 3.31 болж буурсан байна. Тээвэр, мэдээлэл холбоо 2010 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 2 байсан бол 2020 оны байдлаар хамгийн бага дүн буюу 0.45 болж буурсан байна. Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа 2011 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 8.4 байсан бол 2018 оны байдлаар хамгийн бага дүн буюу 5.1 болж буурсан байна. Бусад үйлчилгээ 2012 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 22.4 байсан бол 2018 оны байдлаар хамгийн бага дүн буюу 16.4 болж буурсан байна.

Хүснэгт 22: Дотоодын нийт бүтээгдэхүүн салбараар

Дотоодын нийт бүтээгдэхүүн											
	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
ДНБ, зах зээлийн үнээр	65977.1	89180.9	125.4	164.4	219.4	2320.017	2391.76	2685.03	3218.36	3333.01	4104.41
Хөдөө аж ахуй	28722.5	38854.7	655.423	939.349	349.3	1278.898	1320.549	1521.545	1858.319	1732.666	2226.515
Газар тариалан	988	669.5	105.03	106.0	742.2	1089.491	1535.433	1273.626	1900.513	2000.681	2538.836

Мал аж ахуй	27359.4	37963.2	642.23	927.23.4	105.506.9	1262.09.8.24	1295.86.2.27	1493.50.2.13	1833.11.0.92	1706.45.0.19	2194.12.6.93
ХАА-н бусад	375.1	222	269	151.5	100.2	590.543	933.311	1530.669	620.303	620.949	700.021
Үйлдвэрлэл	1518.7	8982	975.9	135.06.8	388.62.1	2568.4.29.5	2990.6.03.2	3573.3.96.9	5065.5.32.9	5847.6.22.2	7874.5.43.1
Уул уурхай, олборлох	148.3	1005.3	488.6	51.2	126.8.48	943.202	1481.888	1774.531	1865.617	1790.634	2603.12
Боловсруулах	3962.1	8013.6	859.7.3	132.99.4	163.91.2	2017.0.40.6	1751.1.91.9	2698.4.10.8	3923.3.57.4	4420.1.67.3	6337.6.95.9
Цахилгаан, хий, уур хангамж; усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	-3703.3	-1160.6	-938.9	-170.8.2	765.0.7	2686.717	8718.648	5499.758	7309.205	9247.476	7569.781
Барилга	1111.6	1123.8	161.2	186.4.4	213.5.3	1883.97	2193.577	1475.573	2246.934	3236.438	5195.571
Үйлчилгээ	35736	41344.1	505.24.1	573.61.7	744.06	7842.7.56.4	7721.0.17.4	8064.8.92.5	8532.9.39.8	1016.02.1.3	1090.70.9.61
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	14420	13447.1	110.74.1	987.6.9	126.20.5	1260.0.16	1088.6.51.8	1262.3.42	1335.5.62.6	1549.2.80.7	1357.6.60.4
Тээвэр, мэдээлэл, холбоо	1295.7	1578.3	171.0.5	233.3.1	263.2.6	2603.195	2238.239	2777.866	2956.958	2921.22	1849.701
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	5314	7506.2	951.2.1	118.22.1	140.51.3	1389.1.22.7	1398.6.35.1	1465.3.39.1	1634.4.26.6	1844.9.67.6	2154.9.63.7
Бусад үйлчилгээ	14706.3	18812.5	282.27.4	333.29.7	451.01.6	4933.2.98.2	5009.9.06.5	5059.4.24.8	5267.2.54.8	6473.8.42.8	7209.5.01.8




График 5: Дотоодын нийт бүтээгдэхүүн салбараар

Графикаас харахад ДНБ/зах зээлийн үнээр/ 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 65977.1 байсан бол 2020 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 410467.941 болж өссөн байна. Хөдөө аж ахуй 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 28722.5 байсан бол 2020 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 222651.55 болж өссөн байна. Газар тариалан ахуй 2011 оны байдлаар хамгийн бага дүн буюу 669.5 байсан бол 2020 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 2538.836 болж өссөн байна. Мал аж ахуй 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 27359.4 байсан бол 2020 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 219412.693 болж өссөн байна.

ХАА-н бусад 2014 оны байдлаар хамгийн бага дүн буюу 100.2 байсан бол 2017 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 1530.669 болж өссөн байна. Үйлдвэрлэл 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 1518.7 байсан бол 2020 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 78745.431 болж өссөн байна. Уул уурхай, олборлол 2013 оны байдлаар хамгийн бага дүн буюу 51.2 байсан бол 2017 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 2603.12 болж өссөн байна. Боловсруулах 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 3962.1 байсан бол 2020 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 63376.959 болж өссөн байна. Цахилгаан, хий, уур хангамж; усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа 2012 оны байдлаар хамгийн бага дүн буюу 938.9 байсан бол 2019 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 9247.476 болж өссөн байна. Барилга 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 1111.6 байсан бол 2020 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 5195.571 болж өссөн байна. Үйлчилгээ 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 35736 байсан бол 2010 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 109070.961 болж өссөн байна. Худалдаа, зочид буудал, зоогийн газар 2013 оны байдлаар хамгийн бага дүн буюу 9876.9 байсан бол 2019 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 15492.807 болж өссөн байна. Тээвэр, мэдээлэл холбоо 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 1295.7 байсан бол 2018 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 2956.958 болж өссөн байна. Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 5314 байсан бол 2020 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 21549.637 болж өссөн байна. Бусад үйлчилгээ 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 14706 байсан бол 2010 оны байдлаар уг үзүүлэлт хамгийн өндөр дүн буюу 72095.018 болж өссөн байна.

Хүснэгт 23: Ядуурлын үзүүлэлт

Ядуурлын үзүүлэлт			
		2016	2018
Ядуурлын хамралтын хүрээ	Улсын дүн	29.6	28.4
Ядуурлын хамралтын хүрээ	Говь-Алтай	43.3	45.1
Ядуурлын гүнзгийрэлт	Говь-Алтай	12.2	13.4
Ядуурлын мэдрэмж	Говь-Алтай	4.7	5.1




График 6: Ядуурлын үзүүлэлт

Ядуурлын хамрах хүрээ улсын дүнгээр буурсан үзүүлэлттэй байна. Харин Говь-Алтай аймгийн дүнгээр ядуурлын хамрах хүрээ, гүнзгийрэлт, мэдрэмж гэх үзүүлэлтүүд өссөн дүнтэй байна.

Хүснэгт 24: Хадгаламж ба зээлийн мэдээ

Хадгаламж ба зээлийн мэдээ											
	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эцсийн байдлаар	160	183	200	113	165	679	1,495	1,198	890	1,026	1,069
НИЙТ ХАДГАЛАМЖ , бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр,	16982. 1	23265. 3	30900	38117. 8	41569	47026. 5	58826. 8	66730. 5	90218.4	92807.9	123098. 6

жил бүрийн эцэст											
НИЙТ ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, бүс, аймаг, нийслэл, сум, дүүргээр, жил бүрийн эцэст	21334.9	35173.4	44285.9	68576.2	83393.2	77515	88328.2	98162.9	123253.8	127665.3	124537.7




График 7: Хадгаламж ба зээлийн мэдээ

Графикаас харахад чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 2013 оны байдлаар хамгийн бага дүн буюу 113 байсан бол 2016 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 1495 болж өссөн байна. Нийт хадгаламж 2010 оны байдлаар хамгийн бага үзүүлэлт буюу 16982.1 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 123098.6 болж өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдэл 2010 оны байдлаар хамгийн бага дүн буюу 21334.9 байсан бол 2019 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 127665.3 болж өссөн байна.

Хүснэгт 25: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд




График 8: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД

Графикаас харахад уг үзүүлэлт 2010 оны байдлаар хамгийн бага үзүүлэлт буюу 1445 байсан бол 2018 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 2789 болж өссөн байна.

ӨРХ ТОЛГОЙЛСОН ГАНЦ БИЕ ЭЦЭГ, ЭХ														
2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
2421	2310	2420	2688	2662	2836	2677	2830	2834	3007	2986	3271	2944	2150	2009

Хүснэгт 26: өрх толгойлсон ганц бие эцэг, эх



График 9: ӨРХ ТОЛГОЙЛСОН ГАНЦ БИЕ ЭЦЭГ, ЭХ

Графикаас харахад уг үзүүлэлт 2017 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 3271 байсан бол 2020 оны байдлаар хамгийн бага дүн буюу 2009 бол буурсан байна.

Хүснэгт 27: Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт

Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт			
	2018	2019	2020
Хүн ам	58471	57748	57674
Хөдөлмөрийн насны хүн ам	39042	36606	39361
Эдийн засгийн идэвхгүй хүн ам /Ажиллах хүчнээс гадуурх хүн ам/	10414	9453	17165
Ажиллах хүч	28628	27153	22196
Ажиллагсад	26896	24249	20491
Ажилгүй иргэд	1731	2904	1663




График 10: Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт

Графикаас харахад хүн ам 2018 оны байдлаар хамгийн өндөр үзүүлэлт буюу 58471 байсан бол 2020 оны байдлаар 57674 болж буурсан дүнтэй байна. Хөдөлмөрийн насны хүн ам 2019 оны байдлаар хамгийн бага дүн буюу 36606 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр үзүүлэлт буюу 39361 болж өссөн байна. Эдийн засгийн идэвхгүй хүн ам 2019 оны байдлаар хамгийн бага дүн буюу 9453 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 17165 болж өссөн байна. Ажиллах хүч 2018 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 28628 байсан бол 2020 оны байдлаар хамгийн бага дүн буюу 22196 болж буурсан байна. Ажиллагсад 2018 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 26896 байсан бол 2020 оны байдлаар хамгийн бага дүн буюу 20491 болж буурсан үзүүлэлттэй байна. Ажилгүй иргэд 2019 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 2904 байсан бол 2020 оны байдлаар хамгийн бага дүн буюу 1663 болж буурсан байна.

Хүснэгт 28: Ажилгүйдлийн түвшин



График 11: Ажилгүйдлийн түвшин

Хүснэгт 29: Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал

Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал			
	2018	2019	2020
Бүртгэлтэй ажилгүй иргэн	919	934	996
Шинээр бий болсон ажлын байр	1154	1053	1178
Ажлын байрны захиалга	683	583	570




График 12: Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал

Графикаас харахад бүртгэлтэй ажилгүй иргэн 2018 оны байдлаар хамгийн бага дүн буюу 919 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр буюу 996 болж өссөн байна. Шинээр бий болсон ажлын байр 2019 оны байдлаар хамгийн бага дүн буюу 1053 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 1178 болж өссөн байна. Ажлын байрны захиалга 2018 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 683 байсан бол 2020 оны байдлаар хамгийн бага дүн буюу 570 болж буурсан байна.

Хүснэгт 30: Төсвийн орлого, зарлага

Төсвийн орлого, зарлага															
	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОСОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, бүс, аймаг, нийслэлээр, жилээр	965.6	215.2.6	251.2.7	111.7.1	832.8	106.9.8	255.2	922.8.9	936.6.1	967.6.5	941.6.7	907.7.3	112.67	117.05.9	149.04.7
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, аймгаар, жилээр	146.5.5	270.6.7	404.9.2	337.2.7	458.1.1	566.6.7	781.5.5	623.78.3	665.56.9	647.91.6	693.57.7	713.29.3	780.12.3	779.13.6	897.83.8
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, аймгаар, жилээр	221.5.5	348.9.8	485.7.9	387.8.4	508.0.1	832.1.8	107.93	493.40.4	567.46.2	503.10.4	523.86	521.32.3	571.33.8	596.39.6	719.94.9




График 13: Төсвийн орлого, зарлага

Графикаас харахад улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 2012 оны байдлаар хамгийн бага дүн буюу 255.2 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 14904.7 болж өссөн байна. Орон нутгийн төсвийн зарлага 2006 оны байдлаар хамгийн бага дүн буюу 1465.5 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 89783.8 болж өссөн байна. Орон нутгийн төсвийн орлого 2006 оны байдлаар хамгийн бага дүн буюу 2215.5 байсан бол 2020 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 71994.9 болж өссөн байна. Малчдын тоо 2016 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 13691 байсан бол 2019 оны байдлаар хамгийн бага дүн буюу 12287 болж буурсан байна.

Хүснэгт 31: Бүртгэлтэй ажилгүй иргэд/нас,хүйсээр/

		Бүртгэлтэй ажилгүй иргэд /нас,хүйсээр/													
		2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021 II
15-24	Эмэгтэй	203	239	152	112	161	288	213	81	80	93	94	80	63	45
15-24	Эрэгтэй	77	80	84	117	78	210	156	77	62	53	86	53	51	48
25-34	Эмэгтэй	189	232	171	111	216	175	169	154	149	126	123	153	112	114
25-34	Эрэгтэй	115	101	93	159	98	119	110	132	111	115	111	107	117	119
35-44	Эмэгтэй	142	149	132	82	108	115	82	56	90	64	79	76	78	77
35-44	Эрэгтэй	106	65	63	106	59	87	70	46	54	59	74	58	81	84
45-54	Эмэгтэй	73	66	61	56	55	91	38	37	51	45	51	44	63	62
45-54	Эрэгтэй	79	64	61	44	65	129	52	38	53	50	63	47	60	65
55-59	Эмэгтэй							6	7	3	5	5	10	11	12
55-59	Эрэгтэй							9	14	15	11	14	17	15	15
60+	Эмэгтэй							1	1	2	5	4	5	6	6
60+	Эрэгтэй							6	1	4	3	5	3	5	6




График 14: Бүртгэлтэй ажилгүй иргэд /нас, хүйсээр/

Графикаас харахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн үзүүлэлт 15-24 насны эмэгтэйчүүд 2013 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 288 байна. Харин 60+ насны эмэгтэйчүүд хамгийн бага дүнтэй байна. 15-24 насны эрэгтэйчүүд 2013 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 210 байна. Харин 60+ насны эрэгтэйчүүд хамгийн бага дүнтэй байна

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН														
	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021 II
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн	215	31	309	543	403	313	181	272	99	184	305	229	179	83
Тайлант хугацаанд хасагдсан иргэн	218	57	354	1118	382	146	162	177	137	118	177	203	129	82
Ажилд зуучлагдан орсон иргэн	217	57	354	1112	382	146	58	59	35	17	83	158	85	10
Ажил хайхгүй шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэн	1	0	0	6	0	0	104	118	102	101	94	45	44	72

Хүснэгт 32: бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн




График 15: БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН

Графикаас харахад тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн 2009 оны байдлаар хамгийн бага үзүүлэлт буюу 31 байсан бол 2011 оны байдлаар хамгийн өндөр дүн буюу 543 болж өссөн байна. Тайлант хугацаанд хасагдсан иргэн 2009 оны байдлаар хамгийн бага дүн буюу 57 байсан бол 2011 оны байдлаар 1118 болж өссөн байна. Ажилд зуучлагдан орсон иргэн 2011 оны байдлаар 1112 байсан бол 2017 оны байдлаар 17 болж буурсан байна.

Ажил хайгч иргэд, насаар								
	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021 II
Бүгд	1237	1044	802	788	919	965	996	980
15-24	395	193	152	154	205	212	175	133
25-34	382	425	294	299	294	335	310	315
35-44	272	230	192	174	228	218	260	271
45-59	155	153	131	124	151	135	188	201
60+	24	32	25	24	24	49	44	41

Хүснэгт 33: Ажил хайгч иргэд, насаар




График 16: Ажил хайгч иргэд, насаар

Графикаас харахад 25-34 насныхан өндөр дүнтэй байгаа бол 60+ насныхан хамгийн бага байна.

Ажил хайгч иргэд, насаар /эмэгтэй/								
	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021 II
Бүгд	696	547	449	427	462	516	481	457
15-24	229	96	86	99	102	118	85	54
25-34	222	217	165	156	151	195	145	149
35-44	162	134	123	96	126	114	128	129
45-59	73	83	64	57	69	64	98	101
60+	8	10	9	12	6	16	16	16

Хүснэгт 34: Ажил хайгч иргэд, насаар /эмэгтэй/




График 17: Ажил хайгч иргэд, насаар /эмэгтэй/

Хүснэгт 35: Ажил хайгч иргэд, насаар /эрэгтэй/

Ажил хайгч иргэд, насаар /эрэгтэй/								
	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021 II
Бүгд	541	497	353	361	457	449	515	523
15-24	166	97	66	55	103	94	90	79
25-34	160	208	129	143	143	140	165	166
35-44	110	96	69	78	102	104	132	142
45-59	82	70	67	67	82	71	90	100
60+	16	22	16	12	18	33	28	25

Графикаас харахад 25-34 насныхан хамгийн өндөр дүнтэй байгаа бол 60+ насныхан хамгийн бага дүнтэй байна. Дундажаас харахад 2014 оны байдлаар ажил хайлт хамгийн өндөр буюу 696 байгаа бол 2017 онд хамгийн бага буюу 427 болж буурсан дүнтэй байна.





График 18: Ажил хайгч иргэд, насаар /эрэгтэй/

Графикаас харахад 25-34 насныхан хамгийн өндөр дүнтэй байна. Харин 60+ насныхан хамгийн бага байна. Дундаж үзүүлэлтээс харахад 2014 оны байдлаар ажил хайлт 541 буюу хамгийн өндөр дүнтэй байгаа бол 2016 оны байдлаар хамгийн бага буюу 353 болж буурсан байна.

4.4 Монгол улсын эдийн засгийн орчны судалгаа

Монгол Улсын эдийн засгийн өсөлт сүүлийн 20 гаруй жил дунджаар 6.8 хувь байлаа. Хөдөө аж ахуй, уул уурхай, аж үйлдвэр, газар тариалангийн салбар 2000 оноос сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн. 2004 онд ДНБ 2.8 их наяд төгрөг (2005 оны зэрэгцүүлэх үнээр) болж ДНБ-ний өсөлт 10.6 хувьд хүрч анх удаа 2 орон тоогоор өссөн юм. Үүнээс хойш Монгол Улсын эдийн засаг уул уурхайд түшиглэн хөгжиж байна.

График 19. Монгол улсын эдийн засгийн өсөлт, хувиар




Эх сурвалж: ҮСХ

ДНБ-ний өндөр өсөлт нь монголын эдийн засаг уул уурхайн салбар, уг салбарт оруулсан гадаадын хөрөнгө оруулалтын шууд нөлөөллийн үр дүн байлаа. 2004-2008 оны хооронд дунджаар ДНБ 3.4 их наяд төгрөг байсан бөгөөд дундаж өсөлт нь 9 орчим хувьтай байсан. Гэвч дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг хямралд өртөж ДНБ 2009 онд 1.3 хувиар буурсан. Тухайн үеийн эдийн засгийн хямрал нь Монгол Улс олон улсын эдийн засаг, уул уурхайн бүтээгдэхүүний үнээс ихээхэн хамааралтай болсны илрэл байлаа. Уг хямралын дараа 2011 он хүртэл эдийн засаг огцом өсч ДНБ 11.4 их наяд (2010 оны зэрэгцүүлэх үнээр) хүрч өмнөх оноос 17.3 хувиар өссөн нь зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших хамгийн өндөр өсөлт байлаа. Түүнээс хойш эдийн засгийн өсөлт саарсаар 2016 онд ДНБ-ний өсөлт 1.6 хувь байсан нь 2000 оноос хойших эдийн засгийн хамгийн бага өсөлт байв. Харин сүүлийн гурван жилийн эдийн засгийн дундаж өсөлт 5.9 хувьтай байв. Мөн 2019 онд эдийн засгийн өсөлт 5.1 хувиар өссөн байна. Эдийн засгийн өсөлт, бууралт нь уул уурхайн бүтээгдэхүүний олон улсын зах зээл дээрх эрэлт, үнэ ханш, гадаадын хөрөнгө оруулалтаас шууд хамааралтай хэвээр байна.

Уул уурхайн салбарын хөгжил эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүд сайжирч буй хэдий ч тогтвортой хөгжлийг бий болгоход төдийлөн нөлөө үзүүлэхгүй байна.


График 20. Нэг хүнд ногдох ДНБ /2010 оны зэрэгцүүлэх үнээр/



Эх сурвалж: ҮСХ

Нэг хүнд ногдох ДНБ 2010 оноос дунджаар 5.5 хувиар өсч 2019 онд 5.9 сая төгрөг болсон хэдий ч ам.доллараар тооцож харвал 2013 оноос буурч эхэлжээ. Төгрөгийн ханш унаж 2019 онд 2680 орчим төгрөг болсон нь эдийн засагт болон иргэдийн амьжиргаа, орлогод сөргөөр нөлөөлж, ядуурлыг нэмэгдүүлж байна.

График 21. Үнийн өсөлт




Эх сурвалж: ҮСХ

Үнийн тогтворгүй байдал нь эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлсөөр байна. Сүүлийн 20 жилийн хугацаанд инфляци 1.4 хувиас 22.1 хувь хүртэл хэлбэлзэж эдийн засгийн өсөлтөөс өндөр байв. Өөрөөр хэлбэл эдийн засгийн бодит

өсөлт бий болохгүй байгаагаас хамаарч улс орны хөгжил удаан, ядуурал буурахгүй, хот хөдөөгийн ялгаа ихэсч, орлогын тэгш бус байдал нэмэгдэх хандлагатай байна.

Улсын эдийн засгийн хөгжлийг тэтгэж, төгрөгийн ханшны тогтвортой байдлыг хангахад валютын орох урсгал чухал үүргийг гүйцэтгэдэг. Энэ үүднээс гадаад худалдааны тэнцэл эерэг байх тусам дотогш урсах валютын урсгал сайн байгааг илтгэнэ. Манай улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос эерэг гарах болсон нь экспортын хэмжээ 2000 оноос өсч 7.6 тэрбум ам.доллар хүрсэн, харин импорт 2011-2013 оны түвшинээс буурч 6.1 тэрбум ам.долларт хүрч буурсантай холбоотой юм.

График 22. Гадаад худалдаа




Эх сурвалж: ҮСХ

Экспортын бүтээгдэхүүний өсөлтөд нүүрс, зэс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нөлөөлж байна.

Засгийн газрын зүгээс улсын болон бүсийн чанартай томоохон бүтээн байгуулалтыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, эдийн засгийн хөгжлийн суурийг бэхжүүлэх үүргээ гүйцэтгэдэг. Иймд улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын динамикийг судлах шаардлага гардаг. Сүүлийн 20 жилд эдийн засгийн тэлэлтийг даган төсвийн орлого нэмэгдэж, улмаар төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардал 26 дахин нэмэгджээ.

График 23. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, тэрбум төгрөг



Эх сурвалж: ҮСХ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2000 оноос 2015 оныг хүртэл тасралтгүй өсч 5.9 их наяд төгрөг, зарлага нь 2016 оныг хүртэл өсч 9.5 их наяд төгрөгт тус тус хүрсэн. 2016 оны хямралын үеэр төсвийн орлого буурч нэгдсэн төсвийн тэнцэл хамгийн өндөр буюу 3.6 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан.

Дэлхийн улс орнуудад шинэ корона вирус 2020 оны 1 дүгээр сараас эхлэн гарсанаас үүдэн Монгол Улс бусад улс орнуудын нэгэн адил хилээ хааж хөл хорио тогтоосон билээ. Энэ нь эдийн засагт сөргөөр нөлөөлж бизнесийн үйл ажиллагаа хумигдаж зарим салбарын хувьд зогсонги байдалд орсон. 2020 оны эхний улирлын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 орчим хувиар буурч 3.2 их наяд төгрөгт хүрэв. Мөн аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 35 хувиар багасчээ. Үйлдвэрлэл буурахад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн үйлдвэрлэл 30 орчим хувиар буурсан нь голлох нөлөө үзүүлсэн. Борлуулалтад мөн л уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 48 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Азийн хөгжлийн банк Монгол улсын эдийн засгийг 2020 онд 2.1 хувиар өсөх ба 2021 оноос эдийн засаг сэргэж эдийн засгийн өсөлт 4.6 хувьд хүрнэ хэмээн таамаглаж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага цар тахалын хэмжээнд хүрсэн энэхүү Ковид-19 вирусын тархалтаас болж дэлхийн хүн амын аж амьдралд томоохон өөрчлөлт гарч, хэзээ ч өмнөх байдалдаа эргэн очихгүй байх гэж таамаглаж байна. Энэ нь ялангуяа үйлчилгээний салбарын хөгжил, хэв шинжид нэлээдгүй өөрчлөлт авчирна гэж үзэж байна.

- **Үйлчилгээний салбарын эдийн засгийн төлөв байдал**

Монгол Улсын эдийн засгийн бүтцийг харвал 2000-2009 онд хөдөө аж ахуйн салбар дунджаар 20%, уул уурхайн салбар 17%, боловсруулах үйлдвэрлэл 8.6%, худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ 15%-ийг эзэлж ДНБ-ний 60 орчим хувийг бүрдүүлж байв. Харин зочид буудал, нийтийн хоол болон бусад үйлчилгээ 0.7 хувийг л эзэлж байна.

График 24. ДНБ-ний бүтэц




Эх сурвалж: ҮСХ

Харин сүүлийн 10 жилд хөдөө аж ахуйн салбар дунджаар 11%, уул уурхайн салбар 20%, боловсруулах салбар 10%, худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ 18%-ийг бүрдүүлэх болжээ. Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарын оролцоо тодорхой хэмжээгээр өссөн байна. Зочид буудал, нийтийн хоол болон бусад үйлчилгээний салбар дунджаар 0.8 хувийг бүрдүүлж буй нь уг салбарын өсөлт сайн биш байгааг илтгэнэ.

Зочид буудал, зоогийн газар нь аялал жуулчлалын салбартай нягт уялддаг бөгөөд уг салбарын хөгжлийг тодорхойлох нэг хүчин зүйл болдог.

График 25. Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ /сая.төг/




Эх сурвалж: ҮСХ

Зочид буудал нийтийн хоолны салбар 2000 оноос дунджаар 6.1 хувиар өсч байна. Тус салбарын үйлдвэрлэл 2010 онд 52.6 тэрбум төгрөг байсан бөгөөд 2019 оны байдлаар 95.1 тэрбум төгрөгт хүрчээ.

Хөрөнгө оруулалтын хандлагыг харвал зочид буудал нийтийн хоолны салбарт сүүлийн 10 жилийн хугацаанд 2019 онд хөрөнгө оруулалтын хэмжээ 700 гаруй тэрбум төгрөгт хүрсэн нь дээд зэрэглэлийн зочид буудал болох Шангрила зочид буудал барих хөрөнгө оруулалтын үр дүн юм.

График 26. Хөрөнгө оруулалт /2009-2019/



Эх сурвалж: ҮСХ

• Аялал жуулчлалын салбар

Манай улсын хувьд аялал жуулчлалын салбар нь уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарын дараа орох эдийн засгийн гуравдагч том салбар байх ирээдүйтэй бөгөөд эдийн засгийн бусад салбаруудтай нягт уялдаатайгаар тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх хамгийн боломжтой салбар юм.

Энэ үүднээс тус салбар нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан эдийн засгийн зорилтуудын нэг билээ. Зорилт Нэгийн хүрээнд “Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно” хэмээн тодорхойлж 3 үе шаттайгаар уг зорилтонд хүрэхээ заасан. Үүнд:

I үе шат (2016-2020): Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1 саяд хүргэх.

II үе шат (2021-2025): Бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах, гадаадын жуулчдын тоог 1.5 саяд хүргэх.

III үе шат (2026-2030): Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчлан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэн, гадаадын жуулчдын тоог 2.0 саяд хүргэх зорилт тавьжээ.

Манай улсын хувьд аялал жуулчлалын салбар нь жар гаруй жилийн түүхтэй бөгөөд анх төрийн өмчит “Жуулчин” компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн бол өдгөө уг салбарт 475 гаруй тур оператор компани, 517 зочид буудал, 674 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж, нийт 50 мянга гаруй хүн тус салбарт ажиллаж байна.

Дэлхий дахинд сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж, дэлхийн нийтийн экспортын 7%, үйлчилгээний экспортын 30%-ийг бүрдүүлж, ажил эрхэлж байгаа 10 хүн тутмын 1 нь тус салбарт ажлын байраар хангагдаж, шинээр бий болж байгаа 5 ажлын байр тутмын 1 нь аялал жуулчлалын салбарт бий болж байгаатай харьцуулахад манай аялал жуулчлалын салбар цаашид эрчимтэй хөгжих шаардлагатай байна.

Үндэсний статистикийн хорооны судалгаанаас харахад бүртгэлтэй бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн 1.6% нь л аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг.

Хүснэгт 36: Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо


	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо	40,921	48,086	51,938	54,929	59,843	64,301	72,182	78,585
Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа	426	1,022	709	850	1,013	989	1,123	1,270

эрхэлж байгаа ААНБ-ын тоо								
Аялал жуулчлалын салбарын эзлэх хувь	1,0%	2,1%	1,4%	1,5%	1,7%	1,5%	1,5%	1,6%

Эх сурвалж: ҮСХ

Аялал жуулчлалын салбарын нэмүү өртөг 2010-2017 онд 18.2 тэрбум төгрөгөөс 57.2 тэрбум болж өссөн. Уг салбарын орлого нь гадаад болон дотоодын жуулчдын төлсөн дүнгээс бүрддэг. Гадаад валютын эерэг урсгалыг бүрдүүлдэг гадаад жуулчдын тоо нэмэгдэх нь тус салбарын өсөлт, манай улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой. Энэ үүднээс дараах зурагт сүүлийн 10 жилд ирсэн гадаад жуулчдын тоог харуулав.

График 27. Гадаадын жуулчдын тоо




Эх сурвалж: ҮСХ

Өнгөрсөн 19 жилд гадаад жуулчдын тоо 3.7 дахин нэмэгдэж 577,300 хүрсэн. Харин 2010-2019 оны хооронд гадаад жуулчдын тоо 26 хувиар өсчээ. Аялал жуулчлалын үйлчилгээний орлого 2007 оноос эхлэн буурч 2011 онд 156 сая ам.доллар (ДНБ-ний 1.5%)-т хүрсэн хэдий ч 2011 оноос эхлэн эрчимтэйгээр өссөөр 2019 онд 607.2 сая ам.доллар буюу ДНБ-ий 4 хувьд хүрсэн.

Дэлхийн эдийн засгийн форумаас 2007 оноос хойш 2 жил тутамд 140 орныг хамруулан аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтийг тооцон эрэмбэлдэг. Манай улс 2017 онд 136 орноос 3.3 оноогоор 102-т эрэмбэлгдэж байсан бол 2019 оны байдлаар уг индексийн 7 онооны 3.5-ыг авч 93-р байрт эрэмблэгджээ. Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтэд ахиц гарахын хэрээр тухайн оронд ирж буй гадаад жуулчдын тоо их хэмжээгээр нэмэгддэг байна.

Хэдийгээр манай улсын аялал жуулчлалын салбар улам бүр хөгжиж үйлчилгээний чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, олон улсын стандартыг нэвтрүүлэх, жуулчдад зориулсан аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүлэх зэргээр тэдний сонирхолыг татах, ая тухыг хангах санаачлагууд хэрэгжсээр байгаа ч цаашид аялал жуулчлалын салбарыг системтэй хөгжүүлэх, тус салбарт ажиллагсадын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг улам сайжруулах, тус салбарын хөгжлийн бодлогыг боловсронгуй болгон хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай. Ялангуяа бүс нутгийн хөгжлийг хангах нэг тулгуур салбар болохын хувьд аймгууд энэ чиглэлд ихээхэн анхаарал хандуулж эхлээд байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Зураг 27: аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал

Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018 он, УБ хот

МОНГОЛ ОРНЫГ ГАДААДЫН ЖУУЛЧИД СОНГОН АЯЛЖ БУЙ ЗОРИЛГО




2017 ОНД ИРСЭН ЖУУЛЧИД, УЛИРЛААР



Зураг 28: Жуулчдын зорилго

Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2019 он, УБ хот

ЖУУЛЧДЫН МОНГОЛ УЛСАД ИРСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ (2017 ОН)



БҮС НУТАГ ДАХЬ БООМТООР НЭВТЭРСЭН ЖУУЛЧДЫН ТОО (2017 ОН)



Зураг 29: Жуулчдын тоо бүсээр

Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018 он,

УБ хот



Зураг 30: Аялалын зорилго, бүс

Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018 он,

УБ хот

- **Дэд бүтцийн салбарын эдийн засгийн төлөв**

Эрчим хүчний салбар нь улс орны аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, түрүүлж хөгжүүлэх шаардлагатай эдийн засгийн суурь салбар билээ. Иймд өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангах, цаашид эрчим хүч экспортлогч орон болох зорилго тавин УИХ-аас 2015 онд “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого 2015-2030”-ыг тодорхойлж, тус салбарыг хөгжүүлэх арга хэмжээг нийт 2 үе шаттай: I үе шат 2015-2023, II үе шат 2024-2030 онуудад авч хэрэгжүүлж байна.

Манай улс цахилгаан хангамжийнхаа 80 хувийг дотоодод үйлдвэрлэж импортоор 20 хувийг авч ашигладаг. Газар нутгийн алслагдмал байдал, дэд бүтцийн хөгжлөөс хамааран дөрвөн бүсээс бүрддэг. Анхдагч эрчим хүчний хувьд баялаг бөгөөд нүүрс, газрын тос, уран, сэргээгдэх эрчим хүчний тогтоогдсон нөөц болон шатдаг занар, байгалийн хийн нөөц ихтэй.


Улсын хэмжээнд цахилгаан үйлдвэрлэлийн нийт суурилагдсан хүчин чадлын 85% нь нүүрсээр ажилладаг дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэх станц, 5% нь салхин парк, 7% дизель станц, 2% усан цахилгаан станц, 0.62% нь бага оврын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүрдүүлдэг.

Дэлхийн хандлага бол 2050 он гэхэд дэлхийн нүүрсний хэрэглээг 50% бууруулж, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг 85%-д хүргэх зорилттой байна. Энэ үзүүлэлт 2017 онд 25% байв. Харин Монгол улсын хувьд нар, салхины сэргээгдэх эрчим хүчээр Ази тивийн эрчим хүчний 60% буюу дэлхийн хэрэглээний 20 хувийг хангахуйц асар их нөөцтэй гэдгийг судлаачид тогтоогоод байна.

Улсын эрчим хүчний хангамж төвийн бүсэд Улаанбаатар, Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцууд, Зүүн бүсэд Дорнодын дулааны цахилгаан станц зэрэг байгаа бөгөөд одоог хүртэл үндэсний хэмжээний найдвартай сүлжээтэй болоогүй байна. Иймд баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг хангах шаардлагын улмаас ОХУ-аас, Оюутолгойн цахилгааны хэрэглээг хангахын тулд БНХАУ-аас цахилгаан эрчим хүч импортоор авдаг.

Эдийн засгийн хөгжлийг хангах суурь салбарын нэг нь дэд бүтцийн салбар бөгөөд тус салбарын үйлдвэрлэл жил бүр өсөн нэмэгдэж 2019 онд 2.2 их наяд төгрөг болсон. Сүүлийн 10 жилийн дундаж үйлдвэрлэл 1.7 тэрбум төгрөг байв.


График 28. ДНБ, дэд бүтцийн салбараар, сая төгрөг, /2010 оны зэрэгцүүлэх үнээр/



Эх сурвалж: ҮСХ

Хэдийгээр мөнгөн дүнгээр салбарын үйлдвэрлэл 2 дахин нэмэгдсэн ч, ХАА, уул уурхай олборлох, боловсруулах үйлдвэрлэл өсөхийн хэрээр ДНБ-нд эзлэх дэд бүтцийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ багассаар байна. Сүүлийн 10 жилийн дундаж нь 9.8 хувь байсан бол 2000-2009 оны дундаж нь 35.3 хувь байлаа.

График 29. ДНБ-нд дэд бүтцийн салбарын эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ


Дэлхийн эдийн засгийн форумын өрсөлдөх чадварын судалгаагаар дэд бүтцийн салбарын хөгжил 2018 онд 56.2 оноогоор 103, харилцаа холбооны салбар 48,7 оноогоор 78 дугаар байрт тус тус орж байсан. 2019 онд дэд бүтцийн салбарын үнэлгээ 56.6 болж 101 дүгээр байр руу урагш ахисан бол харилцаа холбооны салбарын үнэлгээ 46.5 болж 96 дугаар байр руу ухарсан байна.

Хүснэгт 37: Дэлхийн эдийн засгийн форумын өрсөлдөх чадварын судалгаа

Салбар	2018		2019	
	оноо	байр	оноо	байр
Дэд бүтэц	56.2	103	56.6	101
Харилцаа холбоо	48.7	78	46.5	96

Монгол Улсын хөрөнгө оруулалт 2016 оноос жил бүр өсч 2019 оны байдлаар 13.8 их наяд төгрөг болж үүнээс 8.7 хувь нь дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт байлаа. Сүүлийн 10 жилд дунджаар нийт хөрөнгө оруулалтын 10.5 хувь дэд бүтэцийн салбарт хийгдэж байсан.


График 30. Хөрөнгө оруулалт дэд бүтцийн салбараар, тэрбум төгрөг



Эх сурвалж: ҮСХ

Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт нь салбар тус бүрээр харьцуулахад харилцан адилгүй хэлбэлзэлтэй байна. Мөн түүнчлэн жил бүр аль нэг салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэхэд бусад салбарын хөрөнгө оруулалт буурсан байна. Тухайлбал 2019 онд Цахилгаан эрчим хүч, усан хангамжид оруулсан хөрөнгө оруулалт буурсан бол тээвэр болон агуулахын үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт өссөн байна.

График 31. Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтад зарим салбарын хөрөнгө оруулалтын эзлэх хувь




Эх сурвалж: ҮСХ

• **Эрчим хүчний салбар**

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл жил бүр нэмэгдэж 2019 онд 314.1 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ний 2 хувийг, дэд бүтцийн салбарын 14 хувийг бүрдүүлжээ. Сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлтийг харвал 244.6 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явагдаж, 5.2 хувийн өсөлттэй, ДНБ-ний 1.8 хувийг, дэд бүтцийн салбарын 15 хувийг бүрдүүлж ирсэн.


График 32. Цахилгаан, хий, уур, агааржуулалтын үйлдвэрлэл, /2010 оны зэрэгцүүлэх



Эх сурвалж: ҮСХ

Эрчим хүчний салбарт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр өсч 2018 онд 970 тэрбум төгрөгт хүрсэн ч, 2019 буурч 460.3 тэрбум болжээ. Нийт хөрөнгө оруулалтад эзлэх эрчим хүчний салбарт оруулсан хөрөнгө оруулалтын хувь хэмжээ сүүлийн 10 жилд 20-64 хувийн хооронд хэлбэлзэж байлаа.


График 33. Хөрөнгө оруулалт, цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж



Эх сурвалж: ҮСХ

Цахилгаан, хий, уур, агааржуулалтын үйлдвэрлэлд оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт 2019 онд 1.3 сая ам.доллар байв. Тус салбарт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт 2016 оныг хүртэл аажмаар буурсан ч 2017 онд 25.1 сая ам.доллар болж өссөн. Энэ нь 2011-2016 онуудад тус салбарт оруулсан дундаж хөрөнгө оруулалтаас 5 дахин их байлаа.

График 34. Гадаадын шууд хөрөнгө оруулалт: Цахилгаан, хий, уур, агааржуулалт, сая ам.доллар



Эх сурвалж: ҮСХ

Аж үйлдвэр, ХАА зэрэг бусад салбар өсөн нэмэгдэхийн хэрээр эрчим хүчний салбарын бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт өсч байна.

График 35. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл /сая кВт.цаг/




Эх сурвалж: ҮСХ

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 2018 онд 6.5 тэрбум кВт.цаг болж 2000 оноос 2.2 дахин, 2010 оноос 1.5 дахин нэмэгджээ. Сүүлийн 10 жилийн хугацаанд дунджаар 5.1 хувийн өсөлттэй байв.

- **Тээврийн салбар**

Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 2010 хойш дунджаар 8.5 хувиар өсч 2019 онд 1.4 их наяд төгрөг хүрсэн. Энэ нь 2010 оноос 2 дахин их байна. Гэвч уг салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2010 оноос буурсаар 2019 онд 4.5 хувийг эзлэх болжээ. Гэсэн хэдий ч дэд бүтцийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүтцэд эзлэх хувь нь тогтвортой буюу сүүлийн 10 жилийн дундаж нь 61 орчим хувь байна.

График 36. Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 2010 оны зэрэгцүүлэх үнээр



Эх сурвалж: ҮСХ

Тээвэр ба агуулахын чиглэлээр 2019 онд 509.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд энэ нь нийт хөрөнгө оруулалтын 4 хувь дэд бүтцийн салбарт хийсэн хөрөнгө оруулалтын 42 хувийг эзэлж байв. Сүүлийн 11 жилийн хугацаанд нийт 2.9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд жилд дунджаар 261.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байлаа. 2011 онд хөрөнгө оруулалт өмнөх жилээс 105 хувиар, 2012 онд 82 хувиар, 2014 онд 68 хувиар, 2016 онд 97 хувиар, 2019 онд 81 хувиар тус тус огцом өсч байв. Харин 2013 онд 58 хувиар, 2015 онд 77 хувиар тус тус огцом буурчээ.


График 37. Хөрөнгө оруулалт: Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа



Эх сурвалж: ҮСХ

Тээврийн салбарын орлого 2000 оноос 2010 оныг хүртэл аажмаар харин 2011 оноос хурдацтай өссөн. Бүтцээр нь авч үзвэл 2010 оныг хүртэл төмөр замын орлого нийт орлогын 50 гару хувийг бүрдүүлдэг байсан бол 2011 оноос аажмаар буурчээ. Авто замын салбар хөгжихийн хэрээр түүний орлогын хэмжээ нэмэгдэж тээврийн салбарын нийт орлогод эзлэх хувь нь 40 хувь хүртэл өссөн. Агаарын тээврийн орлого тогтвортой өсч түүний нийт орлогод эзлэх хувь 19-25 хувьтай байлаа.

График 38. Тээврийн нийт орлого, тэрбум төгрөг




Эх сурвалж: ҮСХ

Ачаа тээвэрлэлтийн өсөлт тогтвортой бус боловч ерөнхий хандлага нь өсөн нэмэгдэж байна. Нийт ачаа тээвэрлэлт 2019 онд 68.9 сая.тн болсон бөгөөд энэ нь 2010 онтой харьцаалахад 2.3 дахин өндөр байна. Бүтцээр нь авч үзвэл 2010 оныг хүртэл төмөр замын ачаа ачаа тээвэрлэлт 57-87 хувийг эзэлж байсан бол сүүлийн 10 жилд авто тээврийн ачаа тээвэр 51-62 хувийг эзлэх болсон.

Зорчигч тээврийн хувьд 2000 оноос 2014 он хүртэл алгуур өссөн боловч 2015 оноос хойш аажмаар буурч 2019 онд 173 сая хүн болов. Нийт зорчигчдын 98 орчим хувь нь авто замаар зорчиж байна.

График 39. Зорчигчдын тоо, сая хүн




Эх сурвалж: ҮСХ

• Усан хангамж


Усан хангамжийн үйлдвэрлэл сүүлийн 10 жилийн хугацаанд 30-33.0 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж ДНБ-нд дунджаар 0.4 хувийг, нийт дэд бүтцийн салбарын үйлдвэрлэлийн 2 орчим хувийг эзэлж байна. Уг салбарын үйлдвэрлэл 2011-2016 оны хооронд дунджаар 0.5 хувийн бууралттай байсан бол сүүлийн 3 жилийн дундаж өсөлт 3.3 хувь байлаа.

График 40. Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны үйлдвэрлэл /2010 оны зэрэгцүүлэх үнээр/



Түгээсэн усны хэмжээ 2001 онд 60.0 гаруй сая.м³ болж өссөн ба түүнээс хойш харьцангуй тогтвортой 60-68 сая.м³ байлаа. Эдийн засгийн өсөлт, зарим салбарын хөгжлийг дагаж усан хангамж нэмэгдээгүй байна. Гэвч цашид усан хангамжийг


нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаад анхаарч хувийн хэвшил, Засгийн газар болон олон улсын байгууллагууд хамтран хөрөнгө оруулалт хийж эхлээд байна.

График 41. Түгээсэн ус, мян. м³

Эх сурвалж: ҮСХ

Ус хангамж, ариутгалын борлуулалт 2001 оноос тасралтгүй өссөөр 2017 онд 73.2 тэрбум төгрөг болжээ.

График 42. Ус ариутгал, усан хангамжийн борлуулалт, сая төгрөг



Эх сурвалж: ҮСХ


Өрсөлдөх чадварын судалгаагаар Монгол Улс усан хангамжийн найдвартай байдлын үзүүлэлтээр 2018 онд 52.4 оноогоор 100, 2019 онд 56.2 оноогоор 92 дугаар байрт орж 8 орноор урагшилсан. Шаардлага хангаагүй ундны усны хэрэглээний үзүүлэлтээр 2018 онд 81.9 оноогоор 93 дугаар байрт, 2019 онд 71.3 оноогоор 91 дүгээр байрт орсон.

- **Мэдээлэл, холбооны салбар**

Мэдээлэл холбооны салбарын ДНБ 2010 онд 255.7 тэрбум төгрөг байсан бол 2019 онд 460.4 тэрбум төгрөг болж 1.8 дахин өссөн. 2010-2014 оныг хүртэл дунджаар 5 хувиар, 2017-2019 онуудад 10 хувиар өссөн. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд 2015-2016 онуудад 2.5-6.6 хувиар буурч байсан. ДНБ-нд мэдээлэл холбооны салбарын хувь хэмжээ 2010 оноос харьцангуй тогтвортой буюу 2-3 хувийн

хооронд хэлбэлзэж байгаа боловч ерөнхий хандлага буурах төлөвтэй байна. Энэ нь бусад салбарын өсөлт, хөгжил, дэвшилээс хамааралтай юм.

График 43. Мэдээлэл холбооны ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр




Эх сурвалж: ҮСХ

Дэд бүтцийн салбарын ДНБ мэдээлэл, холбооны салбарын эзлэх хувь хэмжээ сүүлийн 10 жилийн хугацаанд тогтвортой байсан ба дунджаар 2.2 хувь байлаа.

Мэдээлэл, холбооны салбарын хөрөнгө оруулалт 2013 он хүртэл тогтвортой өсч байсан ба 2013 онд огцом 150 орчим хувиар өссөн. Гэвч түүнээс хойш дараалан 4 жил 9-30 хувиар бууржээ. Сүүлийн 2 жил 14-39 хувиар өсөв.

График 44. Мэдээлэл холбооны салбарын хөрөнгө оруулалт




Эх сурвалж: ҮСХ

Мэдээлэл, холбооны хөрөнгө оруулалтын хэмжээ зарим жилүүдэд буурч байсан боловч түүний дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтад эзлэх хувь хэмжээ дагаж буураагүй харин эсрэгээрээ өндөр байлаа. Энэ нь мэдээлэл холбооны

салбарт хувийн хэвшлийн оролцоо бусад дэд бүтцийн салбартай харьцуулахад илүү их байдагтай холбоотой юм.

График 45. Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг



Эх сурвалж: ҮСХ

Өрсөлдөх чадварын судалгаагаар мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн үзүүлэлтээр 2018 онд 78, 2019 онд 96 дугаар байрт тус тус эрэмбэлэгдсэн. 2019 оны оноо өмнөх оноос 2.2 оноогоор дутуу байхад 18-аар ухарч 96 дугаар байрт орсон нь олон улсад энэ салбар хэрхэн хурдацтай өрсөлдөөнтэй хөгжиж байгааг илэрхийлж байна

Хүснэгт 38: Дэлхийн эдийн засгийн форумын өрсөлдөх чадварын судалгаа


Салбар	2018		2019	
	оноо	байр	оноо	байр
Мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжил	48.7	78	46.5	96
Гар утасны хэрэглээ	100	49	100	36
Хөдөлгөөнт өргөн зурвасын холбооны хэрэглээ		50	-	55
Тогтмол өргөн зурваст интернетийн хэрэглээ	18.5	76		76
Шилэн калбелийн интернет хэрэглээ		45		71
Насанд хүрэгчдийн интернет хэрэглээ			23.7	119
Интернет хэрэглэгчид	22.3	115		

Энэ бүлэг үзүүлэлтээс гар утасны хэрэглээгээр 2018 онд 100 оноогоор 49 дүгээр байрт орж байсан бол 2019 онд оноо өмнөх оны түвшинд байхад 36 дугаар байрт орж 10 орноор урагшилсан байна. Үүнээс үзэхэд гар утасны хэрэглээ энэ

салбарын хөгжлийг тодорхойлогч гол үзүүлэлт биш ажээ. Бусад үзүүлэлтүүдийг харахад тогтмол өргөн зурваст интернетийн хэрэглээ өмнөх оны түвшиндээ байна. Харин эдгээрээс бусад үзүүлэлт нь буурчээ. Ялангуяа шилэн кабелийн интернет хэрэглээний үзүүлэлтээр 2018 онд 45 дугаар байрт орж байсан бөгөөд 2019 онд 26 орноор ухарч 71 дүгээр байрт оржээ. Энэ нь энэ бүлэг үзүүлэлтээр байр ухарч 96 дугаар байрт ороход нөлөөлсөн.


Холбооны салбарын орлого 10 жилийн өмнө 406.2 тэрбум төгрөг байсан бол 2019 онд 1.2 их наяд төгрөг болж 3 дахин өссөн байна. Нийт орлогын 98 орчим хувь нь Улаанбаатар хотод, 2 хувь нь орон нутагт бий болжээ. Тус салбарын орон нутгийн орлого сүүлийн 10 жилд 1.9 дахин өсжээ. Бүс нутгаар нь авч үзвэл дунджаар 38 хувь нь Төвийн бүсээс, 32 хувь нь Хангайн бүсээс, 18 хувь нь Баруун бүсээс орсон ба үлдсэн 12 хувь нь Зүүн бүсэд бий болжээ.

График 46. Холбооны салбарын орлого, бүс нутгаар



Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо 2019 онд 820.7 мянга буюу 10 жилийн өмнөхөөс 4.5 дахин өссөн. Үүнээс 94 хувь нь Улаанбаатар хотын хэрэглэгчид бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд 5 дахин, нэмэгдсэн. Харин 6 хувь нь орон нутгийн хэрэглэгчид ба 2010 оноос 1.9 дахин олон хүн кабелийн телевиз хэрэглэдэг болжээ. Бүс нутгаар нь авч үзвэл 33 нь Хангайн бүсийн хэрэглэгчид, 30 хувь нь Төвийн бүсийн, 20 хувь Баруун бүс, 17 хувь нь зүүн бүсийн хэрэглэгчид байна.


График 47. Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо, бүс нутгаар



Эх сурвалж: ҮСХ

Суурин утасны цэгийн тоо 2012 оноос эхлэн дунджаар 13.6 хувиар өссөн ба 2019 онд 355 мянган ширхэг болж 2010 оноос 2.5 дахин нэмэгджээ.


График 48. Суурин утасны цэгийн тоо (ширхэг)



Эх сурвалж: ҮСХ

Телефон яриа 2010 оноос тасралтгүй дунджаар 77 хувиар буурч 2019 онд 9 сая минут болсон нь 10 жилийн өмнөхөөс 10 гаруй дахин богино хугацаагаар ярьжээ.

График 49. Телефон яриа (сая минут)



Эх сурвалж: ҮСХ

Үүрэн сүлжээний ярианы ачаалал сүүлийн 10 жилийн хугацаанд 2.4 дахин нэмэгдэж 7.4 тэрбум минут болсон байна. Үүрэн сүлжээнээс гарах, орох ярианы ачаалал тус тус 1.8 дахин их болжээ.

График 50. Үүрэн сүлжээнээс орсон гарсан яриа, сая минут




Эх сурвалж: ҮСХ

4.5 Бүсийн эдийн засгийн нөхцөл байдал

Баруун бүсийн нэг хүнд ногдох ДНБ

График 51. Баруун бүсийн нэг хүнд ногдох ДНБ, мян.төгрөг



Эх сурвалж: ҮСХ


Амьжиргааны доод түвшин 2018 онд 178000 төгрөг байсан ба 2019 онд 190700 төгрөг болж нэмэгджээ.

Салбарын үйлдвэрлэлийг харвал 2018 онд Говь-Алтай аймгийн ХАА салбарын үйлдвэрлэл 166.1 тэрбум төгрөг, үйлчилгээний салбар 136.4 тэрбум төгрөг, үйлдвэрлэл 54.1 тэрбум төгрөг, боловсруулах салбар 45.5 тэрбум төгрөг байлаа.

ДНБ-ний бүтцийг бүс нутгаар харьцуулан харвал 2018 онд баруун бүсийн ХАА салбар 42,9 хувь, үйлчилгээний салбар 35,9 хувийг эзэлж байгаа нь бусад бүсүүдээс хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Харин үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь хамгийн бага нь буюу 21.2 хувь байлаа.

• **Бүсийн ДНБ-ний бүтэц**


График 52. Бүсийн ДНБ-ний бүтэц, салбараар, 2018, хувиар



Эх сурвалж: Аймгийн эдийн засаг, нийгмийн 2019 оны танилцуулаа

Баруун бүсийн орон нутгийн төсвийн орлого


График 53. Баруун бүсийн орон нутгийн төсвийн орлого, сая төгрөг



Эх сурвалж: ҮСХ

• Баруун бүсийн орон нутгийн төсвийн зарлага

График 54. Баруун бүсийн орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөг



Эх сурвалж: ҮСХ

Баруун бүсийн орон нутгийн төсвийн зарлага 2019 онд 354.9 тэрбум төгрөг байлаа. Өмнөх онтой харьцуулахад 1.05 хувь өссөн байна. Үүнд Баян-Өлгий аймаг 22.0%, Говь-алтай аймаг 17.4%, Завхан аймаг 18.7%, Увс аймаг 22.5%, Ховд аймаг 19.4% тус тус эзэлж байна.

5. ХҮН АМ ЗҮЙН СУДАЛГАА

Монгол улсын хүн амын тоо аймгийн дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ. Монгол Улсын нийт хүн ам 2020 онд 3,357,542 болсон.




График 55: Монгол Улсын нийт хүн ам

Үндэсний статистикийн хорооны хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоонд Монгол Улсын хүн ам 1962 онд 1 сая, 1988 онд 2 сая, 2015 онд 3 саяд хүрч байсан бол 2031 онд 4 сая, 2045 онд 5 саяд хүрнэ гэж тооцоолсон байна. Хүн амын тоо тасралтгүй өсж байгаа нь дотоодын аялал жуулчлалын багтаамж нэмэгдэж зах зээл тэлж байгаа томоохон үзүүлэлт болох юм.




График 56: Монгол улсын хүн амын нас хүйсийн суварга

2020 оны байдлаар Нийт хүн амын 63.8% нь 35 хүртэл насны залуучууд байна. Тодруулбал нийт хүн амын 30.9% буюу 1,002,052 нь 0-14 насны хүүхэд, 62,4% буюу 2,020,696 нь 15-59 насны хүмүүс, 6.7% буюу 215,731 нь 60 ба түүнээс дээш насны өндөр настай байна.

Хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн амын насны бүтэц идэрших хандлагатай байгааг харуулж байна. Харин 10-19 насны бүлгийн хүн амын хэсгээр нарийссан байгаа нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин эрс буурч байсныг харуулж байна. Нийт хүн амын 63.8 хувь нь 35 хүртэл насны залуучууд байна. Дээрх суваргад хөдөлмөрийн насны хүн ам буюу 25-34 насны бүлгийн хүн ам харьцангуй их харагдаж байна. Үүнээс хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь нэмэгдэж байгааг харж болно. Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Олон улсад хүн ам зүйн “цонх үе”-д тухайн орны эдийн засаг хамгийн хурдацтай өсдөг байна. Тэгэхээр 2025 он хүртэл хүн ам зүйн “цонх үе” тохиож байгаа нь Монголын хувьд хөрөнгө оруулагчдыг татах, эдийн засгаа өсгөх маш том боломж юм. Хүн амын “хэт насжилтын” асуудалд ч манай улс санаа зовох шаардлагагүй нь Moody’s-ийн судалгаанаас харагдаж байна. 2015 онд Монгол Улсын нийт хүн амд 65-аас дээш насныхны эзлэх хэмжээ 3.8 хувь байх бол 2020 онд 4.4 хувь, 2030 онд 7.2 хувьд хүрэхээр байна. Энэ үед Монгол Улс эдийн засгийн өсөлтөө дотоодын ажиллах хүчнээр хангах боломжтой болох бөгөөд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлөх боломжтой. Хүн ам зүйн цонх нээгдсэн үед хүүхэд,

залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц байх нөхцөл бүрэлдээд байна.

Үйлчлүүлэгчдийн хувьд авч үзвэл идэр насны бүлгийнхнийг залуучууд бүрдүүлэх бөгөөд тэдгээрт тулгарсан бүтээгдэхүүн, үйчлилгээг хөгжүүлж ажиллахаар төлөвлөж байна.

6. НИЙГЭМ СОЁЛЫН ОРЧНЫ СУДАЛГАА



Зураг 31: Нийгэм соёлын орчны судалгаа

6.1 Монгол улсын угсаатны бүтэц

Үндэсний статистикийн хорооны судалгааны тайлан дүнгээс Монгол Улсын хүн амын үндэс угсааны байдлыг танилцуулж байна.

Монгол Улсын суурин хүн амын 84.5 хувийг Халх үндэстэн, 3.9 хувийг Казах, 2.4 хувийг Дөрвөд, 1.7 хувийг Баяд, 1.3 хувийг Буриад ястан эзэлж байгаа нь улсын нийт хүн амын 94 орчим хувь болж байна. Байршлын хувьд Халхчууд бүх аймаг, нийслэлд оршин сууж байгаагийн дотор нийт хүн амд хамгийн бага хувиар Ховд 28.4 хувь, Увс 13.8 хувь, Баян-Өлгий 1.2 хувийг эзэлж байгаа бол Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өмнөговь аймгуудын нийт хүн амын 99-с дээш хувь нь Халхчууд байна. Өмнөх тооллогоор Цаатан, Тува, Казах, Дархадчуудын ихэнх нь хөдөө орон нутагт суурьшиж байсан бол 2015 оны тооллогоор ихэнх нь хотод суурьшсан байна.



Зураг 32: Монгол орны ястнууд

Монгол Улсын харьяат суурин хүн амын 84.5 хувийг халхчууд эзэлж байгаа нь өмнөх тооллогоос 2.1 пунктээр өссөн үзүүлэлт юм. Казахуудын нийт хүн амд эзлэх хувийн жин 3.9 хувь байгаа нь халхчуудын дараа орж байна. Харин Буриад, Баяд, Захчин, Өөлд угсаатнууд 2010 оныхоос ихээр буурсан байна Хотон, казахуудын дунд 0-14 настай хүүхдийн эзлэх хувийн жин тус бүр 37.4, 35.2 хувь байж, бусдаас нэлээд өндөр байгаа нь тэдний дунд төрөлт өндөр байгаатай холбоотой юм. Харин Сөнөд, Хорчин, Харчин, Элжигэн, Сартуулуудын дунд 45-аас дээш настай хүний эзлэх хувийн жин 25 хувиас илүү байгаа нь насжилтыг илэрхийлж байна.



Олон угсаатны өлгий нутаг Ховд аймгийн нийт хүн амын дотор Халх 28.4 хувь, Захчин 24.7 хувь, Казах 12.2 хувь, Урианхай 7.8 хувь, Торгууд 7.3 хувь, Дөрвөд 6.4 хувь, Өөлд 6.3 хувь, Мянгадууд 4.9 хувь байгаа нь бусад аймгаас онцлог юм.



Хотон

Баяд

Дөрвөд

Торгууд

Бүс нутгаар үзэхэд Баруун бүсийн нийт хүн амын дотор Халх 41.6 хувь, Казах 25.1 хувь, Дөрвөд 10.6 хувь, Баяд 7.2 хувь, Захчин 5.4 хувийг эзэлж байна. Казахчуудын 75.5 хувь нь Баян-Өлгий аймагт, Дөрвөдүүдийн 48.6 хувь, Захчингуудын 54.3 хувь, Хотончуудын 49.9 хувь нь Увс аймагт оршин сууж байна. Хангайн бүсийн нийт хүн амын дотор Халх 89.6 хувь, Дархад 3.5 хувь, Хотогойд 3.4 хувийг эзэлж байгаа бөгөөд Хотогойдуудын 89.6 хувь, Дархадчуудын 85.4 хувь нь

Хөвсгөл аймагт оршин сууж байна. Зүүн бүсийн нийт хүн амын дотор Халх 75.3 хувь, Дарьганга 11 хувь, Буриад 9.9 хувь, Барга 1 хувийг эзэлж байна. Дарьгангачуудын 81.2 хувь, Үзэмчингүүдийн 7.9 хувь нь Сүхбаатар аймагт оршин сууж байна. Мөн Дорнод аймгийн нийт хүн амын 2.6 хувь нь Барга, 2.2 хувь нь Үзэмчингүүд байгаа нь эдгээр угсаатны хамгийн олноороо оршин суудаг аймаг бөгөөд тухайн угсаатны бүлгийн 74.1 ба 79.9 хувийг тус тус төлөөлж байна. Төвийн бүсийн нийт хүн амын дотор Халх 92.8 хувь, Баяд 1.5 хувь, Дөрвөд 1.4 хувийг эзэлж байна. Монгол Улсын суурин хүн амын 84.5 хувь Халхчууд бөгөөд бүх аймаг, нийслэлд тархан суурьшсан байдаг. Нийт хүн амд эзлэх хувийн жингээр хамгийн их угсаатны бүлэгт Халх, Казах, Дөрвөд, Баяд, Буриадчууд орж байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

6.2 Говь-Алтай аймгийн угсаатны бүтэц

Монгол Улсын угсаатны бүтэц

Хүснэгт 39. Хүн амын тоо, үндэс угсаа, насны бүлэг, хувиар, 2015 он

Үндэс угсаа	Бүгд	Насны бүлэг					
		0-14	15-24	25-34	35-44	45-54	55+
БҮГД	100.0	30.2	16.6	18.4	14.2	10.8	9.8
Халх	100.0	30.0	16.1	18.7	14.4	10.9	9.9
Казах	100.0	35.2	19.4	16.9	12.0	8.6	7.8
Дөрвөд	100.0	30.2	19.4	17.1	13.5	10.7	9.2
Буриад	100.0	26.5	17.8	17.5	13.8	11.3	13.0
Баяд	100.0	30.7	19.3	16.6	13.2	10.5	9.6
Дарьганга	100.0	25.3	18.2	17.6	15.3	11.8	11.9
Урианхай	100.0	28.9	18.9	17.5	13.8	10.8	10.2
Захчин	100.0	30.6	20.4	17.0	12.8	9.7	9.5
Дархад	100.0	29.3	19.1	17.6	13.3	11.2	9.6
Торгууд	100.0	27.3	17.5	17.9	14.3	11.8	11.3
Өөлд	100.0	27.7	18.9	16.5	14.2	11.2	11.5
Хотон	100.0	37.4	20.3	15.8	11.2	8.8	6.5
Мянгад	100.0	30.9	19.7	15.8	14.1	9.9	9.6
Барга	100.0	25.6	17.8	19.3	13.9	10.1	13.2
Үзэмчин	100.0	24.8	19.1	18.9	13.1	12.0	12.2

Харчин		100.0	27.7	16.3	14.5	15.1	10.5	16.0
Хотогойд		100.0	30.1	17.1	17.0	14.9	11.2	9.8
Элжигэн		100.0	22.9	17.1	15.9	18.4	13.0	12.7
Цаатан		100.0	30.5	17.4	17.6	14.8	10.0	9.8
Сартуул		100.0	22.9	15.5	19.2	16.3	11.3	14.9
Тува		100.0	33.0	19.6	16.4	12.9	8.9	9.2
Хорчин		100.0	12.5	23.6	18.1	16.7	13.9	15.3
Узбек (Чантуу)		100.0	30.0	18.2	22.2	11.8	8.4	9.4
Халимаг		100.0	31.8	22.7	9.1	13.6	18.2	4.5
Түмэд		100.0	23.5	14.7	17.6	20.6	11.8	11.8
Сөнөд		100.0	25.0	12.5	0.0	18.8	25.0	18.8
Хамниган		100.0	24.3	20.6	16.5	14.8	9.2	14.6
Хошууд		100.0	32.7	20.7	14.4	13.2	8.4	10.5
Монголын харьяат бусад		100.0	62.0	11.4	6.4	7.3	5.9	7.0
Монголын харьяат гадаад		100.0	70.3	9.6	6.7	6.0	3.6	3.8

Говь-Алтай аймгийн нийт хүн ам нь Монгол Улсын нийт хүн амын 2.3 хувь бөгөөд тус аймагт оршин сууж байгаа үндэстэн угсаатнуудын дийлэнх нь халхчууд, нийт халхчуудын 2,7 хувь, нийт хотгойдуудын 1.3 хувь нь, монголын нийт сартуулчуудын 0.4 хувь нь, монголын нийт торгууд, харчин, элжигэн халхчуудын 0.3 хувь, нийт цаатангуудын 0.2 хувь нийт казак, буриад урианхай, захчин, өөлд, мянгад, баргуудын 0.1 хувь нь тус аймагт амьдарч байна.

6.3 Монголын тэмдэглэлт арга хэмжээнүүд

- **Цагаан сар**

Монгол үндэстний уламжлалт шинэ жилийн баяр юм. Цагаан сарын баярыг Буддын шашины Шарын шашин Төгсбуянт буюу билгийн тооллын дагуу хаврын эхэн сард тэмдэглэдэг. Монголын Цагаан сарын баярыг Монгол улсаас гадна ОХУ-ын Буддын шашинт Буриад, Тува, Алтай, Халимагийн ард түмэн тэмдэглэн өнгөрүүлдэг.

- **Наадам**

Наадам — монгол үндэстний зуны дэлгэр баяр, олон төрөлт спортын тэмцээн юм. Наадмыг 2010 онд ЮНЕСКО «Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалт»-д бүртгэн авчээ.

- **Мөсний баяр**

“Мөсний баяр”-г өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 2000 оноос эхлэн Хөвсгөл нуурын мөсөн дээр зохион байгуулж байгаа. Мөсний баярын үеэр мөсөн хотхон баригдаж “Чаргатай морьдын уралдаан”, “Мөсөн дээрх шагайн харваа, тэшүүрийн тэмцээн, үндэсний хувцасны үзүүлбэр, олс таталт, галын наадам, бөөгийн ёслол зэрэг арга хэмжээ зохион байгуулагддаг.

- **Тэмээний баяр**

Эл арга хэмжээ нь хоёр бөхтэй тэмээн сүргийг хамгаалах, тэмээчин ардын уламжлалт соёл, зан заншлыг олон нийтэд сурталчлан, таниулах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой. Баярын үеэр тэмээтэй жагсаал, тэмээн поло, шагайн харваа, буухиа, тайлаг, ат болон торомны уралдаан зэрэг арга хэмжээ зохион байгуулах юм байна. Дэлхийд хоёр зүйлийн тэмээ байдгийг уншигчид андахгүй. Үүнээс хос бөхтэй нь нийт тэмээний ердөө 10 хувийг л эзэлдэг, ховор амьтан.

- **Бүргэдийн баяр**

Манай улсыг зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, бүргэдээр ан хийлгэх уламжлалт заншлыг хадгалах зорилгоор БОАЖЯ, Нийслэлийн аялал жуулчлалын холбоо хамтран энэхүү арга хэмжээг 19 дэх жилдээ зохион байгуулсан байна. Хамгийн анх 2000 онд Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газраас санаачлан "Бүргэдийн баяр"-ыг хийж эхэлсэн түүхтэй.

Хүн төрөлхтөний түүхэн дэх шувуугаар ан хийлгэх буюу шувуучлахуйн том зан үйл болох энэ үйл явдлыг 2010 онд ЮНЕСКО-оос “Хүн төрөлхтний соёлын биет бус өв”-д албан ёсоор бүртгэн авчээ.

Монголд тэжээгдэж буй нийт бүргэдийн 70 хувь нь 1-4 настай шувуу байдаг бөгөөд бүргэдийг 5-6 нас хүрмэгц нь байгальд буцаан тавьдаг аж.

- **Дээлтэй Монгол**

Гадаад, дотоодын олон зочид төлөөлөгчдөд Монгол үндэснийхээ хувцсыг танин мэдүүлж, бидний хойч үе болох үр хүүхдүүддээ Монгол ёс заншил, соёлын өв болсон үндэсний дээлээ өвлүүлэн үлдээх зорилготой. Жилээс жилд хамрах хүрээ илт нэмэгдэж өнгөрсөн онд гэхэд 2800 хүн “Дээлтэй Монгол наадам” хөтөлбөрт хамрагдсан байна.

6.3.1 Гэмт хэрэг, зөрчил

		2020 оны эхний 4 сарын байдлаар	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад
   	Бүртгэгдсэн гэмт хэрэг	10 130	□ 2802 (21.7%)
	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	1 355	□ 212 (18.5%)
	Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг	383	□ 103 (21.2%)
	Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг	1 009	□ 82 (8.8%)
	Хүүхэд оролцсон гэмт хэрэг	175	□ 57 (24.6%)
	Гэмт хэргийн улмаас		
	Гэмтсэн иргэн	2 634	□ 333 (11.2%)
	Нас барсан иргэн	307	□ 167 (35.2%)
	Учирсан хохирол	51.2 тэрбум төгрөг	□ 14.7 тэрбум төгрөг (22.3%)
	Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ	9.0 тэрбум төгрөг	□ 4.4 тэрбум төгрөг (32.8%)
Эрүүлжүүлэгдсэн хүн	35.3 мянга	□ 2.3 мянга (6.1%)	
Баривчлагдсан хүн	5.2 мянга	□ 1.2 мянга (29.7%)	

Зураг 33: гэмт хэрэг, зөрчил

7. ТЕХНОЛОГИЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Говь-Алтай аймгийн Тайширын Гэгээн нуурын УЦС нь аялал жуулчлалд их чухал ач холбогдолтой. Монгол Улсын Засгийн Газар, Арабын Эдийн Засгийн Хөгжлийн Кувейтийн Сан, Эдийн засгийн Абу Даби Сангийн хооронд станцыг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн зээлийн хэлэлцээрүүд байгуулагдсан юм. Тайширын УЦС-ын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын Синохайдро корпораци, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын Камко Интернейшнл компаниуд шалгаран 2004 оны 10 дугаар сараас ажлаа эхэлсэн.

Тайширын УЦС-ын үндсэн барилга байгууламж нь голын урсацыг шилжүүлэх 6м голчтой 165м урт туннель, барилгын үйлдвэрлэлийн бааз, ажилчдын түр тосгон, 305 м урт 6 м диаметртэй ашиглалтын туннель, станцын барилга 50м өндөр, хярын урт нь 192м, эзэлхүүн нь 187 000м³ багтаамжтай далан зэрэг болно. УЦС-ын үндсэн үзүүлэлтүүд: Суурилагдсан чадал 11 МВт. Жилд үйлдвэрлэх цахилгаан 37 сая кВтц Далангийн өндөр 50 м4. Далангийн урт 190 м. Төсөвт өртөг 38,9 сая \$ Цахилгаан дамжуулах шугам: Алтай хот хүртэл 47 км 35кВ Улиастай хот хүртэл 135 км 110 кВ Сумдын төвүүд хүртэл 260 км 10-35 кВ. Агрегатын тоо 4 ш

Станцын барилга угсралтын ажлыг 2007 онд, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлыг 2008 оны 10 дугаар сард дуусаж эхний агрегатыг ашиглалтанд оруулсан ба усан сангийн дүүргэлт зохих түвшиндээ хүрээгүйгээс бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна. УЦС-ыг ашиглалтанд оруулснаар хоёр аймгийн төв болон Говь-Алтай аймгийн Тайшир, Бигэр, Жаргалан, Халиун, Шарга, Баян-уул, Дэлгэр, Төгрөг, Завхан аймгийн Цагаанчулуут, Цагаанхайрхан, Шилүүстэй, Отгон, Алдархаан зэрэг сумууд эрчим хүчээр хангаж байна.



7.1 Нар, салхины эрчим хүч ашиглах шийдэл



Зураг 34: Нар, салхины эрчим хүч ашиглах шийдэл

Нарны халаалт


Дэлхийд түгээмэл хэрэглэгдэж буй 3 төрлийн нарны халаалт байдаг. Үүнд:

- Хавтгай коллектор – Ихэвчлэн дулаан оронд ашигладаг.
- Агаарын коллектор – агаар халаахад зориулж ашигладаг. /хүлэмж г.м/
- Вакуум коллектор – хүйтэн, сэрүүн орчинд ашиглахад тохиромжтой. Орчны температурын нөлөөнд бага автдаг.

Манай орны хувьд хүйтэн сэрүүн уур амьсгалтай тул вакуум коллекторыг ашиглан нарны эрчим хүчийг ашиглаж байна.

Монгол орон нарны эрчим хүчний арвин нөөцтэй болохыг гадаад, дотоодын эрдэмтдийн судлагаагаар тогтоогдон нөөцийг нь батласан байдаг. Монголд нарны энергийг эрчим хүчний зориулалтаар ашиглах бүрэн боломжтой. Сэргээгдэх эрчим хүчийг ашиглахад тухайн хэрэглэгчийн дулааны хэрэглээ бага буюу барилгын хаших хийцүүдийн дулааны алдагдал бага байх тусам сэргээгдэх эрчим хүчний анхны хөрөнгө оруулалтын хэмжээ буурах давуу талтай байдаг.

Төвийн дулааны шугамаас алслагдсан барилга, байгууламж, хувийн орон сууц, жуулчны бааз зэргийн халаалт, халуун ус хангамжинд нарны вакуум коллектор системийг ашигласнаар бие даасан халаалтын системийг бий болгох бөгөөд төвийн дулааны шугамаас хямд өртгөөр шийдэх боломжтой юм.



Зураг 35: нарны вакуум коллектор систем

Нарны халаалт болон хэрэглээний халуун ус бэлтгэх системийн гол давуу тал нь бүрэн автомат ажиллагаатай учраас ашиглалтын үед хүний оролцоо шаардлагагүйгээрээ онцлогтой. Нарны вакуум коллектор халаалтын системийг суурилуулахад тухайн барилга нь жилийн туршид /тэр дундаа өвлийн улиралд/ өдөржингөө нар тусаж байхаар байгалийн болон зохиомол сүүдэрлэлтэнд өртөхөөргүй байрлалд байх ёстой. Нарны вакуум коллектор халаалтын системийг тухайн барилгын дээвэр дээр нь суурилуулах боломжтой байдаг. Энэ нэмэлт суурь

хийх, дулааны урт шугам татах зэрэг зардлуудыг хэмнэдэг. Мөн нарны халаалтын систем суурилуулах тухайн барилга нь чанх өмнө зүгээс баруун болон зүүн тийш хэт их хазайж байрласан тохиолдолд дээвэр дээр нь суурилуулбал халаалтын системийн үр ашиг буурдаг учраас газар дээр нэмэлт суурь хийж суурилуулах шаардлагатай болдог нь халаалтын системийн үнийг ихэсгэдэг.

Нарны эрчим хүчээр дулаан хангамж, хэрэглээний халуун ус бэлтгэх чиглэлээр хот хөдөө орон нутагт байрлах барилга байгууламжид нарны халаалтын системийг туршиж байгаа олон ажлууд байна. Монгол орны эрс тэс уур амьсгалд энэхүү нарны халаалтын систем нь тохирох эсэх, өвлийн улиралд найдвартай тасралтгүй ажиллах эсэхийг хувийн хэвшлийн байгууллагууд, судалгааны байгууллагууд туршилт судалгааг сүүлийн жилүүдэд олон янзаар хийж байна. Эдгээр ажлуудын нэг нь Хустайн нурууны тахь үржүүлэх цогцолбор газарт байрлах оффисийн зориулалттай 420м² талбайтай барилгын халаалт, хэрэгцээний халуун усны системийг цогцоор нь нарны эрчим хүчний тоног төхөөрөмжөөр шийдэх туршилт юм. Энэ ажил нь Монголдоо талбайгаараа хамгийн том буюу 88м² талбайтай нарны халаалтын систем билээ.

Монгол орны хувьд өвлийн улиралд нарны эрчим хүчээр дулааны эрчим хүч гарган авахад АҮК харьцангуй бага байдаг бөгөөд өрхийн бага оврын нарны тоног төхөөрөмж ашиглан хэрэглээний халуун усаар ажлыг хувийн хэвшлийн зарим байгууллагууд үр дүнтэй туршиж байна.

Нар, салхины эрчим хүч ашиглах шийдэл

Нарны цахилгаан үүсгүүр

Нараар цахилгаан үүсгэдэг технологи нь дараах 2 төрөлтэй.

- Моно
- Поли

Манай оронд дээрх 2 технологийг аль алиныг нь ашиглаж байна. Ерөнхийдөө нараар цахилгаан үүсгэхэд тухайн газар орны нарны цацрагийн 14% нь цахилгаан эрчим хүч болж хувирдаг. Манай орны хувьд уг энергиэр гэрэлтүүлэх, индүү, угаалгын машин зэрэг цахилгаан барааг ажиллуулах зэрэгт ашиглах бүрэн боломжтой. Харин дулааны энерги болгон хувиргах тухайд хэрэглээний ус халаах, усанд орох ус халаах зэрэгт л ашиглах боломжтой болохоос дулаацуулгын энерги болгох боломж хомс байдаг хэмээн мэргэжлийн хүмүүс дүгнэсэн байдаг. Түүнчлэн,

Нарны эрчим хүчийг ашигласан технологио жуулчны баазын архитектурын шийдэл болгосон жишээ дэлхий дээр олон байдаг. Малдив улсын Гасфинолхуд байрлах Финолху Виллас 5 одтой зочид буудал нь нарны цахилгаан үүсгүүрийг ашиглан эрчим хүчний үр ашигтай технологийг ашигласнаар дэлхийд эко аялал жуулчлалд дурлагсдыг шууруулж чадсан билээ.

Эрчим хүчний үр ашигтай технологи ашиглах, хэмнэлт гаргах боломжууд

Нарны налаалт

Нарны цахилгаан үүсгүүр

2 товчлуурт 00

Мэдрэгчтэй угаалтуур

Халуун усыг дахин эргэлдүүлэх систем

Усан халаалтын систем

Эрчим хүчний хэмнэлттэй гэсэн тэмдэглэгээтэй цахилгаан бараа ашиглах

Эрчим хүчний үр ашигтай халаалт/сэрүүцүүлэлтийн систем


- Эрчим хүчний үр ашигтай гэрэлтүүлэг
- Саарал усыг дахин ашиглах систем

7.2 Усны хэмнэлтийн технологи ашиглах нь

“International tourism partnership” байгууллага 2012 оноос эхлэн “Water working group” –ийг байгуулан аялал жуулчлалын байгууллагууд усыг үр ашигтай ашиглах, хэмнэх ямар боломжууд байгаа талаар судалж байна. Ялангуяа амралтын газар, зочид буудлууд усны их хэмжээний хэрэглээтэйгээ хэрхэн үр ашигтайгаар тэмцэх талаар багагүй хэлэлцүүлэг өрнүүлсний эцэст “Stockholm International Water Institute” –тэй хамтран энэ талаар судалгаа хийснээр Хүйтэн сэрүүн, дундаж, халуун уур амьсгалтай орнуудад үйл ажиллагаа явуулж буй зочид буудлуудын нэг хоногийн нэг жуулчинд зарцуулж буй усны хэрэглээг судалж үзээд дээрх үр дүн гарчээ. Эдгээр үр дүнд үндэслэн дэлхийн аялал жуулчлалын байгууллагуудад дараах нэг жуулчны нэг хоногийн усны хэрэглээнд дараах стандартыг тогтоосон байна. Хүйтэн сэрүүн уур амьсгалтай манайх шиг орны тансаг зэрэглэлийн буудлын нэг жуулчны нэг хоногийн усны хэрэглээ $0,3\text{м}^3$ -с бага болон маш сайн, $0,45\text{м}^3$ - $0,3\text{м}^3$ -ийн хооронд бол боломжийн, $0,7$ - $0,45\text{м}^3$ н хооронд бол эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан байна.

Дээрх стандартыг хангаж ажиллахын тулд аялал жуулчлалын байгууллагууд дараах усны үр ашигтай хэмнэлтийн технологиудыг ашиглах нь зүйтэй.


Хэрэглэсэн ахуйн усаа дахин ашиглах



Зураг 36: Хэрэглэсэн ахуйн усаа дахин ашиглах

Борооны ус ашиглах

Дээврийн болон борооны ус ашиглах зорилгоор байрлуулсан савтай уснуудыг нэг цэгт төвлөрүүлэн хадгалж саарал ус ашиглах боломжтой талбаруудад хуримтлуулсан борооны усаа ашиглах.



Зураг 37 : хуримтлуулсан борооны усаа ашиглах

Ингэхдээ дээр зурагт үзүүлсэн борооны усыг байгууламжийн дор цуглуулж ашиглах шийдлийг ашиглаж болох юм.

7.3 Мэдээллийн технологи ашиглах боломж

Манай орны нийт хүн амын 60% нь интернетэд холбогдож, 80% нь ухаалаг утас ашиглаж буй өнөөгийн нийгэмд мэдээллийн технологийг ашиглах нь хамгийн оновчтой шийдэл болох юм. Мэдээллийн технологийг аялал жуулчлалын байгууллагууд үйл ажиллагаандаа идэвхитэй ашигласнаар дараах үр ашиг бий болно. Үүнд:

- Цаасны хэрэглээг бууруулах,
- Хүний хөдөлмөрийг хэмнэх,
- Бүтээмжийг нэмэгдүүлэх,
- Мэдээллийг шуурхай дамжуулах буюу цаг хэмнэх
- Жуулчдад сонирхолтой байдлаар үйлчилгээгээ хүргэх

Хүснэгт 40. Мэдээллийн технологи

Хэлмэрч төхөөрөмжүүд /олон хэлтэй/	
Мэдээллийн технологи	Интернет
	Оффлайн / Онлайн аппликэйшн /Резортын дотоод газрын зураг/
	Захиалгын систем
	Утас / Таблет / Компьютер
	GPS

7.3.1 Хөрсний бохирдлоос сэргийлэх арга зам буюу байгаль орчинд ээлтэй эко ариун цэврийн байгууламжууд

Хөрсний бохирдол гэж юу вэ?¹

Хөрсний бохирдол гэдэг нь тухайн хөрсний хэвийн үйл ажиллагаа гадны ямар нэгэн нөлөөгөөр байгалийн шинжээ алдах үйл явцыг хэлнэ. Ерөнхийдөө хөрс нь агаарт цацагдсан хорт бодис, утаа тортог, газар дээрх хуурай нойтон хог хаягдлаар бохирддог. Ялангуяа хүн, амьтны хатуу ба шингэн хаягдал, ургамлын үлдэгдэл, ахуйн ба үйлдвэрийн бохир ус зэрэг нь бохирдуулагч эх үүсвэр болдог байна.

Хөрсний бохирдлын хэлбэр

¹ <http://www.nogoonhutuch.mn/a/51>

Химийн бохирдол: хүнд металлууд, цацраг идэвхит бодисууд, нефтийн нүүрс усууд, эрдэс бордоонууд.

Биологийн бохирдол: мал амьтны сэг, хөдөө аж ахуйн, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлууд, ойн хортон шавжтай тэмцэхэд хэрэглэдэг бактериуд.

Халдвар дамжих зам

Бохирдсон хөрсөнд цусан суулга өвчин үүсгэгч нян 25-100, балнадын нян 100-400, саажилтын вирус 100-150 хоног тус бүр хадгалагддаг ба халдвар дамжуулагч хачиг, нохой бөөс, бясаа, шумуул, ялаа үржих таатай орчин болдог байна. Бохирдсон хөрснөөс эвгүй үнэр гарч, индол, хүхэрт устөрөгч, метан зэрэг хорт хий ялгарч агаарыг бохирдуулдаг.

Хөрсний бохирдлын эх үүсвэр

- Гэр хорооллын жорлон
- Ил задгай бие засах
- Үхсэн мал, нохойны сэг зэмийг ил хаях
- Фермерийн аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгжүүд болон хувь хүмүүс амьтан, малын ялгадас бууцыг гол, уулын ам, жалга руу замбараагүй ихээр асгах
- Автомашины задгай угаалгын газар
- Эмнэлгийн аюултай хог хаягдал

Хөрсний бохирдлын нөлөө

- Гадаргын болон газрын доорх усыг бохирдуулдаг
- Гэдэсний халдварт өвчин
- Цусан суулга
- Халдварт шар
- Балнад
- Урвах тахал
- Малаас хүнд дамжин халддаг боом, бруцеллэз
- Мэрэгч амьтдаас хүнд халддаг тарваган тахал, галзуу, шимэгч хорхойн халдварууд гэгддэг хялгасан хорхой, цагаан хорхой, өргөн туузан хорхой, хуж хорхой
- Үхрийн болон шахайн туузан хорхой, сүрьеэ, амьсгалын замын өвчин

Хөрсний бохирдлоос сэргийлэхийн тулд нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас дараах зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:

- Ундны усыг баталгаатай эх үүсвэрээс авах
- Усыг буцалгаж хэрэглэх, түүхий ус уухгүй байх
- Угааж цэвэрлэсэн тагтай, зориулалтын саваар усыг зөөвөрлөн хадгалах
- Усны савыг 7 хоногт 1-2 удаа бүрэн суллаж цэвэрлэх (Хүнсний сод эсвэл зориулалтын шингэн бүхий халуун усаар угааж, цэвэр усаар зайлах)
- Булаг, шанд, гол, горхины усыг хүнсэнд хэрэглэхгүй байх
- Гараа сайтар савандаж угаах
- Ахуйн хог хаягдлыг ялган ангилж, өдөр бүр тогтсон цэгт хаях;

- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй, шатаахгүй байх;
- Гуу жалганд хурсан хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах;
- Стандартын шаардлага хангасан нүхэн жорлон, угаадасны нүхтэй байх
- Жорлон, угаадасны нүхийг хлорлог бодис (жавелион, кальцийн гипохлорид, натри гипохлорид, клорсепт...)- оор халдваргүйтгэх, авгалдай устгал хийх
- Бие засах газарт халдваргүйтгэл хийх, шимэгч хорхойн өндөг, ялааны авгалдай устгах арга хэмжээ авах
- Гудамж, талбайд нус, шүлс, цэр, тамхины иш хаяхгүй байх, угаадас асгахгүй байх.

Ахуйн бохир ус гэж юу вэ?

Ахуйн бохир ус нь хүн амьтны физиологийн ялгадас, ахуйн угаалга цэвэрлэгээ, хоол хүнс бэлтгэхэд хэрэглэсэн уснаас бүрдэнэ. Түүний үндсэн бохирдол нь органик бодисууд, ялгадас, хүнсний бүтээгдэхүүний хаягдал ахуйн химийн бодис, өвчин үүсгэгч нян зэрэг байна.

Дэвшилтэт ногоон технологи гэдэг нь

- Байгаль орчинд ээлтэй
- Эрчим хүчний хэмнэлттэй
- Эдийн засгийн хувьд үр ашигтай гэсэн 3 шаардлагыг хангаж буй технологийг хэлнэ.

Бохир усны төрөл /MNS 6279:2011/

- Grey water – саарал ус
Ямар нэг ялгадасгүй зөвхөн ахуйн бохир ус
- Black water
Усан шингэлэн зайлуулсан өтгөн, шингэн ялгадас
- Brown water
Усаар шингэлэн зайлуулсан өтгөн (шээсний хольцгүй) өтгөн ялгадас
- Yellow water
Өтгөн хольцгүй шингэн ялгадас

Бохир усны төрөл

Бохир усыг түүний үүсэл гарлаар нь дараах төрөлд ангилна.

Ахуйн бохир ус нь хүн амьтны физиологийн ялгадас, ахуйн угаалга цэвэрлэгээ, усанд орох, хоол хүнс бэлтгэхэд хэрэглэсэн уснаас бүрдэнэ. Түүний үндсэн бохирдол нь органикууд, ялгадас, хүнсний бүтээгдэхүүний хаягдал, ахуйн химийн бодис, өвчин үүсгэгч нян зэрэг байна.

Үйлдвэрийн бохир ус нь үйлдвэрийн технологийн төрөл бүрийн технологийн процесст хэрэглэсэн ус байна.

Хур тунадасны ус гэдэг нь бороо, хайлсан цасны ус барилгын дээвэр, гудамж, зам талбай дээр бууж түүн дээрх бохирдлыг агуулсан ус байна.

Ахуйн бохир усыг дотор нь хар ба саарал ус гэж ялгадаг. Хар ус гэдэг нь ялгадас зайлуулах төхөөрөмжөөс гарах хүний өтгөн, шингэнийг агуулсан ус байна. Саарал ус гэдэг нь усанд орсон, гар нүүр, хувцас, гал тогооны сав суулга, угаахад гарсан усыг хэлнэ. Ахуйн бохир усны 30% орчмыг хар ус эзэлдэг ба энэ нь фосфор, азот, төрөл бүрийн нянгийн бохирдлыг ихээр агуулдаг тул түүнийг зайлшгүй цэвэрлэж халдваргүйжүүлэх шаардлагатай.

Бохир усыг тодорхойлох үндсэн үзүүлэлтүүд

- Бохир усны тоо хэмжээ (м.куб/хоногт, м.куб/цаг)
- Бохирдлын төрөл (БХХ, умбуур бодис)
- Бохирдлын концентраци (мг/л)
- Бохир усны тоо хэмжээ (м.куб/хоногт, м.куб/цаг)

$$Q = \frac{N * B}{1000}$$

Үүнд: N- хүний тоо

B- нэг хүний ус гаргалгааны норм

Бохир ус цэвэрлэгээний аргууд

- Механик
 - Сараалж
 - Элс баригч
 - Тунгаагуур
 - Жигдрүүлэх сан
 - Шүүлтүүр
- Биологийн арга

Шүүх талбай
Усалгаат талбай
Био цөөрөм
Исэлдүүлэх суваг
Аэротанк
Био шүүлтүүр
Аноксик байгууламж

- Физик химийн арга
 - Экстраци
 - Сорбци
 - Флотаци
 - Ион солилцоо
 - Диализ
 - Бүлэгнүүлэх
 - Хлоржуулах

Эко ариун цэврийн байгууламжийг ашиглах нь

Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас 2017 оны 04-р сарын 26-ны 10/2386, 2017 оны 05.27-ны өдрийн 10/2780, 2017 оны 07.17-ны өдрийн 07/4285, 2017 оны 09.15-ны өдрийн 10/5615, 2017 оны 11.24-ний өдрийн 10/7194 тоот албан бичгүүдээр Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаадад хүргүүлж стандартыг мөрдүүлэхийг үүрэг болгосон.

2018 оны 06 сарын 01-ний өдрөөс эхлэн тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын зориулалтаар үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь тус стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж болон бусад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжгүй, байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд үйл ажиллагааг зогсоох, газар ашиглах эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг мэдэгдсэн байна.



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**



**ТУСГАЙ
ХАМГААЛАЛТТАЙ
ГАЗАР**

**2018.06.01-НЭЭС ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАРТ
СТАНДАРТЫН БУС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ АШИГЛАХЫГ ХОРИГЛОНО**



YES



YES



NO

Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас 2017 оны 04 дүгээр сарын 26-ны 10/2386, 05 дугаар сарын 12-ны өдрийн 10/2780, 07 дугаар сарын 17-ны өдрийн 07/4285, 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 10/5615, 11 дүгээр сарын 24-ний өдрийн 10/7194 тоот албан бичгүүдээр Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаадад хүргүүлж стандартыг мөрдүүлэхийг үүрэг болгосон.

Иймд 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын зориулалтаар үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тус стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж болон бусад хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа стандартуудад нийцсэн ариун цэврийн байгууламжгүй, байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд үйл ажиллагаа зогсоох, газар ашиглах эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг үүгээр мэдэгдэж байна.

Тус стандарт шаардлагатай холбоотой мэдээлэлийг тус линкээр орж авна уу.

 <http://ebook.mpa.gov.mn/i/2067>
 <http://ebook.mpa.gov.mn/i/2064>

MNS5924:2015 стандартаар доор дурдсан 4 төрлийн ариун цэврийн байгууламжийг санал болгосон.Үүнд:

- Агааржуулагчтай сайжруулсан ариун цэврийн байгууламж
- Бага усаар зайлуулах ариун цэврийн байгууламж
- Хуурайшуулах ариун цэврийн байгууламж
- Бордоожуулах ариун цэврийн байгууламж

Эдгээр төрлүүдийн хийц бүтээц, ашиглалтын технологи өөр хоорондоо ялгаатай бөгөөд тухайн хэрэглэгч нь хөрсний шинж чанар, газрын тогтоц, эдийн засгийн боломж зэрэг өөрсдийн онцлог, нөхцөлдөө тааруулан сонголтоо хийнэ.

1. Соруулдаг усны хэрэглээ багатай нийтийн ариун цэврийн байгууламж
2. Өтгөн шингэнийг ялгадаг хуурайшуулах шийдэлтэй ариун цэврийн байгууламж
3. Зөөврийн буюу шилжүүлэх ариун цэврийн байгууламж
4. Агааржуулагчтай, сайжруулсан ариун цэврийн байгууламж

Загвар 1. Соруулдаг ариун цэврийн байгууламж


АНУ-ын тусгай хамгаалалттай газруудад ашигладаг. Соруулдаг, усны хэрэглээ багатай, байгальд ээлтэй хуурай жорлонгийн энэ загвар нь уламжлалт бусад жорлонтой харьцуулахад өртгийн хувьд өндөр боловч ашиглалтын даац өндөртэй, аялагч жуулчид ихээр ирдэг газруудад байршуулан төлбөртэй үйлчилгээ үзүүлэх боломжтой.

Хүснэгт 41. Соруулдаг ариун цэврийн байгууламж загвар 1 –ийн тайлбар

Суултуурын төрөл	Энгийн эсвэл өтгөн, шингэн ялгагдаг суултуур
зориулалт	Нийтийн хэрэглээ
Бохир хуримтлуулах арга	Метал танканд хадгална.
Зөөвөрлөлт тээвэрлэлт	Зориулалтын машинаар бохирыг соруулж цэвэрлэх байгууламжинд зөөвөрлөн хаяна
Ариутгал халдваргүйжүүлэлт	Бохирыг тухай бүрт нь зөөвөрлөн цэвэрлэх байгууламжинд хаях тул энгийн ариутгал халдваргүйжүүлэлт хийгдэнэ.
Дахин ашиглалт	Бохирыг дахин ашиглах боломжгүй
Ашиглалтын даац	7 кабинтай /эм-4, эр-2, хөгжлийн бэрхшээлтэй -1 /шээлтүүр-4, угаалтуур-2 Нэг нүх өдөрт 1000 хүнд үйлчлэхээр тооцвол 30 хоногийн турш тасралтгүй ашиглах боломжтой
Хийцийн хэмжээ	Бүхээг: 1200*950*2000 /у*өр*өнд мм-ээр/ Хаалга: 2100*700мм Суурь: 8,2,5*1,5 м бетон, 1100-тасалгаануудтай, тасалгаан дотроо ган ёмкосттой /1,8м ³ /, суурийг 2 тэнцүү хуваан ялгас нэвчихгүй битүүмжлэл сайтай таславч хана өрнө. Таславч бүрт таславчийн 2/3-оос багагүй хэмжээтэй хаалга хийнэ. Тавцан: 2мм-ийн зузаан, 1,2*7 м-ийн хээтэй төмөр лист Цонх: байгууламжийн арын хананд 30*40 см шил Агааржуулалт: 300мм-ийн диаметртэй хуванцар хоолой,
Байрших газар	Усны эх үүсвэрээс 200 м дотор, олон нийтийн газар, дамжин өнгөрөх цэг
Давуу тал	Хөрсөнд шингэхгүй Үнэр бага, агааржуулалт гэрэлтүүлэг сайн

	<p>Гар угаах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглах боломжийг бүрдүүлсэн</p> <p>Улирлын чанартай үйлчилгээ эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжийн хэрэгцээнд загвар болохуйц</p> <p>Хэрэглэгчийн тав тухтай байдлыг хангасан</p> <p>Усны хэрэглээ бага</p>
<p>Анхаарах зүйл</p>	<p>Анх ашиглахаас өмнө буюу танкийг суллах бүрт танкны эзэлхүүний 10%-тай тэнцэхүйц ус хийх</p> <p>Бүхээгийн хаалгыг салхины зонхилох чигийн дагуу байрлуулах</p> <p>Агааржуулалтыг бохирын танктай шууд холбох</p> <p>Бохирыг соруулах үедээ ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөх,</p> <p>Хамгаалалтын хувцас хэрэглэл ашиглах</p> <p>Жорлонг ашиглах үеийн зааварчилгааг байршуулах</p> <p>Жорлонгийн менежментийг гэрээгээр хариуцуулах</p> <p>Төлбөр авах замаар жорлонгийн засвар үйлчилгээний санхүүжилтийг бүрдүүлэх, эсвэл орон нутгийн төсөвт суулгах</p>





Зураг 38: ариун цэврийн байгууламж


1. Өтгөн шингэнийг ялгадаг хуурайшуулах шийдэлтэй ариун цэврийн байгууламж

Нар, салхины байгалийн нөлөөгөөр ялгадасыг хатаах зарчимтай, ус хэрэглэдэггүй, хуурайшуулах шийдэлтэй ариун цэврийн байгууламж нь суурь, бүхээг гэсэн үндсэн 2 хэсэгтэй, суурь нь тэнцүү 2 хэсэгт хуваагдах бөгөөд нэг талыг нь ашиглаж байхад нөгөө талд нь хуримтлагдсан ялгадас хатаж, хуурайшиж байхаар тооцоолж хийгдсэн шийдэл юм. Хуурайшиж хатсан ялгадас нь жин, эзлэхүүн багасаж, өвчин үүсгэгч нян бохирдлууд тодорхой хэмжээнд устан халдваргүйддэг.

Хүснэгт 42. Хуурайшуулах шийдэлтэй ариун цэврийн байгууламжийн тайлбар

Суултуурын төрөл	Өтгөн шингэнийг ялгадаг тусгай суултуурын тагтай.
зориулалт	Тусгай хамгаалалттай газрыг жуулчны бааз. Отоглох цэгүүд, нуур, голын эргээс 200м-ийн зайтай байрлаж үйлчилгээний цэгүүд, өрхийн түвшинд хүчин чадлыг нь тохируулан ашиглах боломжтой.
Бохир хуримтлуулах арга	Өтгөнийг суултуурын доорхи суурьт, шээсийг хуванцар саванд тус тусад нь хуримтлуулна.
Зөөвөрлөлт тээвэрлэлт	2 жилд 1 удаа өтгөн хуримтлагдсан суурийг суллаж, тусгайлан бэлтгэсэн талбайд зөөвөрлөн хаяна. Шээсийг: цэвэр усны эх үүсвэртэй ойр газарт бол цэвэрлэх байгууламж, эсвэл холбогдох зөвшөөрлийн дагуу тусгайлан ухсан нүх рүү зөөвөрлөн асгаж, савыг сольж тавина. Усны эх үүсвэрээс хол газарт жорлонгийн суурийн орчимд хөрсийг ухаж хийсэн хайрган шүүлтүүр, тусгайлан холбосон бохирын хоолойгоор дамжуулан хөрсөнд шингээж болно.
Ариутгал халдваргүйжүүлэлт	Өтгөнийг хуримтлуулж суурийн хэсэгт хадгалан ариутгана.
Дахин ашиглалт	2 жил хадгалж хуурайшсан өтгөнийг хөрс сайжруулагчаар, нэг жил хадгалсан шээсийг бордоо болгон ашиглах боломжтой.
Ашиглалтын даац	1 нүхийг 1 өдөрт 50 хүн ашиглахад 30 хоног ашиглах боломжтой.
Хийцийн хэмжээ	Бүхээг: 1200*950*2000 /у*өр*өнд мм-ээр/ Хаалга: 2100*700мм Суурь: өргөн нь 800мм, өндөр урд хэсэгтээ 70см (ард хэсэгтээ 7см/12см-ийн тоосгон өрлөг) өтгөнийг хуурайшуулах танкны хаалга наран тал руугаа төмөр хаалгатай, суурийн урт нь доод хэсгээрээ 1568 мм урт, дээд хэсэгтээ 1200мм байна. Зарим нь /экосан буюу бордоожуулах технологи/ 0,4*0,4*0,4 м бетон аяган суурь, 1м диаметртэй 1,8м гүн нүхтэй 2 бочка залган хайргаар дүүргэнэ.

	<p>Шингэнийг хуванцар хоолойгоор бочкатай холбоно.</p> <p>Өтгөнийг 0,6*0,6*0,53 м-ийн саванд хуурайшуулна.</p> <p>Тавцан: 2мм-ийн зузаан, 1,2*3 м-ийн төмөр лист</p> <p>Цонх: байгууламжийн арын хананд 30*40 см шил</p> <p>Агааржуулалт: 200мм-ийн диаметртэй хуванцар хоолой,</p>
Байрших газар	Усны эх үүсвэрээс 200 м дотор отоглох цэг, жуулчны бааз, айл өрхүүдэд ашиглахад тохиромжтой.
Давуу тал	<p>Хөрсөнд шингэхгүй, байгаль орчинд халгүй</p> <p>Дэлхийн олон оронд хуурайшуулсан өтгөн, ялгаж цуглуулсан шээсийг зохих стандартын дагуу ариутгаж, халдваргүйжүүлэн сайн чанарын био бордоо үйлдвэрлэн мод үржүүлэг, цэцэрлэгжүүлэлтэнд өргөнөөр ашигладаг.</p> <p>Хэрэглэгчийн тав тухтай байдлыг хангасан үнэргүй</p>
Анхаарах зүйл	<p>Өтгөн шингэнийг хуваарь хугацаанд зөөвөрлөхдөө, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны болон эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөх,</p> <p>Хэрэглэгчийг өтгөнөөр бие зассан үедээ нэг утгуур үнс, үртэс зэрэг органик материалыг суултуурт хийх дадалд сургах,</p> <p>Жорлонг хариуцан ажиллуулж буй иргэн түүнийг ашиглах зааврыг хэрэглэгчид өгч, санамж ашиглах зааварчилгааг дотор талд байрлуулна.</p> <p>Ариун цэврийн хэрэглэл, цаас зэргийг зориулалтын хогын саванд хаях дадлыг хэрэглэгчдэд эзэмшүүлэх</p>



Зураг 39: Зөөврийн буюу шилжүүлэх ариун цэврийн байгууламж

2. Зөөврийн буюу шилжүүлэх ариун цэврийн байгууламж

Ихэнхдээ хөнгөн хуванцар материалаар хийдэг. Агааржуулалт, суултуурын нүх, ялгадасыг суллах тагтай бүхэл цул их бие хэсэг, зөөврийн суултуур, сав гэсэн

бүрдэл хэсгүүдтэй. Савыг зөөх, тээвэрлэх боломжтой, мөн битүү сав тул бохир нь хөрсөнд нэвчихгүй.

5. МЭДЭЭЛЛИЙН ЛАВЛАГАА

Шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барьж ашиглах явцад асууж тодруулах, туршлага судлах, материал хэрэгсэл, үйлчилгээ худалдаж авах гэх мэт олон шаардлага тулгардаг тул дараах байгууллагууд зөвлөгөө өгдөг.

Хүснэгт 43: Мэдээллийн лавлагаа /байгууллагаар/

Агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлон

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам

Хаяг:	Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэсний гудамж 5/2, Засгийн газрын II байр, Улаанбаатар 15160, Монгол
Хэлтэс:	НХБТГ-ын Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс
Холбоо барих:	(+976) 11 311086; (+976)11 311127;
Цахим хуудас:	www.mne.mn

Эрүүл Мэндийн Яам

Хаяг:	Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэсний гудамж 5/2, Засгийн газрын II байр, Улаанбаатар 15160, Монгол
Хэлтэс:	Нийгмийн эрүүл мэндийн газар, Тандалт шуурхай удирдлагынхэлтэс
Холбоо барих:	(+976-51) 261 632; (+976-51) 261629
Цахим хуудас:	www.mohs.mn

Барилга, Хот байгуулалтынЯам

Хаяг:	Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын XII байр, Улаанбаатар 15160, Монгол
Хэлтэс:	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар,
Холбоо барих:	(+976-51) 261426

Цахим хуудас:	www.m cud.gov.mn
---------------	--

“Дэлхийн зөн Монгол” ОУБ

Хаяг:	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Их Тойруу -93, Барилга МегаСтор зүүн жигүүр “Б” блок, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 70155323
Факс:	(+976) 70155322
Цахим хуудас:	www.wvi.org/mnmongolia.wvasiapacific.org
Имэйл:	mongolia@wvi.org

Монголын улаан загалмайн нийгэмлэг

Хаяг:	Сүхбаатар Дүүрэг, Энхтайвны гудамж, МУЗН-ийн төв байр, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 11 323334
Цахим хуудас:	www.redcross.mn
Имэйл:	info@redcross.mn

Бордоожуулах жорлон

GIZ Германы хамтын ажиллагааны нийгэмлэг

Хаяг:	Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж 21, Найман зовхис, Улаанбаатар-14251, Монгол
Холбообарих:	(+976) 11 315 340-24, (+976)7011 5340-24
Факс:	(+976)11 315342
Имэйл:	giz-mongolei@giz.de

“Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв”ТББ

Хаяг:	Чингэлтэй дүүрэг, Баруун сэлбийн гудамж, Дөчин мянгат, 1-р хороо, Гандирс-26, 703 тоот, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 11 330368
Цахим хуудас:	www.washaction.mn
Имэйл:	info@washaction.mn

“Бүүжим экспедишн”ХХК

Хаяг:	Ренчингийн гудамж, Ш/х 902 Төв шуудан, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 11 310 852, (+976) 11 327 298, (+976) 99115929
Цахим хуудас:	www.boojum.com
Факс	(+976) 11 310852
Имэйл:	info@boojum.com

Хуурайшуулах жорлон

“Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв” ТББ

Хаяг:	Чингэлтэй дүүрэг, Баруун сэлбийн гудамж, Дөчин мянгат, 1-р хороо, Гандирс-26, 703 тоот, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 11 330368
Цахим хуудас:	www.washaction.mn
Имэйл:	info@washaction.mn

Зөөврийн бордоожуулах жорлон

“Монголын усны түншлэл” ТББ

Хаяг:	Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, ШУТИС-ийн 2-р байр, 103 тоот, Улаанбаатар
Холбообарих:	(+976) 8828 6539 (+976) 99116135
Факс:	(+976) 11 310852
Цахимхуудас:	www.monwater.org
Имэйл:	mwp_2013@monwater.org ; basangreen@gmail.com

Септик систем

Ультра соник ХХК

Хаяг:	Төв оффис: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Маршал Таун, 117-рбайр
-------	--

Холбообарих:	(+976) 11 453 892; (+976) 7715 3892; (+976) 7000 3892; (+976) 88100686
Цахимхуудас:	www.ultrasonic.mn
Имэйл:	info@ultrasonic.mn

АтморХХК

Хаяг:	Баянгол дүүрэг, Баруун 4 зам, Рокмон бюлдинг -605, Үндэсний хуулийн гудамж, Улаанбаатар, Монгол
Холбообарих:	(+976) 9910 4380 (+976) 8801 4380 (+976) 99994380
Цахимхуудас:	www.atmor.mn
Имэйл:	info@atmor.mn

Тооно тушаа ХХК

Хаяг:	Сонгинохайрхан дүүрэг, 1-р хороо, толгойт 128-112, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 8811 7509, (+976) 9516 5606, (+976) 91915606
Цахим хуудас:	www.toonotushaa.mn
Имэйл:	toonotushaa@gmail.com

Газком ХХК

Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-хороолол, Сөүлийн гудамж, Роял Плаза 2 давхар
Холбоо барих:	(+976) 70133499, (+976) 88113759, (+976) 89307700
Цахим хуудас:	http://royalgroup.mn/
Имэйл:	info@gascom.mn

Хөөсөн технологитой ариун цэврийн байгууламж**“Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв”ТББ**

Хаяг:	Чингэлтэй дүүрэг, Баруун сэлбийн гудамж, Дөчин мянгат, 1-р хороо, Гандирс-26, 703 тоот, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 11 330368
Цахим хуудас:	www.washaction.mn
Имэйл:	info@washaction.mn

Ариун цэврийн байгууламжийн талаар сургалт мэдээлэл өгөх байгууллагууд:

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Хаяг:	Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо, Энхтайвны гудамж17, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 11 458645
Цахим хуудас:	www.ncph.gov.mn
Имэйл:	info@ncph.gov.mn

Нийслэлийн эрүүл мэндийн газар

Хаяг:	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Хангарьд ордон-901 тоот, Улаанбаатар-15160, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 7011 0500 (+976) 11 325 076 (+976) 70110500. (+976) 1800 1893 (+976)11 320 981 (+976) 11 329114 (+976) 11 324124 (+976) 11 325054
Цахим хуудас:	www.ubhealth.mn
Имэйл:	nemg@emg.ub.gov.mn

Хот суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл

Хаяг:	Сүхбаатар дүүрэг, их тойруу 48/2, 10-р хороо, 7-р хороолол, Эмон бизнес төв, 5 давхар, Улаанбаатар хот, Монгол улс
Холбоо барих:	(+976)7014-7447
Факс:	(+976)7014-7447
Цахим хуудас:	www.wsrc.mn

Имэйл:	info@wsrc.mn
--------	--------------

“Дэлхийн зөн Монгол” ОУБ

Хаяг:	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Их Тойруу -93, Барилга МегаСтор зүүн жигүүр “Б” блок, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 70155323
Факс:	(+976) 70155322
Цахим хуудас:	www.wvi.org/mnmongolia.wvasiapacific.org
Имэйл:	mongolia@wvi.org

“Монголын усны түншлэл”ТББ

Хаяг:	Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, ШУТИС-ийн 2-р байр, 103 тоот, Улаанбаатар
Холбоо барих:	(+976) 8828 6539 (+976) 99116135
Факс:	(+976) 11 310852
Цахим хуудас:	www.monwater.org
Имэйл:	mwp_2013@monwater.org; basangreen@gmail.com

Нэмэлт тоноглол авах газрууд:**“Мөнхийн хүндлэл” ХХК –суултуур**

Хаяг:	Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Бүрд худалдааны төв, 2-р давхар, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 9911 7421 (+976) 9911 3630 (+976) 9666 5225 (+976) 99755182
Имэйл:	servicemon@yahoo.com

“Үнэт ирээдүй” ТББ –өтгөн шингэн тусгаарлагч

Хаяг:	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чагдаржавын гудамж, 42-20, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 91915294
Имэйл:	unetireedui@yahoo.com

Бохирыг задлах, хатаах үйлчилгээтэй бодис, ЕМ зардаг байгууллагууд:

“Хийрэв”ХХК

Хаяг:	Сүхбаатар дүүрэг, 11-р хороолол, 4-60 тоот, Улаанбаатар, Монгол
Холбоо барих:	(+976) 352 112; (+976) 9668 1901; (+976)88004307
Имэйл:	dugar21mn@yahoo.com

Ирвес интертрейд ХХК

Хаяг:	Баянзүрх дүүрэг, 10-р хороо, 16 хэсэг 81/1, Улаанбаатар
Холбоо барих:	(+976) 8800 0150 (+976) 9191 0750, (+976) 8808 0613, (+976) 88031130
Цахим хуудас:	www.irves.mn
Имэйл:	info@irves.mn

Вакуум ариун цэврийн байгууламж барих**ПонкуриХХК**

Хаяг:	Сүхбаатар Дүүрэг 8-р хороо, Сити Таур, 11 давхар 1102 тоот, Улаанбаатар хот, МонголУлс
Холбоо барих:	(+976) 7700 5256; (+976) 88001543
Цахим хуудас:	www.pungori.mn

Биологийн аргаар задлах бодис**Хими, химийн технологийн хүрээлэнгийн дэргэдэх Технологийн Инкубатор ТӨВ**

Хаяг:	Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө, ШУА-ийн IV байр, Улаанбаатар-13330, Монгол
Холбоо барих:	(+976) 9908 9698; (+976) 99257129
Цахим хуудас:	www.icct.mas.ac.mn
Имэйл:	sukhbat987@yahoo.com

Барилга, хот байгуулалтын яамны харъяа “Хот суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл”-өөс тусгай

зөвшөөрөл авсан бохирын цооног, жорлон соруулах эрх бүхий аж ахуйн нэгж,байгууллагууд.

№	Нэр	Өмчийн хэлбэр	Хаяг, байршил
1	Алтан дорнын хүч	ХХК	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 5-2т
2	Анунболор	ХХК	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо, Даваажавын гудамж,16-150т
3	Эс Жи БиЭм	ХХК	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21-р хороо, Өндөрхаан2,1т
4	Сөрттамир	ХХК	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 11-р хороо, Нуурын 11-152т
5	Данхаадай	ХХК	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12-р хороо, 6-р бичил хороолол,11-50т
6	Талст эрчим	ХХК	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 9-р хороо, Баруун баян уулын3-24т
7	Өргөжих хаус	ХХК	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 9-р хороо, Малчны2-83т
8	Мандах гарам	ХХК	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, Өнөр хороолол,9-348т
9	ГалтайЧойндон	ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,14-рхороо, Хандгайтын28-230т
10	Зуслан сэрвэнцохио	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,24-р хороо, хоршооллын 3-17тоот
11	Баянбулагбаянзүрх	ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 6-244тоот
12	Кью ЭмЭс	ХХК	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12-р хороо, 6-р бичил хороолол, 7/3-р байр 23тоот
13	Сутайхонгор	ХХК	Улаанбаатархот, Сонгинохайрхан дүүрэг, 4-р хороо, 53а-р байр,21тоот.
14	Тэнүүн билэгтхангай	ХХК	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4-р хороо, Арцатын 1-44бтоот.
15	Арвай ихтамгат	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,24-рхороо, хоршоолол-3,17тоот
16	Даймомент	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,1-р хороо, 12-р хороолол, MW плаза 207тоот

17	Монголын алт МАК ХХК	ХХК	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол, Монголын алт МАК ХХК-ийн төв байр 44
18	Юу Эн Пи Эм Жи Эл	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, 12-р хороолол, Токио, 3,16
19	Цагдаагийн ерөнхий газрын олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын хамгаалалтын хоёрдугаар газар	ТБАГУТУГ	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 22-р хороо, Хилчин холбоочдын гудамж, өөрийнбайр
20	Өгөөж их бүрд	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Эрдэнэ толгой 40, 222атоот
21	Грийн инвайро	ХХК	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 14-р хороо, 16-15тоот
22	Бар сүүлт	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 17-р хороо, Эмнэлгийн 9-398т
23	Томмасс	ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, 31-56 тоот
24	Далив	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 23-р хороо, Сургуулийн 1791тоот
25	Грандпиглет	ХХК	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол, 38-83тоот
26	Мөнхийн амьд ус	ХХК	Улаанбаатар хот, Сонгинохйрхан дүүрэг, 30-р хороо, Хамба 2-18 тоот
27	Тэрэлж сувд	ХХК	Улаанбаатар хот, Сонгинохйрхан дүүрэг, 7-р хороо, 0119-р цэргийн анги, 1-10тоот
28	Говийн марз хайрхан	ХХК	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,7-рхороо, хувьсгалчид г, 675тоот
29	Голден-Эко	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 15-р хороолол,53-12т
30	Маргад Монгол	ХХК	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19-р хороо, 4-р хороолол,52-101т
31	Жавхлант говь инвестмент	ХХК	Өмнөговь аймаг, Ханбогдсум,2-рбаг, Гавилууд

32	Сонгинохайрхан дүүргийн захиалагчийн алба	ОНӨААТҮГ	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, Минж төвийн 6-р давхар, 601, 602тоот
33	Улаан суварга хайрхан	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Товчоо дэнж, 3-24тоот
34	БЛ даул	ХХК	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, Шар хад 64-946тоот
35	Жей Си Консалтинг	ХХК	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 220 мянгат, 23-77тоот
36	Эс Би Жи глобал	ХХК	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 5-р хороо, Баянгол 5-5тоот

Технолгийн талаар мэдээлэл

Бохирын септик систем гэж юу вэ?

Бохирын төвийн шугамд холбогдоогүй газруудад хамгийн байгаль орчинд ээлтэй бөгөөд ашиглалтын зардал бага бохирын систем нь септик систем юм. Уг систем нь 120 гаруй жилийн өмнөөс төв шугамд холбогдох боломжгүй АНУ, Канад, Австрали, Европын холбооны улсуудад ашиглагдаж байгаа систем юм.

Монголын уур амьсгал, байгал орчны онцлогийн улмаас хөлдөлтийн түвшин бусад орнуудаас харьцангуй гүн байдаг тул бохирын септик системийн технологид олон хүндрэл тулгардаг хэдий ч манай орны мэргэжлийн байгууллагууд уг системийг нутагшуулан хэрэгжүүлж байгаа юм.




Зураг 40: Ахуйн бохирын септик системийн ерөнхий зураг

Ажиллах зарчмын тухайд гурван үе шаттай. Эхнийх нь механик цэвэрлэгээ буюу гэрээс гарсан бохир септик танкинд орж хүнд элемент нь лаг болон тунана. Харин шингэн хэсэг нь дараагийн хэсэг рүү шилжинэ. Энэ бол

биологийн цэвэрлээний үе бөгөөд хүчилтөрөгчгүй орчинд анаэробик бактери бий болсноор бохир усан дахь бусад бичил биетүүдийг устгадаг байна. Ингээд 50-60 хувь цэвэрлэгдсэн саарал ус болно. Гуравдахь цэвэрлэгээ нь хөрсөнд хийгддэг. Учир нь хөрс бол хамгийн үр дүнтэй цэвэрлэгч талбай юм. Септик танкнаас гарсан саарал ус хөрсөндөө шингэн зарим бохир хэсэг нь хөрсөнд наалдсанаар микробын ялзрал явагдаж цэвэрлэгддэг байна. Септик систем ашиглалтын зардал багатай. Тодруулбал 3–5 жилдээ 1 удаа лагийг нь соруулж цэвэрлэнэ.

Хэрэглээнээс хамааран 2 – 40 тн хүртэлх танктай. Септик бохирын систем нь “халдваргүйжүүлэгч” гэсэн үгнээс гаралтай бөгөөд үл нэвтрэх, хүчилтөрөгчгүй тунгаагч саванд бий болсон анаэробик бактер нь бохир хаягдлыг задралд оруулж,

эзэлхүүнийг нь багасган нягтруулж байгаатай холбоотой. Септик бохирын системийг аялал жуулчлалын бүтээн байгуулалтад суурилуулах боломжтой юм.



Зураг 41: Тунгаагчтай септик системийн ерөнхий бүдүүвч

Одоогоор АНУ-д 40 сая септик систем хэрэглэгдэж байгаа ба Канад, Австрали, Европын холбооны улсуудад мөн хэмжээний септик систем ашиглагдаж байна.

Системийн зорилго нь бохир хаягдлыг ялган задалж, ялгаран тунасан шингэн хэсгийг нь газрын хөрсөөр дамжуулан бүрэн цэвэршүүлэн шүүж, улмаар хөрсний усанд тэнцэх хэмжээнд цэвэр усыг гаргахад чиглэдэг юм.

Энэхүү систем нь өртөг, ашиглалтын зардал багатай, цэвэрлэх давтамж цөөн (3-5 жилд 1 удаа) гэсэн давуу талуудтай.



Зураг 42: Септик системийн танкууд

Септик системийн танкууд

Жишээ нь:

200 хүн хүлээж авдаг зочид буудлын хэрэгцээнд 20м³ хүчин чадалтай 40м³ багтаамжтай бохирын систем суурилуулна.

Энэхүү бохирын систем нь үндсэн 3 үе шаттайгаар цэвэрлэгээ хийдэг.

1. Механик
2. Хөрсний
3. Биологийн гэсэн үндсэн 3 үе шаттайгаар цэвэрлэгээг хийдэг.

Септик системийн давуу талууд

Энэхүү систем нь доох давуу талуудтай

- Байгаль орчинд ээлтэй
- Газар төлөвлөлтөнд нөлөө үзүүлэхгүй
- Ашиглалтын зардал багатай
- Цэвэрлэх давтамж цөөн (3-5 жилд нэг удаа)

Монгол улсад “Усны чанар, хаягдал бохир ус”-ны стандарт болох MNS 4943:2000 мөрдөгдөж байна. Энэхүү стандартын дагуу, хаягдал бохир усыг зохих түвшний цэвэршүүлэлт хийсний дараа 1-т усны эх үүсвэрт 2-т хөрсөнд хаяж болохыг

зөвшөөрсөн байдаг. Мөн энд бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж ба бусад үзүүлэлтийн хязгааруудыг зааж өгсөн байдаг.

Бохирын системийг төлөвлөхөд анхаарах зүйл

Бохирын системийн дээгүүр машин техник явах ёсгүй.

Тухайн газар орны хөлдөлтийн гүнээс доош газар доор суулгах шаардлагатай.

Газар доор суулгахдаа хөлдөлтөөс хамгаалах дулаалгын ямар нэг төрөлийн материалыг төлөвлөх хэрэгтэй. Хөөсөнцөр, үнс, керамзит гэх мэт хөрсөн доор тэсвэртэй ямар ч материал ашиглаж болно.

Ойр орчмыг асфальт эсвэл бетоноор бүрхэж болохгүй. Зүлэг тарих нь хамгийн тохиромжтой.

Амархан бөглөрөлт үүсгэх зүйл хийж болохгүй. Яс, тамхины иш, нярайн живх, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэгсэл, зориулалтын бус цаас гэх мэт.

Энзим, дроз, химийн бодис, будаг, шатахуун, фото зургийн шингэн, пестицид болон бусад химийн хорт бодисыг хийж болохгүй.

Бохирын системийг байрлуулахад мөрдөх зай.²

Бага хүчин чадалтай эко цэвэрлэх байгууламжийн технологи

Монгол улсын MNS EN 12566-2011 стандартаар 50 хүртэлх тооны бохир ус цэвэрлэх байгууламжийн угсармал септик болон түүний дагалдах тоног төхөөрөмжинд тавигдах шаардлагыг тогтоосон.

Үүнд: 1-р хэсэг буюу угсармал септик

Угсармал септикийн төхөөрөмжинд тавигдах шаардлагууд болон лабораторийн туршилтын аргачлалыг тодорхойлно. Угсармал септик гэж үйлдвэрийн аргаар хийсэн, шалгаж угсрахад бэлэн болгосон оролт, гаралтын түвшингийн холболтой иж бүрдэл юм. Зөвхөн саарал ус хүлээн авах септик систем энэ стандардат хамаарахгүй. Септикийн хамгийн бага хүчин чадал нь 2м.куб байхаар төлөвлөнө. Оролт ба гаралтын хоолойн хэмжээсийг хэрвээ 6м.кубээс бага бол 100мм, 6м.кубээс их бол 150мм-ээр хийнэ.

Агааржуулалт. Исэлтийн хий хуримтлахаас сэргийлэн, септик болон оролтын шугам хоолойг хангалттай агааржуулалттай байхаар төлөвлөнө. Төлөвлөлтийг хийхдээ хэрэглэгчийн ачаалал, лаг хадгалах тодорхойлсон хэмжээс, амралт сувилал,

² Барилга сэтгүүл №40

арилжаа үйлчилгээний байгууллагын бохир усанд тавигдах нэмэлт үзүүлэлтүүдэд үндэслэсэн байна.

2-р хэсэг буюу хөрсөөр шүүрүүлэх систем.

Хөрсөнд шүүрүүлэх системийн зураг төслийн үзүүлэлтүүд болон барилгын ажил, угсралт, суурилуулалт, тоног төхөөрөмжүүдэд тавигдах шаардлагыг тусгасан, тухайн газар нутгийн онцлогийг тооцсоны үндсэн дээр ус хаях талбайн байршлыг сонгох зорилгоор талбайн нарийвчилсан судалгааг заавал хийнэ. Гүний ус ялангуяа ундны усны эх үүсвэрийг заавал хамгаалах ёстой. Хаях талбай нь гүний усны эх үүсвэрээс гидравликийн хувьд газрын доод талд нь байрлаж байвал гүний усыг бохирдуулах эрсдэл хамгийн бага байна. Гүний усны урсгалын чигийг сорилтын цооног өрөмдөж, эсвэл топографийн байрлал, орон нутгийн мэдээлэл дээр үндэслэн тогтооно. Хөрсний шүүрэлтийн гол үзүүлэлт нь хөрсний шинж чанараас хамаарна. Шүүрүүлэх системийн талбай нь хоногийн нийт зарцуулалтаас шууд, хөрсний чанараас урвуу хамаарна. Энэ тухай дээрх стандартад тодорхой заасан байдаг. Шүүрүүлэх системийг суурилуулахад анхаарах бас нэг зүйл бол шүүрүүлэх системийн төрлийг сонгох асуудал юм.

Энэ нь үндсэн 4 төрөл байна. Шүүрүүлэх суваг, гүехэн шүүрүүлэх талбай, гүн шүүрүүлэх талбай, шүүрүүлэх овоолго

Шүүлтүүрийн хэсэг нь урсан ирсэн саарал усыг бүгдийг нь байнга соруулах давтамж үүсгэлгүйгээр газрын хөрсөнд аажмаар бүрэн цэвэршүүлж тархаах үүрэгтэй. Тархаж буй ус нь газрын хөрсөнд шингэх явцад үлдсэн бохирдуулагч бодисууд нь хөрсний молекулуудын гадаргуу дээр наалдаж, хөдөлгөөнгүй үлдэж тогтдог ба тэдгээр хэсгүүдийн ихэнхи нь микробын ялзрал болон шүүрүүлэх явцаар цэвэршдэг. Микробын ялзрах процесс явагдсанаар эцсийн буюу хөрсний цэвэрлэгээ хийгддэг юм.

2 хэсэг. Шүүрүүлэх системтэй септик танк байгуулахын өмнө заавал хөрсний судалгаа хийсэн байвал зохино. Сорилын нүх ухаж, хөрсний усны түвшинг тогтоосны дараа хөрсний шинж чанарыг тогтоосон байна. Хамгийн сүүлд шүүрүүлэх системийн төрлийг сонгож байршлыг тодорхойлно.

3 хэсэг. Угсармал болон газар дээр нь угсарч болох ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн тухай.

Бага хүч чадалтай цэвэрлэх байгууламжийн технологийн энэ шийдлийг байгуулах үед тавигдах гол нөхцөл нь механик даралтанд өртөхгүй байх газарт булна. Ахуйн бохир усыг хүлээн авч шаардагатай хэмжээ буюу MNS 4943:2015 стандартаар зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл цэвэрлэх зориулалттай байгууламж юм.

4 хэсэг. Угсардаг иж бүрдлийг ашиглан газар дээр нь угсрах септик нь тухайн газар нутагт угсарсан септикт тавигдах шаардлага, туршилтын аргачлалыг тодорхойлно. Том оврын цэвэрлэх байгууламжийн технологи хийцэд тавигдах шаардлагыг MNS EN 12255:2015 стандартад заасан байна.

Бага оврын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж

Сүүлийн үед өндөр хөгжилтэй орнуудад үнэ өртөг ихтэй, олон зуун км бохирын шугам хоолойг ашиглан, хэрэглэхэд төвөгтэй, доголдол гарсан нөхцөлд бүхэлд нь сольж шинэчлэх хэрэгтэй болдог зардал ихээхэн шаарддаг, нүсэр төвлөрсөн төв цэвэрлэх байгууламжаас татгалзах болсон. Түүний оронд инженерийн шугам хоолой, холболт шаарддаггүй, хямд төсөр, бага оврын, бохирыг шууд цэвэршүүлж байгальд шингээдэг төвлөрсөн бус системийг нэвтрүүлж байна.

Манай улсад ч мөн амины орон сууц, жижиг сууцанд зориулсан бага оврын цэвэрлэх байгууламжийн ач холбогдлыг ойлгож, хэрэглээнд нэвтрүүлэх нь эрс нэмэгдсэн. Хямд төсөр, авсаархан, хэрэглэхэд хялбар гээд олон давуу талтай бөгөөд манай улсад нэвтрүүлж буй, ахуйн бохир усыг цэвэршүүлэх жижиг байгууламжуудийг айл өрхүүд болон бага хэмжээний ахуйн бохир усыг цэвэршүүлэх төхөөрөмжүүд байна. Цэвэрлэх байгууламжийн систем нь гол үзүүлэлтээрээ Монгол Улсын "Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага" MNS4943:2011 стандартыг хангах шаардлагатай. Бага оврын цэвэрлэх байгууламж нь төвийн шугамаас алслагдсан барилга байгууламж, суурин газрын бохир усыг анаэробик орчинд цэвэрлэх бага оврын, биологийн цэвэрлэх байгууламж юм. Мөн лагийн гарц багатай, лагийг дотроо автоматаар дахин цэвэрлэдэг. Ингэж дахин боловсруулдаг систем дэлхийд одоогоор байхгүй болно. Энэ нь маш энгийн хийцтэй технологийн шийдэл бөгөөд горим нь хялбар, химийн бодис, бактерийн нэмэлт тэжээл шаардахгүй, хөдөлдөг, зэврэх эд ангигүйгээс найдвартай ажилладаг, ашиглалтын зардал, цахилгааны зарцуулалт бага тул хямд төсөр, эдийн засгийн өндөр үр ашигтай технологи болно.

Бохир усны төрөл

Бохир усыг түүний үүсэл гарлаар нь дараах төрөлд ангилна.

- Ахуйн бохир ус нь хүн амьтны физиологийн ялгадас, ахуйн угаалга цэвэрлэгээ, усанд орох, хоол хүнс бэлтгэхэд хэрэглэсэн уснаас бүрдэнэ. Түүний үндсэн

бохирдол нь органикууд, ялгадас, хүнсний бүтээгдэхүүний хаягдал, ахуйн химийн бодис, өвчин үүсгэгч нян зэрэг байна.

- Үйлдвэрийн бохир ус нь үйлдвэрийн технологийн төрөл бүрийн технологийн процесст хэрэглэсэн ус байна.
- Хур тунадасны ус гэдэг нь бороо, хайлсан цасны ус барилгын дээвэр, гудамж, зам талбай дээр бууж түүн дээрх бохирдлыг агуулсан ус байна.

Ахуйн бохир усыг дотор нь хар ба саарал ус гэж ялгадаг. Хар ус гэдэг нь ялгадас зайлуулах төхөөрөмжөөс гарах хүний өтгөн, шингэнийг агуулсан ус байна. Саарал ус гэдэг нь усанд орсон, гар нүүр, хувцас, гал тогооны сав суулга, угаахад гарсан усыг хэлнэ. Ахуйн бохир усны 30% орчмыг хар ус эзэлдэг ба энэ нь фосфор, азот, төрөл бүрийн нянгийн бохирдлыг ихээр агуулдаг тул түүнийг зайлшгүй цэвэрлэж халдваргүйжүүлэх шаардлагатай.

Бохир усны цэвэрлэгээний төрөл

- Механик цэвэрлэгээ
Шүүх, тунгаах арга хэрэглэнэ
- Биологи цэвэрлэгээ
Бохир усны органик бохирдлыг исэлдүүлэн боловсруулах бичил биетийн чадвар дээр үндэслэгдэнэ.
- Гүн цэвэрлэгээ

Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж гэж юу вэ?

Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг сонгох үндэслэл хэрэгцээ шаардлага нь НҮБ-ийн судалгаагаар хөрсний бохирдлоор дэлхийд 7-р байранд орж байна. Ультрасоник компани нь Монгол улсад ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж барьж ашиглалтанд оруулсан үндэсний томоохон, туршлагатай компани юм. Тус компани нь Хан хужирт амралт сувилалын газарт 500 хүний септик системийг суурилуулсан бөгөөд энэ одоогоор бие даасан ахуйн бохир ус цэвэрлэх хамгийн том байгууламжийн нэг болж байна. Мөн Цонжин Болдог, Тэрэлжийн баазуудад 50 хүртэлх хүний багтаамжтай ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламжийг суурилуулсан байна.

Төвлөрсөн бус суурин газарт зориулсан бага оврын цэвэрлэх байгууламжийн шийдэл

ХБНГУ-ын Bergmann группын ахуйн бохир ус цэвэрлэх төхөөрөмж нь WSB (хөвөгч эргэлдэх биет биореактор) технологийн зарчимаар ажилладаг. Уг төхөөрөмж нь төвлөрсөн бус системийн барилга, байгууламжид зориулагдсан бөгөөд 5-5000 хүний хэрэглээнд тохирсон хүчин чадлын сонголтуудтай. Тухайн газрын байршил, хөрсний бүтэц, аялал жуулчлалын байгууллага болон баазын онцлогоос хамаарч нэмэлт төхөөрөмж болон тоноглолуудыг сонгон хэрэглэнэ.

WSB технологи нь биологийн цэвэрлэх байгууламжийн төрөлд орно. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн усны стандарт MNS 4943 стандартыг бүрэн хангана. Уг стандартад заагдсан хязгаарлалтын үзүүлэлтээс доош үзүүлэлт үзүүлдэг. Уг цэвэрлэх байгууламжийг хөлдөлтийн гүнээс доош байрлуулж, хаших хийцийг өндөр чанарын бетоноор хийж гүйцэтгэдэг. Энэ нь манай орны нөхцөлд ашиглахад маш тохиромжтой. Мөн хөлдөлтийн гүнээс Насжилтийн хувьд 30-аас дээш жилийн үзүүлэлттэй байдаг. /Хуванцар саваар хийж гүйцэтгэхэд насжилтын хувьд урт байж чаддаггүй, мөн хөрсний бүтэцээс шалтгаалан хуванцар сав нь тохиромжгүй байх магадлалтай/.

Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламж нь үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

1-р танк нь Тунгаагуур танк бөгөөд гүн бохир нь доош тунана. Цэвэрлэгдэхгүй гүн лаг нь уг танканд тунаж үлдэнэ. Гүн лаг нь /Монгол орны хувьд лаг соруулах хугацаа нь Германтай харьцуулахад урт байдаг. Энэ нь манай усны хэрэгцээтэй холбоотой байдаг./

2-р танк нь Биофилм буюу хөвөгч эргэлдэх биетийг байрлуулна. Энэ нь микро организмыг хадгалах үүр нь болж өгдөг. Мөн хүчилтөрөгчөөр хангах диффузерийг суулгаж өгнө. Энэ компресороор шахагдаж микро организмын амьдрах нөхцөл буюу хүчилтөрөгчийг нөхөж өгнө. Хэрэглээний их болон бага ачаалалд найдвартай ажиллагаатай. Хэрэглээ бага байна гэдэг нь микро организмыг хоол тэжээлийн дутагдалд оруулах, Хэрэглээний их ачаалалд биологийн микро организмын ачаалал ихэсэх үзэгдэл явна.

3-р танк нь Тунгаагуур танк байна. Уг танканд хуримтлагдсан механик бохирдлыг мөн 1-р танк руу шахах насосыг байрлуулж өгнө. Энэ танканд бохир ус 97 хувь хүртэл цэвэршиж дараагийн шат буюу хөрсөн шингээх болон бусад хэрэглээнд ашиглахад тохиромжтой

Зайнаас удирдах удирдлагын систем нь бүрэн автомат ажиллагаатай бөгөөд цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг тогтмол хянаж Германд байх сервертэй холбогдож ажилладаг учир байнгын үзлэг шаардахгүй бөгөөд аливаа доголдол гарахад бодит хугацаанд мэдэгдэх боломжтой. Шаардлагатай тохиодолд мэдээллийн системээс авсан мэдээллийн дагуу тохиргоо болон засвар үйлчилгээг хийх боломжтой.

WSB ТЕХНОЛОГИЙН ДАВУУ ТАЛУУД:

- Бохир усыг өндөр түвшинд цэвэршүүлэнэ (97%)
- Байгальд сөрөг нөлөөгүй
- Өвчин үүсгэгч нянгуудыг микробиологийн аргаар устгана
- Хэт их болон бага ачаалалтай үед найдвартай хэвийн ажиллагаатай
- Зогсолтоос үүсэх саатал гэмтэл байхгүй
- Ашиглахад хялбар, бүрэн автомат ажиллагаатай
- Алсын зайнаас хянах боломжтой
- Ашиглалтын хугацаа 30 жилээс багагүй
- Ашиглалт, засвар үйлчилгээний зардал бага
- Урт хугацаанд бага лаг үүснэ
- Олон улсын стандарт болон дотоодын стандартыг бүрэн хангасан
- Монгол орны эрс тэс уур амьсгалд бүрэн тохирсон

Өндөр түвшний цэвэрлэгээний нууц нь микробиологийн жижиг биофилм юм.

Байгаль дээр орших булаг нь WSB® технологийн байгалийн хувилбар бөгөөд урсгал усны эргэлтээр усны бохирдлыг цэвэрлэдэг онцлогтой. WSB® технологийн цэвэрлэх процессын хоёр гол хүчин зүйл нь:

- Цэвэрлэгээний биофилм буюу хөвөгч эргэлдэх биетийг үүсгэх микро биетүүдийг усан дахь чулуунаас гаргаж авдаг. Энэхүү микро биетүүдийг чулууны өнгөн хэсгийн гулгамтгай дээрээс харах боломжтой.
- Системийн аюулгүй ажиллагааг хангах гол хүчин зүйл нь булгийн налуу юм.



Зураг 43: Системийн аюулгүй ажиллагаа



Зураг 44: Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны процесс

Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны процесс

1. Анхдагч тунгаагуур

Бохир ус байшингаас гарч байгууламжруу ороход түүхий бодисууд болон лаг доош сууна. Механикаар цэвэрлэгдсэн ус биологийн цэвэрлэгээний шатруу шилжинэ.

2. Биологийн цэвэрлэгээ

Дотор хэсэгт микро биетүүд амьдрах, тээвэрлэгч материалууд байх ба тэдгээрийн тусламжтайгаар хорт бодисыг 99% хүртэл устгах чадалтай өндөр түвшний биофилмийг үүсгэнэ.

3. Агааржуулалт

Дотор хэсэгт микро биетүүд амьдрах, тээвэрлэгч материалууд байх ба тэдгээрийн тусламжтайгаар хорт бодисыг 99% хүртэл устгах чадалтай өндөр түвшний биофилмийг үүсгэнэ.

4. Хоёрдогч тунгаагуур

Биологийн цэвэрлэгээнээс гарсан хатуу бодисууд шаланд тунаж үлдэнэ.

5. Лаг цэвэрлэх

Хоёрдогч тунгаагуураас лагийн үлдэгдлийг зайлуулна.

6. Гаралт

Цэвэрлэгдсэн ус дээж авах хэсгээр дамжин гол горхи руу урсах ба эсвэл газрын хөрсөнд шингэнэ.

7. Цэвэрлэгдсэн усны шинжилгээ

Усны чөлөөт урсгалаас дээжийг авч, гарч байгаа уснаас шаардлагатай үзүүлэлтүүдийг шинжлэхийн тулд дээжийг энгийн аргаар авах боломжтой.

8. Wsb[®] технологийн удирдлага

M2m дэвшилтэт технологи бүхий удирдлага нь ажлын цаг болон нөхцөл байдлын мэдээллийг хадгалж, байгууламжийн ажиллагааг хэвийн явуулна.

Стандартууд

Хүснэгт 44: Стандартууд

№	Стандарт болон норм дүрмийн бичиг баримтууд дугаар	Нэршил
1	MNS 4943:2011	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
2	MNS4586-1998	Усны чанарын стандарт
3	MNS 4288:1995	Бохир ус цэвэрлэх байгууламжуудын байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавигдах үндсэн шаардлага

4	MNS1-2:2006	Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм
5	БНБД40-01-06	Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж
6	MNS 5775 : 2014	Хот, суурины ундны ус түгээх цэг(байр)-ийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага